




ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 40 (227)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Ээлжит чуулганыг нээх хугацааг хойшлуулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Ерөнхий Консулын газрыг татан буулгах тухай*
- *Орон сууц хувьчлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны аравдугаар сарын 15 №40 (227)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

472. Комисс байгуулах тухай Дугаар 67 957
473. Орон даяар гашуудал зарлах тухай Дугаар 68 958
474. Ээлжит чуулганыг нээх хугацааг хойшлуулах тухай Дугаар 69 958

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

475. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 59 959
476. Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай Дугаар 60 959

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

477. Олимпийн наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай Дугаар 187 959
478. Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Дугаар 188 962
479. Ерөнхий консулын газрыг татан буулгах тухай Дугаар 189 962
480. Ажлаас чөлөөлөх тухай Дугаар 190 963
481. Орон сууц хувьчлах тухай Дугаар 191 963
482. Хөрөнгө гаргах тухай Дугаар 192 964
483. Олон улсын театрын анхдугаар наадам, симпозиум зохион байгуулах тухай Дугаар 193 964
484. Хөрөнгө гаргах тухай Дугаар 198 964

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 67** **Улаанбаатар хот**

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүн, МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Лхамсүрэнгийн Энэбишийн шарилыг оршуулах Улсын Их Хурал, Засгийн газрын комиссыг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Энхбаяр - Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн

Орлогч дарга:

Ж.Бямбадорж - Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Гишүүд:

Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга

Ш.Гунгаадорж - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны дарга

Т.Ганди - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга

Д.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Н.Баяртсайхан - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга

Ц.Шаравдорж - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга

Т.Очирхүү - Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга

С.Төмөр-Очир - Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ахлагч

Ө.Энхтүвшин - Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Ч.Улаан - Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайд

Ц.Нямдорж - Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд

П.Нямдаваа - Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд

Ж.Гүррагчаа - Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд

Л.Эрдэнэчулуун - Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд

Б.Батхишиг - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

Л.Жавзмаа - Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны дарга

М.Энхболд - Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Ц.Энхбат - Булган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга

М.Оюунбат - Булган аймгийн Засаг дарга

Б.Ганболд - Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга

Д.Нямбаяр - Төрийн ёслолын албаны даргын үүрэг гүйцэтгэгч

Э.Мөнхбаяр - Талийгаачийн хүү

Нарийн бичгийн дарга

Д.Батбаатар - УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга

ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 68** **Улаанбаатар хот**

Орон даяар гашуудал зарлах тухай

Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхамсүрэнгийн Энэбишүүлийн 2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр таалал төгссөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүн Лхамсүрэнгийн Энэбишийн гэгээн дургсалыг хүндэтгэж 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаагаар орон даяар гашуудал зарласугай.

2.Гашуудал зарласан өдрүүдэд гашуудлын ёслол үйлдэх /Төрийн далбаа бөхийлгөх, суүлчийн замд нь үдэх үеэр хөдөлгөөнийг түр зогсоох, буудлага хийх, гашуудлын дуут дохио өгөх зэрэг арга хэмжээ авч явуулах/ түр журам тогтоож хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3.Орон даяар урлагийн тоглолт, кино зэрэг цэнгэлийн үйл ажиллагаа явуулах, ёслолын арга хэмжээ зохиохыг өнөөдрөөс эхлэн гашуудал дуустал хориглосугай.

4.Энэхүү тогтоолыг батална өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 69** **Улаанбаатар хот**

Ээлжит чуулганыг нээх хугацааг хойшлуулах тухай

Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхамсүрэнгийн Энэбишүүлийн 2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр таалал төгссөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганыг 2001 оны 10 дугаар сарын 10-ны өдөр нээхээр тогтоосугай.

2.Энэхүү тогтоолыг батална өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 01-ний өдөр **Дугаар 59** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лодойдамбын Галбадрахыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Пэрэнлэйн Үржинлхүндэвийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 03-ны өдөр **Дугаар 60** **Улаанбаатар хот**

Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгох нь:

1. Монгол Улс терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулах хүчин чармайлтыг тууштай дэмжиж дипломат, хууль зүй, санхүү, цэрэг, тусгай албадын шугамаар эвслийн үйл ажиллагааг өөрийн хувь нэмрийг оруулахад бэлэн байгаагаа мэдэгдэх;

2. Терроризмтай тэмцэхэд дэлхийн улс түмнээс хамтын хүчин чармайлтаа нэгтгэхийг уриалсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1333, 1267, 1368, 1373 тоот тогтоолуудын заалтыг хэрэгжүүлэхэд өөрийн орны зүгээс шаардлагатай арга хэмжээ авах;

3. Терроризмтай хийх тэмцлийг эрчимжүүлэх тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56 дугаар чуулганы бүгд хуралдаанаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх талаар НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд эвслийн орнуудтай байр сууриа зохицуулан идэвхтэй хамтран ажиллах;

4. Терроризмын эсрэг тэмцэхэд туслалцаа үзүүлэхийг хүссэн улс орнуудтай хамтран ажиллах, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр **Дугаар 187** **Улаанбаатар хот**

Олимпийн наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хангах,2004 оны Афины зуны олимпийн наадмын бэлтгэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 оны зуны олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хороо байгуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор батлсугай.

2. 2004 оны зуны олимпийн наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион

байгуулах арга хэмжээ авахыг Үндэсний хорооны орлогч дарга П.Нямдаваад үүрэг болгосугай.

3. "Мөнгөн шагнал олгох журам"-ыг 2 дугаар, "Олимп, дэлхийн аварга, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчинд олгох мөнгөн шагналын хэмжээ"-г 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталасугай.

4. Олимпийн наадамд оролцох эрх авах боломжтой спортын төрлөөр шилдэг тамирчдыг сонгон шалгаруулж 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн үндэсний шигшээ баг (байнгын бус) байгуулж бэлтгэл, сургуулилтад хамруулах арга хэмжээнд болон олимпийн наадмын бэлтгэл ажилд шаардагдах хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

5. Энэ тогтоолын 3, 4 дүгээр заалттай уялдуулан баг, тамирчдыг спортын гадаад арга хэмжээнд оролцуулах, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээнийг санхүүжүүлэх, 2004 оны олимпийн тоглолтод оролцох Үндэсний шигшээ баг байгуулж, санхүүжүүлэхтэй холбогдсон журам, заавырыг 2001 оны IY улиралд багтаан гаргаж мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шагналын журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 252 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2001 оны 187 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

2004 ОНЫ ЗУНЫ ОЛИМПИЙН НААДАМД БЭЛТГЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр
Орлогч дарга	-Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа
Гишүүд:	-Улсын Их Хурлын гишүүн Н.Содномдорж (өвөртэй нь зөвшилцсөнөөр);
	-Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан;
	-Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг;
	-Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа;
	-Байгаль орчны сайд У.Барсболд;
	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд;
	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Б.Эрдэнэсүрэн;
	-Гадаад хэргийн дэд сайд С.Батболд;
	-Дэд бүтцийн дэд сайд У.Уламбаяр;
	-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд С.Чинзориг;
	-Хууль зүй,дотоод хэргийн дэд сайд Ц.Мөнх-Оргил;
	-Хүнс,хөдөө аж ахуйн дэд сайд Д.Тэрбишдагва;
	-Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Р.Рааш;
	-"МИАТ" компанийн ерөнхий захирал Ж.Баярсайхан;
	-"Эрдэнэт" хамтарсан үйлдвэрийн ерөнхий захирал Х.Наранхүү;
	-"М СИ Эс Холдинг"-ийн ерөнхий захирал Ж.Оджаргал (өвөртэй нь зөвшилцсөнөөр);
	-Монголын үндэсний олимпийн хорооны ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Д.Загдсүрэн (өвөртэй нь зөвшилцсөнөөр).
Нарийн бичгийн дарга	-Биеийн тамир, спортын үндэсний төвийн дарга Г.Пүрэв-Очир.

Засгийн газрын 2001 оны 187 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Засгийн газраас олгох мөнгөн шагналын зорилго нь Олимп, дэлхийн аварга, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчдыг урамшуулж, спортын амжилт үзүүлэх нөхцөлийг нь бүрдүүлэхэд оршино.

2. Олимп, дэлхийн аварга, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарсан тамирчин, дасгалжуулсан бүрэлдэхүүнийг шагнахад энэ журмыг баримтална.

3. Засгийн газраас олгох мөнгөн шагналыг зөвхөн сонирхогчдын тэмцээнд олгоно.

4. Олимп, дэлхийн аварга, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчид, спортын холбоо, клубүүдийн хоорондох нотариатаар баталгаажуулсан гэрээг тухайн тэмцээн эхлэхээс 3 сараас доошгүй хугацааны өмнө Биеийн тамир, спортын үндэсний төвд ирүүлэх бөгөөд уг гэрээнд журамд заасан шагналыг хуваарилах талаар тусгасан байна.

5. Шагнуулах тодорхойлолтыг тухайн тэмцээн дуусан өдрөөс хойш нэг сарын дотор Биеийн тамир, спортын үндэсний төвд ирүүлэх бөгөөд тус төв олимп, дэлхийн аварга, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагч, спортын холбоод, клубүүдийн хамтын ажиллагааны гэрээ, тэмцээнд оролцуулах зөвшөөрөл, сургалт дасгалжуулалтын төлөвлөгөө, тэмцээний албан ёсны протокол зэргийг шалган шагнал олгуулахаар биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд өргөн барина.

6. Тэмцээнд тухайн спортын төрлийн зай, оролдлого, жинд 10-аас доош орны тамирчид оролцсон тохиолдолд олгох мөнгөн шагналын хэмжээг 50 хүртэл хувиар багасгаж болно.

7. Олимпийн наадмын төрлөөр дэлхийн аваргын тэмцээн 3-4 жил тутамд болдог бол 3 дугаар хавсралтын ёсоор, 2 жил тутам болдог бол 3 дугаар хавсралтад заасны 80 хувиар, жил тутам болдог бол 60 хувиар тус тус бодож шагнал олгоно.

8. Цувралаар зохиогддог тэмцээний шагналыг тухайн тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтаар жилд нэг удаа олгоно.

9. Дэлхийн цомын тэмцээнийг тивийн наадамтай; дэлхийн залуучуудын аварга, Пара олимп, дэлхийн дүлий иргэдийн спортын тоглолт, Универсиад, оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг олимпийн наадамд оролцдоггүй спортын төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнтэй тус тус адилтган үзнэ.

10. Тивийн залуучуудын аварга, Дэлхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээний медальт байрны шагналыг тивийн аваргын шагналын 50 хувьтай, тивийн өсвөр үеийн аваргыг тивийн аваргын шагналын 25 хувьтай тэнцэх хэмжээгээр тогтооно.

11. Оюуны спорт-шатар, зуун буудалт даамын төрлөөр өндөр амжилт үзүүлэн олон улсын их мастер (гроссмейстер)-ын норм биелүүлвэл шагналыг тивийн наадмын алтан медальтай адилтган нэг удаа олгоно.

12. Тэмцээн зохион байгуулагчид, улсын төсвөөс зардлыг нь дааж буй тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй бөгөөд тухайн тэмцээнээс мөнгөн шагнал олгосон тохиолдолд шагналыг давхардуулан олгохгүй, зөвхөн зөрүүг олгоно.

13. Олимп, дэлхийн аварга, дэлхийн цом, тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд багийн тоглоотоор медальт байранд шалгарвал багийн гишүүн тус бүрт мөнгөн шагналын тавин хувьтай тэнцэх шагналыг олгоно.

Засгийн газрын 2001 оны 187 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ОЛИМП, ДЭЛХИЙН АВАРГА, ТИВИЙН НААДАМ, ТИВИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АМЖИЛТ ГАРГАСАН ТАМИРЧИНД ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

№	Тэмцээний нэр	Медаль	Мөнгөн шагнал (сая төгрөг)
	1. Олимпийн наадмын төрөл		
1.	Олимпийн наадам	Алт	100.0
		Мөнгө	40.0
		Хүрэл	20.0
2.	Дэлхийн аварга	Алт	50.0
		Мөнгө	20.0
		Хүрэл	10.0
3.	Тивийн наадам	Алт	20.0
		Мөнгө	8.0
		Хүрэл	3.0
4.	Тивийн аварга	Алт	8.0
		Мөнгө	4.0
		Хүрэл	2.0
	2. Олимпийн наадамд оролцдоггүй спортын төрөл		
1.	Дэлхийн аварга	Алт	10.0
		Мөнгө	4.0
		Хүрэл	2.0
2.	Тивийн наадам, аварга	Алт	5.0
		Мөнгө	2.0
		Хүрэл	1.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 8 дугаар сарын 29-ний өдөр **Дугаар 188** **Улаанбаатар хот**

Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дарга Цэдэвийн Буянбадрахад Гадаадын иргэн, харьяатын бүртгэл, зөвшөөрлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 9-ны өдөр **Дугаар 189** **Улаанбаатар хот**

Ерөнхий консулын газрыг татан буулгах тухай

Монгол Улсын Их Хурлаас Канад Улсын Оттава хотод Эгчин сайдын яам нээн ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Канад Улсын Торонто хот дахь Монгол Улсын Ерөнхий консулын газрыг татан буулгасугай.

2. Ерөнхий консулын газрын орон тоог Оттава дахь Элчин сайдын яаманд шилжүүлэн зохицуулахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр **Дугаар 190** **Улаанбаатар хот**

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Канад Улсын Торонто хот дахь Монгол Улсын Ерөнхий консулын газрыг татан буулгасантай холбогдуулан Далхжавын Сандагийн гадаадад ажиллах томилолтын хугацааг дуусгавар болгон Монгол Улсаас Канад Улсын Торонто хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр **Дугаар 191** **Улаанбаатар хот**

Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний барилгын цэргийн удирдах газрын харьяа хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хавсралтад заасан зарим орон сууцыг оршин суугч офицер, ахлагч, тухайн салбарын ажилчин, албан хаагч, цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд, тэдний гэр бүлийнхэнд хувьчлахаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан орон сууцны хувьчлалын ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /Л.Пүрэвдорж/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

Засгийн газрын 2001 оны 191 дүгээр тогтоолын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ БОЛОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГЫН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЧЛАГДАХ ОРОН СУУЦ

№	Орон сууцны					Үүнээс	Сууцны харьяалал
	Эзэмшигч байгууллагын нэр	Барилгын нэр	Барилгын байршил	Ашиглалтад орсон он	Сууцны тоо	Хувьчлагдах	
1	Зэвсэгт хүчний орон сууц ашиглалтын 13 дугаар анги	Үгсармал орон сууц №74	Нийслэлийн Баянзүрх дүүрэг 16 дугаар хороолол	1998	58	11	Батлан хамгаалах яам, "Сар хайрхан-Уул" ХХК
2	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 022 дугаар анги	14 айлын сууц №3	Сонгино-хайрхан дүүрэг 5-р хороо	1983	14	14	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
3	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 022 дугаар анги	4 айлын сууц №5	Сонгино-хайрхан дүүрэг 5-р хороо	1963	4	4	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
4	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 073 дугаар анги	8 айлын сууц №3	Хан-Уул дүүрэг 3-р хороо	1988	8	8	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
5	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 073 дугаар анги	4 айлын сууц №1	Хан-Уул дүүрэг 3-р хороо	1982	4	4	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
6	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 073 дугаар анги	4 айлын сууц №2	Хан-Уул дүүрэг 3-р хороо	1982	4	4	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
7	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 110 дугаар анги	8 айлын орон сууц үгсармал /ОЩА/ №10	Орхон аймгийн Баян-Өндөр сум Говил баг	1981	8	8	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
8	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 110 дугаар анги	8 айлын орон сууц үгсармал /ОЩА/ №11	Орхон аймгийн Баян-Өндөр сум Говил баг	1981	8	8	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар
9	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 110 дугаар анги	8 айлын орон сууц үгсармал /ОЩА/ №12	Орхон аймгийн Баян-Өндөр сум Говил баг	1981	8	8	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр | **Дугаар 192** | **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тооцож гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

БНЭУ-ын Мэдээлэл, технологийн болон Парламентын асуудал эрхэлсэн сайд П.Махажан тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийх айлчлалын зардалд зориулан 4,120 (дөрвөн сая нэг зуун хорин мянга) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгийн зарцуулагдаагүй хэмнэлтээс

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр | **Дугаар 193** | **Улаанбаатар хот**

Олон улсын театрын анхдугаар наадам, симпозиум зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Орчин үеийн театрын шинэ урсгал Монголд" сэдэвт Олон улсын театрын анхдугаар наадам болон симпозиум, семинар сургалтыг 2001 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Олон улсын театрын анхдугаар наадмын арга хэмжээнд зориулж 8780 /найман мянга долоон зуун наян/ ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ,ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр | **Дугаар 198** | **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Испанийн Уэска хотод зохиогддог Олон улсын төгөлдөр хуурчдын Ш уралдаанд оролцож I, П байр эзэлсэн Хөгжим бүжгийн коллежийн төгөлдөр хуурын 8 дугаар ангийн сурагч Батсүхийн Баярт, Бадрахын Номингуа нарт тус бүр 500,0 (таван зуун мянган) төгрөгийг олгосугай.

2. Мөнгөн шагналд шалгарсан 1,0 (нэг) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (228)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай*
- *Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Журам батлах тухай*
- *Монголын хэсгийн даргыг томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны аравдугаар сарын 22 №41 (228)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

485. Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай — Дугаар 63 — 965

486. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай — Дугаар 64 — 966

487. Ө.Рэнцэнпэлжидийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай — Дугаар 65 — 966

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

488. Журам батлах тухай — Дугаар 200 — 966

489. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай — Дугаар 201 — 967

490. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай — Дугаар 202 — 968

491. Монголын хэсгийн даргыг томилох тухай — Дугаар 203 — 968

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

:001 оны 10 дугаар :арын 12-ны өдөр — Дугаар 63 — Улаанбаатар хот

Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 :гээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4, 5 дахь аалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн аналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Нямсүрэнгийн эрэлсүрэнг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн үүгчийн, Жамъянгийн Энхтайванг Өвөрхангай ймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, өр ажил, албан тушаалд томилогдох болсон ашнямын Цогтсайханы Дорноговь аймгийн үүхийн шүүгчийн, Цэнд-Аюушийн Батхүүг Завхан ймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, өнхий шүүгчийн, тэгтэвэрт гарах насанд хүрсэн л Ламжавын Цэдэндамбаг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Долгорсүрэнгийн Энхээг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн, Пүрэвдоржийн Нэргүйг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай Шүүгчийн мэргэшлийн хорооноос гаргасан дүгнэлтийг үндэслэн Рагчаагийн Сүрэнжавыг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан Дашдэлгэрийн Улааныг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"- ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дашнямын Цогтсайханы Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Зүндүйн Хосбаярыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Цэнд-Аюушийн Батхүүг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн, Лхагвадоржийн Энхбилэгийг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн, Лувсанцэрэнгийн Энхтунгалагийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Дашнямын Цогтсайханы Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

Ө.Рэнцэнпэлжидийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг удаа дараа зөрчсөн Өлзийсүрэнгийн Рэнцэнпэлжидийг Говь- Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 200 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 14.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Аялал жуулчлалын санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 200 дугаар тогтоолын хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аялал жуулчлалын сан (цаашид "сан" гэх)-г бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Аялал жуулчлалын тухай хуулийн 19.2-т заасны дагуу сан нь төвлөрсөн төсвийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүний гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцаат Төсвийн тухай хуулиар зохицуулна.

3. Сангийн хөрөнгийг Аялал жуулчлалын тухай хуулийн 21.1-д заасны дагуу дэд бүтцийг хөгжүүлэх, монгол орныг гадаад, дотоодод сурталчлах, жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, байгаль, түүх, соёлын өвийг дэмжих, хамгаалахад зарцуулна.

4. Сангийн хөрөнгийг улсын төвлөрсөн төсвийн тусгай дансанд байршуулна.

Хоёр. Сангийн удирдлага

5. Сангийн захирал бөгөөд төвлөрүүлэн захирагч нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

Аялал жуулчлалын газрын дарга байна.

6. Сангийн захирал сангийн асуудлаар дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

а/сангийн хөрөнгийг хуваарилан зарцуулах;

б/сангийн хөрөнгийг энэ журамд заасны дагуу бүрдүүлэх үйл ажиллагаат эрхэлж, арвижуулах, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх;

в/хууль тогтоомжид заасны дагуу сангийн санхүүгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусгуулах арга хэмжээ авах;

г/сангийн гүйцэтгэлийг зохион байгуулж Засгийн газрын өмнө хариуцах;

д/сангаас санхүүжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг тооцох, шаардлагатай бол санхүүжилтийг зогсоох;

е/ сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

Гурав. Санг бүрдүүлэх, зарцуулах

7. Аялал жуулчлалын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/тухайн жилд улсын төвлөрсөн төсөөс хуваарилсан хөрөнгө;

б/гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив;

в/хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

8. Сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

а/монгол орны байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний соёл, хүн ардын зан заншил, түүхийг сурталчилсан кино, дүрс болон дууны бичлэг хийх, ном, ил захидал танилцуулга цомог хэвлэх, мэргэжлийн сонин, сэтгүүл гаргах, улсын болон олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн, дотоод, гадаадын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;

б/аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

в/аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг санхүүжүүлэх;

г/байгаль, түүх, соёлын өвийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах.

9. Аялал жуулчлалын газрын дарга нь тухайн жилд сангийн хөрөнгөөр хэрэжүүлэх арга хэмжээ, зардлын төсвийн төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагын саналыг үндэсэн боловсруулж аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулна.

10. Энэ журмын 10-т заасны дагуу батлуулсан төсвийн төслийг Аялал жуулчлалын газрын дарга жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

11. Сангийн хөрөнгөөр хийх ажлын гүйцэтгэчийг шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэч сонгох журмын тухай хууль заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

12. Сангийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа онд шилжүүлэн зарцуулна.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих

13. Аялал жуулчлалын газрын дарга Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу сангийн гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

14. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

15. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих мэргэжлийн хяналтыг санхүүгийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Тав. Бусад зүйл

16. Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зээлээр ашиглуулах, хууль болон энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

17. Энэ журамд заасныг зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр **Дугаар 201** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Говь” хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан

"Уралдаант шалгаруулалт (тендер)-ын зар мэдээ"-ний "Урьдчилан шалгаруулах шалгуур" гэсэн хэсгийн "4. 100 хувь хувийн өмчийн эзэгтэй байх" гэсний дараа "эсвэл Засгийн газраас олгосон хөрөнгийн эх үүсвэрийг хязгаарлагдмал байдлаар ашиглаж байгаа болон төрийн өмчийн оролцоо нь 10 хувиас илүүгүй аж ахуйн нэгжийг уралдаант шалгаруулалт (тендер)-д оролцуулах асуудлыг Төрийн өмчийн хороо тухай бүр нэгбүрчлэн авч үзэж шийдвэрлэнэ." гэж, мөн "Уралдаант шалгаруулалтын журам"-ын 4.1 дэх хэсэгт "4.1.5 Засгийн газраас олгосон хөрөнгийн эх үүсвэрийг хязгаарлагдмал байдлаар ашиглаж байгаа болон төрийн өмчийн оролцоо нь 10 хувиас илүүгүй аж ахуйн нэгжийг уралдаант шалгаруулалт (тендер)-д оролцуулах асуудлыг Төрийн өмчийн хороо тухай бүр нэгбүрчлэн авч үзэж шийдвэрлэнэ." гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр **Дугаар 202** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Ядуурлыг бууруулж, өсөлтийг хангах хөтөлбөрийн урьдчилсан арга хэмжээний хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дансны тогтолцоог журамлах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын 3 дахь заалтаас "...болон валютын тус бүр..." гэснийг хассугай.

2. Өөрийн байгууллагын валютын дансыг 2001 оны 9 дүгээр сарын 15-ны дотор хаалгах арга хэмжээ авахыг төсвийн эрх захирагч нарт даалгасугай.

3. Хариуцсан асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын судалгааг гарган, тэдгээр сангуудын 2001 оны эхний хагас жилийн тайлангийн хамт 2001 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Санхүү, эдийн засгийн яаманд ирүүлж цаашид улирал бүр тус яаманд тайлагнаж байхыг Сайд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр **Дугаар 203** **Улаанбаатар хот**

Монголын хэсгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Равдангийн Хатанбаатарыг Монгол Улс, БНХАУ-ын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн дарга, Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайдаар томилсугай.

2. Монгол Улс, БНХАУ-ын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн баримтлах удирдамжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын хэсгийн дарга, Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Р.Хатанбаатарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эрхлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487





ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 42 (229)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх тухай*
- *"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны аравдугаар сарын 31 №42 (229)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

492. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2001-10-18-ны хууль) 970

493. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан түүхэмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх тухай (2001-10-18-ны хууль) 970

494. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2001-10-18-ны хууль) 970

495. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2001-10-18-ны хууль) 970

496. Гаалийн албан татвараас чөлөөх тухай (2001-10-18-ны хууль) 971

497. Зарим төрлийн үйлчилгээ, барааны тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон гаалийн тарифын тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-10-18-ны хууль) 972

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

498. Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Дугаар 70 972

499. 2000 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Дугаар 71 972

500. Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Дугаар 72 974

501. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэх тухай Дугаар 73 974

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

502. Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 68 975

503. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 69 975

504. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 71 975

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

505. Хөрөнгийн эх үүсвэрийг зохицуулах тухай Дугаар 204 976

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Улаанбаатар хот

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Мянганы зам" төслийн хүрээнд авто замын салбарын техникийн шинэчлэл хийх зориулалтаар импортлох автогрейдер, замын индүү, бульдозер, ачигч, экскаватор, автосамосвал, асфальт дэвсэгч, чулуу бутлуур, асфальт завод, усны машин, битум зөөгч зэрэг зам барилгын технологийн машин, механизмыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан, улсын хилээр нэвтрүүлэх машин, тоног төхөөрөмжийн зориулалт, тоо хэмжээний жагсаалтыг Бараа тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангиллаар Засгийн газар батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Улаанбаатар хот

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Мянганы зам" төслийн хүрээнд ашиглах хайрга, чулуу, элс, шороо зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалыг түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Улаанбаатар хот

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Мянганы зам" төслийн хүрээнд авто замын салбарын техникийн шинэчлэл хийх зориулалтаар импортлох автогрейдер, замын индүү, бульдозер, ачигч, экскаватор, автосамосвал, асфальт дэвсэгч, чулуу бутлуур, асфальт завод, усны машин, битум зөөгч зэрэг зам барилгын технологийн машин, механизмыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан, улсын хилээр нэвтрүүлэх машин, тоног төхөөрөмжийн зориулалт, тоо хэмжээний жагсаалтыг Бараа тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангиллаар Засгийн газар батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын иргэний паспортыг Монгол Улсын иргэний үнэмлэхээр солихоор Англи Улсын "Де Ла Ру" компаниас 1999 онд хүлээн авсан иргэний үнэмлэх хэвлэх материал, хэвлэлийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. БНМАУ-ын иргэний паспортыг Монгол Улсын иргэний үнэмлэхээр солих үйлчилгээнд хэрэглэх зориулгоор Англи Улсын "Де Ла Ру" компаниас оруулж ирсэн болон ирэх дор дурдсан тоо, хэмжээ бүхий иргэний үнэмлэх хэвлэх материал, хэвлэлийн тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгслийг 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	-Үнэмлэхний гялгар хавтас -Үнэмлэх наагч гялгар цаас	60 м боодол 60 м боодол	3000 2000
2.	Хаягийн шошго: -шошгоны цаас -шошгоны хамгаалагч -шошго лацдах бахь	 ш ш ш	 300000 300000 395
3.	Лазерийн өнгөт принтерийн бул	ш	222
4.	Сервер компьютер	ш	1
5.	Лазерийн өнгөт принтерийн хор /хар/	ш	22
6.	Лазерийн өнгөт принтерийн хор /өнгөт/	ш	46
7.	Сканнерийн дүрсний ламп	ш	15
8.	Хүчдэл хуримтлуулагч	ш	4
9.	Deskey /принтерийн эд анги/	ш	3
10.	"Tektronix" лазерийн өнгөт принтер	ш	4
11.	Компьютерийн гар	ш	20
12.	Ламинатор	ш	5
13.	Компьютерийн тэжээлийн блок	ш	8
14.	Компьютерийн майнборд	ш	8

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын иргэний паспортыг Монгол Улсын иргэний үнэмлэхээр солих үйлчилгээнд хэрэглэх зорилгоор Англи Улсын /Де Ла Ру/ компаниас оруулж ирсэн болон ирэх дор дурдсан тоо, хэмжээ бүхий иргэний үнэмлэх хэвлэх материал, хэвлэлийн тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгслийг 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлсүгэй:

№	Барааны нэр	Барааны код	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	-Үнэмлэхний гялгар хавтас -Үнэмлэх наагч гялгар цаас	3920.69.00 3920.69.00	60 м боодол 60 м боодол	3000 2000
2.	Хаягийн шошго: -шошгоны цаас -шошгоны хамгаалагч -шошго лацдах бахь	 4821.10.00 3919.10.00 8203.20.00	 ш ш ш	 300000 300000 395
3.	Лазерийн өнгөт принтерийн бул	8473.30.00	ш	222
4.	Сервер компьютер	8471.49.00	ш	1
5.	Лазерийн өнгөт принтерийн хор /хар/	8473.30.00	ш	22
6.	Лазерийн өнгөт принтерийн хор /өнгөт/	8473.30.00	ш	46
7.	Сканнерийн дүрсний ламп	8473.30.00	ш	15
8.	Хүчдэл хуримтлуулагч	8504.31.00	ш	4

9.	Deskey /принтерийн эд анги/	8473.30.00	ш	3
10.	"Tektronix" лазерийн өнгөт принтер	8471.60.00	ш	4
11.	Компьютерийн гар	8471.60.00	ш	20
12.	Ламинатор	8439.30.00	ш	5
13.	Компьютерийн тэжээлийн блок	8471.80.00	ш	8
14.	Компьютерийн майнборд	8473.30.00	ш	8

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Улаанбаатар хот

ЗАРИМ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, БАРААНД ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХАМААРУУЛАХГҮЙ БАЙХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Зарим төрлийн үйлчилгээ, бараанд Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд болон Гаалийн тарифын тухай хуулийн зарим заалтыг хамаарууллахгүй байх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "2001 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл" гэснийг "2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 70 — Улаанбаатар хот

Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн орлогыг 301.007.110.7 мянган төгрөгөөр, зарлагыг 372.532.668.2 мянган төгрөгөөр батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр — Дугаар 71 — Улаанбаатар хот

2000 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2000 оны сонгуулийн дараа байгуулагдсан Засгийн газар улсын урсгал төсөв алдагдалтай байсныг ашиглаж болгон, олон сараар олгоогүй цалин, тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтийг шийдвэрлэж, олон улсын банк, санхүүгийн байгууллагатай тогтоосон харилцаат

сэргээж, дотоод, гадаад нөхцөлийг хэвийн болгох талаар тодорхой үр дүнтэй ажилласныг Улсын Их Хурлаас онцлон тэмдэглэж байна.

Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн биелэлтийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцсэн байдлаас үзэхэд төрөөс тухайн жилд явуулах нийгэм, эдийн засаг, санхүүгийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх бодит арга хэмжээг төлөвлөх үндсэн гол хэлбэр болсон улсын төсвийн боловсруулалт, түүний биелэлтийг хангах үйл ажиллагааны ихээхэн дутагдал оршиж байна.

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төвлөрсөн төсвийг боловсруулах ажлын уялдаа, төсвийн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах хариуцлага, сахилга бат суларснаас төсвийн зарлагыг хэтрүүлэх, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах явдал гарч байна. Энэ нь төрөөс баримтлах эдийн засаг, санхүүгийн бодлогын хэрэгжилтийг сулруулж, үр дүнг бууруулахад хүргэж байна.

Төсвийн хуулийн биелэлтэд тавих байнгын хяналтгүй, хууль зөрчсөнөөс учирсан хохирлыг төлүүлэх хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байгаа нь дээр заасан дутагдлууд бодитойгоор орших үндэс болж байна гэж Улсын Их Хурал үзэж байна.

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлд өгсөн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэг, Төрийн хяналт шалгах хорооны дүгнэлт, УИХ-ын чуулганы хуралдаан дээр УИХ-ын гишүүдээс гаргасан саналыг нэг бүрчлэн судлан дүгнэлт хийж дараахь ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

1/Төвлөрсөн болон орон нутгийн төсөв зохиох ажлыг бүх шатанд сайжруулж төсвийн орлого тооцох нэгдсэн аргачлалыг шинэчлэн орлогыг бүрэн дайчилж төлөвлөх, зарлага, санхүүжилтийн норм норматив боловсронгуй болгох, зарлагыг оновчтой арга хэмжээнд зарцуулан үр ашгийг нь дээшлүүлэх, улсын нийтлэг үйлчилгээ, батлан хамгаалах арга хэмжээ, нийгмийн үйлчилгээний салбарын зардлыг хорогдуулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг 2002 онд багтаан авч хэрэгжүүлэх;

2/Бүх түвшинд санхүүгийн шинжилгээний үүргийг өндөржүүлж, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвийн байгууллагуудад хийх хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр барагдуулах, хяналтын байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх, тэдний ажлын уялдаа сайжруулан Төсвийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих нэгдсэн тогтолцоог бүрэлдүүлэх арга хэмжээг 2002 оны I улиралд багтаан зохион байгуулах;

3/2000 оноос эхлэн төсвийн хууль биелүүлээгүй, төсөв хэтрүүлэн зарцуулсан, өр авлага үүсгэсэн, төсвийн эрх захирагч болон татварын орлогыг тасалдуулсан, өмч хөрөнгийг хууль бусаар зарцуулсан хүмүүст хуулийн дагуу хариуцлага тооцож, дүнг жил бүр Улсын Их Хурлын хаврын чуулганд илтгэж байх;

4/Төсөв, санхүүгийн байгууллагад олон улсын жишигт нийцсэн бүртгэл нэвтрүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн үзлэг шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, дүнг 2002 оны II улиралд илтгэх;

5/Төвлөрсөн төсвийн улирлын гүйцэтгэлийг дараа улирлын 2 дахь сард багтааж Улсын Их Хуралд, орон нутгийн төсвийн улирлын гүйцэтгэлийг дараа улирлын эхний сард багтаан орон нутгийн ирэгдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан, төсвийн хуулийн хэрэгжилтийг дүгнэж холбогдох арга хэмжээг авч байх:

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 72** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Санжбэгзийн Төмөр-Очирыг сонгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 73** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 10 жилийн ойг Монгол Улсын Үндсэн хууль батална өдөр буюу 2002 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр орон даяар тэмдэглэхээр тогтоосугай.

2.Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах комиссыг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

3.Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг комисс /Ж.Бямбадорж/-т даалгасугай.

4.Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

УИХ-ын 2001 оны 73 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 10 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: -Монгол Улсын Их Хурлын дэд дарга **Ж.БЯМБАДОРЖ**

Комиссын нарийн бичгийн дарга: -УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Д.БАТБААТАР**

Гишүүд: -/ИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга **Д.ДЭМБЭРЭЛ**

-УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга **Д.ЛУНДЭЭЖАНЦАН**

-УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга **Т.ОЧИРХҮҮ**

-УИХ-ын гишүүн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга **Ө.ЭНХТҮВШИН**

-Улсын Их Хурлын гишүүн **С.ТӨМӨР**-Улсын Их Хурлын гишүүн **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

-Үндсэн хуулийн цэцийн дарга **Н.ЖАНЦАН**

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч **М.ЭНХБОЛД**

-Санхүү, эдийн засгийн дэд сайд **Л.ЭНХТАЙВАН**

-Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга **Б.ГАНБОЛД**

-УИХ-ын Тамгын газрын нарийн бичгийн дарга **П.БЯМБАЦЭРЭН**

-Улсын Их Хурлын зөвлөх **Б.ЧИМИД**

-Үндсэн хуулийн цэцийн дарга асан **Г.СОВД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 19-ний өдөр — Дугаар 68 — Улаанбаатар хот

Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр ажил албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Баавалын Баатарыг Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Доржийн Тайванхүүг Булган аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Ёндонгийн Бямбацэрэнг Ховд аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Гомбын Лхагвамаагаг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Лхагвын Энхтайванг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Бодьгэрэлийн Бямбасүрэнг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Дашзэвэгийн Улааныг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Цэрэндоржийн Баасанжавыг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 19-ний өдөр — Дугаар 69 — Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Гомбын Лхагвамаагаг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Доржийн Тайванхүүг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Ёндонгийн Бямбацэрэнг Булган аймгийн шүүхийн шүүгчийн, Лхагвын Энхтайванг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн, Бодьгэрэлийн Бямбасүрэн, Дашзэвэгийн Улаан нарыг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн, Баавалын Баатарыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн, Далантайн Нарантуяаг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Шарын Оюунгэрэлийг Сухбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Ламжавын Соёлмаагаг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Чантуугийн Элдэв-Очирыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цэрэндоржийн Баасанжавыг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Гомбын Лхагвамаагаг Говьсүмбэр аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Доржийн Тайванхүүг Ховд аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Ёндонгийн Бямбацэрэнг Булган аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Баавалын Баатарыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Ламжавын Эхлэлтийг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн, Цэрэндоржийн Баасанжавыг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 22-ны өдөр — Дугаар 71 — Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин уравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн , Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар үйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох ь:

1. Монгол Улсаас Бельгийн Вант Улсад уугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бельгийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содовын Ононг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 204 | Улаанбаатар хот

Хөрөнгийн эх үүсвэрийг зохицуулах тухай

Цаг үеийн шаардлагыг харгалзан Засгийн газрын нөөц сангаас хөрөнгийг нь гаргаж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн дараахь төсөл, арга хэмжээний зардлын эх үүсвэрийг дор дурдсан байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэзд Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын чанартай дараахь ажил хэмжээг 2001 оны хөрөнгө оруулалтын зардлын хүрцээтгэлд оруулж тооцохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй:

а/Увс аймгийн Цагаанхайрхан сумын дүнд сургуулийн шатсан барилгыг сэргээн засварлахад гарах зардал 105 (нэг зуун тав) сая төгрөг (Ерөнхий сайдын 2001 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар захирамж);

б/Ховд аймгийн Жаргалант сумын дүүлааны станцын технологийг шинэчлэхэд шаардагдах 43.2 (дөчин гуран сая хоёр зуун мянга) сая төгрөг (Ерөнхий сайдын 2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 55 дугаар захирамж);

в/зудын улмаас мал өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Архангай, Завхан, Өмнөговь аймагт улсын нөөцөөс олгосон автомашин, дизель станцыг нехен бүрдүүлэхэд шаардагдах зардал 36.8 (гучин зургаан сая найман зуун мянга) сая төгрөг (Ерөнхий сайдын 2001 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 45 дугаар захирамж).

2. Хүний дархлал, хомсдолын вирусын халдвар, ДОХ, БЗХӨ-ний оношлогоо, эм, багаж төхөөрөмж авахад шаардагдах зардал 77.3 (далан долоон сая гурван зуун мянга) сая төгрөгийг (Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 167 дугаар тогтоол) 2001 онд батлагдсан Эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын хэмнэлтээс гаргахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдавваад даалгасугай.

3. Ойн санг хамгаалж, хөнөөлт хортон шавьжтай тэмцэх ажилд зориулан олгох санхүүжилтийн үлдэгдэл 30.0 (гуч) сая төгрөгийг (Ерөнхий сайдын 2001 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 91 дүгээр захирамж) 2001 онд дээрх зориулалтаар батлагдсан хөрөнгийн дүнд багтаан санхүүжүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

4. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан зардлын зөрүү болон устгасан малын нехен олговорт зориулсан зардлаас олгогдоогүй байгаа 194.1 (нэг зуун ерэн дөрвөн сая нэг зуун мянга) сая төгрөгийг энэ зориулалтаар гадаад, дотоодын байгууллага, иргэдээс олгосон хандив, тусламжийн хөрөнгөөс гаргахыг Улсын Байнын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (230)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Харилцаа холбооны тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *ОХУ-ын зарим иргэнийг шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арваннэгдүгээр сарын 7 №43 (230)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

506. Харилцаа холбооны тухай (2001-10-18-ны хууль) 978
507. Гэрээ соёрхон батлах тухай (2001-10-26-ны хууль) 985
508. Ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай (2001-10-26-ны хууль) 985
509. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын консулын конвенцийн тухай (2001-10-26-ны хууль) 986

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

510. Журам батлах тухай Дугаар 74 986
511. Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 75 987
512. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 76 987
513. Улсын Их Хурлын 1998 оны 59 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 77 987

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

514. ОХУ-ын зарим иргэнийг шагнах тухай Дугаар 72 988
515. Шүүгч, ерөнхий шүүгчийг чөлөөлөх, томилох тухай Дугаар 73 988

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

516. Хөрөнгө гаргах тухай Дугаар 141 988
517. Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 157 989
518. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах тухай Дугаар 194 991
519. Журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 195 995
520. "Цэвэр орчин" аяны дүнгийн тухай Дугаар 205 996
521. Төсөл дэмжих тухай Дугаар 206 997
522. Хөрөнгө гаргах тухай Дугаар 207 997
523. Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай Дугаар 209 997
524. Ажлаас чөлөөлөх тухай Дугаар 210 998
525. Зөвлөлдөх хороо байгуулах тухай Дугаар 211 998
526. Ажилд томилох тухай Дугаар 213 1000

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хууль тогтоомж

2.1.Харилцаа холбооны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."шугам" гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, орон зай зэрэг/, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, суваглал, багана, цамхаг болон бусад зүйлсийн цогцолборыг;

3.1.2."сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэх холбооны шугам, түүнчлэн шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулалттай техник хэрэгслийн иж бүрдлийг;

3.1.3."ашиглалт" гэж харилцаа холбооны сүлжээний тогтвортой ажиллагаог хангахад чиглэсэн засвар, хэмжилт, тохируулга хийх үйл ажиллагааг;

3.1.4."үйлчилгээ" гэж харилцаа холбооны сүлжээг ашиглан хэрэглэгчийн холбоо мэдээллийн хэрэгцээг хангах үйл ажиллагааг;

3.1.5. "үйлчлэгч" гэж харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдийг;

3.1.6. "хэрэглэгч" гэж харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх гэрээнд үйлчилгээг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг;

3.1.7. "зааглах цэг" гэж үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг;

3.1.8."шуудангийн илгээмж" гэж шуудангийн байгууллагын өдрийн тэмдгийн дардсаар баталгаажсан бичиг захидал, илгээлт, шуудангаар илгээж байгаа бусад зүйлийг;

3.1.9. "шуудангийн хаяг" гэж хэрэглэгчийн оршин суугаа газрын /аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хот, тосгон, гудамж, талбайн нэр болон барилга, орон сууц, хашааны дугаарыг багтаасан/ байршлын нэр, үйлчлэгчийн дугаарыг агуулсан мэдээллийг;

3.1.10."шуудангийн үнэт цаас" гэж шуудангийн марк, захидлын маркжуулсан дугтуй, ил захидлын маркжуулсан хуудсыг;

3.1.11."бүх нийтийн үйлчилгээний үүрэг" гэж төрийн бодлогын хүрээнд цахилгаан холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг аслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэхийг;

3.1.12."бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан" гэж бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэхээр төвлөрүүлсэн хөрөнгийг;

3.1.13."харилцаа холбоо" гэж цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийг;

3.1.14."цахилгаан холбооны үйлчилгээ" гэж цахилгаан холбооны сүлжээг ашиглан бүх төрлийн мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг;

3.1.15. "дуудаврлалтын нэгдсэн төлөвлөгөө" гэж улс, хот хооронд, орон нутгийн сүлжээ болон үйлчлэгчийг ялгаж таних, дуудлагын чиглэлийг тодорхойлох тоон илэрхийллийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Харилцаа холбооны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1.Улсын Их Хурал харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлно.

5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

5.1.Засгийн газар харилцаа холбооны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.харилцаа холбооны талаар баримтлах төрийн бодлого хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

5.1.2.Харилцаа холбооны зохицуулах хороо байгуулах, түүний дүрмийг батлах;

5.1.3.бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам батлах.

6 дугаар зүйл. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

6.1. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.харилцаа холбооны тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.1.2.харилцаа холбооны талаар баримтлах бодлого боловсруулах;

6.1.3.харилцаа холбооны зах зээлд өрсөлдөөн бий болгох бодлого боловсруулах;

6.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах;

6.1.5.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө батлах;

6.1.6.бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаархи бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

6.1.7.шуудангийн үнэт цаасыг үйлдэрлэх бодлого боловсруулах, улсын фонд байгуулах, хяналт тавих;

6.1.8.харилцаа холбооны үйлчилгээг найдвартай, шуурхай, чанартай байлгах, захидал харилцааны нууцын хамгаалалтанд хяналт тавих;

6.1.9.харилцаа холбооны зэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах;

6.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6.2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөхдөө эрх бүхий байгууллага нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөнө.

7 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

7.1.Бүх шатны Засаг дарга харилцаа холбооны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.нутаг дэвсгэртээ харилцаа холбооны үйлчилгээг сайжруулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

7.1.2. тухайн нутаг дэвсгэрт шуудан хүргэх хуваарийг хянаж, батлах;

7.1.3. аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, талбай, барилга, орон сууц, хашаа хаягжуулах арга хэмжээ авах;

7.1.4.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас харилцаа холбооны сүлжээнд гарсан осол, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулах;

7.1.5.радио, телевизийн болон харилцаа холбооны бусад сүлжээ байгуулж, ашиглах санаачлагыг дэмжих, туслалцаа үзүүлэх;

7.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Харилцаа холбооны зохицуулах хороо

8.1.Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ ажиллана.

8.2.Зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэнэ.

8.3.Зохицуулах хорооны дарга, гишүүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Ерөнхий сайд томилно.

8.4. Зохицуулах хорооны дарга, гишүүний

бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2,4,6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно.

8.5. Зохицуулах хорооны даргыг нэг удаа улируулан томилж болно.

8.6. Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны дарга, гишүүнээр томилно:

8.6.1.эдийн засаг, мэдээлэл холбоо, техник, хууль зүй, удирдлагын дээд боловсролтой, өндөр мэргэжил, ажлын туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай;

8.6.2. Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.

8.7.Зохицуулах хорооны дарга, гишүүд харилцаа холбооны улсын байцаагчийн эрхтэй байна.

8.8.Зохицуулах хороо нь ажлын албатай байна.

8.9.Зохицуулах хороо нь орон нутагт орон тооны бус гишүүдээс бүрдэх салбар зөвлөлтэй байж болно.

8.10.Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөс санхүүжинэ.

8.11.Зохицуулах хорооны жилийн төсвийг Засгийн газар батална. Зохицуулах хороо нь ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Засгийн газарт тайлагнана.

8.12.Зохицуулах хороо нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэлнэ.

9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

9.1.Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.харилцаа холбооны талаар төрөөс бариматлж буй бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

9.1.2.харилцаа холбооны талаар баримтлж буй бодлогын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах;

9.1.3.харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, баталгаажуулах;

9.1.4.сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах;

9.1.5.харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах;

9.1.6.харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх;

9.1.7.бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах;

9.1.8.харилцаа холбооны стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

9.1.9.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;

9.1.10.радио давтамжийн зурвасыг хуваарилах, хяналт тавих;

9.1.11.энэ хуулийн 6.1.4-д заасан журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтоох;

9.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;

9.1.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Шуудан, цахилгаан холбооны газар

10.1.Шуудан, цахилгаан холбооны газар нь улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдсэн цахилгаан холбооны төрийн өмчийн үндсэн сүлжээ эзэмшигч байх бөгөөд дараахь эрх, үүрэгтэй байна:

10.1.1.төрийн өмчийн үндсэн сүлжээний тогтвортой ажиллагааг хангах, хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх техник, технологи, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах;

10.1.2.төрийн өмчийн үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлэх, холбогдох тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

10.1.3.төрийн өмчийн үндсэн сүлжээний хөрөнгө оруулалтыг зохион байгуулах, сүлжээ ашиглалтын гэрээг үйлчлэгчтэй байгуулах;

10.1.4.бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төлөвүүлэн зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг Засгийн газрын гишүүнд тайлагнах;

10.1.5.харилцаа холбооны талаар төрөөс баримтлаж буй бодлого хэрэгжүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

10.1.6.төрийн өмчийн үндсэн сүлжээг хөгжүүлэх, төрийн захиргааны төв байгууллагыг холбогдох мэдээллээр хангах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

11 дүгээр зүйл. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

11.1.Зайлшгүй шаардлагатай цахилгаан холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэхийн тулд шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлж, зарцуулна.

11.2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

11.2.1. хандив, зээл, тусламжийн хөрөнгө;

11.2.2. бусад хөрөнгө.

11.3.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг зөвхөн энэ хуулийн 11.1-д заасан зориулалтаар зарцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Тусгай зөвшөөрөл

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

12.1.Зохицуулах хороо Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэнд тусгай зөвшөөрөл олгоно:

12.1.1.харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх;

12.1.2.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

12.1.3.шуудангийн үнэт цаас үйлдвэрлэх.

12.2.Тусгай зөвшөөрлийг 20 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

12.3.Энэ хуулийн 12.1 дэх хэсэгт зааснаас бусад харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд Зохицуулах хороонд бүртгүүлнэ.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

13.1.Иргэн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хуульд заасан баримт бичгийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

13.2.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хууль тогтоомжид зааснаас гадна дараахь бичиг баримтыг хавсаргана:

13.2.1.санхүү-эдийн засаг, техникийн чадавхи болон мэргэжлийн боловсон хүчний хангалтын талаархи тооцоо, мэдээлэл;

13.2.2.хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаархи мэдээлэл /үйлчилгээний хамрах хүрээ, байршил, технологи, үйлчилгээний тарифын санал/.

14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

14.1.Тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд дараахь зүйлийг тусгана:

14.1.1.үйлчлэх нутаг дэвсгэр, үйлчилгээний хүртээмж;

14.1.2.холбооны шугам, сүлжээний техник, тоног төхөөрөмжийн технологийн үзүүлэлт;

14.1.3. онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хүлээх үүрэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

14.1.4. харилцан холболт хийх нөхцөл;

14.1.5. Зохицуулах хороо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг;

14.1.6. бусад .

14.2.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

14.2.1.өргөдөл гаргагчийн хүссэн давтамжийн зурвас байхгүй;

14.2.2.өргөдөл гаргагч нь харилцаа холбооны сүлжээг байгуулах, ашиглах, санхүү-эдийн засаг, техникийн болон мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй;

14.2.3. нийтийн эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэж үзсэн.

14.3. Нэг нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн этгээд өргөдөл гаргасан бол сонгон шалгаруулах замаар олгоно.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

15.1.Зохицуулах хороо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

15.1.1.харилцаа холбооны хууль тогтоомжийг зөрчсөн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

15.1.2.харилцаа холбоо, захидал харилцааны нууц задруулсан;

15.1.3.тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулж эхлээгүй;

15.1.4. хууль, гэрээнд заагаагүй үйл ажиллагаа явуулсан.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос учирсан хохирлыг Зохицуулах хороо хариуцахгүй.

15.3.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ
Харилцаа холбооны сүлжээ

16 дугаар зүйл.Харилцаа холбооны сүлжээний төрөл

16.1.Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ.

16.2.Харилцаа холбооны сүлжээг зориулалтаар нь нийтийн үйлчилгээний болон дотоодын, тусгай хэрэглээний сүлжээ гэж ангилна.

17 дугаар зүйл. Цахилгаан холбооны сүлжээ

17.1.Хэрэглэгчийн хооронд аливаа тэмдэг, дохио, бичиг, дуу, дүрс зэрэг бүх төрлийн мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад зориулсан шугам, тоног төхөөрөмж, техник хэрэгслээс цахилгаан холбооны сүлжээ бүрдэнэ.

17.2.Улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдсэн, нийтийн үйлчилгээнд зориулсан сүлжээг цахилгаан холбооны үндсэн сүлжээ гэнэ. Үндсэн сүлжээ нь төрийн өмчлөлд байж болно.

17.3.Цахилгаан холбооны сүлжээ эзэмшигч нь техник, технологийн нэгдсэн удирдлагатай, тасралтгүй ажиллагаатай байхаар сүлжээг зохион байгуулна.

17.4.Үндсэн сүлжээг төр, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн байгуулж, өмчилж болно.

18 дугаар зүйл. Шуудангийн сүлжээ

18.1.Шуудангийн сүлжээ нь шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулсан тоног төхөөрөмж, техник хэрэгслээс бүрдэнэ.

18.2.Шуудангийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд гүйцэтгэнэ.

18.3.Шуудан солилцох, хүргэх ажиллагааг дор дурдсан эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан хуваарь, чиглэлийн дагуу зохион байгуулна:

18.3.1.улс хоорондын шуудан солилцох, хүргэх үйл ажиллагааг хоёр талын харилцаа холбооны эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан гэрээ;

18.3.2.аймаг, нийслэл, хотуудын хоорондох шуудан хүргэлтийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн гишүүн;

18.3.3. нийслэл, дүүрэг, аймаг, сум, баг болон хот, тосгоны доторх шуудан хүргэлтийг холбогдох Засаг дарга.

18.4.Шуудангийн байгууллага менгөн гуйвуулга, хадгаламж, даатгал, илгээмжийн худалдаа, санхүүгийн бусад үйлчилгээг өөрийн сүлжээг ашиглан зохих зөвшөөрлийн дагуу эрхэлж болно.

19 дүгээр зүйл. Радио, телевизийн сүлжээ

19.1.Радио, телевизийн сүлжээ нь радио болон телевизийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, хүлээн авах, дамжуулах тоног төхөөрөмж, техник хэрэгслээс бүрдэнэ.

19.2.Радио, телевизийн сүлжээг радио, телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллага үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.

20 дугаар зүйл. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ

20.1.Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, иргэний хамгаалалт, гэмт хэрэг, нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно.

20.2.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ төрийн хамгаалалтад байна.

20.3.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ байгуулах, ашиглах журмыг Засгийн газар тогтооно.

20.4.Тусгай хэрэглээний холбооны сүлжээнд цахилгаан холбооны суваг, тоног төхөөрөмжийг үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.

20.5.Харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах тусгай хэрэглээний холбооны мэдээллийн нууцлалт, хамгаалалтыг энэ хуулийн 20.1-д заасан байгууллага хариуцна.

21 дүгээр зүйл. Дотоодын хэрэглээний холбооны сүлжээ

21.1.Аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо ашиглах зориулалтаар дотоодын хэрэглээний холбооны сүлжээ байгуулан ажиллуулж болно.

21.2.Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дотоодын хэрэглээний холбооны сүлжээг цахилгаан холбооны сүлжээнд холбож үйлчилгээ явуулж болно.

22 дугаар зүйл. Харилцаа холбооны сүлжээнд холболт хийх

22.1.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ эзэмшигч, дотоодын хэрэглээний сүлжээ бүхий болон шинээр сүлжээ байгуулах этгээд бусдын өмчлөлийн сүлжээнд холболт хийхдээ сүлжээ хооронд зааглах цэгт тавигдах нэмэгдэл шугам, тоног төхөөрөмжийг хариуцна.

22.2.Үйлчлэгч нь техникийн боломжийг харгалзан өөрийн сүлжээнд бусад сүлжээг саадгүй холбох нөхцөлийг хангана.

22.3.Сүлжээний заагласан цэгийг Зохицуулах хороо тогтооно.

23 дугаар зүйл. Холбооны сүлжээг дайчлан ажиллуулах

23.1.Монгол Улсад онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд харилцаа холбооны сүлжээг хууль тогтоомжид зааснаар дайчлан ажиллуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх үүрэг

24 дүгээр зүйл.Үйлчлэгч, хэрэглэгчийн хүлээх хариуцлага

24.1.Үйлчлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр зохицуулна.

25 дугаар зүйл. Үйлчлэгчийн эрх, үүрэг

25.1.Үйлчлэгч нь дараахь эрхтэй байна:

25.1.1.харилцаа холбооны үйлчилгээний тарифыг Зохицуулах хороонооc гаргасан аргачлалын дагуу тогтоох;

25.1.2.хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол үйлчилгээг зогсоох, гэрээг цуцлах;

25.1.3.гэрээнд заасан бусад эрх.

25.2.Үйлчлэгч нь дараахь үүрэгтэй байна:

25.2.1.тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчийг ялгаварлахгүйгээр үйлчилгээгээр шуурхай хангах;

25.2.2.харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандарт, техник, технологийн нөхцөл, горимыг дагаж мөрдөх;

25.2.3.харилцаа холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, үйлчилгээний зориулалтыг өөрчлөх, түр зогсоох тухай Зохицуулах хороо болон хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх;

25.2.4.харилцаа холбооны сүлжээгээр дамжих буй бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах;

25.2.5.энэ хуулийн 23.1-д заасан нөхцөл байдал тохиолдсон үед холбооны сүлжээг хууль тогтоомжийн дагуу саадгүй хэрэглүүлэх;

25.2.6.хууль тогтоомжид зааснаас бусад үед харилцаа холбооны үйлчилгээг зогсоохгүй байх, хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээх;

25.2.7.зохицуулах хорооноос шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;

25.2.8.хууль, гэрээгээр хүлээсэн бусад үүрэг.

25.3.Үйлчлэгч байгууллагын эрх бүхий ажилтан нь төрийн тусгай хамгаалалттай аж ахуйн нэгж, байгууллагад байгаа холбооны шугам, сүлжээнд засвар, үйлчилгээ хийхээр саадгүй нэвтэрнэ.

25.4.Хүлээлгэн өгөх, буцаан хүргүүлэх хаяггүй шуудангийн илгээмжийг Олон улсын болон Монгол Улсын шуудангийн дүрмийн дагуу зохицуулна.

26 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

26.1.Хэрэглэгч дараахь эрхтэй байна:

26.1.1.харилцаа холбооны стандарт, техникийн нөхцөлийг хангасан, баталгаажсан тоног төхөөрөмж ашиглах;

26.1.2.харилцаа холбооны сүлжээнд гарсан гэмтлийг арилгахыг шаардах, энэ талаар мэдээлэл авах;

26.1.3.энэ хуулийн 23.1-д зааснаас бусад шалтгаанаар үйлчилгээгээ зогсоосон буюу тоног төхөөрөмжөө ажиллуулаагүй, шуудангийн илгээмжийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

26.1.4.гэрээнд заасан бусад эрх.

26.2. Хэрэглэгч дараахь үүрэгтэй байна:

26.2.1.өөрийн хэмжилтэнд барилга байгууламж, нутаг дэвсгэр дэх харилцаа холбооны сүлжээ, тоног төхөөрөмжийг хамгаалах, түүнд гарсан болон гарч болох гэмтэл, хохирлын талаар үйлчлэгчид мэдээлэх;

26.2.2.харилцаа холбооны үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

26.2.3.үйлчлэгчээс өгсөн техникийн нөхцөл, шаардлагыг хангаж баталгаажсан тоног төхөөрөмж ашиглах;

26.2.4.гэрээгээр хүлээсэн бусад үүрэг.

ДОЛДУГААР БҮЛЭГ
Харилцаа холбооны сүлжээг хамгаалах

27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийтлэг үүрэг

27.1.Харилцаа холбооны сүлжээг хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

27.1.1.инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, барилга байгууламж барих, шугам, сүлжээ байгуулахдаа үйлчлэгчээс зөвшөөрөл авах, түүнийг шилжүүлэх шаардлагатай бол үүнтэй адилаар өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХООРОНДЫН КОНСУЛЫН КОНВЕНЦИЙГ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1990 оны 8 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын Консулын Конвенцийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2002 оноос эхлэн Үндсэн хуулийн цэцийн жил бүрийн төсөвт туусан олгож байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2001 оны 74 дүгээр тогтоолын хавсралт

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНД ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нь Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдлыг хангах баталгаа мөн.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох

3. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн гишүүний төрийн байгууллагад ажилласан хугацаат харгалзан түүний албан тушаалын сарын цалингаас доор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

4. Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан тооцно:

1/ төрийн албанд ажилласан;

2/ төрийн алба хаах хугацаандаа мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, дахин мэргэших, шинээр мэргэжил эзэмших дамжаа болон магистрантур, аспирантур, докторантурт суралцсан

3/ Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан албан тушаал эрхэлж байсан.

5. Үндсэн хуулийн цэцийн орон тооны бус гишүүнд төрийн албаа хаасан хугацааны нэмэгдлийг Цэцийн орон тооны гишүүний албан тушаалын цалингаас бодож олгоно.

6. Төрийн албаа хаасан хугацааг Үндсэн хуулийн цэцийн ажлын алба тодорхойлж, гишүүнд олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хувийг Үндсэн хуулийн цэцийн даргын тушаалаар тогтооно.

7. Төрийн алба хаасан хугацааг тогтоох үндсэн баримт бичиг нь хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр байна.

8. Үндсэн хуулийн цэцийн орон тооны бус гишүүн нь төрийн алба хашиж байгаа бол энэхүү нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 75** **Улаанбаатар хот**

Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Улсын Их Хурлын 1999 оны 24 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хангаагүйгээс нөхөн олговор авч байгаа иргэдийн нөхөн олговрын доод хэмжээг сард 18850 төгрөгөөр тогтоож 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай " Улсын Их Хурлын 2000 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 35 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 76** **Улаанбаатар хот**

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.12.5-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хуралд 1997 онд өргөн мэдүүлсэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төслийг Засгийн газарт буцаасугай.

2.Энэхүү хуулийн төслийг Улсын Их Хурлын Байнгын хороодын дүгнэлт, гишүүдийн гаргасан саналыг харгалзан дахин боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар / Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 77** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын 1998 оны 59 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 1998 оны 59 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "1998" гэснийг "2001", 2 дахь заалтын "1999" гэснийг "2002", 3 дахь заалтын "1999 оны нэгдүгээр улиралд" гэснийг "2001" онд гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 29-ний өдөр — Дугаар 72 — Улаанбаатар хот

Монгол Улс, СХУ-ын харилцаа, хамтын ажилллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэрийг нь үнэлж СХУ-ын дор дурдсан иргэдийг одон, медалиар шагнасугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Игорь Сергеевич Иванов - СХУ-ын Гадаад хэргийн сайд

2. Александр Прохорович Лосюков - СХУ-ын Гадаад хэргийн дэд сайд

3. Николай Викторович Павлов - Гадаад хэргийн яамны Азийн нэгдүгээр газрын дэд захирал

4. Евгений Максимович Примаков - СХУ-ын Хөгжлийн Хүрээлэн Төрийн Думын гишүүн

5. Сергей Эдуардович Приходько - СХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга

СХУ-ын зарим иргэнийг шагнах тухай

"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР

1. Анатолий Александрович Иллюк - СХУ-ын Дипломатын академийн орлогч захирал

2. Валерий Павлович Воробьев - Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн орлогч захирал

3. Иван Сергеевич Мостыка - СХУ-ын Гадаад хэргийн яамны Азийн нэгдүгээр газрын монголын хэлтсийн дарга

4. Юрий Евгеньевич Фокин - СХУ-ын Дипломатын академийн ректор

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 10 дугаар сарын 31-ний өдөр — Дугаар 73 — Улаанбаатар хот

Шүүгч, ерөнхий шүүгчийг чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул Дашдаваагийн Чулуунхүү Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Нямдоржийн Ичинхорлоог Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчээс чөлөөлж, Нийслэлийн Баянгол дүүргийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 27-ны өдөр — Дугаар 141 — Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөгжлөөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдээс сонгогдын хүсэлтийг харгалзан зохион байгуулж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын үйл ажиллагааны хөгжлөөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах 760.0 (долоон зуун жаран) сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрсөн төсвөөс тооцож гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 7 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 157 | Улаанбаатар хот

Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Сумын хөгжлийн сангийн зээлийн олголт, ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сумын хөгжлийн сан байгуулах,хөрөнгийг зарцуулах, ашиглалтад хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн батлсугай.

2. Сумын хөгжлийн сангийн зээлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийг хянан шалгаруулах, зээл олгох, хяналт тавих, буцаан төлүүлэх үйл ажиллагааг аймгуудын Засаг даргын Тамгын газарт хариуцуулсугай.

3. Сумын хөгжлийн санд олгох хөрөнгийг 2001 оноос эхлэн орон нутгийн татааст нэмж тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд, аймгийн төсвөөс сумын хөгжлийн санд хуваарилсан зээлийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн буцаан төлөлтийн мэдээг улирал, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгайлан гаргаж байхыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сум /аймгийн төвийн сумаас бусад/-ын хөгжлийн сан байгуулах, зарцуулах журам батлах тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 157 дугаар тогтоолын хавсралт

СУМЫН ХӨГЖЛИЙН САН БАЙГУУЛАХ, ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, АШИГЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Суманд жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, орон нутгийн төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэх зорилгоор сумын хөгжлийн сан (цаашид "хөгжлийн сан" гэж нэрлэнэ) байгуулах, зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаагаар энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хөгжлийн сангийн эх үүсвэр

2.1. Хөгжлийн сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

а/төсвөөс нэг удаа олгох сумын хөгжлийн сангийн зээлийн хөрөнгө;

б/иргэд, гадаад улс, олон улсын байгуулагатай болон дотоодын төрийн өмчийн хэлцүүлэгч аж ахуйн нэгж, байгуулагаас тухайн сумын хөгжүүлэхэд зориулан хандивласан мөнгөн болон бусад эд хөрөнгө;

в/сумын хөгжлийн санд олгосон зээлийн хүү;

г/хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

2.2. Хөгжлийн санд аймаг, сумын төсвийн хөрөнгө болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын төрийн өмчид ногдох хэсгийн хөрөнгөөс хандивлахыг хориглоно.

Гурав. Хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах

3.1. Сумандаа жижиг, дунд үйлдвэр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, түүнийг өргөтгөх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан тодорхой төслийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг ил тод, шударга шалгаруулж, тухайн Хурлаар хэлэлцүүлэн батлуулна. Хөгжлийн сангийн хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар

батагсан төсөлд хөнгөлөлттэй зээл олгоход зарцуулна.

3.2 Хөгжлийн сангаас хөнгөлөлттэй зээл олгохтеслийг сонгон шалгаруулах орон тооны бус ажлын хэсгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн сумын Засаг даргаар ахлуулан гаваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр нэг жилийн хугацаатай байгуулж ажиллуулна.

3.3. Хөгжлийн сангаас зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

а/иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн суманд бүртгэлтэй, цаашид тогвортой ерөлсөн суух, ажиллагаа баталгаажуулсан байх;

б/зээлийн хөрөнгийн баталгаат зохих журмын дагуу гаргасан байх;

в/иргэд, байгууллагагад хөгжлийн сангийн зээлийн өргүй байх;

г/ зээл авсны дараа зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах үүрэг хүлээх, зээлээ хугацаанд нь төлөх чадвартай байх.

3.4 Хөгжлийн сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загварыг аймгийн Засаг дарга батална. Гэрээнд зээлийн зориулалт, хэмжээ, хүү, эргэж төлөгдөх хугацаа, талуудын хүлээх үүрэг хариуцлага, маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх журам зэргийг тодорхой тусгаж, зээлийн хөрөнгийн баталгааг хавсаргасан байна.

3.5 Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шалгаруулсан төслийг сумын Засаг дарга тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулж, үг төсөл батлагдсанаас хойш 10 хоногт багтаан зээлийн гэрээний хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.6 Шалгарсан төслийн дагуу хэрэгжүлэх үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогийг харгалзан зээлийн хэмжээ, түүний хүүг тогтоох бөловч хугацаа нь 1 жилээс илүүгүй, хүүгийн хэмжээ сар бүтам 5 хувиас илүүгүй байх бөгөөд давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн гэж үзвэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүүг 50 хүртэл хувиар бууруулж болно.

3.7 Аймгийн Засаг дарга зээлийн гэрээг баталгаажуулснаар уг төсөлд олгох хөрөнгийг тухайн сумын хөгжлийн санд шилжүүлнэ.

3.8 Сумын хөгжлийн санд хуваарилсан зээлийн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд аймгийн төсөвт эргүүлэн төлөх бөгөөд түүний хүүгийн орлогыг нь тухайн сумын хөгжлийн санд үлдээнэ.

3.9 Хөгжлийн сан нь тусгай данстай байх бөгөөд орлого, зарлагын гүйлгээ нь банкны байгууллагаар дамжин хийгдэнэ.

3.10 Хөгжлийн сангийн хөрөнгийг энэхүү журмын 3.1-д зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хатуу хориглоно.

Дөрөв. Хөгжлийн сангийн зарцуулалтад хяналт тавих

4.1 Хөгжлийн сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод явуулна. Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын иргэд шууд хяналт тавина. Хяналт тавих ажлын хэсгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна. Тус ажлын хэсэг нь жилд 2-оос доошгүй удаа хөгжлийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийж, дүнг сумын Иргэдийн Хурлаар хэлэлцүүлэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байна.

4.2 Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг алдалгүй арилгах үүргийг сумын Засаг дарга биечлэн хариуцна.

4.3 Сумын хөгжлийн сангийн үйл ажиллагаанд тавих давхар хяналтыг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэх бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг хугацаа алдалгүй арилгах, гэм буруутай хүмүүст холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллана.

4.4 Сумын Засаг дарга хөгжлийн сангийн орлого, зарлагын мэдээ болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, дараа улирал, жилийн эхний сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 194 | Улаанбаатар хот

Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах тухай

Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн нэгдсэн эмнэлгийн боловсон хүчин, материаллаг баазад тулгуурлан Дорнод, Өвөрхангай, Ховд аймагт Эрүүл мэндийн яамны харьяа Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг байгуулан тэдгээрийн үйлчлэх хүрээний аймаг, сумыг 1 дүгээр хавсралт,Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийн барилга, инженерийн шугам сүлжээг засварлах, эрчим хүчээр найдвартай хангах нөөц эх үүсгүүртэй болгох, эмч, мэргэжилтний орон сууцаар хангах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнд онгоц, нисдэг тэрэг ашиглах, алсын зайны оношлогооны аргыг нэвтрүүлэх асуудлыг судалж санал боловсруулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

3. Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн зорилт, чиг үүрэг,үйлчилгээг олон нийтэд сурталчлах, шаардлагатай боловсон хүчин, түүнээ тусламжийн машин, эмнэлгийн багаж хэрэгсэл болон мэргэжлийн удирдлагаар хангах арга хэмжээ авч үйл ажиллагааны нь үр дүнг 2002 оны 9 дүгээр сард Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад үүрэг болгосугай.

4. Үйлчлэх хүрээний аймаг, сумаас ирсэн өвчтөн, түүний ар гэрийхэнд үйлчлэх нөхцөл боломж бүрдүүлэх тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Дорнод, Өвөрхангай, Ховд аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2001 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

БҮСИЙН ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНИЙ АЙМАГ, СУМ

№	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	Үйлчлэх хүрээ	
		Аймгийн нэр	Сумын нэр
1	Дорнод аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	Дорнод	Бүх сум
		Сүхбаатар	Бүх сум
		Хэнтий	◆ Дадал ◆ Баян-Овоо ◆ Батноров ◆ Норовлин ◆ Бэрх ◆ Баян-Адарга
2	Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	Өвөрхангай	Бүх сум
		Архангай	Бүх сум
		Баянхонгор	Бүх сум
		Дундговь	◆ Сайхан-Овоо ◆ Эрдэнэдалай ◆ Дэлгэрхангай

		Өмнөговь	♦ Мандал-Овоо ♦ Булган ♦ Сэврэй ♦ Гурвантэс ♦ Ноён ♦ Баяндалай ♦ Хүрмэн ♦ Ханхонгор
		Булган	♦ Рашаант
		Говь-Алтай	♦ Дэлгэр /Гуулин/ ♦ Чандмань ♦ Эрдэнэ ♦ Цогт /Баянтоорой/
3	Ховд аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	Ховд	Бүх сум
		Увс	Бүх сум
		Баян-Өлгий	Бүх сум
		Говь-Алтай	♦ Тонхил ♦ Дарви ♦ Хөхморьт ♦ Баян-Уул ♦ Төгрөг ♦ Шарга ♦ Жаргалан ♦ Цээл ♦ Халиун ♦ Алтай ♦ Бигэр ♦ Тайшир ♦ Бугат ♦ Есөнбулаг
		Завхан	♦ Ургамал ♦ Завханмандал ♦ Эрдэнэхайрхан ♦ Дөрвөлжин ♦ Сантмаргац ♦ Алдархаан ♦ Цагаанхайрхан ♦ Яруу ♦ Цэцэн-Уул ♦ Сонгино ♦ Баянхайрхан ♦ Тэс ♦ Баянтэс ♦ Түдэвтэй ♦ Нөмрөг ♦ Тэлмэн ♦ Идэр ♦ Улиастай ♦ Отгон

Засгийн газрын 2001 оны 194 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

БҮСИЙН ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв /цаашид Төв гэх/ нь хүн амд эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр нарийн мэргэшлийн оношлогоо, эмчилгээний лавлагаа тусламж,үйлчилгээ үзүүлэх, сургалт судалгаа явуулах эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага мөн.

2. Төвийн зорилго нь бүс нутгийн хүн амд чанарын үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдэд эмнэлгийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

3. Төв нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, энэхүү дүрэм болон тэдгээрт нийцүүлэн батлагдсан дүрэм, журмыг баримтална.

4. Төв нь төлөрсөн болон орон нутгийн өсөв, иргэний эрүүл мэндийн даатгалын сан, бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

5. Төвийг өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

6. Төв нь тогтоосон журмын дагуу үйлдсэн гэрээ, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргын нутаг дэвсгэрийн газартай гэрээ байгуулан ажиллана.

Хоёр. Төвийн удирдлага, зохион байгуулалт

8. Төв нь тус төвийн зорилт, чиг үүргийг бүрэн гүйцэтгэхэд шаардлагатай төлөвлөгөөг батлах, захирлын үйл ажиллагааны үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг бүхий удирдах зөвлөлтэй байна.

9. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10. Төвийн удирдлага нь захирал болон эмчилгээ,сургалт эрдэм шинжилгээ, эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан дэд захирлууд байна.

11. Төвийн захирлыг удирдах зөвлөлийн саналыг харгалзан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

12. Дэд захирлыг удирдах зөвлөлтэй зөвшилцөн төвийн захирал томилж, чөлөөлнө.

13. Захирал нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж төвийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон удирдах зөвлөлийн өмнө бүрэн хариуцаж тайлагнана.

14. Төв нь захиргаа, эрдэм шинжилгээ, сургалт арга зүйн зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг төвийн захирал батлан, зөвлөлийг удирдаж ажиллана.

15. Төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн захирал батална.

Гурав. Төвийн үүрэг, эрх

16. Төв нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/үйлчлэх хүрээний хүн амд үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшлийн лавлагаа тусламж, дуудлагаар нарийн мэргэшлийн яаралтай тусламж үзүүлэх;

б/төвийн болон бүс нутгийн эмнэлгүүдийн эмч, мэргэжилтний мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэжил, арга зүйн заавар зөвлөгөө өгөх;

в/бүс нутгийн хүн амын эрүүл мэндийн байдал, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг судлах, анагаах ухааны судалгаа шинжилгээний ажил эрхлэх;

г/оношлогоо, эмчилгээнд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

д/бүс нутгийн хэмжээнд өөрийн чиг үүрэгт нийцсэн хурал семинар, уулзалт зохион байгуулах;

е/олон улсын хөл хориот өвчнийг оношлох, зөвлөгөө өгөх;

17. Төв нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/эмчилгээ, үйлчилгээг чанаржуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлаар заавар, журам, даалгавар, удирдамж гаргах;

б/ аймгуудад захиалгаар үйлчлэх зөвлөх эмч нараас бүрдсөн нарийн мэргэшлийн явуулын багийг үйлчлэх хүрээний аймгуудаас бүрдүүлж ажиллуулах;

в/холбогдох асуудлаар дээд шатны болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

г/гадаад орны адил төстэй байгууллага, төвүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах;

д/оношлогоо, эмчилгээний алдаа зөрөөг мэдээлэх, лавлагаа шаардах.

Дөрөв. Төв болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн байгууллагуудын харилцаа

18. Төв нь жил бүрийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгах хөрөнгийн тухай саналаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймгийн Засаг даргын Тамгын газарт тавина.

19. Төв нь эмч, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, тэдгээрийн мэргэшлийг нь дээшлүүлэх төлөвлөгөөг жил бүр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж мөрдөнө.

20. Судалгаа шинжилгээний ажлын төсөл боловсруулан Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж хэрэгжүүлнэ.

21. Төвийг ажиллах нөхцөлөөр хангах, орон нутгийн төсөв болон даатгалын сангаас олгох санхүүжилтийг цаг хугацаанд нь хийж байх асуудлыг тухайн аймгийн Засаг дарга хариуцна.

22. Явуулын үйлчилгээ үзүүлэх захиалгыг үйлчлэх хүрээний аймгуудын эрүүл мэндийн газраас төвд ирүүлнэ.

23. Төвд эмчлүүлэх даатгуулагчийн эмчилгээний хувьсах зардлын тарифыг Санхүү, эдийн засаг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Эрүүл мэндийн сайдын хамтарсан шийдвэрээр тогтооно.

Тав. Өвчтөн хүлээн авах, оношлох, эмчлэх үйл ажиллагаа

24. Төв нь үйлчлэх хүрээний аймгуудын Эрүүл мэндийн газартай үйлчлүүлэх өвчтөний зардлыг санхүүжүүлэх гэрээ хийж төрөлжсөн нарийн мэргэшлийн оношлогоо, эмчилгээний лавлагаа тусламжийг өвчтөнд үзүүлнэ.

25. Нарийн мэргэжлийн яаралтай тусламжийн дуудлагыг үйлчлэх хүрээний аймаг, сумдаас шууд хүлээн авч үйлчилнэ.

26. Оношлогоо, эмчилгээний лавлагаа, тусламж үзүүлэх өвчний жагсаалт, дуудлагаар нарийн мэргэшлийн яаралтай тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 195 | Улаанбаатар хот

Журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны өтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын асгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Их сургууль, оллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, уцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам"-дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

а/журмын 2 дахь заалтын төгсгөлд Аймаг, сумын захиалгын дагуу гэрээгээр суралцах гсэгчдийн тоог тусгайлан заасан байна" гэж, 9 дэх заалтын "... сургалтын албаны хооронд" гэсний дараа "аймаг, сумын захиалгын дагуу гэрээгээр уралцагчийн хувьд суралцагч, сургалтын төрийн эн, тухайн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын хоорондох тус тус" гэж, 33 дахь заалтын ципломын" гэсний дараа "хуулбарын" гэж тус тус эмсүгэй;

б/ журмын 35 дахь заалтыг Суралцагч сургууль төгсөөд төрийн захиргаа, ялчилгээний болон дээд боловсрол олгох айгууллагатай хийсэн хөдөлмөрийн гэрээний дагуу эмшсэн мэргэжлээрээ 8 жил, түүний дотор суманд аас доошгүй жил ур бүтээлтэй ажиллаж байгаа охиолдолд тухайн байгууллагын тодорхойлолтыг дэслэн хөнгөлөлттэй зээл, хүүгийн төлбөрөөс элөөлж болно. Уг асуудлыг Сургалтын төрийн нгийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж ийдвэрлэнэ" гэж өөрчлөн найруулсугай.

2. Засгийн газрын 2000 оны 158 дугаар гтоолоор батлагдсан "2000-2001 оны хичээлийн жилд тоодын их сургууль, коллежид суралцаж байгаа рим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс нхүүжүүлэх журам"-д дор дурдсан нэмэлт, рчлөлтийг оруулсугай:

а/журмын 2 дахь заалтын "... ерх тус бүрийн ..." гэсний дараа "магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцаж байгаа эвөхөн нэг хүүхдийнх нь сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлнэ" гэж нэмсүгэй;

б/журмын 7-гийн "а" заалтын "200" гэснийг "500" гэж, мөн 7-гийн "б" заалтын "40" гэснийг "60" гэж, "нэн ядуу" гэснийг "ядуу" гэж тус тус өөрчилсүгэй;

в/журмын 15 дахь заалтыг "Суралцагч нь сурлага, сахилга батаар тэнцээгүй хасагдсан, түүнчлэн сургуулиа орхисон тохиолдолд энэ талаар сургууль нь Сургалтын төрийн санд ажлын 10 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй. Иймхүү мэдэгдээгүй бол тухайн сургуулийн дараа улирлын санхүүжилтээс уг суралцагчийн сургалтын төлбөрийг суутгаж тооцно" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

г/журмын нэрээс "2000-2001 оны хичээлийн жилд" гэснийг болон журмын 11 дэх заалтыг хассугай.

3. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан "Сургалтын төрийн сангийн дүрэм"-ийн 2 дахь заалтын "дарга - Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга" гэснийг "Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд" гэж, "гишүүд - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Гэгээрлийн яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга, Гэгээрлийн яамны боловсрол, шинжлэх ухааны төсөв, санхүүгийн нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Сангийн яамны боловсролын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн" гэснийг "гишүүд - Санхүү, эдийн засгийн дэд сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны

Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны боловсролын санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэж, 8 дахь заалтын "б" хэсгийн "төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшигчдэд ..." гэснийг "магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллежид суралцагчдад" гэж тус тус өөрчилсүгэй.

4. "Хөдөөгийн сумдаас ирсэн захиалгын дагуу суманд багш, эмчээр ажиллахаар гэрээ хийсэн их сургууль, коллежид суралцагчийн суралцах хугацааны сүүлчийн 2 жилийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлж байхаар тогтоосугай.

5. Орон нутгийн захиалгаар хөнгөлөлттэй зээлээр суралцан төгсөгчдийн зээлийн төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг даргад нарт үүрэг болгосугай.

6. Сургалтын төлбөрийн зээлийн эргэн төлөлтийн 20 хүртэл хувийг зээлээр суралцан төгсөөд хөдөө орон нутагт үр бүтээлтэй ажиллаж байгаа багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан зарцуулж байхыг Сургалтын төрийн сангийн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 205 | Улаанбаатар хот

"Цэвэр орчин" аяны дүнгийн тухай

Ардын хувьсгалын 80 жилийн ойг угтаж зохион байгуулсан "Цэвэр орчин" аяны дүнг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цэвэр орчин" аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, уг аянд шаардагдах хөрөнгийг 2002 оноос эхлэн төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. "Цэвэр орчин" аяныг 2001 онд зохион байгуулахад гарсан зардлыг санхүүжүүлэх,болзлын дагуу урамшуулал олгоход зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 17.0 (арван долоо) сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч, шаардагдах бусад хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай тохиролцож орон нутгийн төсвөөс гаргуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, Байгаль орчны сайд У.Барсболд нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

)01 оны 9 дүгээр
рын 19-ний өдөр

Дугаар 206

Улаанбаатар
хот

Төсөл дэмжих тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг
мгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь
сгийн 1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн
дахь заалтад заасныг үндэслэн Монгол Улсын
ісгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үхэр, хонь, ямааны бруцеллёз өвчинтэй
мцэх", "Үхрийн арьсны гууртах өвчинтэй тэмцэх"
слүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. "Үхэр, хонь, ямааны бруцеллёз өвчинтэй
мцэх" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах
өнгийг улсын төсөв, хандивлагч орнуудын зээл,
сламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ
ахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал,
анхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт, "Үхрийн
арьсны гууртах өвчинтэй тэмцэх" төслийг мал бүхий
иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар
санхүүжүүлж хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн
сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга
нарт тус тус даалгасугай.

3. Төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион
байгуулж, үр дүнг аймгуудаас авч нэгтгэн жил
бүрийн I улиралд Засгийн газарт мэдээлж байхыг
Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд
даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД** Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**01 оны 9 дүгээр
рын 19-ний өдөр**

Дугаар 207

Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
:

төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг
Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

АНУ-ын Нью-Йорк, Вашингтон хотод
лдэгдсэн алан хядах халдлагын уршгаар
архдаж, түлэгдсэн хүмүүсийн эмчилгээнд зориулж
0.0 мянган тун (флакон) панкипсин эмийг АНУ-ын
ісгийн газарт хүмүүнлэгийн туслamжаар
йлүүлэхэд зориулан 52.0 (тавин хоёр) сая

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД** Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**01 оны 9 дүгээр
рын 21-ний өдөр**

Дугаар 209

Улаанбаатар
хот

Ажлаас чөлөөлөх, ажилд
томилох тухай

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5
таар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол
сын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чимиддоржийн Амарболдыг Засгийн
рын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий
рын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Данзангийн Сандаг-Очирыг Засгийн
газрын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий
газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД** Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр | Дугаар 210 | Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Гунгаагийн Баясгаланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр | Дугаар 211 | Улаанбаатар хот

Зөвлөлдөх хороо байгуулах тухай

Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, хувийн хэвшлийн болон зарим төрийн бус байгууллагатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороог байгуулсугай.

2. Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Зөвлөлдөх хорооны дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 31 дүгээр тогтоол, "Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 211 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТАРСАН ЗӨВЛӨЛДӨХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Санхүү, эдийн засгийн сайд;

-Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга.

Гишүүд: -Үйлдвэр худалдааны сайд;

-Монгол банкны дэд ерөнхийлөгч;

-Гадаад хэргийн дэд сайд;

-Дэд бүтцийн дэд сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;

-Үндэсний татварын ерөнхий газрын дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

-Гадаадын хөрөнгө оруулалт,гадаад худалдааны агентлагийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын дарга;

-Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, Бизнесийн хөгжлийн агентлагийн удирдлагын зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр);

-Монголын нооц, ноолуурын холбооны

ргүүн (зөвшилцсөнөөр);

-Арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны ргүүн (зөвшилцсөнөөр);

-Уул, уурхайн үндэсний ассоциацийн ргүүн (зөвшилцсөнөөр);

-Өмөл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн олбооны тэргүүн (зөвшилцсөнөөр);

-Монголын хүнсчдийн холбооны өнхийлөгч;

-Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч;

-Монголын үйлдвэрлэлийн хоршооны төв холбооны дарга;

-Монголын ардын аж ахуйтны хоршоодын холбооны дарга;

-Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны ерөнхийлөгч;

Нарийн бичгийн дарга: -Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын мэргэжилтэн.

Засгийн газрын 2001 оны 211 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТАРСАН ЗӨВЛӨЛДӨХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Засгийн газар болон хувийн хэвшлийн мтарсан Зөвлөлдөх хороо (цаашид "Зөвлөлдөх роо" гэх) нь хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх маар эдийн засгийн өсөлтийг хангах, мөн нийгэм, ийн засгийн хөгжлийн талаар төрийн бодлого оловсруулж, хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийнхний тээс гаргасан санал, санаачилгыг тусгах, хувийн вшил хөгжих эдийн засаг, эрх зүйн таатай орчинг рдүүлэх талаархи үйл ажиллагаат уялдуулан хицуулах, санал солилцох, мэдээллээр хангах, нэл, дүгнэлт болон зөвлөмж гаргах чиг үүрэг хий орон тооны бус байгууллага мөн.

2. Зөвлөлдөх хороо нь улс орны нийтлэг эрх ашгийн үүднээс харилцан санал солилцох, вшилцөх, хамтран ажиллах хэлбэрээр энэхүү рмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Зөвлөлдөх хорооны бүтэц, зохион байгуулалт

3. Зөвлөлдөх хороо нь Засгийн газар, хувийн вшлээс тус тус 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. влөлдөх хорооны бүрэлдэхүүнийг хувийн вшлийг төлөөлөх төрийн бус байгууллагуудтай вшилцөн Засгийн газар батална.

4. Зөвлөлдөх хорооны даргаар Засгийн рыг төлөөлж Санхүү, эдийн засгийн сайд, хувийн хэвшлийг төлөөлж Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга байна. Зөвлөлдөх хорооны нарийн бичгийн дарга нь Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газрын мэргэжилтэн байна.

5. Зөвлөлдөх хороо сард нэг удаа хуралдана. Хуралдааныг Зөвлөлдөх хорооны дарга нар ээлжлэн зарлаж, хуралдааныг удирдана. Зөвлөлдөх хорооны нийт гишүүдийн болон тэл тус бүрийг төлөөлөх гишүүдийн олонхи ирсэн тохиолдолд хуралдааныг хуралдуулна.

6. Зөвлөлдөх хорооны хуралдаанаас санал, дүгнэлт, зөвлөмж гаргах ба хуралдаанд оролцогчид шийдвэрийг санал нэгтэй батална. Хэрэв хуралдааны шийдвэрээс өөр санал гарах бүюу талууд зөвшилцөлд хүрээгүй бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд тодорхой бичнэ.

7. Зөвлөлдөх хорооны дарга нар харилцан тохиролцож хуралдаанд хэлэлцэх асуудлын жагсаалтыг батална. Уг жагсаалтыг Зөвлөлдөх хорооны нарийн бичгийн дарга ээлжит хуралдаанаас 7 хоногийн өмнө гишүүдэд тараана.

Судалгаа, тооцоо шаардсан тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

8. Зөвлөлдөх хорооны ажлын алба нь Санхүү, эдийн засгийн яаманд байна.

Гурав. Зөвлөлдөх хорооны эрх, үүрэг

9. Зөвлөлдөх хороо нь дараахь эрхтэй байна:

а/хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх, улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд элэж байгаа байр суурийн өөрчлийн байдлын талаар талууд харилцан санал, мэдээлэл солилцож шаардлагатай бол цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах;

б/улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар боловсруулж байгаа төрийн бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөрийн төсөлтэй танилцаж, хувийн хэвшлийн саналыг түлхүү тусгах талаар зөвлөмж гаргах;

в/хууль тогтоомж, хөтөлбөрийн төсөлтэй танилцаж тэдгээрийн хувийн хэвшлийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тооцож санал, дүгнэлт гаргах.

10. Зөвлөлдөх хороо нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

а/хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахад төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх;

б/хувийн хэвшлийг хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар үндэсний зөвлөлгөөн, чуулга уулзалт, семинар, үзэсгэлэн зохион байгуулах санаачилга гаргах, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

в/хувьчлалын дараахь шатанд үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэх, хөтлөн явуулах удирдлагын чадавхийг дээшлүүлэх, мөн нийт хувийн хэвшлийн удирдах ажилтны хууль, эрх зүйн болон эдийн засгийн мэдлэгийг системтэй дээшлүүлэх ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

г/гадаад улс орны Засгийн газраас хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх талаар явуулж байгаа туршлагыг судлан танилцах, сурталчлах, төрүүн туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх талаар санал боловсруулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Дугаар 213 **Улаанбаатар хот**

Ажилд томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Балчингийн Цэрэндоржийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 44 (231)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай*
- *Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох ажлыг дэмжих тухай*
- *Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арваннэгдүгээр сарын 14 №44 (231)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

527. Дүрэм батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 214	1001
528. Цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай	Дугаар 215	1003
529. Шонхор шувуу нэмж гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 216	1004
530. Гашуудлын ёслол үйлдэх тухай	Дугаар 218	1004
531. Хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 219	1004
532. Улсын нөөцөөс гэр, автомашин гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай	Дугаар 220	1012
533. Хэлэлцээрүүдийг батлах тухай	Дугаар 221	1012
534. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай	Дугаар 222	1012
535. Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох ажлыг дэмжих тухай	Дугаар 223	1013
536. Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 224	1013

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

001 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 214** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Усны үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор батлсугай.

2. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 999 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

"**Дарга** -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга

Гишүүд: -Санхүү,эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Нарийн бичгийн дарга -Үндэсний хорооны ажилтан."

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2001 оны 214 дүгээр тогтоолын хавсралт

УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Усны үндэсний хороо нь /цаашид "Үндэсний хороо" гэх/ "Усны үндэсний хөтөлбөр"-ийг /цаашид "хөтөлбөр" гэх/ хэрэгжүүлэх ажлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий байгуулагад мөн.

2. Үндэсний хороо нь усны нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хомсдох, бохирдохоос хамгаалах, үйлдвэрлэл болон хэрэглэгчдийг чанартай, хүрэлцээтэй усаар найдвартай хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, уялдуулан зохицуулна.

3. Хороо нь үйл ажиллагаандаа Усны тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Үндэсний хорооны бүтэц, зохион байгуулалт

4. Үндэсний хорооны дарга, нарийн бичгийн даргыг Засгийн газар томилж, бүрэлдэхүүнийг батална.

5. Үндэсний хорооны дарга нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга байна.

6. Үндэсний хорооны гишүүд нь байгаль орчин, баттлан хамгаалах, дэд бүтэц, санхүү, эдийн засаг, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын төлөөллүүдээс бүрдэнэ.

7. Үндэсний хорооны гишүүд нь тухайн салбарынхаа усны бодлогын зохицуулалтын асуудлыг эрхлэн хариуцна.

8. Усны үндэсний хороо нь орон тооны нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь Үндэсний хорооны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

9. Хорооны нарийн бичгийн даргын хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудал нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулагдана.

10. Хорооны даргын шийдвэрээр холбогдох яамдын мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан төслийн баг, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

11. Үндэсний хороо нь аймаг, нийслэлд салбар хороотой байх бөгөөд салбар хорооны дарга нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна. Салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг салбар хорооны дарга батална.

12. Салбар хороо нь Үндэсний хороонд ажлаа тайлагнана.

13. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь гишүүдийн хурал байна. Үндэсний хороо хэлэлцсэн асуудлаараа зөвлөмж гаргана.

14. Хурлын дэг, журмыг Үндэсний хорооны хурлаар хэлэлцэн батална. Хурлыг Үндэсний хорооны дарга удирдана.

15. Үндэсний хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Үндэсний хорооны эрх, үүрэг

16. Үндэсний хороо нь дараахь эрхийг эдэлнэ:

а/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дотоод, гадаадын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

в/салбар хороодын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт шинжилгээ хийж, үнэлэлт өгөх;

г/усны салбарт улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын бодлого, зохицуулалт, үр дүнд үнэлгээ өгөх, хяналт шинжилгээ хийх;

д/усны салбарын эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

е/хорооны төсөв, зардлыг төлөвлөх, батлуулах, зарцуулалтад нь хяналт тавих;

ж/хөтөлбөрийн хэрэгжилтийг орчимжүүлэх болон хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

17. Үндэсний хороо нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга замжээ авах;

в/хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааг нэгдсэн дирдлагаар хангах, уялдуулан зохицуулах;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлж буй өрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

д/хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Засгийн газраар хэлэлцүүлэх;

е/хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, нийслэлд дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

18. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

а/Үндэсний хорооны хэвийн, асралтгүй үйл ажиллагааг хангах;

б/хорооны хурлаар хэлэлцэх суудлын төлөвлөгөөг боловсруулж Үндэсний хорооны даргаар батлуулж бэлтгэлийг хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

в/хурлын тэмдэглэл хөтлөх, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

г/салбар хороодыг мэргэжлийн удирдлагаар хангах;

д/Үндэсний хорооны ажлыг төлөвлөх, биелэлтэд хяналт тавих, хөтөлбөрт өөрчлөлт оруулах санал бэлтгэх;

е/хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Хорооны хуралд оруулах;

ж/хөтөлбөрийн хэрэгжилт, ач холбогдол, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

з/байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдлийг Үндэсний хорооны даргад танилцуулах, төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

и/Үндэсний хорооны архив, бичиг хэргийг хөтлөн явуулах.

Дөрөв. Бусад зүйл

19. Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг тухайн хорооны хурлаар хэлэлцэн Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын төсөвт тусган санхүүжүүлнэ.

20. Үндэсний хороо нь ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөх бөгөөд холбогдох яам, салбар хорооны тайланг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан хөтөлбөрийн биелэлтийг Засгийн газарт танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 215** **Улаанбаатар хот**

Цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дээрх Төв цэнгэлдэх хүрээлэнгийн өмнөх талбайд "Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэн" байгуулж, холбогдох зардлыг балбарынхаа 2001 оны төсөвт багтаан санхүүжүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр | **Дугаар 216** | **Улаанбаатар хот**

Шонхор шувуу нэмж гаргахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

Арабын Нэгдсэн Эмират Улсад 30 (гучин) ширхэг шонхор шувуу нэмж гаргахыг Байгаль орчны

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр | **Дугаар 218** | **Улаанбаатар хот**

Гашуудлын ёслол үйлдэх тухай

Монгол Улсын Их Хурлын дарга Лхамсүрэнгийн Энэбиш таалал төгссөнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2001 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 68 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын дарга Лхамсүрэнгийн Энэбиш таалал төгссөнтэй холбогдуулан гашуудлын өдрүүдэд орон даяар төрийн далбааг 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулган эмгэнэл илэрхийлсүгэй.

2. Гашуудлын өдрүүдэд соёл, урлагийн тоглолт, кино, биеийн тамир, спортын зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ явуулах, ёслолын арга хэмжээ зохиохыг хориглосугай.

3. 2001 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 12.00 цагт орон даяар авто замын хөдөлгөөнийг 3 минут зогсоож автомашин, галт тэрэг, цахилгаан станцын дуут дохиолол өгсүгэй.

4. Талийгаач Л.Энэбишийн шарилыг оршуулах үед Төрийн дуулал эгшиглүүлж, ёслолын буудлага 19 удаа үйлдсүгэй.

5. Талийгаач Л.Энэбиштэй салах ёс гүйцэтгэх үйл ажиллагаат шууд дамжуулах арга хэмжээ авахыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

6. Энэ тогтоолын 4 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны үеэр радио, телевизээр Төрийн дуулал эгшиглүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 1-ний өдөр | **Дугаар 219** | **Улаанбаатар хот**

Хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Бөөний худалдааны сүлжээ" шинэчилсэн хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, үг ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрт

эргүүлэх ач холбогдол өгч, мэдээллийн сүлжээ байгуулах болон хэмжил зүйн баазыг бүрдүүлэх арга хэмжээг гадаадын зээл, тусламж, олон улсын байгууллагуудын шугамаар хэрэгжүүлэх төсөлд амруулах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, дийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгасугай.

3. Түүхий эдийн бэлтгэл, бараа эргэлтийг рон нутагт дэмжих зорилгоор аймгуудад бараа, үүхий эдийн сан байгуулахад зориулан энэ отгоолын 2 дугаар хавсралтаар батална өтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасны дагуу эргэж төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө төсвөөс олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, олгосон зээлийг зарцуулах журмыг Санхүү, эдийн засгийн яамтай хамтран боловсруулж хэрэгжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт тус тус даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 98 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ СҮЛЖЭЭ" ШИНЭЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

Эрхэм зорилго

1. Хүн амыг чанар сайтай хүнс, өргөн эрэглээний бараагаар, үйлдвэрлэлийг түүхий дээр тасралтгүй хангах, бараа, түүхий эдийн элтгэл, нийлүүлэлтийн зохистой тогтолцоог бий олгох, бараа, түүхий эдийн хадгалалт, эвэврлэлтийг оновчтой болгох замаар зах зээлийн одит үнийн түвшинг бүрдүүлж хот, хөдөөгийн оорондох үнийн зөрүүг багасгахад оршино.

Үйл ажиллагааны зарчим

2. Бөөний худалдааны сүлжээ нь бараа, үүхий эдийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, рилжаалагч, тээвэрлэгч, хэрэглэгч, банк анхүүгийн болон мэдээлэл, сурталчилгааны йлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тэдгээрийн оорондын үйл ажиллагааны харилцан үйлчлэл үхий нөэлттэй тогтолцоо байна.

Нэг. Бөөний худалдааны сүлжээний зохион байгуулалтын бүтэц

3. Бөөний худалдааны сүлжээ нь дотоод олон гадаад бүтцээс бүрдэнэ. Дотоод бүтэц нь бараа, түүхий эдийг бэлтгэх, нөөцлөх, хадгалах, рилжааг зохион байгуулагч, үйлдвэрлэгч, йлүүлэгч, хэрэглэгчийг мэдээллээр үйлчлэгч, үчлагч байгууллагаас бүрдэнэ. Гадаад бүтэц нь өөний худалдааны үйл ажиллагаан дахь бараа, үхий эдийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, нөөцлөлт, рлуулалтыг санхүүгийн нөөцөөр хангах, менгөний эсгалыг зохион байгуулах, бараа түүхий эдийг тээвэрлэх, мэдээллийн харилцаа, дамжуулалтыг хангагч байгууллага байна.

4. Бөөний худалдааны сүлжээний зохион байгуулалтын дотоод бүтэц

Бөөний худалдааны сүлжээ нь дараахь дотоод бүтэцтэй байна:

а/бөөний худалдааны мэдээллийн сүлжээ;

б/бараа, түүхий эдийн төрөлжсөн болон холимог бирж;

в/барааны төрөлжсөн, холимог болон түүхий эдийн нэг цэгийн бөөний агуулах;

г/бөөний худалдааны төв, бөөний худалдааны дэлгүүр;

д/бараа, түүхий эдийн нөөцийн агуулах;

е/бараа, түүхий эд бэлтгэгч агент.

Сүлжээний зохион байгуулалтын бүтцийг бий болгохдоо бүс нутаг, аймаг, хот, сумдын түвшинд хүн амын суурьшил, нягтрал, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, зам харилцааны дэд бүтцийн байдал, хөгжлийн төлөв, бараа, түүхий эд тээвэрлэх зайг оновчлох боломж зэрэг хүчин зүйлийг харгалзана.

5. Бөөний худалдааны мэдээллийн сүлжээ

Мэдээллийн сүлжээ нь мэдээллийн сан, түүнийг байгуулах, хөтлөх, дэмжих зохион байгуулалтын бүтэц, мэдээлэл дамжуулах системээс бүрдэнэ. Мэдээллийн сан нь мэдээллийн бүтцийн хувьд ижилтгэсэн шийдэлтэй байна.

6. Мэдээлэл хангамж

Мэдээлэл хангамж нь "Бөөний худалдааны сүлжээ"-ний үйл ажиллагааг дэмжих дараахь мэдээллийн сантай байна:

а/бараа, түүхий эдийн нөөц, түүнийг борлуулах санал (тоо, хэмжээ, үнийн санал, худалдааны нөхцөл гэх мэт);

б/бараа, түүхий эд худалдан авах санал;

в/арилжааны захиалга хүлээн авах, бүртгэх;

г/дуудлага худалдааны;

д/бараа, түүхий эдийн сурталчилгааны;

е/технологийн тээвэр эрхлэгчдийн;

ж/телетекст.

7. Мэдээлэл дамжуулах суваг, технологи

Бөөний худалдааны сүлжээний үйл ажиллагааг дэмжих мэдээлэл дамжуулалт, солилцоонд холбох харилцааны өнөөгийн суваг, боломжийг ашиглана.

8. Мэдээллийн сүлжээний зохион байгуулалт, үйл ажиллагааны технологийн зарчим

Бөөний худалдааны мэдээллийн сүлжээг төвлөрсөн бус, нээлттэй системийн хэлбэрээр зохион байгуулна. Зохион байгуулалтын дараахь бүтэцтэй байна:

а/Сүлжээг дэмжих төв

Мэдээллийн сангийн дизайн, мэдээллийн санг дэмжих, удирдах, сүлжээний зангилаа байж, программ, технологи, арга зүйн төвийн үүрэг гүйцэтгэж, телетекст горимыг дэмжиж ажиллана. Төв нь Улаанбаатар хотод байрлана. Сүлжээг дэмжих төвийг тендерийн үндсэн дээр мэдээлэл, харилцаанд технологиор ажилладаг компаниудаас шалгаруулна.

б/Биржийн мэдээллийн нэгж

Үйлдвэрлэгч, нийлүүлэгч, худалдан авагч бараа, түүхий эдийн захиалга, нийлүүлэлтийн мэдээллийг хүлээн авч бүрдүүлэн мэдээллийн сан байгуулан хөтлөх, сүлжээнд гаргах үүрэгтэй байна.

в/Сумдын мэдээллийн агент

Бараа, түүхий эдийн агент мэдээллийн агентын үүрэг гүйцэтгэнэ. Малчид, иргэдийн бараа материал худалдан авах хэрэгцээ, түүхий эд нийлүүлэх тоо, хэмжээ, үнийн саналын тухай мэдээллийг бүрдүүлж, утсаар аймгийн биржийн мэдээллийн нэгжүүдэд хүргүүлэх, биржийн мэдээллийн нэгжээс авсан мэдээллийг малчид, иргэдэд хүргэх үүрэгтэй байна.

9. Бараа, түүхий эдийн арилжааны төрөлжсөн болон холимог бирж

Бирж нь үйл ажиллагааны зарчмын хувьд:

Бирж зуучлагч

Бирж + нэг цэгийн үйлчилгээний агуулах хэлбэртэй байж болно.

а/Бирж зуучлагч

Бараа, түүхий эдийг арилжих, арилжааг зохион байгуулах (дуудлага худалдаа) үйлдвэрлэгч, нийлүүлэгч, худалдан авагчийг мэдээллээр хангах үндсэн үүрэгтэй ажиллана.

б/Бирж + нэг цэгийн үйлчилгээний агуулах

Бараа, түүхий эд нийлүүлэх, хадгалах, нөөцлөх, савлах, борлуулах, арилжаат зохион байгуулах гадаад худалдаа хийх, санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, бараа, түүхий эдийн тээвэрлэлтийг зохион байгуулах, зуучлах, мэдээлэл, сурталчилгаа хийх зэрэг үйл ажиллагаа эрхэлнэ.

10. Барааны төрөлжсөн, холимог болон түүхий эдийн нэг цэгийн үйлчилгээний бөөний агуулах

Биржээр хэрэглэгчийн захиалгаар болон эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, прогноз хийх замаар бараа, түүхий эдийг худалдан авах, импортлох, хадгалах, нөөцийн менежмент хийх, бөөний үнээр хэрэглэгчдэд худалдах, тээвэрлэн хүргэх өгөх

эрэг үйл ажиллагаа эрхлэх бөөний худалдааны өвийн үүрэгтэй ажиллана.

Агуулах нь биржтэй нэгдсэн бүтэцтэй буюу ангараа байж болно.

11. Барааны төрөлжсөн агуулах нь:

а/хүнсний барааны;

б/өргөн хэрэгцээний үйлдвэрийн барааны;

в/барилгын материалын;

г/электрон техникийн барааны;

д/тоног төхөөрөмжийн;

е/сэлбэг хэрэгслийн гэх мэт байж болно.

12. Түүхий эдийн төрөлжсөн агуулах нь:

а/ноос, ноолуурын;

б/арьс ширний гэх мэт байж болно.

Түүхий эдийн төрөлжсөн агуулахыг төмөр ам, олон улсад гарцтай авто замын дагуу айршуулах бодлого баримтална.

13. Бөөний худалдааны төв, бөөний удалдааны дэлгүүр

Бараа, материалыг бөөнөөр худалдах үйл жиллагаа эрхлэнэ. Одоо ажиллаж байгаа болон өөний худалдааны сүлжээнд нэгдэж ажиллах онирхол бүхий аж ахуйн нэгж энд хамаарна.

14. Бараа, түүхий эдийн агент

Агент биржтэй гэрээтэй ажиллана. Агент нь ргэн, малчдын хоршоо, аж ахуйн нэгжийн элбэртэй байж болно.

Хоёр. Бөөний худалдааны сүлжээний дотоод бүтцийг бий болгох үндсэн чиглэл

15. Бөөний худалдааны сүлжээний дотоод үтцийг дараахь байдлаар байгуулан ажиллуулна:

а/Улаанбаатар хотод

Улаанбаатар хотод бараа, түүхий эдийн рөлжсөн биржүүд, нэг цэгийн үйлчилгээний бөөний рөлжсөн агуулахын тоглолцоо бий болгох ілэлийг баримтална.

Маркетингийн судалгааны баг ажиллуулж Улаанбаатар хотод бий болгох бирж, агуулахын төрөл, хэлбэр, төрөлжилт, байршил зэргийг тогтоож төсөл боловсруулна. Төслийн даалгаврыг Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газар, Үйлдвэр, худалдааны яам батална.

в/бүсийн төв, аймагт

Маркетингийн судалгааны үндсэн дээр бүсийн төв, аймагт бөөний худалдааны сүлжээний дотоод бүтцийн хэлбэр, төрөл, төрөлжилтийг орон нутаг шийдвэрлэнэ.

Гурав. Бөөний худалдааны сүлжээний гадаад бүтэц

16. Гадаад бүтэц нь бөөний худалдааны сүлжээний дотоод бүтцийн нэгж, оролцогчтой үйл ажиллагааныхаа чиглэлээр ажил хэргийн харилцаанд орж хамтран ажиллаж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж байна.

а/төр, засгийн байгууллага нь бөөний худалдааны сүлжээний үйл ажиллагааны хууль зүйн орчинг бүрдүүлж, хяналт, татвар, санхүүжилт, ээл, төсөл, стандартчилал, мэдээлэл зэрэг механизмаар дамжуулан сүлжээг дэмжих, зохицуулах үйлчилгээ үзүүлнэ;

б/банк, банкны бус санхүүгийн байгууллага, санхүү-зээлийн хоршоод нь бирж, бараа, түүхий эд бэлтгэгч, нийлүүлэгчдээд мөнгөн гүйлгээний бэлэн, бэлэн бус тооцооны үйлчилгээ үзүүлж, агуулахад байгаа бараа, түүхий эдийн үлдэгдэл, ирээдүйд бэлтгэх бараа, түүхий эдийг барьцаалан зээл олгох замаар бөөний худалдааны сүлжээний дотоод бүтцийн нэгжтэй харилцан ашигтай хамтран ажиллана. Бирж нь банк, банкны бус санхүүгийн байгууллагатай тохиролцон агуулахад байгаа бараа, түүхий эдийн үлдэгдэлдээ "вексель", өрийн бичиг гаргах зэргээр мөнгөний урсгалыг шуурхай зохицуулах арга, хэрэгслийг ашиглаж болно;

в/бараа, түүхий эдийн технологийн тээврийн үйлчилгээг бөөний худалдааны сүлжээний хүрээнд бий болгоно;

г/холбоо,харилцааны байгуулагууд бөөний худалдааны сүлжээний хүрээнд үүссэн мэдээллийг сүлжээний дотоод бүтцийн нэгж болон хэрэглэгчдийн өөр хооронд дамжуулах суваг, технологиор хангаж үйлчилнэ. Олон нийтийн мэдээллийн байгууллага (телевиз, радио, сонин)

бөөний худалдааны сүлжээний дотоод бүтцийн нэгжтэй гэрээтэй ажиллан бараа, түүхий эдийн нөөц, эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээний тухай мэдээлэл болон барааны зар сурталчилгааг өөр өөрийн сувгаар дамжуулж иргэд, аж ахуйн нэгжид үйлчилнэ;

д/төрийн бус байгууллага бөөний худалдааны сүлжээний хүрээнд худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчилах, тэргүүний арга хэлбэрийг нэвтрүүлэхэд нь тусламж үзүүлэх, сургалт, семинар зохиох, зарим аймаг, сумдад туршилтын "загвар" төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэхэд зуучлах зэрэг үйл ажиллагаа явуулна.

Дөрөв. Бөөний худалдааны сүлжээний хэрэглэгчид

17. Сүлжээний үндсэн хэрэглэгчид нь үйлдвэрлэгч, импорт, экспортын худалдаа эрхлэгч, жижиглэнгийн худалдааны төв, их дэлгүүр, супермаркет, компани, аж ахуйн нэгж, жижиг худалдаа эрхлэгчид байна. Сүлжээ нээлттэй тогтолцоогоор байгууллагдах учраас гадаадын байгууллага, иргэд сүлжээний хэрэглэгч байж болно.

Тав. Сүлжээний эрх зүйн хангамж

18. Бөөний худалдааны сүлжээний эрх зүйн хангамж нь сүлжээний үйл ажиллагаат үр дүнтэй зохицуулахад чиглэгдсэн хууль тогтоомж, журам, стандарт, техникийн нөхцөл зэргээс бүрдэнэ:

-Худалдааны багц хууль;

-Стандарт, техникийн нөхцөл (Худалдааны стандартууд, агуулахын техникийн нөхцөл, шаардлага, технологийн тээвэрлэгчид тавих шаардлага, техникийн нөхцөл, түүхий эд бэлтгэх үйл ажиллагаанд тавих шаардлага, бараа, түүхий эдийн чанар, хадгалалт, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагууд зэрэг).

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

19. 1 дүгээр үе шат: 2001-2002 он

а/бөөний худалдааны сүлжээний эрх зүйн орчинг бүрдүүлэх хууль тогтоомж, журам, стандарт, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулах, шинэчлэн батлуулах арга хэмжээ авна:

- Худалдааны тухай багц хууль;
- Агуулахын техникийн нөхцөл, стандарт;
- Худалдааны стандартууд;
- Технологийн тээвэр гүйцэтгэх стандарт, шаардлагууд;
- Түүхий эд бэлтгэх ажлын стандарт, шаардлагууд;
- Бараа, түүхий эдийн хадгалалт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага;
- Биржийн үлгэрчилсэн дүрэм.

б/бөөний худалдааны мэдээллийн сан, сүлжээ байгуулах төсөл шалгаруулан дүгнэх. Бөөний худалдааны мэдээллийн сүлжээг дэмжих төвийн үүрэг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж ажлыг нь эхлүүлэх;

в/Улаанбаатар хотод бараа, түүхий эдийн бирж, барааны төрөлжсөн агуулах байгуулах талаар судалгаа явуулах, төсөл шалгаруулах ажлыг зохион байгуулах;

г/бүсийн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүсийн төвүүдэд бирж, бөөний худалдааны төрөлжсөн төв, агуулах байгуулах асуудлыг судлах, байгуулах ажлыг зохион байгуулах:

- 2001 онд Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад;
- 2002 онд Ховд, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай (Хархорин), Дорнод.

д/аймгуудад бараа, түүхий эдийн бирж байгуулах ажлыг нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргатай хамтран зохион байгуулах

20. 2 дугаар үе шат - 2003 он

а/бараа, түүхий эдийн бирж, бөөний худалдааны төвийг бусад аймгуудад байгуулна;

б/бөөний худалдааны мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны программ, технологийг зүгшрүүлж дуусгах;

г/бараа, түүхий эдийн экспортын
тэдэлэл, суртапчилгааг олон улсын мэдээллийн
үлжээнд гаргах;

д/электрон худалдааны технологийг
аймаг, бүсийн төвүүд, Улаанбаатар хотын хороонд
олон Улаанбаатар хотод нэвтрүүлэх.

21. 3 дугаар үе шат - 2004 он

Энэ үед бөөний худалдааны сүлжээний
орготлцоо бүрэн хэмжээгээр ажиллаж эхлэнэ.
Сүлжээг цаашид хөгжүүлж, боловсронгуй болгох
одлого, арга хэмжээний төсөл боловсргодсон
айна.

**Долоо. Хөтөлбөрийн удирдлага,
зохион байгуулалт,
санхүүжилт**

22. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан
охион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг
үхий Үндэсний зөвлөл ажиллана.

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг
асгийн газар батална. Орон нутагт салбар зөвлөл
жиллана.

Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг
үрмээр зохицуулна. Дүрмийг зөвлөл өөрөө
атална.

**Найм. Хөтөлбөрийн
санхүүжилт**

23. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн
араахь эх үүсвэрийг ашиглана:

а/аж ахуйн нэгж, байгууллага,
эгэдийн өөрийн хөрөнгө;

б/хөгжлийн сангуудын санхүүжилт,
ээл;

в/банк болон банк бус санхүүгийн
эйгууллагын зээл;

г/олон улсын байгууллага,
ндивлагч орнуудын зээл, тусламж;

д/улсын төвлөрсөн төсвөөс орон нутагт
бараа, түүхий эдийн сан байгуулахад олгох зээл.

**Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр
гарах үр дүн**

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр
дүн гарна:

а/худалдаа, түүхий эд бэлтгэлийн
тогтолцоо бий болж худалдаа, үйлчилгээний бүтэц,
зохион байгуулалт сайжран, иргэдийг эрэлт
хэрэгцээнийх нь дагуу чанартай бараагаар
тогтвортой, цаг тухайд нь ханган үйлчлэх нөхцөл
бүрдэнэ;

б/бараа, материалыг олноор нь
импортлох боломж бүрдэн, импорт бүхэлдээ эдийн
засгийн хувьд үр ашигтай болж, хадгалалт,
савлалт, тээвэрлэлтийн соёлжсон технологи
нэвтэрсний үндсэн дээр нэгж барааnd ногдох
зардал буурч эрэлт, нийлүүлэлтэд тулгуурласан
зах зээлийн бодит үнэ бүрэлдэн тогтоно;

в/зах зээлийн зарчимд тулгуурласан
түүхий эд бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо
бүрдэж,үйлдвэрлэгчдийг чанартай түүхий эдээр
ханган, түүхий эдийн экспортыг оновчтой, үр
ашигтай зохион байгуулах нөхцөл бүрдэнэ;

г/бүсийн төвүүд болон аймаг,
сумдын хүрээнд барааны хангалт, түүхий эд
бэлтгэл, тээвэрлэлтийн оновчтой, үр ашигтай
тогтолцоо бүрэлдэж, хөдөөгийн иргэдийн өсөн
нэмэгдэж байгаа хэрэгцээг бараа, материалаар
хангах байнгын тогтолцоо бий болно;

д/аймаг, хот, сум, дүүргийг
хамарсан худалдааны мэдээллийн сүлжээ
байгуулагдаж бараа, түүхий эдийн талаархи
мэдээллийн хангамж эрс дээшилнэ. Худалдааг
электрон сүлжээгээр дамжуулан хийх орчин үеийн
арга технологи бүрэлдэн хэрэгжиж улмаар гадаад
орнуудтай электрон сүлжээгээр худалдаа хийх
нөхцөл бий болно;

е/хүн амын амьжиргааны түвшин
дээшилнэ.

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах яам, агентлаг	Шаардагдах хөрөнгө (сая төг)	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Худалдааны тухай хууль, түүнийг дагалдах салбар хуулиудын төслийг санаачилж, Улсын Их хуралд өргөн барих	2002	ҮХЯ		
2	Бөөний худалдааны сүлжээг бүрдүүлэхэд шаардагдах стандарт, техникийн нөхцөлүүдийг боловсруулж, батлах	2001-2002	ҮХЯ, СХЗҮТ		
3	Бөөний худалдааны мэдээллийн сан, сүлжээ байгуулах төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах	2001	ҮХЯ		
4	Бөөний худалдааны мэдээллийн сүлжээг дэмжих төвийн ажлыг эрхлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, ажлыг нь эхлүүлэх	2002	ҮХЯ		
5	Улаанбаатар хотод бараа, түүхий эдийн төрөлжсөн болон холимог агуулах, бөөний худалдааны төв, бирж зохион байгуулах асуудлыг судалж, байршлыг тогтоон, дээрх үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах, шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх	2001-2002	ҮХЯ, ХХААЯ, ТӨХ,Нийслэлийн Засаг дарга		
6	Бүсийн хөгжлын үзэл баримтлалын хүрээнд аймгуудад бирж, бөөний худалдааны төв зохион байгуулах: • Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад; • Ховд, Завхан, Дорнод, Дархан-Уул, Өвөрхангай (Хархорин) • Бүсад аймгуудад	2001 2002 2003	Үндэсний зөвлөл, ҮХЯ, СЭЗЯ, ДБЯ, ТӨХ, Аймгуудын Засаг дарга нар	650.0 1170.0 2640.0	Эргэж төлөгдөх нөхцөл бүхий төсвийн хүүгүй зээл

	Бирж, бөөний худалдааны төв, агуулахад байгаа үлдэгдэл бараа, түүхий эд, ирээдүйд бэлтгэх түүхий эд, барааны дүнгээр вексель, өрийн бичиг гаргах, түүнийг мөнгөжүүлэх талаар чиглэл гаргаж банк, банк бус санхүүгийн байгууллагуудтай тохиролцох. Монгол банкнаас хийх вексель, өрийн бичгийн туршилтад зарим бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг хамруулах	2001 оны 9 дүгээр сард	ҮХЯ, Монгол банк		
	Бөөний худалдааны мэдээллийн сүлжээ байгуулах төслийг хандивлагч орнуудын зээлийн төсөлд хамааруулах арга хэмжээ авах	2001 оны 6 дугаар сард	ҮХЯ, СЭЗЯ	2000.0	Хандивлагч орнуудын зээл, тусламж
	"Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг хэрэжүүлэх ажлын хүрээнд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл, төлөвлөгөөг тохиролцон,хэрэжүүлэх ажлыг зохион байгуулах	2001 оны 12 дугаар сард	Үндэсний зөвлөл, ҮХЯ		

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

"БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ СҮЛЖЭЭ" ХӨТӨЛБӨРИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Үйлдвэр, худалдааны сайд

Орлогч дарга - Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд: -Санхүү,эдийн засгийн яамны нарийн нарийн бичгийн дарга;

-мөн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн сын хяналтын албаны дарга;

-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний вийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын эгжилтийг зохицуулах газрын дарга;

-мөн яамны Хүнсний хэлтсийн дарга;

-Дэд бүтцийн яамны Стратегийн нэгдсэн төвлөлтийн газрын дарга;

-Монгол банкны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого,хамтын ажиллагааны газрын дарга;

-Улаанбаатар хотын ерөнхий менежер;

-"ХААН" банкны дэд захирал;

-Монголын худалдаа,аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);

-Монголын мах экспортлогчдын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын ноос, ноолуурын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын эд хэрэглэгчдийн хоршоодын төв холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын орлогч дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 220 | Улаанбаатар хот

Улсын нөөцөөс гэр, автомашин гаргаж,нөхөн бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Байгалийн гамшиг, хүчтэй шуурга, гал түймэрт өртсөний улмаас гэр нь шатсан Төв аймгийн Эрдэнэсант сумын 3 дугаар багийн иргэн, өндөр настан А.Уртнасан, мөн аймгийн Цэцэл сумын 3 дугаар багийн иргэн О.Ганзориг нарт улсын нөөцөөс иж бүрэн гэр (давхар бүрээстэй, зуух, яндан, шалавчийн хамт) тус бүр нэгийг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 2 айлд иж бүрэн гэр (хөвөнтэй бүрээстэй, зуух, яндангийн хамт) тус бүр нэг, мөн сумын Засаг даргын Тамгын газарт өөрөө буулгагч ЗИЛ-555 самосвал машин нэгийг тус тус олгож энэ оны IY улиралд багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд, гэр, автомашины үнэ нийт 13300.0 (арван гурван сая гурван зуун) мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 221 | Улаанбаатар хот

Хэлэлцээрүүдийг батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Варшав хотноо гарын үсэг зурсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээр", "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хооронд шинжлэх ухаан, технологийн талаар хамтран ажиллах Хэлэлцээр"-үүдийг батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 222 | Улаанбаатар хот

Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-ын дагуу Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1-ний өдрөөс эхлэн 6 сарын хугацаатайгаар ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

Монголын үндэсний олимпийн хорооны конторын барилгыг барих ажлыг гэрээний дагуу гүйцэтгэж байгаа БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Барилгын ерөнхий компанийн мэргэжлийн 70 ажилчныг 2001 оны 6 дугаар сарын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

01 оны 10 дугаар рын 3-ны өдөр — Дугаар 223 — Улаанбаатар хот

Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох ажлыг дэмжих тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг мгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь сгийн 7 дахь заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх сгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын ісгийн газраас ТОГТООХ нь:

1. Хурдан удмын адууны байр, хашаа барих, чилгаа, маллагаа, тэжээл болон мал эмнэлгийн ьдчилан сэргийлэх арга хэмжээ, дасгал ргуулилттай холбоотой зардалд зориулан 28389.5 рин найман сая гурван зуун наян есөн мянга таван ун) мянган төгрөгийг 2001 оны 10 дугаар сард гтаан Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг анхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг лгосугай.

2. "Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох" төслийг 2002 оноос эхлэн Шинжлэх ухаан, технологийн төслийн жил бүрийн захиалгад оруулж санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

01 оны 10 дугаар рын 3-ны өдөр — Дугаар 224 — Улаанбаатар хот

Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Хүн амын эрүүл мэндийн боловсролыг эшлүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг лөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол ісын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл аж төрөх зан үйлийг лөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, рталчилгааны төлөвлөгөөг хавсралт ёсоор талсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах өнгийг 2002 оноос эхлэн улсын төвлөрсөн төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэрээс гаргахаар тооцож, уг асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ АЖ ТӨРӨХ ЗАН ҮЙЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

сар	№	Үйл ажиллагааны чиглэл	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны Хугацаа	Сэдэв	Хариуцах байгууллага
сар	1	Осол гэмтлээс сэргийлэх өдөр	1 дүгээр сарын 15-наас 10 хоног	"Осол гэмтлээс сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Дад бүтцийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	2	Мал төллөлтийн үе	2 дугаар сарын эхний хагас	"Малчдын эрүүл мэндийг дэмжье"	Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	3	Архидан согтуурахаас сэргийлэх 10 хоног	2 дугаар сарын сүүлийн хагас	"Ухаарал"	Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Батлан хамгаалах яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар

Гуравдугаар сар	4	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдөр	3 дугаар сарын эхний 7 хоног	"Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	5	Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих 7 хоног	3 дугаар сарын 2 дахь 7 хоног	"Эрчүүдээ хайрлая"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Батлан хамгаалах яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	6	3 дугаар сарын 22 Дэлхийн усны өдөр	3 дугаар сарын 3 дахь 7 хоног	"Ус- чандмань эрдэнэ"	Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	7	3 дугаар сарын 24 Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр	3 дугаар сарын сүүлийн 7 хоног	"Сүрьеэгийн халдвараас сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио телевизийн хэрэг эрхлэх газар
Дөрөв-дүгээр сар	8	4 дүгээр сарын 7 Дэлхийн эрүүл мэндийн өдөр	4 дүгээр сарын турш	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, тухайн сэдвээр холбогдох яамд
Тавдугаар сар	9	5 дугаар сарын 1 Хөдөлмөрийн өдөр	5 дугаар сарын эхний 10 хоног	"Эрүүл мэндийг дэмжигч ажлын байр"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Үйлдвэр, худалдааны яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	10	5 дугаар сарын 15 Олон улсын гэр бүлийн өдөр	5 дугаар сарын 2 дахь 10 хоног	"Эрүүл гэр бүл"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	11	Дархлаажуулалтын үндэсний өдрүүд	Үсарын сүүлийн 10 хоног , 10 дугаар сарын эхний 10 хоног	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	12	5 дугаар сарын 31 Тамхи татахгүй дэлхийн өдөр	5 дугаар сарын 4 дэх 7 хоног	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Санхүү, эдийн засгийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
Зургадугаар сар	13	6 дугаар сарын 1 Эх үрсийн баярын өдөр	6 дугаар сарын 1	"Эх, үрсийн эрүүл мэнд"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	14	6 дугаар сарын 5 Дэлхийн орчны өдөр	6 дугаар сарын эхний 7 хоног	"Цэвэр орчин"	Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яам, Дэд бүтцийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар

	15	Гэдэсний халдвараас сэргийлэх үе	6 дугаар сарын 2 дахь 7 хоног	"Гэдэсний халдвараас сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	16	6 дугаар сарын 27 Тамирчдын өдөр	6 дугаар сарын 3 дахь 7 хоног	"Хөдөлгөөн-эрүүл мэнд"	Эрүүл мэндийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	17	6 дугаар сарын 30 Мансууралтай тэмцэх олон улсын өдөр	6 дугаар сарын 4 дэх 7 хоног	"Мансуурлаас сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
Долдугаар сар	18	7 дугаар сарын 11 Дэлхийн хүн амын өдөр	7 дугаар сарын эхний хагас	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	19	Тарвага агналтын урьдал үе	7 дугаар сарын сүүлийн хагас, 8 дугаар сарын 2 дахь 10 хоног	"Тарваган тахлын халдвараас сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
Наймдугаар сар	20	8 дугаар сарын 1-7 Хүүхдийг хөхөөр хооллох дэлхийн долоо хоног	8 дугаар сарын эхний 10 хоног	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	21	Эмийн зохистой хэрэглээний 10 хоног	8 дугаар сарын сүүлийн 10 хоног	"Эмийг зохистой хэрэглэе"	Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
Есдүгээр сар	22	9 дүгээр сарын 1 Хичээлийн шинэ жилийн нээлт	9 дүгээр сарын эхний хагас	"Хүүхэд, залуучуудын эрүүл мэндийг дэмжье"	Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
	23	9 дүгээр сарын эхний Ням гариг Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний өдөр	9 дүгээр сарын эхний 7 хоног	"Иод дутлын эмгэгээс сэргийлье"	Эрүүл мэндийн яам, Үйлдвэр, худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	24	9 дүгээр сарын 24 Зүрхээ хамгаалах дэлхийн өдөр	9 дүгээр сарын сүүлийн хагас	"Зүрхээ хамгаалъя"	Эрүүл мэндийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
Аравдугаар сар	25	10 дугаар сарын 1 Ахмад настны өдөр	10 дугаар сарын эхний 7 хоног	"Ахмад настны эрүүл мэндийг дэмжье"	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	26	10 дугаар сарын 10 Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдөр	10 дугаар сарын 2 дахь 7 хоног	Жил бүр тодорхой сэдвээр	Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (232)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс барimtлах бодлогыг батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай*
- *Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арваннэгдүгээр сарын 20 №45 (232)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

537. Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай Дугаар 78 1018
538. Улсын Их Хурлын гишүүний туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай Дугаар 79 1018
539. Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 80 1018
540. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай Дугаар 81 1019

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

541. Лувсан-Осорын Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 74 1022
542. Начингийн Баасанжавт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай Дугаар 75 1022
543. Пүрэвдоржийн Цэрэндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай Дугаар 76 1023
544. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 77 1023
545. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 78 1023
546. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 79 1028

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

547. Хөрөнгө гаргах тухай Дугаар 225 1029
548. Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай Дугаар 226 1029
549. Шагналын журмыг шинэчлэн батлах тухай Дугаар 227 1030
550. Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 228 1033
551. Үндсэн хөрөнгө худалдах тухай Дугаар 230 1033
552. Ажлын хэсэг байгуулах тухай Дугаар 231 1034
553. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 232 1034
554. Албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 233 1038
555. Хөрөнгө гаргах тухай Дугаар 234 1038
556. Өрх, хүн амын орлого, зарлагын мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 235 1038
557. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 237 1039
558. Журамд нэмэлт оруулах тухай Дугаар 238 1039
559. Баян-Өлгий аймгийн иргэдийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 240 1040

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 78 **Улаанбаатар хот**

Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн өндөр албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2500 төгрөгөөр нэмэгдүүлэн тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 79 **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын гишүүний туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүний туслахын албан тушаалын цалингийн хэмжээг 2500 төгрөгөөр, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын цалингийн хэмжээг 3000 төгрөгөөр 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус нэмэгдүүлэн тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 80 **Улаанбаатар хот**

Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 2 дугаар хавсралтаар 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалт, "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2000 оны 1 дүгээр сарын 20 ны өдрийн 12 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 80 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр)
1	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	98544
2	Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч	90225
3	Улсын дээд шүүхийн шүүгч	85990
4	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	82663
5	Нийслэлийн шүүхийн шүүгч	76008
6	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	72680
7	Дүүргийн шүүхийн шүүгч	69353
8	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	79335
9	Аймгийн шүүхийн шүүгч	73588
10	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	72680
11	Сум, сум дундын шүүхийн шүүгч	69353

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 80 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр)
1	Ерөнхий прокурор	96044
2	Ерөнхий прокурорын орлогч	85990
3	Ерөнхий прокурорын газрын туслах прокурор	83065
4	Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	76379
5	Нийслэлийн прокурор	82663
6	Нийслэлийн прокурорын орлогч	76008
7	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	71250
8	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	70000
9	Дүүргийн ахлах прокурор	72680
10	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	69353
11	Аймаг, тээврийн прокурор	79335
12	Аймаг, тээврийн прокурорын орлогч	73588
13	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	71250
14	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	70000
15	Сум, сум дундын ахлах прокурор	72680
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	69353

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хавсралтын ёсоор батлуулсугай.

2.Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулсантай холбогдуулан арааахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх;

2/Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, 2002 оны II улиралд багтаан батлэх хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь байгаль, хүн, нийгмийн зохицлыг хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Нийгмийн эрүүл мэндийг төлөвшүүлэх гэж хүний амьдралын чанарын түвшинд сөргөөр нөлөөлж, өвчин, эмгэг, осол, гэмтэлд хүргэж буй нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлээс сэргийлэх, шалтгаан, үр дагаврыг арилгах, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн нөөц, бололцоог зүй зохистой ашиглах үйл ажиллагааг хэлнэ.

1.3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зөвхөн өвчин эмгэгийг эрт илрүүлэх, тегс эмчлэх тедийгүй, эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх нь хүний хөгжлийн чухал хэсэг болох нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл болно.

1.4. Энэхүү бодлого нь ойрын 10-15 жилийн хугацаанд нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлох үндсэн баримт бичиг мөн.

Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн зарчим

2.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

2.1.1. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг стандартчилж, чанар, тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;

2.1.2. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн хувьд үр дүнтэй, нийгмийн хувьд үр нөлөөтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх;

2.1.3. нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа нь нийтээр хүлээн зөвшөөрсөн дэвшилтэт технологи, уламжлалд тулгуурласан хямд, энгийн байх;

2.1.4. улсын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан, нэгдсэн сүлжээг бий болгох;

2.1.5. нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан сайн түншлэлийг хөгжүүлэх;

2.1.6. нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагын эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг өргөжүүлж, удирдлагын төвлөрлийг сааруулах.

2.2. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын болон бусад тусламж, дэмжлэгээр санхүүжүүлнэ.

Гурав. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл

3.1. Нийгмийн эрүүл мэндийн бодлого нь дараахь чиглэлээр хэрэгжинэ:

3.1.1. хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй, энгийн арга хэлбэрээр өөрсдийг нь оролцуулах замаар эрүүл мэндийн анхны тусламжийг хөгжүүлэх;

3.1.2. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэдэг зан үйлтэй болгох ажиллагаа бүх талаар хөгжүүлэх;

3.1.3. хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцлийг бүрдүүлэх;

3.1.4. эрүүл мэндийн салбарын тогтолцоог нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглүүлэн боловсронгуй болгож нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын шинэчлэлийг хийх.

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам

4.1. Эрүүл мэндийн анхны тусламж

4.1.1. Сум, баг, ерхийн эмнэлгийг бэхжүүлж, чадамжийг нь дээшлүүлэх, өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар эрүүл мэндийн анхны тусламжийн чанар, тэгш, хүртээмжтэй байдлыг хангана.

4.1.2. Хүн амын эмзэг хэсгийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, хүмүүнлэг, эелтэй тусламж, үйлчилгээг дэмжинэ.

4.1.3. Гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржих, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартыг хангана.

4.1.4. Хүүхдийг хөхөөр хооллох, гэр бүл, нийгмийн орчинд өсгөн бойжуулах, асран хамгаалах, эрүүл өсгөх таатай орчин бүрдүүлэн тэдний бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжилтийг хангана.

4.1.5. Хүн амыг стандарт, эрүүл ахуйн хэм хэмжээнд тохирсон унд, ахуйн усаар найдвартай хангах, усны эх булгийг бохирдлоос хамгаалах нөхцлийг бүрдүүлнэ.

4.1.6. Халдварт өвчний тандалт, мэдээллийг сайжруулж, дэгдэлтийг орон нутгийн хэмжээнд таслан зогсоох чадамжийг дээшлүүлэн. дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлж, зонхилон тохиолдож буй халдварт өвчнөөс сэргийлэх, дархлаажуулах бэлдмэлийг туршин нэвтрүүлнэ.

4.1.7. Хүн ам, ялангуяа түүний эрсдэл ихтэй бүлгийн дунд тандан шинжих аргыг нэвтрүүлж, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэгийн тархалтыг бууруулна.

4.1.8. Мал, амьтнаас хүнд халдварладаг брүцеллёз, тарваган тахал, боом, галзуу, бэтэг зэрэг болон шинэ, дахин сэргэх бүй халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.

4.1.9. Төв, суурин газраас хэт алслагдсан нутаг, говийн бүсийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээ тэгш, хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлнэ.

4.1.10. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол, олон хүний амь насанд аюул учруулах халдварт өвчний үед хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангана.

4.1.11. Сэргийлэх үзлэгийн хүрээг өргөтгөж, удамшлын эмгэг, зүрх судас, мэдрэлийн өвчин, хорт хавдар зэргийг эрт илрүүлэх, төгс эмчлэх орчин үеийн аргыг нэвтрүүлнэ.

4.1.12. Хүн амыг чанарын баталгаатай, зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр тасралтгүй, хүртээмжтэй, жигд хангах нөхцлийг бүрдүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

4.1.13. Монгол хүн амьдралынхаа туршид тэжээллэг чанар бүхий аюулгүй, экологийн цэвэр хоол, хүнсээр хангагдах, зөв хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.2. Эрүүл мэндийн боловсрол, зан үйлийн төлөвшил

4.2.1. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх албан болон албан бус сургалтыг боловсронгуй болгоно.

4.2.2. Эрүүл мэндийг дэмжигч хамт олон болох иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл, санаачлагыг бүх талаар дэмжинэ

4.2.3. Улсын бүртгэлд ороогүй, стандарт, эрүүл ахуйн хэм хэмжээнд нийцээгүй үйлчилгээ, бүтээгдэхүүний зар сурталчилгаанд мэргэжлийн хяналт тавих эрх зүйн орчин бүрдүүлнэ.

4.2.4. Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх, буруу зан үйлийг өөрчлөх замаар зүрх судасны өвчин, хорт хавдар, осол, гэмтлийг бууруулна.

4.2.5. Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдрыг чийрэгжүүлэх чиглэлээр хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, хувь хүний үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, идэвх санаачлагыг дэмжинэ.

4.2.6. Гэр бүл, хамт олон, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжиж, бухимдал, хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх замаар хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаална.

4.3. Орчны эрүүл мэнд

4.3.1. Хүн амын суурьшил, нягтрал, хот төлөвлөлтөнд хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцох, эрүүл ахуйн хэм хэмжээ, стандартад нийцүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

4.3.2. Хот, суурин газрын агаарын бохирдлыг багасгах, шалтгаан, үр дагаварыг арилгахад чиглэсэн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үүнийг төрөөс хөхүүлэн дэмжиж хэрэгжүүлэх замаар хүн амыг амьсгалын эрхтний цочмог болон архаг өвчнөөс сэргийлнэ.

4.3.3. Хот, суурин газрын нийтийн эзэмшлийн газрыг зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх замаар хүн амд ногдох ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлнэ.

4.3.4. Бохир усны сүлжээ, татуурга, цооног, бие засах газрын стандарт, эрүүл ахуйн хэм хэмжээг хангаж, хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийн техник, технологийг сайжруулна.

4.3.5. Ахуйн болон үйлдвэрлэлийн ердийн, хатуу хог хаягдлыг ангилах, боловсруулах, хаях, булшлах технологийг боловсронгуй болгох замаар хөрсийг бохирдлоос хамгаална.

4.3.6. Эрүүл мэндийг хамгаалах үүднээс химийн хортой болон цацраг идэвхт бодис, нянгийн өсгөвөр, эмнэлгийн болон бусад халдвартай хог хаягдлыг байгаль орчинд аюулгүйгээр зайлуулан устгана.

4.3.7. Үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хэм хэмжээ, стандартыг хангаснаар хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослыг бууруулна.

4.4. Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт

4.4.1. Энэ бодлогод нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

4.4.2. Зохион байгуулалтын оновчтой, тогтвортой бүтцийг улсын болон бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бий болгож хөгжүүлнэ.

4.4.3. Нийгмийн эрүүл мэндтэй холбоо бүхий Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийн уялдааг сайжруулан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.4.4. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг архи, тамхины онцгой албан татварын тодорхой хэсгийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.

4.4.5. Нийгмийн эрүүл мэндийн хүний нөөц, санхүү, мэдээллийн удирдлагын чадамжийг бэхжүүлж, хөгжлийг хангана.

4.4.6. Нийгмийн эрүүл мэндийн сургалтын төв, сургууль байгуулж, үндэсний боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог бий болгож, сургалтыг боловсролын талаарх төрийн бодлоготой уялдуулан зохион байгуулна.

4.4.7. Эрүүл мэндийн анхан шатны байгуулагыг эрүүл мэндийг дэмжих төв болгон өөрчлөх, зүрх судасны өвчин, осол, гэмтэл, хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хоолны сувилалын төв зэргийг одоогийн бүтэц дээр тулгуурлан шинэчлэн зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг давамгайлан хөгжүүлнэ.

4.4.8. Нийгмийн эрүүл мэндийн лабораторийг үе шаттайгаар байгуулж, чадамжийг нь дэвшлүүлнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж боловсруулах, тэдгээрийг цаашид боловсронгуй болгоход Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг үндэс болгоно.

5.2. Энэхүү бодлогыг Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамруулж, тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Дугаар 74 Улаанбаатар хот

Лувсан-Осорын Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Төмөр замын тээвэрт илчит тэрэгний машинчаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, галт тэрэгэр зорчигч болон ачаа тээвэрлэх хариуцлагатай үүргийг мэргэжлийн өндөр ур чадвар гарган гүйцэтгэж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөт даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагаанд хангахад оруулж байгаа жилээс хойш нэмрийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын зүтгүүрийн депогийн машинч Лувсан-Осорын Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Дугаар 75 Улаанбаатар хот

Начингийн Баасанжавт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, зүрх судасны өвчний оношлогоо, эмчилгээний дэвшилтэт аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж, олон мянган хүнийг мэс заслын аргаар эмчлэн эдгэрүүлэх, зүрх судасны мэс заслын албыг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны хүрээлэнгийн төслийн удирдагч, клиникийн III эмнэлгийн мэс заслын ерөнхий эмчээр эмч Начингийн Баасанжавт Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр **Дугаар 76** **Улаанбаатар хот**

Пүрэвдоржийн Цэрэндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, жүжиг, киноны олон арван өвөрмөц дүрийг үзэгчдийн сэтгэлд хоногштол чадамгай бүтээж, тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин Пүрэвдоржийн Цэрэндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр **Дугаар 77** **Улаанбаатар хот**

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Боловсрол, урлаг, үйлчилгээний байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, улс орноо хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛООР:

1. Намсрайжавын Алтангэрэл - Улсын багшийн их сургуулийн физик-технологийн тэнхмийн эрхлэгч

2. Дорждэрэмийн Санжсүрэн - Батлан хамгаалахын их сургуулийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛООР:

1. Намсрайн Сувд - Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

2. Лувсанчойдорын Мөнхцэцэг - Сонгодог урлагийн академик театрын гоцлол хөгжимчин

МОНГОЛ УЛСЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛООР:

Банзрагчийн Моюу - Улаанбаатар хотын Гаалийн газрын улсын байцаагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр **Дугаар 78** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Боловсрол, эрүүл мэнд, үйлдвэрлэл, үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, биеийн тамир, спорт, төвөөр, аялал жуулчлал, төрийн бусын төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Лхамсүрэнгийн Алтанцэцэг - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Амгалан-Амар" өөдлын үйлдвэрийн технологич мастер

3. Цэдэндоогийн Буянбат - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч

2. Авирмэдийн Батжаргал - Увс аймгийн авто зам, засвар арчлалтын " АЗЗА - Увс" ХХК -ийн автогрейдерчин

4. Айнаахүүгийн Гажийзаа - Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн больницын зөвлөх эмч

5. Адуучийн Гантогтох - Нийслэлийн 93

дугаар дунд сургуулийн бага ангийн багш

6. Шаравын Готов - Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн унтуулга, сэхээн амьдруулах тасгийн эрхлэгч, их эмч

7. Түвдэнгийн Даваасамбуу - Ховд аймгийн " Шим - Ус" ХХК-ийн ерөнхий инженер

8. Жамбын Дашдондог - Монголын хүүхдийн соёлын сангийн тэргүүн

9. Навааныы Дондог - Халдварт өвчин судлалын төвийн эмч

10. Өвгөний Жүгдэр - Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эх барих, эмэгтэйчүүдийн клиникийн зөвлөх эмч

11. Мядагийн Нэргүй - Нийслэлийн Оёдлын үйлдвэрийн "Бүтээлч үйлс " ХХК-ийн гүйцэтгэх захирал

12. Чойндонгийн Онгоодой - Худалдаа, үйлдвэрийн дээд сургуулийн орой , эчнээ салбарын эрхлэгч

13.Раднаасэдийн Санжаасүрэн - Монгол улсын их сургуулийн Шинэ материалын хими, технологийн төвийн захирал

14. Лэгцэгийн Сандай - Дундговь аймгийн Сайнцагаан сумын " Говийн тэнгэр" ХХК-ийн ерөнхий захирал

15.Балдандоржийн Сумъяабаатар - ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч

16.Чимидцэрэгийн Пунцаг - Анагаах ухааны их сургуулийн тэнхмийн эрхлэгч, багш

17.Дүгэрсүрэнгийн Хишгээ - Улсын багшийн их сургуулийн Биеийн тамирын дээд сургуулийн гимнастикийн тэнхмийн эрхлэгч

18. Жамцын Хишигсүрэн - Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга бөгөөд чанд авиа зүйч эмч

19.Содовын Цэвээнпүрэв - Улаанбаатар коллежийн дэд захирал

20. Думилын Цэдэн-Иш - Нийслэлийн 28 дугаар дунд сургуулийн математикийн багш

21. Цэндийн Цэцгээ - Монголын радиогийн нэвтрүүлэгч

22. Жийжээдоржийн Чойжил - Улсын багшийн их сургуулийн проректор

23. Даваагийн Чойжилсүрэн - Баянхонгор аймгийн барилга угсралт, засварын "Навтгархайрхан"ХХК-ийн захирал

24. Донидын Шагдар - Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч

25. Номтын Юнгэр – Увс аймгийн Хөдөө аж ахуйн газрын үржлийн албаны ерөнхий мал зүйч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Лувсангийн Алтанцэцэг – Орхон аймгийн Баян-Өндөр сумын"Топ стиль" салоны үсчин

2. Балдандоржийн Баасандорж – Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

3. Дуламсүрэнгийн Баасанхүү – Увс аймгийн Улаангом сумын"Эрүүл мэнд" хувийн эмнэлгийн эмч

4. Чүлтэмсүрэнгийн Баатаржав - Дархан-Уул аймгийн Барилга, үйлдвэрийн нэгдлийн ерөнхий захирал

5. Бат-Очирын Банзрагч - Нийслэлийн "Эсгий гутал" ХК-ийн засварчин

6. Баасанжавын Барамсай – Хүнсний технологийн коллежийн захирал

7. Данзангийн Батаа - Булган аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дарга

8. Тогоогийн Батхүлэг - Баянхонгор аймгийн Баянговь сумын 3 дугаар багийн малчин

9. Цэндээхүүгийн Бат-Өлзий – Өмнөговь аймгийн гаалийн хорооны гаалийн улсын байцаагч

10. Дашсугарын Батхуяг - Дархан-Уул аймгийн "Дархан-Рашаан" орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын инженер

11. Батсүхийн Болормаа – Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

12. Жанчивдоржийн Булган – Улаанбаатар хотын Гаалийн газрын сургалт, судалгааны төвийн захирал

13. Дэмидийн Бямбасүрэн – Улсын номын сангийн мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн эрхлэгч

14. Нанзадын Бямбасүрэн – Улаанбаатар төмөр замын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч

15. Пэрэнлэйн Бат-Өлзий - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн

газрын дарга

16. Дэчингийн Володя – Хэнтий аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын слесарьч

17. Очирбатын Галдансамбуу - Гаалийн ерөнхий газрын Тамгын хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

18. Ядамын Ганбаатар – Нийслэлийн "Автобус-3" компанийн ерөнхий нягтлан бодогч

19. Дулмаагийн Ганхуяг – Сонгодог урлагийн академик театрын гоцлол дуучин

20. Найдангийн Гунаажав – Завхан аймгийн Барилгын "Бэрсүм" ХХК-ийн захирал

21. Жамбалын Гунгааням - "Монгол эм импекс" концернийн Орхон аймаг дахь "Орхон" компанийн захирал

22. Отрядын Гүндэгмаа – Зэвсэгт хүчний 311 дугээр ангийн операторч, буудлагын спортын тамирчин

23. Хахааны Давис – Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн "Толгойт-Өргөө" компанийн захирал

24. Бичээрэйн Далай - "Монголчехословак-металл" хамтарсан үйлдвэрийн ерөнхий захирал

25. Догсомын Дариа - Улаанбаатар хотын Гаалийн газрын дарга

26. Санжаажавын Дашдаваа - Орхон аймгийн "Хүүхэлдэйн театр-Эрдэнэт" чуулгын гоцлол дуучин

27. Жагдагийн Дашдондог - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын "Аварга тосон" сувиллын захирал

28. Сандуйжавын Дашдондог - "Нефть импорт концерн" ХХК-ийн дэд захирал

29. Гаадангийн Дунбүрээ - Монголын урчуудын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч, зураач

30. Мягмарын Жанцан - Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын зөвлөх багш

31. Бэх-Очирын Жаргалсайхан - Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

32. Шуумарын Жийдээ - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга

33. Балсангийн Занаа - Нийслэлийн "Жуулчин" ХК-ийн жолооч

34. Ванчингийн Заншир - Увс аймгийн гаалийн хорооны дарга

35. Дамбын Зундуй - Нийслэлийн "Улаанбаатар зам засвар" ТӨҮГ-ын жолооч

36. Жамъянжавын Зүмбэрэл - Нийслэлийн "Талх чихэр" ХК-ийн засварчин

37. Цэнд-Аюушийн Ломбо - Орхон аймгийн музейн захирал

38. Чойжилсүрэнгийн Лундаа - Баянхонгор аймгийн "Хаш-Өргөө" ХХК-ийн ерөнхий инженер

39. Дансранжавын Лхагва - Монгол-Солонгосын техникийн коллежийн захирал

40. Даваанямын Лхагвасүрэн - Хөвсгөл аймгийн "Хөвсгөл жуулчин" ХХК-ийн орлогч захирал бөгөөд ерөнхий инженер

41.Юмчингийн Мөнх-Очир - "Монгол шуудан" компанийн инженер

42.Лувсанжамъянгийн Мягмар - Нийслэлийн "Монгол лифт" компанийн захирал

43.Цэдэвдоржийн Намсрай - Сонгодог урлагийн академик театрын найрал дуучин

44.Намжилмаагийн Намхайнар - Өмнөговь аймгийн Дулааны цахилгаан станцын албаны дарга

45.Банзарын Нацагдорж - Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

46.Цоодолын Нацагням - Үндэсний жүжгийн академик театрын нүүр хувиргагч

47.Гомбосүрэнгийн Онон - Сонгодог урлагийн академик театрын гоцлол бүжигчин

48.Рагчаагийн Оюунчимэг - Улсын клиникийн төв эмнэлгийн тасгийн эрхлэгч

49.Чойжоогийн Ранаажав - Үндэсний жүжгийн академик театрын тайзны машинч

50.Гэндэнпэлийн Сумъяа - Сэтгэл мэдрэлийн улсын диспансерийн сувилагч

51.Лхагважавын Сүхбаатар - Улсын филармонийн "Баян монгол" чуулгын хөгжимчин

52.Мангалын Сэдрагчаа - Нийслэлийн "Үндрам-Сэд" ХХК-ийн захирал

53.Цэрэнгийн Тогтохраважих - Дорнод аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын жолооч

54.Пунцагийн Тогоо - Улсын клиникийн төв эмнэлгийн тасгийн эрхлэгч, их эмч

55.Жадамбын Төмөртогоо - Өвөрхангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн орлогч захирал, зөвлөх эмч

56.Барсын Туяа - Монголын радиогийн

сурвалжлагч

57.Рэнчингийн Түмэнцэцэг - Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчин

58.Жамцын Ухнаа - Дорнод аймгийн гаалийн газрын Эрээнцавын салбарын эрхлэгч, гаалийн улсын байцаагч

59.Шаравын Пүрэв - Ховд аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын техникч

60.Гомбын Пүрэвсүрэн - Дэчинчойнхорлин хийдийн хамба лам, Монголын зурхайчдын холбооны тэргүүн

61.Балдангийн Пүрэвхүү - Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн газрын ерөнхий инженер

62.Лувсангийн Хүрэлбаатар - Нийслэлийн "Моносфарм" ХХК-ийн ерөнхий захирал

63.Есимханы Хатран - Сэлэнгэ аймгийн Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн дэд захирал

64.Батжаргалын Цогтсайхан - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын хүн эмнэлгийн эмч

65.Равжаагийн Цэвээн - Нийслэлийн "Алтан тэвш-Өргөө" компанийн захирал

66.Зундуйн Цэен-Ойдов - Нийслэлийн "Эрдэнэ зам" ТӨҮГ-ын ахлах менежер

67.Пүрэвийн Цэндсүрэн - Сэлэнгэ аймгийн гаалийн газрын гаалийн улсын байцаагч

68.Дэмбэрэлийн Цэрмаа - Булган аймгийн Булган сумын 2 дугаар дунд сургуулийн зөвлөх багш

69.Галсанжамцын Цэрэн - Завхан аймгийн "Улиастай-Тэгш" ХК-ийн агрономч

70.Дондийн Цэрэнжамц - Нийслэлийн "Говь" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

71.Дамдингийн Цэрэннадмид - Орхон аймгийн "Хүүхэлдэйн театр-Эрдэнэт" чуулгын гоцлол бүжигчин

72.Дарамсэдийн Цэрэнсамбуу - Үндэсний жүжгийн академик театрын дэд захирал

73.Амарзаягийн Чойбаатар - Нийслэлийн Ус суваг, ашиглалтын газрын машинч

74.Дамирангийн Чойжилсүрэн - Увс аймгийн Тэс сумын дунд сургуулийн биеийн тамирын багш

75.Нагирын Чойжамц - Улсын клиникийн төв эмнэлгийн хүлээн авахын эмч

76.Дашдоржийн Чойжилжав - Орхон аймгийн "Эрдэнэт хивс" ХХК-ийн ахлах зохион байгуулагч, зураач

77.Шагдарын Чулуундорж - Нийслэлийн 2 дугаар цахилгаан станцын машинч

78.Нацагийн Чимэддорж - Нийслэлийн "Шилмэл гоёл" хоршооны дархан

79.Тумагийн Янжмаа - Ховд аймгийн Зэрэг сумын хүн эмнэлгийн бага эмч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Намгирын Андрей - Нийслэлийн Халаалтын зуухны ашиглалтын газрын механикч

2.Нанзадын Аръяа - Нийслэлийн Ус суваг, ашиглалтын газрын инженер

3.Түндэвийн Баажаахүү - Улаанбаатар төмөр замын Эрдэнэт-Дархан өртөөний орлогч дарга

4.Баянцагааны Баатар - Үндэсний жүжгийн академик театрын ерөнхий найруулагч

5.Балдан-Осорын Бадарч - Шинжлэх ухаан, техник мэдээллийн төв корпорацийн цахилгааны инженер

6.Бүрэнтөгсийн Бадарч - Сэлэнгэ аймгийн Хөтөл тосгоны Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын засварчин

7.Лувсанжумбын Балганшош - "Монгол шуудан" ТӨҮГ-ын менежер

8.Түвдэнгийн Балчинжав - Нийслэлийн "Эрдэнэ зам" ТӨҮГ-ын жолооч

9.Догоогийн Батням - Нийслэлийн "Эсгий гутал" ХК-ийн ажилчин

10.Анандын Баясгалан - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цэцэрлэгийн эрхлэгч

11.Жамъянсамбуугийн Буддорж - Нийслэлийн 3 дугаар цахилгаан станцын машинч

12.Дашзэвэгийн Бямбаа - Гаалийн ерөнхий газрын нефть онцгой албан татварын гаалийн газрын гаалийн улсын байцаагч

13.Дүгэржүржийн Бямбасүрэн - Нийслэлийн "Бат бэх" компанийн үсчин

14.Намжилын Ванчин - Орхон аймаг дахь Эрдэнэтийн цахилгаан шугам сүлжээний газрын монтёрч

15.Доржийн Володя - Улаанбаатар төмөр замын Дархан өртөөний 1 дугээр ангийн механикч

16.Содномдоогийн Галсанжамц - Завхан аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын жолооч

17.Жамъяндоржийн Ганбаатар - Нийслэлийн авто зам, засвар арчлалтын "Ялгуусан" ХХК-ийн замчин

18.Цэгмидийн Ган-Оюу - Хэнтий аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын жолооч

19.Дүгэрсүрэнгийн Гансүрэн - Нийслэлийн "Номин зэрэглээ" ХХК-ийн "Дервөн уул" худалдааны төвийн эрүүл ахуйч, их эмч

20.Цэрэндэжидийн Ганхуяг - Нийслэлийн "Эрчим хүч барилга угсралтын трест" ХК-ийн монтёр

21.Лхагвын Гүндсамбуу - Булган аймгийн Орхон сумын малчин

22.Чойжилжавын Гүнрэгжав - Завхан аймгийн Тэс сумын малчин

23.Чимэдийн Даваа - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын өндөр настан

24.Батын Даваадорж - Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын уран сайхны удирдагч

25.Балдангийн Дариймаа - Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин

26.Ламжавын Дашдорж - Нийслэлийн "Баянгол зочид буудал" ХК-ийн сантехникийн механикч

27.Юндэнгийн Дашхүү - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хувираа хөдөлмөр эрхлэгч

28.Дарийн Долгорцэрэн - Нийслэлийн "Говь" ХК-ийн чанар шалгагч

29.Алтанхуягийн Дондовсамбуу - Нийслэлийн "Шилмэл гоёл" хоршооны дарга

30.Дүгэрсүрэнгийн Дуламсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн 2 дугаар төвийн бариа заслын эмч

31.Дашнямын Дуламханд - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн бус эмчилгээний тасгийн эрхлэгч, их эмч

32.Өлзийн Дулмаа - "Эрэл" ХХК-ийн Дархан-Уул аймаг дахь цементийн үйлдвэрийн ажилчин

33.Аварзэдийн Жаалтар - Орхон аймгийн гаалийн газрын гаалийн улсын байцаагч

34.Чүлтэмдагвын Жаргалсайхан - Гаалийн ерөнхий газрын Буянт-Ухаа дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч

35.Намдагийн Жинсодов - Увс аймгийн Баруунтуруун сумын "Улаан сан" ХК-ийн засварчин

36.Жамъянгийн Загдсүрэн - Ховд аймгийн Нефть хангамжийн баазын механикч

37.Шаравын Зандраа - Улаанбаатар хотын Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

38.Бадамын Зундуйхүү - Улаанбаатар төмөр замын Дархан өртөөний дохиолол холбооны ахлах инженер

39.Жигмэдданзангийн Ичинноров - Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн газрын зэлжийн инженер

40.Моломын Лувсан-Очир - Сэлэнгэ аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дулааны инженер

41.Банзрагчийн Лхамсүрэн - Нийслэлийн шуудан холбооны 49 дүгээр салбарын эрхлэгч

42.Дагвын Лхамсүрэн - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын өндөр настан

43.Монхорын Мандаа - Говь-Алтай аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын слесарьч

44.Жүгдэрийн Мандал - Дорнод аймгийн Сэргэлэн сумын малчин

45.Сүхийн Мөнхбаяр - Улсын филармонийн "Баян монгол" чуулгын хөгжимчин

46.Шадавын Оюун - Үндэсний жүжгийн академик театрын гэрлийн операторч

47.Дамдинсүрэнгийн Оюунбилэг - Улсын төв номын сангийн дэд захирал

48.Санжаагийн Өлзийхүү - Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

49.Мишигийн Пүрэв - Гаалийн ерөнхий газрын Тамгын хэлтсийн гаалийн улсын байцаагч

50.Даваажанцангийн Саранчимэг - Улсын төв номын сангийн ахлах номын санч

51.Чимэддоржийн Содном-Очир - Нийслэлийн "Бат зам" ХХК-ийн механизмчин

52.Бадамдоржийн Сүрэн - Баянхонгор аймгийн Баянговь сумын хүн эмнэлгийн дүн бүртгэгч бага эмч

53.Түдэвийн Сэлэнгэ - Гаалийн ерөнхий газрын Буянт-Ухаа дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч

54.Хөхийн Тогтох - Увс аймгийн

Баруунтуруун сумын малчин

55.Сэмбээгийн Туулай - Увс аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын слесарьч

56.Бямбадоржийн Туяа - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч

57.Чимэдийн Үнэнбат - Нийслэлийн "Жуулчин" ХК-ийн жолооч

58.Танхайн Хибатдолда - Баян-Өлгий аймгийн гаалийн газрын гаалийн улсын байцаагч

59.Намсрайн Хишигжаргал - Хэнтий аймгийн "Хэнтий хангай" ХХК-ийн бригадын дарга

60.Нонжийн Хоролсүрэн - Орхон аймгийн "Эрдэнэт хүнс" ХХК-ийн эрүүл ахуйч эмч

61.Амгаагийн Хүрэлсүх - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Иргэдийн төлөөлөгдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

62.Надмидын Цагаанхүү - Ховд аймгийн "Бадамлах дел" ҮҮГ-ын засварчин

63.Бавуугийн Цэдэнбал - Улаанбаатар төмөр замын Дархан өртөөний дарга

64.Дагвын Цэндсүрэн - Булган аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын бригадын дарга

65.Самдангийн Цэрэндолгор - Өвөрхангай аймгийн Тарагт сумын малчин

66.Магваны Цэцэгмаа - Нийслэлийн "Говь" ХК-ийн ажилчин

67.Жанцандоржийн Чимэдбавуу - Нийслэлийн Орон сууц нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 6 дугаар конторын слесарьч

68.Дашбалбарын Чимэддорж - Говь-Алтай аймгийн Чандмань сумын хүн эмнэлгийн дүн бүртгэгч бага эмч

69.Агвааны Чулуунбаатар - Дорнод аймгийн гаалийн газрын хэлтсийн дарга

70.Халтарын Чулуунбаатар - Гаалийн ерөнхий газрын нефть онцгой албан татварын газрын гаалийн улсын байцаагч

71.Хайсвайн Шоот - Ховд аймгийн Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын слесарьч

72.Чагтсүрэнгийн Шүрэнцэцэг - Нийслэлийн "Жигүүр-Гранд" ХХК-ийн засалчин

73.Цэрэндагвын Энхбат - Гаалийн ерөнхий газрын Буянт-Ухаа дахь гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч

74.Ёндонжамцын Энхтөр - Орхон аймгийн "Эрдэнэт хивс" ХК-ийн гүйцэтгэх захирал

75.Ойдовжамцын Энхтуул - Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин

76.Чадраабалын Энхтуяа - Гаалийн ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсийн дарга

77.Цэвэгдоржийн Эрдэнэбат - Үндэсний жүжгийн академик театрын гэрлийн найруулагч

78.Дэнсмаагийн Энэбиш - Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын хүн эмнэлгийн их эмч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр **Дугаар 79** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Европын Холбоонд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Европын Холбоонд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содовын Ононг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 225 | Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт тусгагдсан Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх тухай заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгахад шаардагдах 14.7 (арван дөрвөн сая долоон зуун мянга) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 226 | Улаанбаатар хот

Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай

"Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 60 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. АНУ, бусад улс орон, тэдгээрийн болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай алан хядагчдын санхүүжилтийн эх үүсвэрийг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байгаагаа нотлон илэрхийлж үйл ажиллагаагаа Монгол банктай уялдуулан зохицуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенцид нэгдэн орох арга хэмжээ авахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

3. Терроризмын эсрэг дэлхийн улс түмэн хүч чармайлтаа нэгтгэхийг уриалсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохиож НҮБ-д эргэж мэдээлэхийг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

4. Террористуудын талаар болон тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр болсон хар тамхи, мөнгө угаах үйл ажиллагааны талаар эвсэлд орсон улс орны холбогдох албадтай хуулийн хүрээнд мэдээлэл солилцох, хамтран ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж болон Тагнуулын ерөнхий газар /М.БАТСАЙХАН/-т тус тус үүрэг болгосугай.

5. Хоёр болон олон талын уулзалт, олон улсын хурал, зөвлөлгөөнд оролцох Монголын талын төлөөлөгчдийн удирдамжид терроризмтай тэмцэх талаархи Монгол Улсын төр, засгийн байр суурийг тодорхой илэрхийлэх асуудлыг тусгаж өгч байхыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд даалгасугай.

6. Эвсэлд орсон улс орнуудын зүгээс терроризмтай тэмцэх асуудлаар Монгол Улсаас тодорхой дэмжлэг туслалцааны талаар хүсэлт гаргавал түүнийг судлан даруй шийдвэрлэх арга хэмжээ авч байхыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 227** **Улаанбаатар хот**

Шагналын журмыг шинэчлэн батлах тухай

Урлагийн бүтээл, уран бүтээлчдийн ур чадварын үнэлэмжийг дээшлүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Олон улсын хэмжээнд зохиогддог урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэнд оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журмыг 1 дүгээр, шагналын хэмжээг 2 дугаар, шагналд хамрагдах урлагийн их наадам, уралдааны жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлуулсугай.

2.Олон улсын хэмжээнд болдог урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэнд оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагналд зарцуулагдах хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүр улсын төсвийн төсөлд тусган Соёл, урлагийн сангаар дамжуулан олгож байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шагналын журам батлах тухай" Засгийн газрын 1998 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 191 дүгээр тогоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2001 оны 227 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД БОЛДОГ УРЛАГИЙН ИХ НААДАМ, УРАЛДААН, ҮЗЭСГЭЛЭНД ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН УРАН БҮТЭЭЛЧДЭД МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Энэхүү журмын зорилго нь урлагийн бүтээл, уран бүтээлчдийн ур чадварын үнэлэмжийг дээшлүүлж дэлхийн жишигт хүргэх, урлагийн салбарт өндөр амжилт гаргах идэвх сонирхлыг өрнүүлэх, урлагийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулахад оршино.

2. Урлагийн төрлөөр олон улсын хэмжээнд болдог их наадам, уралдаан, үзэсгэлэн /цашид их наадам, уралдаан гэх/-д тэргүүн байр /гран при/, нэгдүгээр байр /алтан медаль/, хоёрдугаар байр /мөнгөн медаль/, гуравдугаар байр /хүрэл медаль/-т шалгарсан уран бүтээлчийг шагнахад энэхүү журмыг баримтална.

3. Уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох тухай асуудлыг их наадам, уралдааны албан ёсны тэмдэглэл, онцгой амжилт гаргасан тухай батламж /цом, гэрчилгээ, медаль, диплом, үнэмлэх гэх мэт/ болон энэхүү тогтоолын 3 дугаар хавсралтыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

4. Мөнгөн шагналд зориулах хөрөнгийг төлөвлөн жил бүрийн төсвийн төсөлд тусгуулж Соёл, урлагийн сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

5. Мөнгөн шагнал олгоход зориулсан хөрөнгөөс хэмнэгдсэн хэсгийг өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

6. Их наадам, уралдаанд хамтлагийн тоглолтоор оролцож, онцгой амжилт гаргасан тохиолдолд хамтлагийн гишүүн бүрт энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад заасан мөнгөн шагналын 25 хүртэл хувьтай тэнцэх шагнал олгоно.

7. Бүс нутгийн чанартай /аливаа улсын муж, дүүрэг зэрэг засаг захиргааны нэгжээс зохион байгуулж буй/ олон улсын урлагийн наадам, уралдаан, үзэсгэлэн энэ журамд хамаарахгүй.

8. Их наадам, уралдаанд оролцох бэлтгэл хангах зорилгоор уран бүтээлч нь мэргэжлийн багш, зөвлөх, холбогдох байгууллага, эсхүл ивээн тэтгэгчтэй хамтран ажилласан бол энэ журамд заасан шагналыг хуваарилах талаар тусган гэрээ байгуулж болно.

Засгийн газрын 2001 оны 227 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН УРАН БҮТЭЭЛЧДЭД ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

1. Сонгодог урлагийн төрлөөр шалгарсан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагналын хэмжээ

/сая төгрөг/

№	Их наадам, уралдаан, үзэсгэлэнгийн ангилал	Байр	Мөнгөн шагналын хэмжээ
1	"А" зэрэглэл	тэргүүн шагнал /гран при/	20.0
		нэгдүгээр байр /алтан медаль/	15.0
		хоёрдугаар байр /мөнгөн медаль/	10.0
		гуравдугаар байр /хүрэл медаль/	8.0
2	"Б" зэрэглэл	тэргүүн шагнал /гран при/	6.0
		нэгдүгээр байр /алтан медаль/	5.0
		хоёрдугаар байр /мөнгөн медаль/	4.0
		гуравдугаар байр /хүрэл медаль/	3.0

2. Урлагийн бусад төрлөөр шалгарсан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагналын хэмжээ

/сая төгрөг/

1	"А" зэрэглэл	тэргүүн шагнал /гран при/	15.0
		нэгдүгээр байр /алтан медаль/	10.0
		хоёрдугаар байр /мөнгөн медаль/	8.0
		гуравдугаар байр /хүрэл медаль/	6.0
2	"Б" зэрэглэл	тэргүүн шагнал /гран при/	4.0
		нэгдүгээр байр /алтан медаль/	3.0
		хоёрдугаар байр /мөнгөн медаль/	2.5
		гуравдугаар байр /хүрэл медаль/	2.0

Засгийн газрын 2001 оны 227 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД БОЛДОГ УРЛАГИЙН ИХ НААДАМ, УРАЛДААНЫ ЖАГСААЛТ

	Нэг. Сонгодог урлагийн их наадам, уралдаан	
"А" зэрэглэл	Бүжгэн жүжиг	
	1.Нью-Йоркод зохиогддог сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	2.Москвад зохиогддог сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	3.Парисын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	Дуу хөгжим	
	4.Москвад зохиогддог П.И.Чайковскийн нэрэмжит уралдаан	4 жил тутам
	5.Польшид зохиогддог Ф.Шопены нэрэмжит төгөлдөр хуурчдын уралдаан	2 жил тутам
	6.Италид зохиогддог дуурийн дуулаачдын уралдаан	Жил тутам
	7.ЮНЕСКО-гоос зохион байгуулдаг хөгжмийн зохиолчдын уралдаан	2 жил тутам
"Б" зэрэглэл	Бүжгэн жүжиг	
	8.Япон улсад зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	2 жил тутам
	9.Варнад зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	10.Шанхайд зохиогддог сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	Дуу, хөгжим	
	11.М.И.Глинкийн нэрэмжит дуурийн дуучдын уралдаан	2 жил тутам
	12.Римский-Корсаковын нэрэмжит дуурийн дуучдын уралдаан	2 жил тутам
	13.АНУ-д зохиогддог өсөврийн төгөлдөр хуурчдын уралдаан	жил тутам
	14.Францад зохиогддог өсөврийн төгөлдөр хуурчдын уралдаан	жил тутам
	15.Санкт-Петербургт зохиогддог Образцовагийн нэрэмжит олон улсын дуурийн залуу дуучдын уралдаан	2 жил тутам
	16.Уэска хотод зохиогддог олон улсын өсөврийн төгөлдөр хуурчдын уралдаан	жил тутам
	Хөөр.Урлагийн бусад төрлөөр зохиогддог их наадам, уралдаан	
"А" зэрэглэл	Цирк	
	17.Монте Карлод зохиогддог циркчдийн дэлхийн их наадам	жил тутам
	Кино	
	18.АНУ-ын кино урлагийн академиас зохион байгуулдаг их наадам	жил тутам
	19.Каннын их наадам	жил тутам
	20.Венецийн кино наадам	жил тутам
	Хүүхэлдэйн урлаг	
	21.Францад зохиогддог олон улсын хүүхэлдэйчдийн их наадам	3 жил тутам

"Б" зэрэглэл	Театр	
	22.Англий /Эдинбург/ олон улсын театрын уралдаан	4 жил тутам
	23.ОХУ-ын "Colden Mack"- театрын уралдаан	жил тутам
	Цирк	
	24.Санкт-Петербургт зохиогддог циркүдийн уралдаан	жил тутам
	25.Швейдийн хатан хааны нэрэмжит циркүдийн уралдаан	жил тутам
	26.Будапештэд зохиогддог циркүдийн уралдаан	жил тутам
	27.Цюрихт зохиогддог циркүдийн уралдаан	жил тутам
	28.Ухань, Учо хотуудад зохиогддог циркүдийн уралдаан	жил тутам
	29.Парис хотноо зохиогддог есвэрийн циркүдийн уралдаан	жил тутам
	30.Токиод зохиогддог кино наадам	2 жил тутам
	31.Ямагатад зохиогддог баримтат киноны их наадам	2 жил тутам
	32.Москвагийн киноны их наадам	2 жил тутам
	33.Берлиний баримтат киноны их наадам	3 жил тутам
	34.Фуку-Окод зохиогддог кино наадам	жил тутам
	Хүүхэлдэйн урлаг	
	35.Азийн орнуудын хүүхэлдэйн театруудын их наадам	2 жил тутам
	Эстрадын урлаг	
	36.Алма-Атад зохиогддог эстрадын дуу дуулаачдын "Азийн дуу хоолой" уралдаан	жил тутам
	37.Шанхайд зохиогддог эстрадын дуу дуулаачдын "Азийн дуу хоолой" уралдаан	жил тутам

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 228** **Улаанбаатар хот**

Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай 39,0 /гучин есөн/ сая төгрөгийг төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгож, банкны өр барагдуулах журмын дагуу төлөгдөх хөрөнгөөс төлүүлэх арга хэмжээ авах, тус биржид шаардлагатай эрэлтийн хөрөнгө бий болгох асуудлыг судалж шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Төрийн өмчийн зарим томоохон хувьцаат компанийн төрийн мэдлийн хувьцааны хяналтын багцаас бусад хэсгийг Монголын хөрөнгийн биржээр худалдаалах замаар тус биржийн санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлуудыг судалж шийдвэрлэхийг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 17-ны өдөр **Дугаар 230** **Улаанбаатар хот**

Үндсэн хөрөнгө худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Гаалийн ерөнхий газрын үндсэн

хөрөнгөд буртгэлтэй, улсын орлогын бараа хадгалж байсан А-1, А-2 агуулах, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай нефтийн бүтээгдэхүүний агуулахыг худалдахыг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 231 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын үйл ажиллагаа, худалдааны олон талт хэлэлцээнд Монгол Улсын баримтлах байр суурь, удирдамжийг боловсруулах, Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч - Үйлдвэр, худалдааны сайд

Гишүүд: -Санхүү, эдийн засгийн дэд сайд;

-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;

-Дэд бүтцийн дэд сайд;

-Гадаад хэргийн дэд сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга.

Нарийн бичгийн дарга - Үйлдвэр, худалдааны яамны ахлах мэргэжилтэн.

2. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгах нь:

а/ажлын хэсгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох яам, газрын шинжээч, мэргэжилтэнг татан оролцуулж байсугай;

б/2001 оны 11 дүгээр сард Катар Улсад болох ДХБ-ын сайд нарын IY бага хурлын бэлтгэл ажлыг сайтар хангасугай;

в/ДХБ-ын үйл ажиллагаа, худалдааны олон талт хэлэлцээнд оролцохдоо Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад үйлдвэр, худалдаа, бизнес эрхлэгчид, олон нийтийн байгууллагын санал авч байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 232 Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комиссын ажлын албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, Төрийн тусгай албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлаж 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(Сард төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	35144	37649	40153	42658	45080	48001	50925	53846	56769	59690	62821	66161	69710
2	35666	38170	40675	42680	45603	48524	51550	54681	57604	60525	63760	67205	70754
3	36188	38796	41196	43201	46124	49045	52176	55516	58438	61361	64700	68249	71798
4	36814	39423	41719	43724	46646	49464	52803	56350	59274	62196	65640	69396	72945
5	37440	40153	42240	44245	47168	50194	53429	57291	60213	63135	66579	70545	74093
6	38170	40675	42866	44871	47794	50820	54160	58230	61153	64074	67623	71798	75345
7	38901	41405	42993	45498	48420	51446	54890	59169	62091	65013	68666	73049	76598
8	39528	42033	43620	46124	49045	52073	55620	60004	62821	65953	69710	74301	77745
9	40153	42658	44245	46750	49673	52803	56350	60839	63760	66996	70859	75449	78894
10	40780	42680	44871	47168	50403	53638	57186	61674	64700	68040	72005	76598	79938
11	41405	43306	45498	48001	51133	54473	58021	62509	65744	69083	73049	77641	80981
12	41928	43931	46228	48838	51864	55725	58856	63344	66786	70126	74093	78685	82025
13	42449	44559	46958	49673	52699	56560	59900	64179	67728	71066	75033	79729	-
14	42576	45184	47794	50506	53534	57291	60943	65013	68666	72005	75971	80773	-
15	43201	45811	48629	51238	54368	58021	61986	65848	69605	72945	76911	-	-
16	43724	46436	49464	51969	55204	58751	62821	66684	70545	73780	77850	-	-
17	44140	47063	50194	52699	55934	59379	63656	67414	71379	74615	-	-	-
18	44559	47690	50925	53429	56664	60004	64493	68144	72214	75449	-	-	-
19	44975	48210	51655	54056	57394	60630	65223	68666	73049	-	-	-	-
20	45289	48733	52280	54681	58021	61153	65848	69396	73885	-	-	-	-
21	-	49254	52803	55204	58646	61674	66475	-	-	-	-	-	-
22	-	49673	53220	55725	59274	62196	67100	-	-	-	-	-	-
23	-	-	53638	56143	59795	62716	-	-	-	-	-	-	-
24	-	-	-	56560	60318	63135	-	-	-	-	-	-	-
25	-	-	-	57186	60839	63553	-	-	-	-	-	-	-

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(Сард төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	42784	45080	48001	50925	53846	56769	59690	62821	66161	69501	72841
2	43410	45603	48524	51550	54681	57604	60525	63760	67100	70545	73989
3	44140	46124	49045	52176	55516	58438	61361	64700	68040	71589	75136
4	44975	46646	49464	52803	56350	59274	62196	65640	68979	72633	76250
5	45914	47168	50194	53429	57291	60213	63135	66579	69918	73780	77641
6	46855	47794	50820	54160	58230	61153	64074	67623	71066	74929	78894
7	47690	48420	51446	54890	59169	62091	65013	68666	72110	76180	80146
8	48524	49045	52073	55620	60004	62621	65953	69710	73049	77433	81398
9	49359	49673	52803	56350	60839	63760	66996	70859	73989	78685	82650
10	50194	50403	53638	57186	61674	64700	68040	72005	74929	79938	83903
11	51029	51133	54473	58021	62509	65744	69083	73049	75868	80981	85155
12	51760	51864	55725	58856	63344	66786	70126	74093	76806	82025	-
13	52490	52699	56560	59900	64179	67728	71066	75033	77745	-	-
14	53220	53534	57291	60943	65013	68666	72005	75971	78685	-	-
15	53846	54368	58021	61986	65848	69605	72945	76911	-	-	-
16	54473	55204	58751	62821	66684	70545	73780	77850	-	-	-
17	55099	55934	59379	63656	67414	71379	74615	-	-	-	-
18	55725	56664	60004	64493	68144	71674	75449	-	-	-	-
19	56350	57394	60630	65223	68666	73049	-	-	-	-	-
20	56873	58021	61153	65848	69396	73885	-	-	-	-	-
21	57394	58646	61674	66475	-	-	-	-	-	-	-
22	57813	59274	62196	67100	-	-	-	-	-	-	-
23	-	59795	62716	-	-	-	-	-	-	-	-
24	-	60318	63135	-	-	-	-	-	-	-	-
25	-	60839	63553	-	-	-	-	-	-	-	-

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(Сард төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	32640	35144	37649	40153	41824	42658	43620	45080	48001	48838	49881	50925	53846	56769	59690	62821	66161	69710
2	33474	35978	38693	42449	43620	44245	45706	47168	49673	50716	51760	52803	55934	59065	61986	65326	68458	72214
3	34518	37021	39945	44245	45914	46541	48210	49881	51550	53220	54056	55099	58230	61569	64074	67830	70961	74719
4	35561	37858	40989	46541	48210	48629	50716	52385	53638	55099	56350	57186	60525	63865	66161	70336	73466	77223
5	36396	38901	42240	48838	50506	50925	52385	54681	55308	56978	58438	59274	62821	66370	68249	72841	75971	79729
6	37440	39736	42784	51133	52803	53220	54681	56769	57186	58856	60525	61569	65118	68666	70545	75345	78476	82025
7	38484	40780	44036	53638	55308	55725	56769	58856	59065	60734	62613	63449	67414	71170	72841	77850	80773	-
8	39318	41614	45080	-	-	57186	58856	60839	60943	62613	64283	65326	69396	73885	75449	-	-	-
9	40361	42658	46333	-	-	-	-	-	62716	64283	65744	67100	-	-	-	-	-	-
10	41405	43201	47376	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	42449	44245	48629	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	42993	45289	49673	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

тухай" Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан "Хилийн хяналтын албадын ажлыг зохицуулах журам"-ын 4 дэх заалтын "а"-д "-гааль", мөн заалтын "б"-д "хилийн шалган нэвтрүүлэх" гэсний дараа тус тус "-гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаа" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 240** **Улаанбаатар хот**

Баян-Өлгий аймгийн иргэдийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын зарим гишүүд, Баян-Өлгий аймгийн Засаг даргаас гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Казахстан Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад Баян-Өлгий аймагт буцаж ирсэн орон байргүй 902 өрхөд байшингийн шал, дээврийн банз, хаалга, цонх зэрэг модон хийц худалдан авахад зориулан эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр 180,4 /нэг зуун наян сая дөрвөн зуун мянга/ сая төгрөгийг 2002 онд төсвөөс олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Тус аймгийн орлогогүй өрх, ажилгүй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлийн хандив, зээл, тусламж, төслийн арга хэмжээнд шинээр хамруулах боломж, нөхцөлийг судалж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Баян-Өлгий аймгийн Засаг дарга Х.Баделхан нарт үүрэг болгосугай.

3. Баян-Өлгий аймгийн Цагаannуур тосгон дахь Нефть хангамжийн цогцолборыг баруун бүс нутгийн хэрэгцээнд зориулан шатахуун хадгалах бааз болгон сэргээн ажиллуулах боломжийг судлахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд тус тус даалгасугай.

4. "Мянганы зам" төслийн ажиллах хүчний хэрэгцээ, захиалгыг үндэслэн Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэгүй иргэдээс зам барилгын ажилд оролцуулах арга хэмжээ авахыг "Мянганы зам" төслийн үндэсний хорооны дарга Б.Жигжид, Баян-Өлгий аймгийн Засаг дарга Х.Баделхан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 46 (233)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай*
- *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арваннэгдүгээр сарын 28 №46 (233)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

560. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай (2001-11-8-ны хууль) 1042
561. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2001-11-8-ны хууль) 1050
562. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-8-ны хууль) 1050
563. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2001-11-8-ны хууль) 1051
564. Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2001-11-8-ны хууль) 1051
565. Автотээврийн тухай хуулийн зарим хэсэг, зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай (2001-11-8-ны хууль) 1051
566. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-9-ний хууль) 1052
567. Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-9-ний хууль) 1052
568. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-9-ний хууль) 1053
569. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-9-ний хууль) 1053
570. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-9-ний хууль) 1054
571. Нэмэлт зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон батлах тухай (2001-11-15-ны хууль) 1056
572. Конвенцид нэгдэн орох тухай (2001-11-15-ны хууль) 1056
573. Конвенцид нэгдэн орох тухай (2001-11-15-ны хууль) 1056
574. Гэрээ соёрхон батлах тухай (2001-11-15-ны хууль) 1056

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

575. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт оруулах тухай Дугаар 82 1056
576. Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд эрх олгох тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 83 1057
577. Нөхөн сонгууль зарлах тухай Дугаар 86 1057
578. Нөхөн сонгуулийн зардлын хэмжээг тогтоох тухай Дугаар 87 1058
579. Зарим байгууллын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 88 1058
580. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 89 1058

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

581. Хөтөлбөр батлах тухай Дугаар 242 1058

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 43 дугаарт нийтлэгдсэн "Харилцаа холбооны тухай хууль"-нийн 20.1-д "гэмт хэрэг," гэснийг "гэмт хэрэгтэй тэмцэх," гэж залруулан хэрэглэнэ үү.

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хууль санаачлагч хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

2.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

2.1.1. "хууль санаачлагч" гэж Монгол Улсын Үндсэн хуулийн[1] хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрыг;

2.1.2. "хууль санаачлах эрх" гэж хууль санаачлагчаас тодорхой хууль гаргах тухай санал дэвшүүлж, мэргэжлийн түвшинд боловсруулах, боловсруулсан хуулийн төслийг хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг;

2.1.3. "хуулийн төсөл" гэж хууль санаачлагчаас мэргэжлийн түвшинд боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа уул төслийн эх бичвэрийг;

2.1.4. "Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл" гэж хууль санаачлагч болон эрх бүхий бусад байгууллагаас Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр оруулж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийн эх бичвэрийг.

3 дугаар зүйл.Хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх

3.1. Хууль санаачлагч нь хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь асуудлыг шийдвэрлэсэн байна:

3.1.1. нийгмийн тухайн харилцааны төлөв байдал болон түүнийг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинэээр хууль гаргах болон дагаж мөрдөж байгаа хуулыг нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлсон байх;

3.1.2. хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох;

3.1.3. хуулийг хэрэгжүүлэх талаар цаашид авах арга хэмжээний тухай санал, түүнтэй холбогдон гарах төсөв, санхүүгийн зардлын тооцоог гаргасан байх;

3.1.4. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх.

3.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, САНХҮЖҮҮЛЭХ

4 дүгээр зүйл.Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх

4.1. Хууль санаачлагч нь санаачлан боловсруулах хуулийн төслийнхөө талаар урьдчилан төлөвлөж, хууль боловсронгуй болгох үндэсэн чиглэл /цаашид "Үндэсэн чиглэл"гэх/-д тусгуулна.

4.2. Үндэсэн чиглэлийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагын саналыг авч нэгтгэн судалсны үндэсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

4.3. Үндэсэн чиглэлийн төсөлд санал өгч

[1] *Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

байгаа хууль санаачлагч нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр үг асуудлаар шинэзр хууль гаргах болон дагаж мөрдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг тодорхой заасан байна.

4.4. Үндсэн чиглэлийг тодорхой хугацаагаар боловсруулж, Засгийн газар хуралдаанаараа хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулна.

4.5. Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэх хуулийн жагсаалт, дэс дарааллыг тогтоохдоо Үндсэн чиглэлийг баримтална.

4.6. Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч холбогдох хуулийн төсөл санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

5 дугаар зүйл.Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах

5.1. Хуулийн төсөл боловсруулах ажлыг хууль санаачлагч хариуцан зохион байгуулна.

5.2. Ерөнхийлөгч тодорхой асуудлаар хуулийн төсөл боловсруулах чиглэлийг Засгийн газарт өгч болно.

5.3. Улсын Их Хурал тодорхой асуудлаар хуулийн төсөл боловсруулахыг Засгийн газарт даалгаж болно.

5.4. Засгийн газраас санаачлах хуулийн төслийг төрийн захиргааны төв байгуллага Үндсэн чиглэлийн дагуу буюу Засгийн газрын даалгавраар зохих хүрээ, салбарын асуудлаар хариуцан боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.

6 дугаар зүйл.Хуулийн төсөл боловсруулах талаар хууль санаачлагчийн бүрэн эрх

6.1. Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах талаар дараахь бүрэн эрх эдэлнэ:

6.1.1. хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох;

6.1.2. хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх;

6.1.3. байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр холбогдох эрдэмтэн, мэргэжлийн хүнийг хуулийн төсөл боловсруулах ажилд татан оролцуулах;

6.1.4. хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдгээрийн саналыг авах;

6.1.5. хуулийн төсөл, түүнийг боловсруулах ажлын явцын талаар шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлэх;

6.1.6. иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах;

6.1.7. өргөн мэдүүлсэн хуулийн төслөө татаж авах.

7 дугаар зүйл.Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр

7.1. Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна:

7.1.1. хуулийн төслийг өөрөө боловсруулах;

7.1.2. холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

7.1.3. хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

8 дугаар зүйл.Хуулийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлэх

8.1. Хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг өөрийн төсвөөс санхүүжүүлнэ.

8.2. Засгийн газраас хуулийн төслийг энэ хуулийн 7.1.3-т заасны дагуу гэрээний үндсэн дээр боловсруулахад хөрөнгийн нэмэгдэл эх үүсвэр шаардагдахаар бол холбогдох төсвийг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

8.3. Хуулийн төсөл боловсруулах ажлыг хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх зорилгоогүйгээр ашгийн бус байгууллага санхүүжүүлж болно.

9 дүгээр зүйл.Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах

9.1. Хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулахын өмнө түүний үзэл баримтлалыг тодорхойлно.

9.2. Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчаас өгсөн чиглэлийн дагуу тухайн хуулийн төсөл боловсруулах ажлыг хариуцаж байгаа ажлын хэсэг, хуулийн эрх зүйн боловсруулж болно.

9.3. Хуулийн төслийн үзэл баримтлалд дараахь асуудлыг тусгана:

9.3.1. хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага;

9.3.2. хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

9.3.3. хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

9.3.4. хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал.

9.4. Энэ хуулийн 9.2-т заасан тохиолдолд үзэл баримтлалыг хууль санаачлагчид танилцуулсан байна.

9.5. Энэ хуулийн 9.3.1-д ямар шалтгаанаар уг төслийг боловсруулах гэж байгаа, тухайн харилцааг зайлшгүй зохицуулах үндэслэлийг тодорхой тайлбарлана.

9.6. Хуулийн төслийг төрийн захиргааны холбогдох төв байгууллага боловсруулж байгаа бол үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож, нэгдсэн санал дүгнэлтэд хүрсний үндэсэн дээр хамтран батална.

9.7. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн нь боловсруулж буй хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь зөвлөмж гаргана.

9.8. Ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн хуулийн төслийг түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

9.9. Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болно.

9.10. Хуулийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна.

9.11. Хуулийн төсөл боловсруулж байгаа ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн нь хууль санаачлагч буюу түүнийг зохион байгуулж байгаа байгууллагын удирдлагад ажлын явцыг тогтмол мэдээлж, шаардлагатай зөвлөгөө авч ажиллана.

10 дугаар зүйл.Хуулийн төсөл боловсруулах талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн төсөл боловсруулах талаар дараахь бүрэн эрх эдэлнэ:

10.1.1. Үндсэн чиглэлийн төсөл, төрийн байгууллалт, эрүү, иргэний зэрэг салбарын бус нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг хариуцан боловсруулах;

10.1.2. Засгийн газраас санаачлах хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

10.1.3. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төслийн үзэл баримтлалд зөвлөмж өгөх;

10.1.4. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлогод хэрхэн нийцэж байгаа, түүнчлэн энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан эсэх талаар энэ хуулийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газрын өгөх санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;

10.1.5. Засгийн газраас санаачилсан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, эрх зүйн бодлого болон энэ хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн эсэхийг энэ хуулийн 18.6-д заасны дагуу эцэслэн хянаж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх буюу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгох;

10.1.6. төрийн захиргааны бусад төв байгууллагад хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

10.1.7. хуулийн төсөл боловсруулах арга зүйн асуудлаар зөвлөмж, аргачлал гаргах, хууль зүйн нэр томъёог нэг мөр болгон жигдлэх арга хэмжээ авах.

10.2. Энэ хуулийн 10.1.5-д заасан зөвшөөрлийг бичгээр үйлдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТӨРӨЛ, ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА, БҮТЭЦ, ХЭЛБЭР

11 дүгээр зүйл.Хуулийн төслийн төрөл

11.1. Хуулийн төсөл дараахь төрөлтэй байна:

11.1.1. анхдагч хуулийн төсөл;

11.1.2. хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл;

11.1.3. хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.

12 дугаар зүйл.Хуулийн төсөлд тавих нийтлэг шаардлага

12.1. Хуулийн төсөл дараахь нийтлэг шаардлага хангасан байна:

12.1.1. Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний зааллттай уялдсан байх;

12.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг аль болох бүрэн тусгасан байх;

12.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;

12.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох тухай заалт тусгахгүй байх;

12.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;

12.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;

12.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;

12.1.8. хуулийн зорилт, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хамрах хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчоос удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл /гипотези/, тэдгээрийг биелүүлэх журам, эрх, үүрэг /диспозици/, онцгойлон үзэх нөхцөл байдал, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тодорхой заасан байх;

12.1.9. шаардлагатай тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хэм хэмжээ, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгох, хасах санал;

12.1.10. шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулсан байх.

13 дугаар зүйл.Хуулийн төсөлд тавих нэр томъёо, хэл зүйн шаардлага

13.1. Хуулийн төсөл нь нэр томъёо, хэл зүйн дараахь шаардлагыг хангасан байна:

13.1.1. Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;

13.1.2. нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;

13.1.3. нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн эвшцөрсөн утгаар хэрэглэх;

13.1.4. монгол хэлэнд тохирох уг нь байвал гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй байх;

13.1.5. уг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;

13.1.6. хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;

13.1.7. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.

13.2. Хуулийн төсөлд дараахь тохиолдолд нэр томъёоны тайлбар хийнэ:

13.2.1. нэр томъёо нь олон утгатай бол;

13.2.2. нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол;

13.2.3. шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол.

13.3. Хуулийн төсөлд дараахь тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болно:

13.3.1. уг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол;

13.3.2. уг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

13.3.3. уг нэр томъёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

13.4. Нэр томъёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн "Нийтлэг үндэслэл" гэсэн бүлэгт оруулан заах бөгөөд иймхүү тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томъёо байгаа бол тэдгээрийг "Хуулийн нэр томъёоны тодорхойлолт" гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ.

13.5. Нэр томъёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж, түүний үйлчлэх хүрээг тодорхой заана.

14 дүгээр зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хэм хэмжээ

14.1. Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хэм хэмжээ нь түүнийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой цаг хугацаа, бэлтгэл ханган, бусад хуульд нийцүүлэх зэрэг заалтыг агуулах бөгөөд дараахь асуудлыг зохицуулна:

14.1.1. шилжилтийн хугацаанд шийдвэрлэж дуусгах асудал;

14.1.2. урьд үйлчилж байсан хуулийн дагуу үүссэн эрх, үүргийн хувьд шинэ хэм хэмжээг хэрэглэх эсэх, хэрэглэх бол ямар хүрээ, хэмжээнд хэрэглэх;

14.1.3. шинэ хэм хэмжээгээр хасагдаж байгаа эрх зүйн аливаа ойлголт бүрмөсөн үгүй болж байгаа эсэх, эсүүл ямар хугацаанд хүчинтэй байх;

14.1.4. шинээр бий болж байгаа байгууллага байгуулах, урьд өмнө байсан байгууллагыг өөрчлөх болон шинэ хэм хэмжээнд бусад хуулийг нийцүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлж дуусах хугацааг заах.

15 дугаар зүйл.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих бусад шаардлага

15.1. Хуулийн өөрчлөлтийг хуулийн анхдагч эх бичвэрт оруулна.

15.2. Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараахь төрөлд хуваагдана:

15.2.1. хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

15.2.2. хуульд нэмэлт оруулах тухай;

15.2.3. хуульд өөрчлөлт оруулах тухай;

15.2.4. хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.

15.3. Хуульд оруулах өөрчлөлтийг зөвхөн нэг хуулыг хамааруулж хийх бөгөөд өөрчлөлт орж байгаа хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг тодорхой бичнэ.

15.4. Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд зүйлийн гарчиг тавилгүйгээр зүйлийн агуулгыг дугаарын хойноос шууд бичнэ.

15.5. Хуулийн нэг зүйлд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа бол өөрчлөлт тус бүрийг бие даасан заалт болгон тэмдэглэнэ.

15.6. Өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томъёо, үг хэллэгийг өөрчилсэн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгодхооргүй байвал түүнийг өөрчлөн найруулна.

15.7. Хүчингүй болгож байгаа хуулийн төслийн заалтад уг хуулийн төслөөр хүчингүй болгож байгаа зүйл, хэсэг, заалт, үг, өгүүлбэрийг орхигдуулалгүй бүрэн гүйцэд заана.

15.8. Дараахь тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна:

15.8.1. уг хуульд олон нэмэлт, өөрчлөлт оруулах буюу үүний улмаас хуулийн үзэл баримтлал өөрчлөгдөх, бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орохоор бол;

15.8.2. тухайн хуульд урьд нь олон удаа нэмэлт, өөрчлөлт орсон бол.

15.9. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа энэ хуулийн 10.1.7-д заасан зөвлөмж, аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

16 дугаар зүйл.Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд тавих нэмэлт шаардлага

16.1. Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд уг олон улсын гэрээг гадаад хэлнээс эх хэлнээ, эх хэлнээс гадаад хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг хавсаргана.

16.2. Олон улсын гэрээний орчуулгыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл.Хуулийн төслийн бүтэц, хэлбэр

17.1. Хуулийн төсөл дараахь бүтэцтэй байна:

17.1.1. хуулийн төслийн гарчиг;

17.1.2. хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл;

17.1.3. зүйлийн доторхи хэсэг

17.1.4. хэсгийн доторхи заалт;

17.1.5. заалтын доторхи дэд заалт;

17.1.6. шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.

17.2. Хуулийн төслийн бүтэц нь дараахь шаардлагыг хангасан байна:

17.2.1. зүйл нь хоорондоо уялдаа холбоо, дэс дараалал бүхий, агуулгыг нь товч илэрхийлсэн гарчиг, нэгдсэн дугаартай байна;

17.2.2. бие даасан саналыг бүрийг зүйлд тусгана;

17.2.3. бие даасан саналыг нь хэд хэдэн өгүүлбэрээр илэрхийлэгдэж байвал зүйлийг хэсэгт хуваана;

17.2.4. заалт нь аль болох нэг өгүүлбэрээс бүрдсэн байна;

17.2.5. зүйлүүдийг сэдвээр нь бүлэглэж, бүлгийг хэсэг, анги нэгтгэж болно.

17.3. Хуулийн төслийн бүтцийг дараахь хэлбэрт оруулж байрлуулна:

17.3.1. хуулийн төслийн гарчиг;

17.3.2. нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "ерөнхий анги" буюу, эсхүл "нийтлэг үндэслэл" гэсэн бүлэг, хэсэг;

17.3.3. нэр томъёоны тайлбар;

17.3.4. тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "тусгай анги" буюу, эсхүл агуулгаар нь бүлэг, хэсэг болгосон эрх зүйн хэм хэмжээ;

17.3.5. иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх, үүрэг;

17.3.6. онцгойлон үзэх нөхцөл байдал;

17.3.7. хариуцлага тогтоож байгаа хэм хэмжээ;

17.3.8. шаардлагатай бол хууль хүчин төгөлдөр болох тухай хэм хэмжээ;

17.3.9. бусад зүйл.

17.4. Хуулийн төслийн гарчиг нь дараахь зүйлээс бүрдэнэ:

17.4.1. "Монгол Улсын хууль" гэсэн толгой;

17.4.2. хуулийг баталсан он, сар, өдөр / араб тоогоор бичнэ./;

17.4.3. хуулийг баталсан газар /хот/-ын нэр;

17.4.4. агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн хуулийн нэр.

17.5. Энэ хуулийн 17.4.4-т заасан хуулийн нэрийг дан том үсгээр бичих бөгөөд дараахь төрөлтэй байна:

17.5.1.тухайлсан нь:"... тухай" гэсэн үгээр төгсгөнө. /Ашигт малтмалын тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай г.м/

17.5.2.оноосон нь:"... -ийн хууль" гэдэг үгээр төгсгөнө. /Иргэний хууль, Авилгалын эсрэг хууль г.м/

17.6.Хуулийн төслийн бүтцийн хэсгийг дараахь байдлаар дугаарлана:

17.6.1. ангийг ром тоогоор;

17.6.2. бүлгийг бичгээр;

17.6.3. зүйлийг ард нь "дугээр" буюу "дугаар" зүйл гэж араб тоогоор /1 дүгээр зүйл. г.м/;

17.6.4. хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1. г.м./;

17.6.5. хэсгийн доторхи заалтыг баруун талдаа цэг бүхий араб тоогоор /1.1.1.г.м/.

17.6.6. заалтын доторхи дэд заалтыг үгээр /1.1.1.а г.м/

17.7. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн заалтуудыг дараахь дараалалаар байрлуулна:

17.7.1. хуульд нэмэлт оруулах;

17.7.2. хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах;

17.7.3. хуулийн зарим нэр томъёо, үг өгүүлбэрийг өөрчлөх;

17.7.4. хасах үг, өгүүлбэр;

17.7.5. хүчингүй болгох зүйл, хэсэг, заалт;

17.7.6. шаардлагатай бол хуулийг дагаж мөрдөх хугацаа.

17.8. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл доторхи заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор дугаарлана /1г.м/

17.9. Хуульд шинээр нэмэгдэх зүйлийн дугаарыг тэмдэглэхдээ нэмэлт орж байгаа хуулийн агуулга, зүйлийн дарааллыг баримтлах бөгөөд баруун дээд өнцөгт нь араб тоогоор дугаарлана. / 52[1] дүгээр зүйл г.м/.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ДУУСГАХ, ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

18 дугаар зүйл.Хуулийн төсөлд санал авах

18.1. Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн төслийг боловсруулж дуусмагц хууль санаачлагчид уламжилна.

18.2. Хууль санаачлагч хуулийн төслийг хянан үзэж холбогдох байгууллагаас санал авахаар шийдвэрлэх, эсхүл цаашид дахин боловсруулах чиглэл өгнө.

18.3. Хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад

байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана.

18.4. Хууль санаачлагч хуулийн төсөлд санал авахдаа санал авахаар нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно.

18.5. Төрийн захиргааны төв байгууллага нь боловсруулсан хуулийн төсөлдөө төрийн захиргааны бусад төв байгууллагын саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгах бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын саналд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурсан байна.

18.6. Төрийн захиргааны төв байгууллага хуулийн төсөл боловсруулж байгаа бол төслийг Сайдын эвлөлөөр хэлэлцсэний эцэст, тухайн асуудал эрхэлсэн сайдын гарын үсэгтэйгээр холбогдох бусад бичиг баримтын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хянуулахаар ирүүлнэ.

18.7. Энэ хуулийн 18.6-д заасан хуулийн төсөл нь мөн хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг хуулийн 10.1.5-д заасан эвлөөрлийг ажлын долоон өдөрт багтаан өгнө.

18.8. энэ хуулийн 18.6-д заасан хуулийн төсөл нь мөн хуульд заасан шаардлагыг хангаагүй бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уг төслийг дахин боловсруулуулахаар төрийн захиргааны холбогдох төв байгууллагад үндэслэл бүхий тайлбарын хамт буцаана.

18.9. Энэ хуулийн 18.8-д заасан тохиолдолд төрийн захиргааны холбогдох төв байгууллага нь төслийг дахин боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хянуулахаар дахин ирүүлнэ.

18.10. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад хуулийн төслөө явуулна.

18.11. Засгийн газар энэ хуулийн 18.10-т заасан төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлтээ ЗО хоногт багтаан хууль санаачлагчид хүргүүлэх ба шаардлагатай бол хууль санаачлагчтай тохиролцон энэ хугацааг хойшлуулж болно.

18.12. Улсын Их Хурлаас шийдвэр гаргахаар тогтсон болон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дотоод зохион байгуулалттай холбогдон гарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд Засгийн газраас санал авахгүй байж болно.

18.13. Засгийн газар энэ хуулийн 18.10-т заасан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндэсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцэгүй, энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

18.14. Энэ хуулийн 18.11-д заасан хугацаанд Засгийн газар хариу ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

19 дүгээр зүйл. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх

19.1. Шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцаог зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулж болно.

19.2. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд төслийг ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэхийг тодорхой заасан байна.

19.3. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэхдээ дараахь хүрээнд хэлэлцүүлж болно:

19.3.1.нийт ард түмнээр;

19.3.2.нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд;

19.3.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд.

19.4.Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар энэ ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн Улсын Их Хурлын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхэд танилцуулна.

19.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай[1] хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад заасны дагуу хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

---

[1] *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-"Ардын эрх" сониныі 1992 оны 126 дугаарт, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт тус тус нийтлэгдсэн.*

20 дугаар зүйл.Хуулийн төслийг өргөн мэдүүлэх

20.1. Хууль санаачлагч хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх бөгөөд ийнхүү өргөн мэдүүлэхээс өмнө түүнийг холбогдох бичиг баримтын хамт Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлнэ.

20.2. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга 72 цагийн дотор хуулийн төсөл, холбогдох бичиг баримтыг энэ хуулийн 20.3, 20.4-д заасны дагуу хянаж, шаардлага хангасан гэж үзвэл төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацаанд товлон хууль санаачлагчид мэдэгдэх ба төсөл нь дээрх шаардлагыг хангаагүй байвал түүнийг хангуулах арга хэмжээ авна.

20.3. Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулийн төсөлд дараахь бичиг баримтыг хавсаргасан байна:

20.3.1. хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг;

20.3.2. хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга;

20.3.3. шаардлагатай бол холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл;

20.3.4. хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шаардлагатай арга хэмжээний санал, түүнтэй холбогдон гарах төсөв, санхүүгийн зардлын тооцоо;

20.3.5. Засгийн газар, холбогдох бусад байгууллагын санал дүгнэлт, Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа хуулийн төслийн тухайд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр өгсөн зөвшөөрөл;

20.3.6. олон улсын гэрээ соёрхон батлуулах тухай хуулийн төсөлд уг олон улсын гэрээний орчуулга, түүнийг хариуцсан гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан бичиг.

20.4. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төсөл, холбогдох бусад бичиг баримт нь албан бичиг хэргийг хөтлөх нийтлэг шаардлагыг хангасан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ САНААЧЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл

21.1. Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн[1] 36 дугаар зүйлд зааснаар тогтоол хэлбэртэй байна.

22 дугаар зүйл.Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлах

22.1. Улсын Их Хурлын тогтоол /цаашид "тогтоол" гэх/-ын төслийг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуульд заасан бол бусад байгууллага санаачилна.

22.2. Улсын Их Хурлын өөрийн дотоод зохион байгуулалт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тухай болон Улсын Их Хурлаас тогтоол гаргахаар хуульд заасан асуудлаар гаргах тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо санаачилж болно.

22.3. Энэ хуулийн 22.1, 22.2 нь Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох тухай гаргах тогтоолын төсөлд хамаарахгүй.

23 дугаар зүйл. Тогтоолын төсөлд тавих шаардлага

23.1. Тогтоолын төсөл нь дараахь шаардлагыг хангасан байна:

23.1.1. Үндсэн хууль, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай нийцсэн байх;

23.1.2. хуулийн заалтыг давтахгүй байх;

23.1.3. хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх.

24 дүгээр зүйл.Тогтоолын төслийн бүтэц

24.1. Тогтоолын төсөл нь тэмдэглэх / шаардлагатай бол/, тогтоох гэсэн хэсэгтэй байна.

24.2. Тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт уг тогтоол гарах болсон үндэслэл, шаардлагыг товч тодорхой дурдаж, хуулийн заалтыг аль болохоор үндэслэсэн байна.

24.3. Тогтоолын төслийн тогтоох хэсэгт уг тогтоолоор шийдвэрлэх асуудлыг энгийн, ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ.

24.4. Тогтоолын төслийн бүтцийн үндсэн нэгж нь заалт байх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнийг дэд заалтад хувааж болно.

25 дугаар зүйл.Тогтоолын төслийн бүтцийн хэлбэр

25.1. Тогтоолын төслийн бүтэц дараахь

[1] *"Монгол Улсын Их Хурлын тухай хууль" - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 27 дугаарт нийтлэгдсэн.*

хэлбэртэй байна:

25.1.1. тогтоолын төслийн гарчиг;

25.1.2. тэмдэглэх хэсэг /шаардлагатай бол/;

25.1.3. тогтоох хэсэг;

25.1.4. шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг;

25.1.5. шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа.

25.2. Тогтоолын төслийн гарчиг нь дараахь хэсгээс бүрдэнэ:

25.2.1. "Монгол Улсын Их Хурлын тогтоол" гэсэн толгой;

25.2.2. баталсан он, сар, өдөр /араб тоогоор бичнэ/;

25.2.3. тогтоол баталсан газар /хот/-ын нэр;

25.2.4. тогтоолын нэр. Тогтоолын нэр нь "... тухай" гэж төгсөнө.

25.3. Шаардлагатай тохиолдолд тогтоол хавсралттай байж болох бөгөөд энэ тухай заалтыг "... -ыг хавсралтаар батална." гэсэн "... -ыг 1,2,3 дугаар хавсралтаар тус тус батална." гэж томъёолно.

25.4. Тогтоолын хавсралтын эхний хуудасны баруун дээд буланд "Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын хавсралт", эсхүл "Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын ... дугаар хавсралт" гэж заана.

25..5. Тогтоолын төслийн заалтыг дараахь байдлаар дугаарлана:

25.5.1. заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. гм/;

25.5.2. заалтын доторх дэд заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор /1/ гм/.

26 дугаар зүйл. Тогтоолын төслийг өргөн мэдүүлэх

26.1. Тогтоолын төсөл санаачлагч нь төслөө энэ хуулийн 20.1, 20.2-т заасан журмын дагуу өргөн мэдүүлнэ.

26.2. Тогтоолын төсөлд энэ хуулийн 20.3.1-20.3.5-д заасан бичиг баримтыг хавсаргасан байна.

26.3. Тогтоолын төсөлд хавсргадаг бичиг баримт нь албан бичиг хэргийг хөтлөх нийтлэг шаардлагыг хангасан байна.

26.4. Энэ хуулийн 26.1, 26.2 нь мөн хуулийн 22.2, 22.3-т хамаарахгүй.

27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

27.1. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 6 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 10 дахь хэсэг нэмсүгэй:

"10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийн өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон тухайн төслийг хариуцан боловсруулсан Засгийн газрын гишүүний албан ёсны зөвшөөрлийг авсан байна."

2 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн дугаарыг "11" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 4, 6 дахь заалт, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалт тус тус нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Тээвэрийн хэрэгслийн жолооч бэлтгэх журмыг боловсролын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран; жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн; жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална."

2/6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Тээвэрийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

3/7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Тээвэрийн хэрэгслийн тооллого, техникийн улсын үзлэг явуулах журмыг дэд бүтцийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

4/16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 4, 6 дахь заалт:

"3/тээвэрийн хэрэгслийн тоо бүртгэлийг хөтлөх;

4/тээвэрийн хэрэгслийн улсын дугаар олгох;

6/тээвэрийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авч, жолоодох эрхийн үнэмлэх олгох;"

5/16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/жолооч бэлтгэх сургалтыг хангалтгүй зохион байгуулсан, шаардлага хангаагүй сургууль, дамжааны сургалт явуулах эвөшөөрлийг хураах, багшлах эрхийг хасах санал тавих, мэргэжлийн шалгалт авах хугацааг хойшлуулах;".

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн байгуулагын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2.Цагдаагийн байгуллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа автотээврийн болон замын хөдөлгөөнд оролцдог өөрөө явагч хэрэгслийн тоо бүртгэлийг хөтөлж, тэдгээрийг жолоодох эрхийн үнэмлэх олгоно."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 17.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 5.1.3, 5.1.4 дэх заалт нэмсүгэй.

"5.1.3 импортлох архи, тамхины тоо хэмжээг үнэн зөвөөр тодорхойлж, харьяалах татварын алба болон холбогдох гаалийн байгууллагад өгөх;

5.1.4. импортлох архи, тамхинд онцгой албан татварын тэмдэг наах."

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "үйлдвэрлэсэн" гэсний дараа "болон импортолсон" гэж, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "нийлүүлэх" гэсний дараа "импортлох" гэж, 5 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1, 2 дахь хэсгийн "үйлдвэрлэл" гэсний дараа "болон импортын үйл ажиллагаа" гэж, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бол" гэсний дараа "гаалийн болон" гэж, мөн зүйлийн "5.1.1" гэсний дараа "5.1.2; 5.1.3; 5.1.4" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"4.1. Онцгой албан татварын тэмдгийг Монгол Улсад үйлдвэрлэсэн архи, тамхинд аж ахуйн нэгж, байгууллагын архи, тамхи үйлдвэрлэх зөвшөөрөл, тэдгээрийг худалдах, худалдан авах гэрээг, импортын архи, тамхинд аж ахуйн нэгж, байгууллагын импортлох, худалдан борлуулах гэрээг тус тус үндэслэн Үндэсний татварын алба олгоно."

4 дүгээр зүйл. Энэ хууль 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг /хүснэгт/-т дор дурдсан агуулгатай 7, 8 дахь заалт нэмсүгэй:

7	Автобензин			
	90 хүртэл октантай	-	Тонн тутмаас 11.0	
	90-ээс дээш октантай	-	Тонн тутмаас 12.0	
8	Дизелийн түлш	-	Тонн тутмаас 15.0	

2 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2," гэсний дараа "4" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хууль 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий 4, 5 дахь хэсэг нэмсүгэй:

"4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг дараа сарын 15-ны дотор улсын төвөрсөн төсвийн орлогын дансанд төлнө.

5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшинд ногдсон албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Үндэсний татварын албанд гарган өгч, албан татварын эцсийн тооцоо хийнэ."

2 дугаар зүйл. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн "импортлон" гэсний өмнө "үйлдвэрлэсэн болон" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"**7 дугаар зүйл. Албан татвар ногдуулах**

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг Үндэсний татварын алба, Монгол Улсын нутаг дэвсгэрт импортоор оруулж ирсэн автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг Гаалийн байгууллага энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тус тус ногдуулна."

4 дүгээр зүйл. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/ Монгол улсад оршин суугч бус хуулийн этгээд;"

2/ 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Хуулийн этгээдэд эрхлэн гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанаас нь хувьд энэ хуулийн 4, 5, 7 дугаар зүйлд заасны дагуу татвар ногдуулах, татвараас чөлөөлөх, хөнгөлөхдөө төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг баримтална."

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "хөдөлмөрийн хөлс" гэсний дараа "нэмэгдэл хөлс" гэж, "онцгой" гэсний дараа "болон үл хөдлөх эд хөрөнгийн" гэж, "бусдад учруулсан хохирлыг нөхсөн төлөөс" гэсний дараа ", харилцан хамаарал бүхий хуулийн этгээдээс татвар төлөгчид олгосон зээл болон хүү тооцогдох аливаа өр төлбөрийн дүн нь зээлдүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгийн 30-аас дээш хувь байвал илүү гарсан дүнд ногдох зээл болон өр төлбөрийн хүүгийн зардлыг" гэж, мөн зүйлийн "Үндэсн хөрөнгийн бүлэг" гэсэн хүснэгтийн "машин,

техник, тоног төхөөрөмж" гэсний дараа "компьютер" гэж, 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "хөнгөлнө." гэсний дараа "Энэ нь ноос, ноолуур үгаах, самнах, арьс ширний анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэрт хамаарахгүй." гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Гадаад валютаар олсон орлогыг төгрөгт шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон ханшийг үндэслэнэ."

4 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "5 хувиас" гэснийг "10 хувиас" гэж, "түлшний хөнгөлөлт" гэснийг "түлшний үнийн хөнгөлөлт" гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "хонжворт олгосон хөрөнгийг" гэснийг "хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг" гэж, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын "татвар төлөгчийн" гэснийг "хуулийн этгээдийн" гэж, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дугаарыг "8" гэж, мөн заалтын "1-6-д" гэснийг "1-7-д" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 1, 4 дэх хэсэг, 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6 дахь заалт:

"5/ автобензин, дизелийн түлшний албан татвар;

6/ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр."

2/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"8/ үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар."

3/ 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар; "

4/ 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад дурдсан "Эрсдлийн сан"-гийн хөрөнгийг зарцуулах журмыг Улсын Их Хурал батлах бөгөөд хөрөнгийн зарцуулалтыг Засгийн газар улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн хамт Улсын Их Хуралд тайлагнаж байна."

2 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "Монгол Улсын" гэсний дараа "төсвийн бодлого тодорхойлох" гэж, 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын "зарцуулах" гэсний дараа ", төсвийн өр үүсгэхгүй байх" гэж, мөн хэсгийн 5 дахь заалтын "гүйцэтгэлийн" гэсний дараа "мэдээ" гэж, 7 дугаар зүйлийн 2 дахь заалтын "төрийн" гэсний дараа "болон орон нутгийн" гэж, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "5" гэсний дараа "8" гэж, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын "Засгийн газрын нөөц хөрөнгө," гэсний дараа "зах зээлийн гадаад, дотоод орчны өөрчлөлтийн таагүй нөлөөлөл, урьдчилан тооцох боломжгүй хүчин зүйлийн улмаас төсвийн орлогын хомсодол үүссэн нөхцөлд зайлшгүй зардлыг санхүүжүүлэх төсвийн "Эрсдлийн сан"," гэж, 14 дүгээр зүйлийн 3, 4, 5, 6, 8, 9, 10 дахь хэсгийн "төслийг" гэсний дараа "дараагийн хоёр жилийн төсвийн хүрээний төсөөллийн хамт" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"20 дугаар зүйл. Төсвийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэтрүүлэн батлагдсан төсөвт хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн сахилга зөрчиж өр, авлага үүсгэсэн бол холбогдох албан тушаалтныг 20000 - 60000 төгрөгөөр торгох;

2/ төсвийн орлогыг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэхгүй бол холбогдох албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг зөрчиж төсвийн хөрөнгийг зөөл буюу гэрээний үүргийн баталгаа болгосон, бусдад хандивласан, ивээн тэтгэсэн, хувь нийлүүлсэн, түр ашиглуулсан бол холбогдох албан тушаалтныг 60000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь заалтыг зөрчиж орлогын нэмэгдэл эх үүсвэрийг цалин, удирдлагын зардал, батлан хамгаалах арга хэмжээнд зарцуулсан бол холбогдох албан тушаалтныг 50000 төгрөгөөр торгох;

5/ энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан тайлангийн хугацааг зөрчиж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь гаргаж ирүүлээгүй бол холбогдох албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр тус тус торгоно.

2. Төсвийн тухай хууль тогтоомжийг зөрчиж энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан зөрчлүүдийг давтан гаргасан нь тухайн шатны төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн болон шууд захирагчийг албан тушаалаас нь зүүлэн татах үндэслэл болно."

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9, 5[1] дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 5, 6, 7, 9, 10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 4, 5, 6-д заасан "Сангийн яам" гэснийг "Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж, 6 дугаар зүйл, 14 зүйлийн 2 дахь заалтын "Сангийн сайд" гэснийг "Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж, 9 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгийн 1, 2 дахь заалтын "төрийн" гэснийг "орон нутгийн" гэж, 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "татаас өгч, санхүүгийн дэмжлэг үзүүлж" гэснийг "санхүүжилт өгч" гэж, 14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн "татаас, санхүүгийн тусламж, дэмжлэгийн талаарх саналын" гэснийг "санхүүжилт, дараагийн хоёр жилийн төсвийн хүрээний төсөөлийн" гэж, 15 дугаар зүйлийн 2, 3, 6 дахь хэсгийн "татаасын" гэснийг "санхүүжилтийн дээд" гэж, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "татаас, санхүүгийн тусламж, дэмжлэгийн хөрөнгийн" гэснийг "санхүүжилтийн" гэж, 17 дугаар зүйлийн 6, 7, 8 дахь хэсгийн дугаарыг "7, 8, 9" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "аж ахуйн нэгжийг" гэснийг, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалтын "улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагаас", "аймаг, нийслэлийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагаас" гэснийг, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "тухайн төсвийн жилд улсын төвлөрсөн төсөвтэй харьцахаар тогтоосон болон нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын импортын барааны, мөн алтны борлуулалтанд ноогдох" гэснийг, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "импортын барааны" гэснийг, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "тухайн төсвийн жилд улсын төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж байгууллагын", "болон онцгой" гэснийг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын" гэснийг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "хүү, торгуулийн орлого" гэснийг, 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "аймаг, нийслэлийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын" гэснийг, 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "сум, дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын" гэснийг, 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "өөрийн төсөвтэй харьцдаг" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 6 дахь заалт, 4 дэх хэсгийн 1, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

НЭМЭЛТ ЗӨӨЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРҮҮДИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын Сэргээн босголтын Зээлийн банк хооронд 2001 оны 6 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан Харилцаа холбоо-2 Нэмэлт Зээлийн Хэлэлцээр болон Харилцаа холбоо-3 Нэмэлт Зээлийн Хэлэлцээрүүдийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас Лондон хотноо 1969 оны 6 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Хөлөг онгоцны багтаамжийг хэмжих тухай олон улсын Конвенцид нэгдэн орсныг соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Женев хотноо 1975 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Бараат олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай ТИР карнейн Конвенцид нэгдэн орсныг соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улс, Олон улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2001 оны 8 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан Хөгжлийн Зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 82 Улаанбаатар хот

"Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн хорин хоёрт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"22.13. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай

асуудлыг шийдвэрлэхдээ шаардлагатай гэж үзвэл анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж, олон нийтээс санал авч болно.

22.14. Хуулийн төслийг хэвлэлд нийтлүүлэх, санал авах, ирсэн саналыг нэгтгэх, судлах ажлыг холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран зохион байгуулна.

22.15. Хуулийн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ санал ирүүлэх хугацаа, саналыг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байна.

22.16. Олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр зохих Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хуулийн төслөд санал өгсөн иргэн бүюу хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн, тухайн саналын талаар асуулт тавьж, хариулт авч болно.

22.17. Хуулийн төслөд олон нийтээс санал авахтай холбогдсон зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгана."

2. Энэ тогтоолыг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр **Дугаар 83** **Улаанбаатар хот**

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд эрх олгох тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд эрх олгох тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

Орон нутгийн төсвийн хомсдолтой өнөөгийн нөхцөлд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хүн амын орлогын зарим албан татварын хувь хэмжээг тогтоох боломжгүй гэсэн үндэслэлээр Засгийн газрын өргөн мэдүүлсэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр **Дугаар 86** **Улаанбаатар хот**

Нөхөн сонгууль зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

дүгээр тойрог дахь нөхөн сонгуулийн санал хураалтыг 2002 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр явуулахаар тогтоосугай.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 11 дүгээр тойрог дахь нөхөн сонгуулийг 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

3.Энэ тогтоолыг 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 11

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 87 Улаанбаатар хот

Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 11 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 8,4 сая төгрөгөөр тогтоож, сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөцөөс санхүүжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 88 Улаанбаатар хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Ч.Авдайг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны, Ё.Баярсайхан, Ц.Дашдорж, Б.Чадраа нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Р.Гаваа, П.Нямдаваа нарыг Нийгмийн бодлогын байнгын хорооны, Ц.Нямдоржийг Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлж, Ч.Авдай, Ё.Баярсайхан, Р.Гаваа, П.Нямдаваа, Б.Чадраа нарыг Эдийн засгийн байнгын хорооны, Ц.Дашдоржийг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны, Ц.Нямдоржийг Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус батлэсүгай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 89 Улаанбаатар хот

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдоржийг Хүний эрхийн дэд хорооны, Г.Төртөгтохыг Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Дугаар 242 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Хүнсний тухай хууль болон "Хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 172 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол, тэжээл" Үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлын асуудлыг зохицуулах Салбар хоорондын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт, Салбар хоорондын үндэсний хорооны дүрмийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны тодорхой хэсгийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх, тодорхой зорилт, шаардагдах зардлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Үндэсний хорооны дарга Д.Насанжаргалд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХООЛ ТЭЖЭЭЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Удиртгал

1. Монгол Улсын Засгийн газар Ромын 1992 оны "Дэлхийн хоол тэжээлийн тунхаглал"-ыг хүлээн зөвшөөрч "Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, монгол хүний хоол тэжээл" Үндэсний хөтөлбөрийг 1994 онд батлан хэрэгжүүлсэн. Гэвч зах зээлийн харилцаанд шилжих эхэн үеийн эдийн засгийн хямрал, хүн амын ядуурал, дахин давтан тохиолдож буй ган, зуд зэрэг байгалийн гамшиг болон хөтөлбөрийг боловсруулах явцад нөхцөл байдлыг дотуур үнэлсэн зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан үндэсний хөтөлбөрийн зарим зорилтууд бүрэн хэрэгжиж чадаагүй юм.

2. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээлийн асуудал нь нийгмийн тогтвортой байдал, улс төр, эдийн засаг, тусгаар тогтнолын чухал баталгаа болдог учир төрийн бодлогын үндсэн чиглэл мөн. Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн талаархи дэлхийн хэмжээнд тавьж буй зорилтын агуулга, үзэл санаа энэхүү үндэсний хөтөлберт тусгалаа олох нь хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангах, эрүүл мэндийг сайжруулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

Хоёр. Монгол хүний хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл-эрүүл мэндийн өнөөгийн байдал

3. Хоол хүнсний хангамж, бэлтгэлийн уламжлалт арга: Монгол түмэн хоол, хүнс бэлтгэх, боловсруулах баялаг өв уламжлалыг өнө эртнээс үе дамжуулан ирсэн билээ. Хүнсний хангамжийг ихэвчлэн өрх гэрийн хэмжээнд 1920-иод оныг хүртэл шийдвэрлэж ирсэн түүхтэй. Эмнэлэг, сүргууль, цэргийг хоол, хүнсээр хангах, төвлөрсөн хот, суурин газрын хүн амыг өдөр тутмын хүнсний хэрэгцээний бүтээгдэхүүнээр хангах асуудал тулгарч, хүнсний үйлдвэрийг шинээр зохион байгуулах замаар шийдвэрлэх зорилтыг хэрэгжүүлснээр хүнсний аж үйлдвэр үүсч хөгжсөн юм.

4. Хүнсний үйлдвэрлэл, хангамж, аюулгүй байдал, бодит хооллолтын хүрсэн түвшин: Монгол Улсын төр, Засгийн газар хүн амын хүнсний хангамж, хоол тэжээлийн талаар тусгайлсан бодлого, хөтөлбөрийг нийгмийн хөгжлийн үе шат бүхэнд авч хэрэгжүүлж ирсэн билээ. Мах, сүү боловсруулах, гурил, талх, боов, чихрийн үйлдвэрүүд төв, хөдөөд байгуулагдаж эх орны хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хүч чадал улсын хэмжээнд бий болсон

байв. Тухайлбал 1980-аад оны эцсэгэ жилд 60-аад мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 60.0 сая литр сүү, цагаан идээ, 4700 тонн цецгийн тос, 187.0 мянган тонн гурил, 41.8 мянган тонн нарийн боов, чихэр, жигнэмэг үйлдвэрлэж, жил бүр 20-30 мянган тонн мах, 400 мянган литр архи, спирт, 1 сая литр пиво, ихээхэн ургац авсан үед 20 мянга хүртэл тонн гурил экспортод гаргаж байв.

5. Хүнсний хангамж: Малын тоо өсөж, махны экспорт эрс багассанаар таваарын малын нөөц нэмэгдэх хандлага 1993 оноос бий болж, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн мах, сүүгээр хүн амын хэрэгцээг хангах боломж бүрдсэн юм. Хөдөө аж ахуйн салбарт мах үйлдвэрлэл (нядалгааны жингээр) 2000 онд 1990 оныхоос 124.7 хувиар, 1995 оныхоос 136.7 хувиар нэмэгдэж, жишсэн дундаж 1 хүний жилийн хэрэглээ 120 кг-д хүрчээ. Сүү үйлдвэрлэл 2000 онд 1990 оныхоос 118.9 хувиар, 1995 оныхоос 101.6 хувиар өсч, жишсэн дундаж 1 хүний жилийн хэрэглээ 126 литр болов. Үр тарианы үйлдвэрлэлд уналт, хямрал улам гүнзгийрч, улаан буудайн үйлдвэрлэл 2000 онд 1990 оныхоос 5.1 дахин, 1995 оныхоос бараг 2 дахин багасч гурилын үйлдвэрлэл мөн хэмжээгээр буурчээ. "Ногоон хувьсгал" Үндэсний хөтөлбөр хэрэгжиж төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд ахиц гарч 2000 оны дүнгээр хүнсний ногооны ургац 1990 оны түвшинд, төмснийх 1995 оны түвшинд хүрсэн боловч төмс, хүнсний ногоог импортоор авч байна. Зах зээлийн харилцаанд шилжих үеийн эдийн засгийн хямрал хүнсний үйлдвэрлэлд хүчтэй нөлөөлж, хүнсний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1995 онд 1990 оныхоос 2.4 дахин, 2000 онд 1995 оныхоос 1.5 дахин буурч гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ялангуяа үйлдвэрлэлийн аргаар боловсруулах мах, сүүний хэмжээ багассан байна. Иймхүү дотоодын үйлдвэрлэл эрс буурснаас тодорхой хэмжээний хүнсний бүтээгдэхүүн экспортлогч байсан Монгол Улс 1996-2000 онд жил бүр 17.3-46.5 мянган тонн улаан буудай, 80.9-450 тн цецгийн тос, жилийн хэрэгцүэт гурилынхаа 70 орчим хувийг импортоор авдаг болжээ. Сүүлийн жилүүдэд хүнсний үйлдвэрлэлийн жижиг, дунд үйлдвэрүүд бүй болж, технологийн зарим дэвшил нэвтэрч, бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодолд бага боловч ахиц гарч эхэллээ. Ундны усны эх үүсвэр, хангамж хот, хөдөөд харилцан адилгүй, ялангуяа говийн аймгуудад усан хангамжийн асуудал бүрэн шийдэгдээгүй байгаагийн зэрэгцээ хүн амын унд, ахуйн хэрэглээний усны чанар, аюулгүй байдал алдагдаж байна.

6. Хүнсний аюулгүй байдал: Хүнс, хоолоор дамжин халдварладаг, хордлого үүсгэдэг 60 гаруй өвчний 30 шахам нь манай орны мал, амьтанд оношлогдсон бөгөөд мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хүнсэнд зориулж бэлтгэх, нийтийн худалдаанд гаргахад мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн шаардлага зөрчилдөх явдал гарсаар байна. Мөн хүнсний түүхий эдийг үзлэг, шинжилгээгээр бүрэн баталгаажуулж чадахгүй байгаа, мах, сүүг гол төлөв үйлдвэрлэлийн боловсруулалт хийлгүйгээр хүн амд худалдаалдаг, хүнсний үйлдвэрүүдэд технологийн болон чанарын дотоодын хяналт сул, технологийн ажиллагсдын мэргэшлийн түвшин хангалтгүй, хэрэглэгчдийн хэрэглээний соёл, боловсрол төлөвшөөгүй зэрэг дутагдал хэвээр байна. Сүүлийн жилүүдэд хүнсний бүтээгдэхүүний нян, хөгц, мөөгөнцрийн бохирдолт 22.7, химийн-14.1, хүнд металлын-6 хувьд хүрч, шаардлага хангахгүй байгаа нийт сорьцын 35.5 хувийг хүнсний бүтээгдэхүүн эзэлж байна. Хорт хавдар үүсгэх, үр хөврөл гэмтээх, удамшилд аюул бүхий өвчин үүсгэдэг 150 гаруй хөгц байдгаас өнөөгийн байдлаар лабораторийн шинжилгээгээр эвэхэн 13 төрлийн хөгцийг хоол, хүнснээс илрүүлж чадаж байна. 1995-2000 онуудад хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, ялангуяа элэгний хорт хавдар тэргүүлэх боллоо. Эрүүл мэндийн тайлангийн дүнгээр нийт халдварт өвчний 30 гаруй хувийг хоол хүнс, орчны бохирдолт, ариун цэврийн шаардлага хангаагүйтэй холбоотой гэдэсний халдварт өвчин, хордлогот халдвар эзэлж байна. Манай улсад хоолны хордлого, хордлогот халдварын бүртгэл, мэдээлэл цэгцтэй бус, олныг хамарсан хордлого, халдварууд оношлон мэдээлэгдэж, гэр бүлийн хүрээнд ганц нэг хүнд тохиолдсон өвчлөл, суулгалт халдварын тохиолдол үндсэндээ бүртгэгдэхгүй байна. 1999 оны байдлаар Халдварт өвчин судлалын төвийн нэгдсэн лабораторийн гэдэсний халдварын шинжилгээгээр халдварын онош батлагдсан 185 тохиолдлын 17.8 хувийг хоолны хордлого,

хордлогот халдвар эзэлж байна.

7. Хоол тэжээл-эрүүл мэнд: Монгол хүн уургаар баялаг, амьтны гаралтай, өөх тос ихтэй, хэт халуун хоол, цай хэрэглэдэг, цайг давстай ууж заншсан, махан хоолыг ихэвчлэн оройн цагаар хэрэглэдэг зэрэг хооллох зан үйлийн өвөрмөц онцлогтой юм. Улирлын чанартай хооллодог заншил нь өнөөг хүртэл хөдөөгийн хүн амын дунд хадгалагдсаар ирлээ. Сүүлийн жилүүдэд хотжилт, иргэншилтэй холбоотойгоор суурин газрын хүн амын хооллолт өөрчлөгдөж байна. Монголчууд хоол хүнсэндээ аминдэм, эрдэс бодисын үндсэн эх үүсвэр болох төмс, хүнсний ногоо, төрөл бүрийн жимс, жимсгэнэ, зарим нэрийн хүнсний бүтээгдэхүүн *(загас, өндөг)*-ийг бага хэрэглэж байна. Жишээн дундаж хүний хоногийн хоолны илчлэг 1963-2462 ккал, уураг 88.6-105.4 гр, өөх тос 77.6-90.1 гр, нүүрс ус 213.8-290.7 гр болж үндсэн шимт бодисуудын хэрэглээний зохистой харьцаа алдагдсан байна. Амьжиргааны баталгаат түвшингээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүн хоногт хоол тэжээлээр хэрэгцээт хэмжээнээс илүү илчлэг (134-135 хувь) авч байхад амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хэрэгцээт илчлэгийн хангамж 58.1-68.5 хувь байна. Хүн амын эмзэг бүлэг, эх, хүүхдийн дунд хоол, тэжээлтэй холбоотой архаг өвчлөл (зүрх судасны өвчин, таргалалт, чихрийн шижин, хоол боловсруулах болон бусад эрхтний хорт хавдар) нэмэгдсээр байна. Бага насны хүүхдүүд хоол, тэжээлийн дутлаас үүдэлтэй уураг, илчлэг дутал, сульдаа, төмөр дутлын цус багадалт, иодын дутал зэрэг эмгэгүүдэд илүүтэй өртөж байна. 5 хүртэлх насны 4 хүүхэд тутмын нэг нь өсөлт хоцорсон, 8 хүүхэд тутмын нэг нь тураалтай, 32.1 хувь нь сульдаатай, 43.6 хувь нь төмөр дутлын цус багадалттай байна. Цус багадалт хэвийн өсөлттэй хүүхдээс харьцуулахад тураалтай хүүхдүүдэд 3 дахин их, өсөлт хоцорсон хүүхдүүдэд 2 дахин их тохиолдож байна. Түүнчлэн 1 хүртэлх насны 4 хүүхэд тутмын нэгд сульдаагийн эмнэлзүйн аль нэг шинж илэрч байжээ. 1999 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 58.5 хувь, 13-27 долоо хоногтой жирэмсэн эхчүүдийн 16.8 хувь, 28 ба түүнээс дээш долоо хоногтой жирэмсэн эхчүүдийн 26.8 хувь цус багадалттай байна.

8. Боловсролын байдал: Хүн ам, өрхийн 1998 оны тооллогоор 8-15 насны хүүхдүүдийн 1.5 хувь бичиг үсэгтэй байсан бол 2000 онд энэ үзүүлэлт 4.9 хувь болж өсчээ. Нийт хүн амын 90-95 хувь бичиг үсэгт тайлагдсан байв. Хүн ам, олон нийтэд зохистой хооллох, хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн сонгож хэрэглэх, хүнсний аюулгүй байдлын талаар мэдээлэл өгөх хоол, тэжээлийн боловсролын тогтолцоо бүрдээгүй байна.

9. Ядуурлын байдал: Хүн амын дунд 1992-2000 онуудад ажилгүйдлийн түвшин буурсан үзүүлэлт байгаа ч энэ нь зөвхөн хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлэгчдийн тоон дээр үндэслэсэн үзүүлэлт юм. 1998 онд хийгдсэн амьжиргааны түвшний түүвэр судалгаагаар үндэсний хэмжээний ажилгүйдлийн түвшин 19 хувь, хөдөөд 12 хувь, хот, сууринд 30 хувь гарсан. 849,8 мянган хүн ядуурлын доод түвшингээс доогуур амьдралтай байгаа нь 1992 оноос даруй 21800 хүнээр нэмэгдсэн, хүн амын 35.6 хувь ядуу, нэн ядуу гэсэн үзүүлэлт гарсан байна. Судалгааны дүнгээр ганц бие өрх толгойлсон, олон хүүхэдтэй эцэг, эхчүүд, ажилгүй хүмүүс, 100-гаас доош малтай өрх *(ам бүлийн тооноос хамаарч)*, боловсролгүй болон эмзэг бүлгийн хүмүүс *(өндөр настан, тахир дутуу, тэнэмэл хүүхдүүд)* ядууралд илүү өртөж байна.

Гурав. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага, үндэслэл

10. Монгол Улсын төр, засгаас хүнсний аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүн амыг чанарын баталгаатай, хүрэлцээтэй хүнс тэжээлээр хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн аюулгүй байдлын нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр явуулж байгаа бодлогын үр дүнд зарим ахиц гарч байгаа боловч салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах тодорхой бодлого, зохицуулалт нь шаардлагатайгаар харагдсан; Монголд хүнсний хомсдол бодитойгоор оршиж байгаа бөгөөд 1998 оны амьжиргааны түвшний түүвэр судалгааны үзүүлэлтээр хүн амын 19.7 орчим хувь нь нэн ядуугийн ангилалд орж,

хүнсний наад захын хэрэгцээнийхээ 50 хувийг л хангаж байгааг үндэслэн; Хоол, тэжээлийн болон бичилбодис, аминдэм дутлаас үүдсэн өвчлөл тууштай буурахгүй, зөв зохистой хооллолт, соёлтой хэрэглээ, дадал хэвшлийг эзэмшээгүйгээс зүрх судас, хоол боловсруулах эрхтний өвчлөл, нас баралт нэмэгдэж байгааг харгалзан; Хүн амын дунд хоол, тэжээлийн боловсрол олгох сургалт сурталчилгааны нэгдсэн тогтолцоо бүрдээгүйг бодолцон; Монгол Улсын Ерөнхий сайд 1996 онд Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалтад оролцож, монгол хүний хүнсний хангамж, хоол тэжээлийн бодит байдалд үнэлгээ өгч, хүн амыг хүнсээр хангах, елсгөлөн, бичилбодис, аминдэм дутлаас урьдчилан сэргийлэх асуудлаар өөрийн орны гол бодлого, чиглэлийг тодорхойлж, үзэл бодлоо илэрхийлснийг үндэс болгон; Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагуудын хооронд 1998 онд харилцан тохиролцож "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" ойлголцлын санамж бичиг хэрэгжүүлэх зорилгоор "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" Үндэсний хөтөлбөрийг боловсруулав.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

11. Хөтөлбөрийн зорилго: Хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй ханган, хоол, тэжээлийн байдлыг дээшлүүлж, улмаар эрүүл мэндийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

12. Хүнсний хангамжийн асуудлаар дэвшүүлсэн зорилт:

Нэгдүгээр зорилт: мах, сүү, үр тариа, төмс, хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн үйл ажиллагаат эрчимжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах;

Хоёрдугаар зорилт: Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, гурилын хэрэгцээ, чанар, аюулгүй байдлыг хангах;

Гуравдугаар зорилт: Дэвшилтэт технологийг нэвтрүүлж, олон улсын стандарт, аюулгүйн шаардлага хангасан зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох.

13. Хүнсний аюулгүй байдлын асуудлаар дэвшүүлсэн зорилт:

Дөрөвдүгээр зорилт: Үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн, хүнсний хяналтыг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох;

Тавдугаар зорилт: Хүнсний аюулгүй байдлын хяналтын лабораториудыг бэхжүүлж үндэсний боловсон хүчний чадавхийг сайжруулах;

Зургадугаар зорилт: Хүнсний аюулгүй байдлын асуудлаар үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд сургалт, сурталчилгаа явуулж ухаалаг, соёлтой хэрэглээг хэвшүүлэх, олон нийтийн оролцоог сайжруулах;

Долдугаар зорилт: Ундны усны хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах.

14. Хоол, тэжээлийн асуудлаар дэвшүүлсэн зорилт:

Наймдугаар зорилт: Хүн ам, олон нийтийн хоол, тэжээлийг сайжруулах;

Есдүгээр зорилт: Эмзэг бүлгийн хүн амын хоол, тэжээлийн байдлыг сайжруулах;

Аравдугаар зорилт: Хүн амын хоол, тэжээлийн талаархи мэдлэг, дадлыг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх;

Арван нэгдүгээр зорилт: Хүн амын эрүүл мэндийг бичилбодис, аминдэмийн дутлаас

сэргийлэх зорилгоор өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүнийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологийн дагуу баяжуулан хэрэглэж хэвших.

15. Нийтлэг зорилт:

Арван хоёрдугаар зорилт: Болзошгүй гамшиг, онцгой байдлын үед хүн амын хоол, тэжээл, эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, мэдээлэх, хяналт тавих, шаардлагатай зориулалтын хүнсийг үйлдвэрлэх, бэлтгэх, туслах тогтолцоог бүрдүүлэх;

Арван гуравдугаар зорилт: Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох;

Арван дөрөвдугээр зорилт: Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээлийн чиглэлээр үндэсний боловсон хүчний чадавхийг сайжруулах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрийн зорилтуудыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

16. Нэгдүгээр зорилтын хүрээнд:

а/хот, суурин газрын хүн амыг эрүүл ахуй, ариун цэврийн аюулгүй байдалд бэлтгэгдсэн мах, махан бүтээгдэхүүнээр хангах;

б/махны үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, хямд төсөр олон нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулалтын зохистой сүлжээг бий болгох;

в/махны үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд чиглэсэн "Махны экспорт" төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

г/"Цагаан хувьсгал" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа арга хэмжээг дүгнэж эрчимжүүлэх;

д/төв, суурин газрын хүн амын сүү, цагаан идээний өдөр тутмын хангамж, ялангуяа нялхас, бага насны хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрлэлийг аюулгүй цэвэр түүхий эдээр хангах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

е/сүү, сүүн бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын зохистой сүлжээг бий болгох;

ж/"Ногоон хувьсгал" хөтөлбөрийн дагуу төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх;

з/төмс, хүнсний ногооны хүн амын физиологийн хэрэгцээний хангалтын түвшинг дээшлүүлэх, улмаар бүрэн хангахтай холбогдсон арга хэмжээг дэмжин дэлгэрүүлэх;

и/өрх гэр, аж ахуйн нэгж, улсын нөөцийн үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн хэрэгцээг хангах, төрөлжсөн үрийн аж ахуйнуудыг хөгжүүлж, зээл, хөрөнгө оруулалтаар дэмжих;

к/төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тарих, хадгалах, боловсруулах үйл ажиллагааг дэмжих, сургалт явуулах, зөв хэрэглээнд сургах.

17. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

а/улаан буудай, бусад үр тарианы дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

б/гурилын үйлдвэрүүдийн жигд ажиллагааг хангах, улаан буудайнаас бусад үр тариа боловсруулах технологи эзэмшихийг дэмжих;

в/талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж тэдгээрийн дотоодын зах зээлд эзлэх хувийг өсгөж хот, хөдөөгийн хангамжийг жигд болгох.

18. Гуравдугаар зорилтын хүрээнд:

а/хүнсний бүтээгдэхүүнийг ариутгах, аюулгүй байдлыг хамгаалах, хаягдалгүй

технологи, дэвшилтэт сав, баглаа боодлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг дэмжих;

б/ургамлын тос, саахар, загас, өндөг зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дотоодод бий болгон хөгжүүлэхэд онцлон анхаарах, найдвартай импортлогчдыг дэмжих;

в/ундааны үйлдвэрлэлд байгалийн цэнгэг ус, жимс, ургамлын гаралтай ханд, бэлдмэлийг өргөн ашиглах;

г/баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг урамшуулан дэмжих.

19. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

а/хүнсний хяналтын салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаог сайжруулах;

б/хүнсний аюулгүй байдлын хяналт болон эрсдэлийн шинжилгээний стандарт аргуудыг боловсруулах;

в/хүнсний аюулгүй байдлын асуудлаар хөрш зэргэлдээ болон бусад улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх;

г/хүнсний хууль эрх зүйн хорооны зөвлөмжийн дагуу үндэсний хууль эрх зүйн хороо (техникийн хороо)-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх.

20. Тавдугаар зорилтын хүрээнд:

а/лабораториудыг хөгжүүлэх төсөл боловсруулан хэрэгжүүлэх;

б/хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэн мэргэшүүлэх.

21. Зургадугаар зорилтын хүрээнд:

а/хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний байгууллагад эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулж зохистой хэрэглээний дадал заншилд иргэдийг сургах.

22. Долдугаар зорилтын хүрээнд:

а/хэрэглэгчдийг чанартай, хүрэлцээтэй усаар найдвартай хангахад чиглэгдсэн усны эх үүсвэрийн хайгуул, судалгааг хийж нөөцийг тогтоох;

б/хүн амын ундны усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож паспортжуулах;

в/усны нөөц нь ундны усны чанарын стандартын шаардлага хангаагүй сум, суурин газруудад ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх арга хэмжээ авах;

г/томоохон хотуудын ус хангамжийн эх үүсвэр-газрын доорхи усны горимын өөрчлөлт, бохирдлыг хянах хэмжилтийн сүлжээг тэдгээрийн ай савуудаар байгуулж эхлэх.

23. Наймдугаар зорилтын хүрээнд:

а/хоол, тэжээлийн үндэсний лавлагаа, норм хэмжээ, зөвлөмжүүдийг хянан шинэчлэх;

б/хүн амын эрүүл мэндийг дэмжих зохистой хооллох үндэсний зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх;

в/цэцэрлэгийн насны болон өсвөр үеийн хүүхдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх;

г/хүн ам, олон нийтийн хоол, тэжээлийн асуудлыг шийдвэрлэхэд нийгэм, сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгох, стандарт шалгуур боловсруулж хэрэгжүүлэх.

24. Есдүгээр зорилтын хүрээнд:

а/эхчүүд, бага насны хүүхдийн хоол, тэжээл, амьдралын хэв маягийг дэмшлүүлэх

чиглэлээр Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газартай хамтарч ажиллах;

б/нялхас, 06-24 сартай бага насны хүүхдүүдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах, нэмэгдэл хоолны тэжээллэг чанар, асран хамгаалахуйн эерэг дадлыг дэмжих;

в/жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах;

г/бага (5 хүртэлх) насны хүүхдийн өсөлтийг дэмжих болон хянах тогтолцоог бүрдүүлэх;

д/бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг төмөр дутлын цус багадалтаас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулах;

е/иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хянан нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

ж/бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг Д аминдэмийн дутлаас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулах;

25. Аравдугаар зорилтын хүрээнд:

а/хүн ам, олон нийтийн зөв зохистой хооллолтын талаар мэдээлэл, сургалт сурталчилгаагаар хангах ажлыг эрчимжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулсан салбар хоорондын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох.

26. Арван нэгдүгээр зорилтын хүрээнд:

а/хүнсийг баяжуулах, ялангуяа гурил, гурилан бүтээгдэхүүнийг Д аминдэм болон төмрөөр, сүү, сүүн бүтээгдэхүүнийг С аминдэмээр баяжуулах орчин үеийн технологийг нэвтрүүлэх;

б/хүнсийг баяжуулах стандарт, технологийн орчинг бүрдүүлэх.

27. Арван хоёрдугаар зорилтын хүрээнд:

а/гамшиг, онцгой байдлын үеийн хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол, тэжээл, эрүүл мэндийн байдлыг хянах, мэдээлэх, зөвлөх, туслах.

28. Арван гуравдугаар зорилтын хүрээнд:

а/үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх.

29. Арван дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

а/хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол судлалын чиглэлээр үндэсний боловсон хүчний мэргэжлийн чадавхийг сайжруулах;

б/хүнсний үйлдвэрлэл, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын хоол, тэжээлийн талаархи мэдлэг, хандлага, чадавхийг дээшлүүлэх.

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

А. Ойрын үр дүн (2001-2005 он)

30. Хүнсний хангамж

а/газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, хүн амын хүнсний хэрэгцээний гурилын 50-60 хувь, төмс, хүнсний ногооны 60-70 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг болно;

б/мах, сүүний бэлтгэл, тэдгээрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хангамж үйлчилгээ сайжирч, үйлдвэрлэлийн аргаар боловсруулагдах хэмжээ 2000 онтой харьцуулбал 2-3 дахин нэмэгдэнэ;

в/баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний талаар төрийн бодлого чиглэл тогтож, баяжуулсан болон зориулалтын хүнсний үйлдвэрлэл хот, хөдөөд жигд хөгжинө;

г/хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалт, импортын

шатанд тавигдах чанар, эрүүл ахуйн хяналт, мэдээ мэдээллийн тогтолцоонд дэвшил гарна.

31. Хүнсний аюулгүй байдал

а/хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтын хууль эрх зүйн орчин, стандарт, дүрэм, заавар боловсронгуй болж, лабораторийн материаллаг баазыг бэхжүүлж, байцаагчдыг мэргэшүүлснээр хяналтыг олон улсын түвшинд хийх нөхцөл бүрдэнэ;

б/хүнсний аюулгүй байдлын хяналтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл тодорхой болж, хяналтын ажил сайжирна;

в/хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад эгзэгтэй цэгийн хяналт нэвтрүүлнэ;

г/хүнсний бүтээгдэхүүнийг импортлох бодлого, чиглэлтэй болж, аюулыг тодорхойлж, аюулгүй байдалд үнэлгээ өгч, хяналт тавьдаг болно.

32. Хоол, тэжээл:

а/монгол хүний зохистой хооллох үндэсний эвлөөмж, хоол, тэжээлийн хэрэглээний лавлагаа, хэмжээ шинэчлэгдэнэ;

б/хоол тэжээлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, зохистой хооллолтын талаар эвлөлгөө өгөх газрууд бий болж үйл ажиллагаа нь тогтмолжино;

в/хоол, тэжээлийн мэдээллийн сан бүрдэнэ;

г/хоол судлалын үндэсний боловсон хүчний чадавхи дээшилнэ;

д/бага насны хүүхдийн өсөлтийг хянах үндэсний тогтолцоо бий болно;

е/хүн амын хоол, тэжээлийн байдлыг үнэлэх нэгдсэн тогтолцоо бүрдэнэ;

ж/хоол, тэжээлийн талаархи хүн амын мэдлэг дадал нэмэгдэнэ;

з/хоол, тэжээлийн байдлыг сайжруулах, хоол, тэжээлтэй холбоотой эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв нэмэгдэнэ.

Б. Алсын үр дүн (2006-2010 он)

33. Хүнсний хангамж:

а/хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээний 80-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана;

б/хүнсний бүтээгдэхүүний хангамж жигдэрч, баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ 2005 онтой харьцуулбал 2 дахин нэмэгдэнэ;

в/хүнсний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээ, аюулгүй байдал,хоол,тэжээлийн талаар төрийн захиргааны байгууллагуудын хооронд шуурхай мэдээлэл солилцох, улсын хэмжээний статистик мэдээ авах нэгдсэн сүлжээ бий болно.

34. Хүнсний аюулгүй байдал

а/халдварт болон халдварт бус өвчин хоол, хүнсээр дамжих явдал тогтвортой буурна;

б/хүнсний аюулгүй байдлын асуудлаар хүн амын мэдлэг, хандлага, дадал сайжирч, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн сонгон авч хэрэглэх байдал сайжирна;

в/хүнсний аюулгүй байдлын хяналтын лабораторийн хүч чадал, материаллаг бааз сайжирч, аккредитатчиллын тогтолцоог нэвтрүүлнэ.

35. Хоол, тэжээл

а/эхчүүд, бага насны хүүхдийн хоол, тэжээлийн дутлын (уураг илчлэг дутлын өсөлт хоцролт, жингийн алдагдал, иод, төмөр дутал) эмгэгийн тархалт буурна;

б/хоол, тэжээлтэй холбоотой

архаг өвчлөл (хоол боловсруулах, зүрх судасны эмгэг, хорт хавдар), нас баралт буурна.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

36. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах арга зам:

а/хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий салбар хоорондын зохицуулах Үндэсний хороо ажиллана;

б/салбар хоорондын зохицуулах Үндэсний хороонд холбогдох төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл оролцох бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд тэргүүлэх үүргэтэй оролцоно.

37. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтолцоо:

а/салбар хоорондын зохицуулах Үндэсний хороог Хүнс, хөдөө аж ахуйн сайд удирдаж, орон тооны нарийн бичгийн дарга Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ажиллуулна;

б/орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлийг хангах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч удирдана.

38. Оролцогч дотоодын болон олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд:

Олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, салбарын холбоод, бусад оролцогч байгууллагуудаас бүрдсэн Зөвлөлдөх ажлын хэсгийг байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцуулж болно.

39. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтыг салбар хоорондын зохицуулах Үндэсний хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, орон нутгийн салбар зөвлөлүүд гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

40. Зардлын тодорхой хувийг улсын төсөвт жил тутам тусгана.

Хөтөлбөрийн хүрээнд 2005 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн нийлбэр дүнгээр түүний нийт санхүүжилтийг тооцно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгах болон гадаадын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулна.

41. Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж:

а/"Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол, тэжээл" Үндэсний хөтөлбөр гарснаар хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны тодорхой хэсгийн хэрэгжилтэд НҮБ-ын төрөлжсөн байгууллага, бусад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас дэмжлэг, туслалцаа авна;

б/Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах зорилгоор хандивлагч орнуудын уулзалтыг тусгайлан зохион байгуулах талаар ажиллана.

42. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хандив, тусламж

Салбар хоорондын зохицуулах Үндэсний хороо, орон нутгийн салбар зөвлөлүүд, Зөвлөлдөх ажлын хэсэг гадаад болон дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс санхүүжилтийн эх үүсвэр олох, хандив, тусламж авах үйл ажиллагааг явуулна.

43. Төрийн бус байгууллагын хандив, тусламж

Хөтөлбөрийн зарим зорилт, үйл

ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага өөрийн туршлага, арга барилд нийцүүлэн оролцох, тодорхой үүрэг хүлээх, хандив, тусламж үзүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

44. Үе шат:

Нэгдүгээр үе шат: 2001-2005 онд дотоодын хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал, хоол, тэжээлийн байдлыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх.

Хоёрдугаар үе шат: 2006-2010 онд Монгол Улсад хүнсний хангамжийг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг ханган, хоол, тэжээлийг төгөлдөржүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн хэтийн зорилгод хүрэх.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,үнэлгээ

45.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг аймаг, нийслэл, улсын хэмжээгээр тодорхойлох.

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараахь байдлаар гүйцэтгэнэ:

а/аймаг, нийслэлийн статистикийн тогтмол мэдээлэл, судалгаанд тулгуурлаж, улсын хэмжээнд харьцуулалт хийх замаар;

б/эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа, тайлан, зөвлөмжүүдээс;

в/олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын мэдээ, дүгнэлт, зөвлөмжөөс;

г/яам, газруудын тайлан, мэдээлэл, судалгаа, хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлангаар.

46. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг зорилт тус бүрээр тодорхойлох:

а/статистикийн тогтмол мэдээлэл, судалгаа, тайлан, зөвлөмжийн зэрэгцээ хөтөлбөрийн зорилт бүрээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үр дүнг тооцно;

б/хөтөлбөрийн үр дүн нь зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжих тусгай хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдоно;

в/хүн амын хоол, тэжээлийн бодит байдал, түүний бүтэц, найрлага, хүнсний зохистой хэрэглээний өсөлт, хоол, тэжээлтэй холбоотой өвчлөлийн бууралтаар тодорхойлогдоно.

(Тус тогтоолын 2, 3, 4 дүгээр хавсралт даралгийн дугаарт орно)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (234)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*
- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2002 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арванхоёрдугаар сарын 7 №47 (234)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

582. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-16-ны хууль) 1069

583. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-16-ны хууль) 1073

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

584. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 84 1073

585. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2002 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 85 1114

586. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 90 1115

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

587. Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоолын 2, 3, 4 дүгээр хавсралт 1116

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуульд [1] дүгээр зүйл, 2, 9, 10, 21 дүгээр зүйлд дор дурдсан гуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ [3] дүгээр зүйл:

"[3] дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

1. Энэ хуульд заасан дараахь нэр томъёог ор дурдсан утгаар ойлгоно:

1/ "татвар ногдох орлого, орлогоос усад татвар ногдох зүйлийг нуусан" гэх орлого, олгоос бусад татвар ногдох зүйлийг биетэр нуун эрагдуулах, үндэслэлгүйгээр бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулах, нягтлан бодох бүртгэл болон татварын тайланд санаатайгаар бууруу бичилт хийх, хууль бус хэлцэл хийж, хууран мэхлэх, холбогдох баримт бичгийг гаргаж өгөхгүй байх, хуурамчаар өглөг үүсгэх, түүнчлэн баримт бичгийг татвар төлөхгүйн тулд хуурамчаар үйлдэх, аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэр, хаяг, тамга, тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөл болон эд хөрөнгө, иргэний бичиг баримтаа бусдад ашиглуулах замаар татвараас зайлсхийх боломж олгосон зөрөг үйлдэл, эс үйлдлийг;

2/ "татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг санаатайгаар бууруулсан" гэх татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийн тоо хэмжээ, үнийг няглан бодох бүртгэл, тайлан тэнцэл, тайлан, мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд санаатай багасган тусгах, орлогоо багасгаж харуулахын тулд засварлах замаар хуурамч баримт бичиг үйлдэх, зардлаа хуурамчаар есгэх буюу орлогоо зохиомлоор багасгах үйлдлийг;

3/ "татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан" гэх татвар ногдох орлого, татвар ногдох зүйлийн тоо хэмжээг няглан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан, мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны үйлдэл алдах, түүнчлэн няглан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтөлж, тайлан тэнцлээ зөв гаргасан боловч татвар ногдох орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүнг буруу тодорхойлсон үйлдлийг;

4/ "тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсноор татвар төлөх үүрэг дуусгавар болох" гэж Улсын Их Хурал үг төрлийн татварын хуулийг хүчингүй болгож, татварын тооцоог хийж дуусгах хугацаа дуусснаар;

5/ "татвар, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн" гэж тухайн татвар төлөгч:

а/ хаягаа буруу тодорхойлсон;

б/ хаягийн өөрчлөлтөө татварын албанд мэдэгдэж, улсын бүртгэлийн гэрчилгээндээ тэмдэглэл хийлгээгүй;

в/ няглан бодох бүртгэлийн болон тайлан тэнцэл, татварын тайлан, мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсыг гаргаж өгөөгүй;

г/ татварын албанаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй;

д/ шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаа нь мэдэгдэхгүй байх зэрэг шалтгаанаар ногдох татвараа хуульд заасан хугацаанд төлөөгүй;

6/ "хүчингүй гэрээ, хэлцэл" гэж утга агуулгаараа хууль зөрчсөн буюу хуулиас гадуур хийгдсэн, бага насны хүмүүс, сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио зэрэг шалтгааны улмаас эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдтэй хийсэн хэлцэл, айлган сүрдүүлэх буюу аргагүй гачигдлыг далимдуулан хийсэн хэлцэл, хууль ёсны үр дүн гаргахын тулд биш зөвхөн дүр үзүүлэн хийсэн хэлцлийг;

7/ "хууль бус үйлдлээр олсон орлого" гэж татварын болон бусад хууль тогтоомжийг зөрчиж олсон орлогыг;

8/ "саад учруулсан" гэж татварын албаны байцаагч албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай санхүүгийн баримт, няглан бодох бүртгэл болон тайлан тэнцэл, татварын тайлан мэдээг гаргаж өгөхгүй байх, байр агуулахад нэвтрэн орох боломж олгохгүй байх, тооллого тооцоог будлиантуулах, түүнчлэн үзлэг шалгалт, ажлын зураг авалтыг хийлгэхгүй байх зэрэг саналтай үйлдэл, эс үйлдлийг;

9/ "эсэргүүцэл үзүүлсэн" гэж татварын албаны байцаагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цохих, өшиглөх, түлхэх, аливаа зүйлээр цацах, биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэх, биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэхээр заналхийлэх, хэл амаар доромжлох үйлдлийг;

10/ "шилжүүлсэн орлого" гэж гэрээ хэлцлийн үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагад болон иргэний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар нь дамжуулан олгохоор бэлэн бусаар шилжүүлснийг;

11/ "татвар төлөгч байгууллага" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татварын албаа болон бүртгэх эрх бүхий бусад байгууллагад бүртгүүлсэн, энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар татвар төлөгч байгууллага гэж тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага, санг;

12/ "ашгийн төлөө байгууллага, сан" гэж аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоороо зардлаа бүрэн нөхөх зарчмаар ажиллах ёстой хуулийн этгээдийг;

13/ "дундын сууталт" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас жилийн дундуур иргэдэд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах болон хуульд заасан бусад орлогод үг орлогыг олгож буй этгээд нь татварын хуульд тогтоожид заасны дагуу татварыг нь ногдуулан суутган авч төсөвт шилжүүлэхийг;

14/ "татварын өр" гэж татварын хуулиар тогтоосон хугацаанд нь төлөгдөөгүй татвар, тэдгээрт ногдсон хүү, торгууль, татварын хяналт шалгалтаар илэрч төлөгдөхөөр тогтоогдсон нөхөн татвар, хүү, торгуулийг."

2/ 2 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

"4. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж тогтвортой байдлын гэрээг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуулийн хүрээнд байгуулна.

5. Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө."

3/ 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Татвар ногдох орлогыг нэхэмжилсэн, падаан бичигдсэн, төлбөр хийгдсэн өдрийн аль түрүүчийнхээр нь тооцно. Хөрөнгө оруулатын санхүүжилтийн эх үүсвэртэй татварын орлогын хугацааг төлбөр хийгдсэн өдрөөс эхэлж тооцно."

4/ 10 дугаар зүйлийн 7-14 дэх заалт:

"7/ татварын хуульд тусгайлан татвар ногдуулахаар заасан орлогод татвар ногдуулж, хуульд заасан хугацаанд төсөвт төлөх;

8/ хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;

9/ аж ахуйн нэгж, байгууллага нь дундын суутгал хийсэн татварын ногдуулалт, төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж, байгууллага, ургэний нэр, хаяг, регистрээр улирал тутам гаргаж өөрийн харьяалагдах татварын албанд өгөх;

10/ татвар ногдох эд хөрөнгө, эрхээ бусдын өмчлөлд шилжүүлсэн тухай баримтыг татварын албанд гаргаж өгөх;

11/ өөрийн нэр хаяг, тамга, тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, харилцах болон хувийн дансыг бусдад ашиглуулан татвараас зайлсхийх боломж олгохгүй байх;

12/ эрх бүхий байгууллагаас авсан бусгай зөвшөөрлийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээслэсэн, худалдсан тохиолдолд харьяалагдах татварын албанд мэдэгдэх;

13/ банкинд данс нээсэн болон түүнийг заасан бол энэ тухай харьяалагдах татварын албанд тэдэгдэх;

14/ татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газраас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, арга чилэл, зөвлөмжийг дагаж мөрдөх;"

5/ 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг :

"6. Үндэсний татварын ерөнхий газрын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд заасан татварын улсын байцаагчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

1/ татварын албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангах;

2/ татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинээр дагаж мөрдөх журам, заавар, арга чилэл, зөвлөмж гаргах;

3/ татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг тодгэлэгүүлэх, сахилгын шийтгэл хүлээлгэх;

4/ татварын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад дагаж мөрдөх тушаал гаргах ;

5/ татварын бодлого боловсруулахад оролцох;

6/ орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээний төсөлд санал өгөх;

7/ татварын улсын байцаагчийн гаргасан актыг хуулийн дагуу хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгох;

8/ Үндэсний татварын ерөнхий газрын ажилтнуудыг томилох, чөлөөлөх;

9/ татварын улсын байцаагч, татварын улсын ахлах байцаагч бүрэн эрхээ хэрэзэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;

10/ Үндэсний татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах."

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4 дэх заалт, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай :

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ тус улсын нутаг дэвсгэрт оршин байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, сан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байрладаггүй боловч тус улсад орлого олж байгаа хуулийн этгээд;"

2/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,4 дэх заалт, 2 дахь хэсэг:

"1/ татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлогын татвар ногдуулах орлоготой тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

4/ татвараас хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнгээс бодож хоног тутам 0.5 хувийн хүү ногдуулах. Энэ "хүү" гэсэн ойлголт нь Монгол Улсын Иргэний хуулийн "анз" гэсэн ойлголтонд хамаарахгүй.

2. Татвар, хүү, торгууль төлөх хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна. Энэ нь Монгол Улсын Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаанд хамаарахгүй. Татвар, хүү, торгууль төлөх хөөн хэлэлцэх хугацааг зохих журмын дагуу татвар тодорхойлж, түүнийг төлөх хуульд заасан хугацаа дууссан үеэс эхэлж тооцно."

3/ 16 дугаар зүйл:

"**16 дугаар зүйл. Улсын татвар**

Улсын татварт дараахь татвар хамаарна:

1/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар;

2/ гаалийн албан татвар;

3/ нэмэгдсэн өртгийн албан татвар;

4/ онцгой албан татвар;

5/ авто бензин, дизелийн түлшний албан татвар;

6/ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр."

4/ 17 дугаар зүйл:

"**17 дугаар зүйл. Орон нутгийн татвар**

Орон нутгийн татварт дараахь татвар хамаарна:

1/ хүн амын орлогын албан татвар;

2/ бууны албан татвар ;

3/ нийслэл хотын албан татвар;

4/ нохойны албан татвар;

5/ өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;

6/ үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

7/ улсын тэмдэгтийн хураамж ;

8/ ус, рашаан ашигласны төлбөр;

9/ авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

10/ ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж ;

11/ байгалийн ургамал ашигласны төлбөр;

12/ түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;

13/ агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж ;

14/ газрын төлбөр;

15/ ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр."

5/ 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Үндэсний татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын албаны бүтцэд татварын хэрэг буртгэх нэгжтэй, үндэсний татварын албанд нь Татварын хөгжлийн сантай байна.Татварын хөгжлийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг Засгийн газар тогтооно."

6/ 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт :

"3/ татвар ногдох зүйл нүүсныг гэрчлэх баримт болон эд хөрөнгийг татвар төлөгчөөс түр хугацаагаар хураан авах, хуулбарлах, барьцаалах, битүүмжлэх; "

3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь заалтын дугаарыг "15" гэж , 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "16 дугаар зүйлийн 1-14" гэснийг "16 дугаар зүйлд" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "16 дугаар зүйлийн 15-19-д" гэснийг "17 дугаар зүйлийн 13-15-д" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн "17 дугаар зүйлд" гэснийг "17 дугаар зүйлийн 1-12-д" гэж, 21 дүгээр зүйлийн гарчигийг "Үндэсний татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх" гэж тус тус өөрчилсүгэй .

4 дүгээр зүйл. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд "13.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулж орон нутагт хуваарилна." гэсэн хэсэг нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 84** **Улаанбаатар хот**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

а/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулж байх;

б/ Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлах, хянах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулан 2002 оны I улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг шуурхай зохион байгуулж, дүнг хагас, бүтэн жилээр гаргаж, дараа сарын 5-ны дотор Засгийн газарт хүргүүлж байхыг Монголбанк, Үндэсний статистикийн газарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2002 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Бодлогын зорилт	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх эзэн
1	2	3	4
	Нэг. Макро эдийн засгийн хүрээнд:		
	Эдийн засаг, нийгмийн хүрээний бутцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төсөв, мөнгө, ханш, гадаад худалдааны оновчтой бодлого явуулах замаар дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2002 онд 4.1 хувьд хүргэнэ.		
1.Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ сэргэн хөгжих орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлнэ.	- Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх удирдлага, зохицуулалтыг сайжруулна.	жилдээ	Ч.Улаан О.Чулуунбат
	- Бизнесийн үйл ажиллагааг дэмжих гадаад, дотоод хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	жилдээ	О.Чулуунбат Ч.Улаан
	- Эдийн засгийн өсөлтийг хангах бодлогыг ядуурлыг бууруулах стратегитэй нягт уялдуулна.	жилдээ	Ч.Улаан
	- Далд эдийн засгийг хязгаарлах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор нягтлан бодох бүртгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулна.	жилдээ	Ч.Улаан Ц.Нямдорж
	- Боловсруулах болон уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах эдийн засгийн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн арга хэмжээ авч, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний өсөлтийг хангана.	жилдээ	Д.Насанжаргал
2.Төсвийн байгууллагын бүт-цийн өөрчлөлтийг эрчимжүүлэн, төсвийн зарлагын хяналтыг өндөржүүлж, орлогын баазыг өргөтгөх замаар ДНБ-д төсвийн	- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг батлуулж, мөрдөж эхэлнэ.	II улирал	Ч.Улаан
	- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль мөрдөхтэй холбоотойгоор төсвийн байгууллагуудын санхүүжилтийн тогтолцоог шинээр	оны эхнээс	Ч.Улаан холбогдох сайд нар

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2001 он №47 (284)

нийт алдагдлын эзлэх хувийг бууруулж 7.1 болгоно.	зохион байгуулах бэлтгэлийг хангаж нэвтрүүлэх, төсвийг дунд хугацаатаар төлөвлөх журмыг бүрэн шинэчлэлтэй хэмжээ авна. - Төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ. - Татварын албаны удирдлага, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн бэхжүүлж, татварын байцаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, татвар хураалтыг бүх шатанд сайжруулна. - Орон нутаг төсвөө бие даан бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авна. - Татвар хураах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх иж бүрэн стратеги боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ. - Татварын баазыг өргөтгөх, татварын ачаалыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах чиглэлээр татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж мөрдөж эхэлнэ. - Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих ажлыг үргэлжүүлэн, Засгийн газрын бэлэн мөнгөний урсгалыг зохистой удирдах, төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, хяналтыг сайжруулах арга хэмжээ авна. - Нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулж аймаг, нийслэлд хуваарилан олгоно. - Монгол суурьтай буртгэлийн тогтолцооноос аккруэль	жилдээ жилдээ жилдээ жилдээ жилдээ оны эхнээс жилдээ	Ч.Улаан Ч.Улаан Ч.Улаан Ч.Улаан Ч.Улаан Ч.Улаан Ч.Улаан

1	2	3	4
	суурьтай бүртгэл шилжих ажлыг хэрэгжүүлж эхэлнэ. - Түстай зориулалтын сан, зээл, тусламжийн үйл ажилагааны тайланг олон улсын жишигт нийцүүлэн гаргадаг мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгоно. - Улсын төвөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, он дамжсан, хугацаа хэтэрч байгаа объектуудыг шалгаж, дүгнэлт гаргана.	жилдээ жилдээ жилдээ	Ч.Улаан Ч.Улаан аймаг, нийслэлийн Засаг дарга О.Чулуунбат
3.Монгөний бодлогыг тэнэ, хяшны хэт хөөрөгдөл гаргахгүй байх, төгрөгийн тогтвортой байдлыг хангах, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ.	- Эдийн засгийн өсөлтийг монгөний бодлогоор дэмжих арга хэмжээ авна. - Төв банкны үнэт цаасны бодит хүүг эерэг түвшинд хадгална. - Үнэт цаасны хөрдөлч зах зээлд Засгийн газрын бондын арилжаат нэмэгдүүлж, банкны бүтцийн өөрчлөлтийн бондыг хөрвөх чадвартай үнэт цаасаар солих арга хэмжээ авна. - Банкны хүчтэй хэтэрсэн, чанаргүй зээлийг бууруулах чиглэлээр холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ. - Төгрөгийн ханшны тогтвортой байдлыг хангах, зах зээлийн зарчмаар тодорхойлогдог ханшны тогтолцоог үргэлжүүлэн мөрдөнө. - Гадаад валютын цэвэр нөөцийг импортын барааны 13 долоо хоногийн хэрэгцээг хангахаас доошгүй хэмжээнд хүртэнэ.	оны эхнээс жилдээ жилдээ жилдээ	О.Чулуунбат О.Чулуунбат Ч.Улаан О. Чулуунбат О.Чулуунбат
4. Гадаадын зээл, тусламжийн ашиглалтыг сайжруулж, гадаад худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	-Хандивлагчдын эзэмшит үүлэлт, зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо зохион байгуулна. - Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулан батлуулж, мөрдөнө. - Хандивлагчдын үүлэлт, зөвлөгөөний үеэр амласан	II-III улирал жилдээ жилдээ	Ч. Улаан Л.Эрдэнэчулуун Ч.Улаан Ч.Улаан

1	2	3	4
	зээл, тусламжийг ашиглах гэрээ, хэлэлцээрийг богино хугацаанд байгуулж, хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.		
	- Гадаад худалдааг нээлттэй, чөлөөтэй болгох чиглэлээр Монгол Улсын гадаад худалдааны үзэл баримтлалыг боловсруулж мөрдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг Ч.Улаан
	- Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг Ч.Улаан
	- Уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, экспортын шинэ нэр төрлийн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэх зорилгоор металлургийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулна.	жилдээ	Ч.Ганзориг
	-"Ноолуур", "Ноос", "Арьс шир" дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр оруулах, гаргах үеийн хорио цээр, ариун цэврийн хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	жилдээ	Д.Насанжаргал Ч.Ганзориг
	-Стратегийн ач холбогдол бүхий импортын түүхий эд, үүний дотор нефтийн бүтээгдэхүүн, цахилгаан, эрчим хүчний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Ганзориг Ч.Улаан
5.Арилжааны банкуудын бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.	-Төрийн өмчийн оролцоотой банкуудын төрийн өмчийн оролцоог нарийвчлан тогтоож, хувьчлах бэлтгэлийг хангаж, хувьчилна.	жилдээ	Ч.Улаан О.Чулуунбат
	-Урт хугацааны санхүүжилтийн тогтолцоог бий болгох	III улирал	Ч.Улаан

1	2	3	4
	чиглэлээр хандивлагч орон, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаа хийж, санал боловсруулна.		О.Чулуунбат
	-Банкны өр барагдуулах асуудлаар хуулийн төсөл боловсруулан батлуулж, мөрдүүлэх, Банкны өр барагдуулах газрын эрх зүйн байдлыг тогтоож, зээл төлөлтийг эрчимжүүлнэ.	II улирал	Ч.Улаан О.Чулуунбат
6.Үнэт цаасны зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэлбэрийг боловс-ронгуй болгоно.	-Үнэт цаасны арилжааг нэмэгдүүлэх, санхүүгийн шударга, оновчтой тогтолцоо, бүтэц бий болгох, үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах чиглэлээр Үнэт цаасны тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах, холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлнэ.	жилдээ	С.Гүндэнбал Ч.Улаан
	-Бүх төрлийн үнэт цаас /Засгийн газрын бонд, компаний үнэт цаас, вексель/-ыг гаргах санаачлагыг дэмжих замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	С.Гүндэнбал О.Чулуунбат Ч.Улаан
	-Хөрөнгийн биржийг хувьчлах бэлтгэлийг хангаж, хувьчилна.	III-IV улирал	С.Гүндэнбал Ч.Улаан
	-Төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцооны газрыг бие даасан байдлаар зохион байгуулах санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.	жилдээ	С.Гүндэнбал
	-Улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр, нийтэд худалдана.	жилдээ	С.Гүндэнбал
	-Компанийн хувь нийлүүлэгчдэд ногдол ашиг олгох, хуваарилах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	I-II улирал	С. Гүндэнбал
	-Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн сүлжээ бүрдүүлнэ.	жилдээ	С. Гүндэнбал

1	2	3	4
7.Даатгалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй	-Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, шийдвэрлүүлнэ.	жилдээ	Ч.Улаан
болгож, арилжааны даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.	-Иргэдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах тогтолцоог бий болгох чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	Ч.Улаан Ц.Нямдорж
	-Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг олшруулж, мэдээллийн сүлжээ бий болгоно.	жилдээ	Ч.Улаан
8.Албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгон мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангана.	-Статистикийн мэдээллийн үндэсний сан байгуулах, статистикийн мэдээллийн сүлжээг үндэсэн хэрэглэгч - төрийн байгууллагуудтай холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч. Даваасүрэн Ч. Улаан
	-Статистикийн мэдээллийн бодит байдлыг хангах үүднээс мэдээлэл авах, боловсруулах ажлыг сайжруулах механизмыг бий болгоно.	жилдээ	Ч. Даваасүрэн
	Хоёр. Үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогын хүрээнд:		
	Эдийн засгийн шинэчлэлийг эрчимжүүлэн, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, бизнесийг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг дэмжин 2002 онд ДНБ-нд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 24.5-д хүргэнэ.		
1.Үндэсний үйлдвэрийг сэргээн, боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтийг нэмэгдүүлж, экспортын үйлдвэрлэлийг дэмжинэ.	-Үндэсний үйлдвэрийг сэргээх, суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулахад гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, дотоодын санхүүгийн нөөцийг ашиглана.	Жилдээ	Ч.Ганзориг
	-Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа нь сэргэж буй үйлдвэрүүдийн өмнө нь бий болсон өрийн асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авна.	Жилдээ	Ч. Ганзориг

1	2	3	4
	-Эдийн засгийн тэргүүлэх салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулах тогтолцоог төгөлдөржүүлнэ.	жилдээ	Ч. Ганзориг Ч. Улаан
	- Гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэжит чулуга	III улирал	Ч. Ганзориг
	уулзалтыг Монгол Улсад зохион байгуулна.		Ч. Улаан Л. Эрдэнэчулуун
	-Аж ахуйн үйл ажиллагааны тустай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, стандартыг нэвтрүүлнэ.	жилдээ	Ч. Ганзориг
	-Япон Улсын Засгийн газар болон ХБНГУ, Дэлхийн банк зэрэг хандивлагчдаас олгож буй хөнгөлөлттэй зээлд экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг тулхүү хамруулж, санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэн экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	жилдээ	Ч. Ганзориг Ч. Улаан
	-Гадаадын хөрөнгө оруулагтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	жилдээ	Ч. Ганзориг
	-Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулалтын түвшинг сайжруулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, эцсийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулалтын технологийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.	жилдээ	Ч. Ганзориг
2.Түшиг эрчим хүчний сал-барын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэн төрийн өмчид ног-дох хэсгийг үе шаттайгаар	-Монгол Улсын ашигт малтмалын баялгийн тухай хуулийн хэмжээнд иттэмжлүүлэх, хуудалданы тэмдэгтэй болох замаар олон улсын мэдээллийн нэгдсэн сүлжээнд бүртгүүлэн, түүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. -Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 2 дахь эзэжийн өргөтгөл, шинэчлэлийг дуусган, бусийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, хамрах хүрээг өргөтгөнө.	жилдээ	Б. Жигжид

1	2	3	4
хувьчлах замаар эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах ажлыг өргөжүүлнэ.	-Дөргөн, Улаанбоомын усан цахилгаан станцыг барих гэрээг байгуулах, Эгийн голын усан цахилгаан станцын санхүүгийн эх үүсвэрийг эрэлхийлэх, Баянтээгийн дулааны цахилгаан станцыг барих санхүүгийн эх үүсвэрийг олж, эхлүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Б. Жигжид
	-Үенчийн усан цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлж, Чаргайтын усан цахилгаан станцыг барих бэлтгэлийг хангана.	жилдээ	Б.Жигжид
	-Улаанбаатар хотын II цахилгаан станц, цахилгаан түгээх сүлжээний техник-эдийн засгийн үндэслэлийг тодотгох үндсэн дээр хувьчилна.	жилдээ	Б. Жигжид
	-"Буман нарны гэр" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Архангай, Хэнтий, Дорнод, Увс, Завхан, Булган, Дархан-Уул, Өмнөговь аймагт айл өрхийг нарны цахилгаан үүсгүүртэй болгох арга хэмжээ авна.	жилдээ	Б. Жигжид
	-Баянтээг, Тавантолгой, Адуунчулуун, Тэвшийн говь, Талын гал, Хар тарвагатай зэрэг орон нутгийн нүүрсний уурхайнуудын техник, технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэн, Шарын голын уурхайн орчимд хайгуул хийж, нөөцийг өсгөх замаар Дархан, Эрдэнэтийн бүс нутгийн нүүрсний хангамжийг сайжруулна.	жилдээ	Б. Жигжид
	-Налайхын нүүрсний уурхайн орд газрыг түшиглүүлэн бага чадлын нүүрсний далд уурхайг байгуулах судалгааг явуулж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлнэ.	жилдээ	Б.Жигжид
	-Газрын тосны салбарт төсөл хэрэгжүүлэх замаар нэмэлт хөрөнгө оруулалт, хамтарсан судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.	II улирал	Ч.Ганзориг

1	2	3	4
	-Газрын тосны эрэл хайгуулын судалгаа болон олборлолтыг нэмэгдүүлнэ.	IV улирал	Ч.Ганзориг
	-Тамсаг, Дорноговийн сав газарт чичирхийллийн судалгаа, хайгуул хийж, үнэлгээний цооног өрөмдөж олборлолтыг нэмэгдүүлнэ.	IV улирал	Ч.Ганзориг
3.Уул уурхайн үйлдвэрлэлээс олох экспортын орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг хангана.	-Зэс, молибден, хайлуур жоншны баяжмалын экспортын хэмжээг урьд онуудаас бууруулахгүй байх арга хэмжээ авна.	жилдээ	Ч.Ганзориг
	-Үйлдвэрлэлийг жигдрүүлэх замаар гянт болдын экспортыг 10 хувь, катодын зэсийн үйлдвэрлэлийг 40 орчим хувиар нэмэгдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Эрдэнэтийн ордын исэлдсэн болон балансын бус хүдрийг гидрометаллургийн аргаар боловсруулах талбайг засаж, эхний туршилтыг хийж эхэлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Төмөртэйн овооны цайрын орд, Бороогийн алтны үндсэн орд, Тосонгийн алтны шороон ордыг ашиглах уулын үйлдвэрийг барьж байгуулах ажлыг үргэлжүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Тосонгийн ордоос олборлох алтны хэмжээг нэмэгдүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг
	-Тавтын алт, Цагаан суваргын зэс, Асгатын мөнгөний ордуудыг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн урьдчилсан тооцоог хийж, ашиглах талаар сонирхогч орнуудад санал тавьж, хамтран ажиллана.	жилдээ	Ч.Ганзориг
4.Геологийн хайгуул, судал-гааны ажлыг өргөжүүлж хэтийн төлөв бүхий ордуудад эрэл,	-1:200000-ын масштабтай геологийн зураглалын ажлыг 6000 кв.км талбайд үргэлжүүлэн гүйцэтгэж, мэдээллийн санг баяжуулна.	жилдээ	Ч. Ганзориг

1	2	3	4
судалгааны ажлыг төлөрүүлнэ.	-1:50000-ын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг 9200 кв.км талбайд үргэлжлүүлэн, 9000 кв.км талбайд шинээр эхлүүлнэ. -Мянганы замын чиглэлийн дагуу барилгын материалын хайгуул, судалгааны ажлыг хийнэ.	жилдээ жилдээ	Ч. Ганзориг Ч.Ганзориг
5.Мал аж ахуйн салбарын тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	- Газрын төлбөрийн тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, газар ашиглалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ. - Бүс нутгуудад аймаг дундын нөөц бэлчээрийг бий болгоно. - Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн, тусламжийн барааны борлуулалтын орлогыг ган зудаас хамгаалах сан төлөврүүлж, ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөхөд уг хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр ашиглах тогтолцоог бий болгоно. -Малын үржлийн албаны бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгож, уг ажлын үр дүнг дээшлүүлнэ. -Малын шүлхий өвчин идэвхжиж болох бүс нутгийн малыг дархлаажуулах ажлыг уе шаттай үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. -Иргэн, аж ахуйн нэгжээс шинээр худаг гаргах, ашиглах, бэлчээрийн эвдэрсэн худгийг зээмших эрх зүй, эдийн засгийн урамшуулал, хөшүүргийг бий болгоно. -Малын даатгалын хуулийн төслийг боловруулан батлуулж, мөрдүүлнэ.	жилдээ III улирал жилдээ жилдээ II улирал жилдээ жилдээ	У. Барсболд Д. Насанжаргал Ц. Нямдорж Д. Насанжаргал Д. Насанжаргал Ч. Улаан Д. Насанжаргал Д. Насанжаргал аймаг, нийслэлийн Засаг дарга Д. Насанжаргал Д. Насанжаргал

1	2	3	4
	-Байгалийн гамшгаас малчдад учирсан хохирлыг багасгах арга хэмжээ авна.	жилдээ	Д. Насанжаргал
6.Газар тариаланг сэргээн хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	-Тариалангийн талбайн эзэмшил, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглаагүй тариалангийн талбайн төлбөрийг нэмэгдүүлж, уриншилсан талбай болон газрыг үр ашигтай ашиглан тогтвортой ургац авч байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөх газрын төлбөрийг хөнгөлөх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	жилдээ	Д. Насанжаргал Ц. Нямдорж У. Барсболд
	-Үр тарианы ургацын эрсдлийг бууруулах чиглэлээр үрийн тариаланг даатгах асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	II-III улирал	Д. Насанжаргал Ц. Нямдорж Ч. Улаан
	-Уринш боловсруулалтыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	II улирал	Д. Насанжаргал
	-Тариалангийн талбайн хог ургамалтай тэмцэх арга хэмжээг эхлүүлэн, хог ургамалтай химийн аргаар тэмцэх талбайн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлнэ.	жилдээ	Д. Насанжаргал
	-Усалгаатай тариаланг сэргээхэд анхаарч энгийн болон инженерийн хийцтэй зарим услалтын системийг засварлахад анхаарна.	жилдээ	Д.Насанжаргал аймаг, нийслэлийн Засаг дарга
	- Газар тариалангийн тухай хуулийн төслийг боловсруулан батлуулж, мөрдөнө.	жилдээ	Д. Насанжаргал У. Барсболд Ц. Нямдорж
7.Хүнсний үйлдвэрлэлийн стандарт, чанарын хяналтын тогтолцоог төгөлдөржүүлж, хүнс-ний аюулгүй байдлыг хангах	-“Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	жилдээ	Д. Насанжаргал
	-Гадаадын зээл, тусламж, сонирхогч талын дэмжлэгтэйгээр мах судлалын лаборатори байгуулна.	жилдээ	Д. Насанжаргал

1	2	3	4
нөхцөлийг бүрдүүлнэ.	-Ангийн мах, загас, самар, жимс, мөөг, тослог ба үнэрт ургамал зэрэг байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг уламжлалт арга, орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулах ажлыг зохион байгуулна.	жилдээ	Д. Насанжаргал
	-Өөрийн орны гол, нуурт загасны аж ахуй эрхлэх бодлогыг боловсруулан батлуулж, мөрдүүлнэ.	жилдээ	Д. Насанжаргал
	-Төвлөрсөн хот, суурин газрын хүн амыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнээр тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	жилдээ	Д. Насанжаргал
8.Тээврийн үйлчилгээг өргөт-гөж, техникийн хяналтын тог-толцоог сайжруулна.	-Төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангана.	жилдээ	Б. Жигжид
	-Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ.	жилдээ	Б. Жигжид
	-Авто замын ерөнхий төлөвлөгөө, "Мянганы зам" төслийг үргэлжлүүлэн, зам, замын байгууламжийг барьж байгуулахдаа эхний ээлжинд Мянганы замын чиглэлийн дагуу ходөлгөөн эхлүүлэхэд хөрөнгө хүчийг төвлөрүүлнэ.	жилдээ	Б.Жигжид Ч.Улаан
	-Зам, гүүрийн ашиглалт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр авто замын сангийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид
	-Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нислэгийн холбоо, навигацийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сүлжээг өргөтгөх, нисэх буудлын үйл ажиллагааг сайжруулах, аюулгүй байдлын хамгаалалтыг бэхжүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид

1	2	3	4
	-Сум, багийн холбооны тогтвортой ажиллагааг хангах, шуудан хүргэх ажлыг сайжруулна.	жилдээ	Б.Жигжид Ж.Гүррагчаа
	Гурав.Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд:		
	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, байгаль орчны доройтлыг бууруулахад чиглэсэн цогцолбор бодлого явуулна.		
1.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд аймаг, сум, хот, тосгон, салбар хоорондын хүч чармайлтыг нэгтгэн чиглүүлнэ.	-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Бүс нутгийн хөгжлийг дэмжих асуудлаар хуулийн төсөл боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ.	II улирал	Ө. Энхтувшин Ц.Нямдорж аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Бүс бүрийн хөгжлийн дунд хугацааны стратегийг тодорхойлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (мастер план) боловсруулах ажлыг эхэлнэ.	жилдээ	Ч.Улаан А.Цанжид
	-Бүс нутаг-хот төлөвлөлт, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж эхэлнэ.	жилдээ	Ч.Улаан Б.Жигжид
	-Бүс нутгийн хөгжлийг эдийн засгийн бодлогоор дэмжих арга хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч.Улаан Ч.Ганзориг Б.Жигжид
	-Нутаг дэвсгэрээ бүсчлэн хөгжүүлэх аймгуудын санал, санаачлагыг дэмжиж, сул хөгжилтэй зарим бүс нутаг, сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, туршина.	жилдээ	Ч.Улаан Д.Насанжаргал холбогдох аймгийн Засаг дарга

1	2	3	4
	-Хоршооны хөдөлгөөнийг бүх талаар дэмжиж, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малын эм, тэжээлийн эргэлтийн сан буй болгох, бэлчээр усжуулах, хөдөөгийн хүн амын ундны усны хангамжийг сайжруулахад зориулан олгож байгаа олон улсын байгууллагын хандив, тусламжийг хоршоогоор дамжуулан олгох чиглэлийг баримтлана.	жилдээ	Д.Насанжаргал Ч.Улаан Ш.Батбаяр Ч.Ганзориг Л.Эрдэнэчулуун
	-Аймгийн төвүүдэд бараа, түүхий эдийн биржийг цахим арилжааны төвтэй хамтад нь байгуулж эхлэх, сумдад хоршоо худалдаа, үйлчилгээний мэдээллийн сүлжээ бий болгох ажлыг эрчимжүүлнэ.	жилдээ	Ч.Ганзориг холбогдох аймгийн Засаг дарга
	- Алтанбулаг (Сэлэнгэ аймаг), Замын-үүд (Дорноговь аймаг), Цагааннуур (Баян-Өлгий аймаг)-т худалдааны чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг судлан тогтоож, Алтанбулагийн чөлөөт бүсийн ерөнхий төслийг боловсруулж, хэрэгжүүлж эхлэнэ.	жилдээ	Ч.Улаан Ч.Ганзориг Б.Жигжид
	-Өвөрхангай аймгийг бүсийн төлөөлөл болгон аж ахуй, нийгмийн үйлчилгээг сумдаар бүсчлэн зохицуулах арга замыг судалж, нутаг дэвсгэр, зохион байгуулалтын төсөл боловсруулах ажлыг дэмжинэ.	III-IV улирал	Ч.Улаан Б.Жигжид аймгийн Засаг дарга
	-Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр орон нутагт хийгдэж байгаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хортон шавьж, хулгана устгах, худаг ус засварлах, эмнэлэг, сургууль, соёлын байгууллагын их засварын хөрөнгийг орон нутгийн байгууллагын оролцоо, хяналттайгаар зарцуулах, зарим тохиолдолд аймгийн Засаг даргыг захиалагчаар оролцуулах асуудлыг судлана.	жилдээ	Ч.Улаан

1	2	3	4
	-Хөвсгөл нуур орчимд болон Хархорин, Хужиртад аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөл, арга хэмжээг дэмжин хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Японы "ЖАЛДА" байгууллагын туслалцаатай боловсруулсан Төвийн бүсийн хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгон, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авна.	I-II улирал	Ч.Улаан Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Говийн бүсийн хөгжлийг түргэтгэх иж бүрэн арга хэмжээний санал боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд Европын холбооны ТАСИС хөтөлбөр болон дотоод, гадаадын бусад байгууллага, хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлнэ.	II-IV улирал	Ч.Улаан Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Дархан-Уул, Зуун мод, Чойрыг харилцан уялдаатай хөгжүүлэх арга замыг судалж, үр дүнг "Бүсийн хөгжлийн дунд хугацааны стратеги"-д тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтооно.	III-IV улирал	Ч.Улаан Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Архангай, Булган, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудад орон нутгийн нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2 дахь шатны төслийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.	жилдээ	Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Улаанбаатар хотын гэр хорооллын усан хангамжийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлнэ.	жилдээ	Б.Жигжид нийслэлийн Засаг дарга
	-Нийт 19 аймгийн 48 сумыг нийтийн халуун устай болгох ажлыг хэрэгжүүлнэ.	жилдээ	Б.Жигжид холбогдох аймгийн Засаг дарга
	-Хүн амын ундны хатуулаг, эрдэсжилт ихтэй усыг зөөлрүүлэн цэнгэгжүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Б.Жигжид

1	2	3	4
	-Нийслэлийн хөгжлийн стратеги, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан эхний үе шатны арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.	жилдээ	Б.Жигжид Нийслэлийн Засаг дарга
2.Тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой байгаль орчны урт хугацааны бодлого, хөтөлбөрийг, бүс нуттийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	-Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн 4.5 мянган га тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэлийн зэрэглэлийг тогтоож, түүнийг хамгаалах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад дахин хуваарилан эзэмшүүлнэ.	жилдээ	У.Барсболд аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Нийслэл болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газрын бүртгэлийг хийж, кадастрын зураглалыг гаргана.	жилдээ	У.Барсболд
	- Ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, мод, сөөгний үр бэлтгэх, тарьц, суулгац ургуулах ажлыг эрчимжүүлж, 8.0 мянган га-гаас доошгүй талбайд ойг нөхөн сэргээнэ.	жилдээ	У.Барсболд
	-Химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулж, химийн хортой, аюултай бодисын үндэсний бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.	жилдээ	У.Барсболд аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Ойн хортон шавьжны судалгааг 400 га-д, хортон шавьжны устгалыг 28000 га-д хийнэ.	жилдээ	У.Барсболд

1	2	3	4
	-Бүс нутгийн онцлогт зохицуулан нутгийн иргэдэд түшиглэсэн нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн удирдлагыг бүрдүүлж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зохих хувийг орон нутагт төвлөрүүлэн, байгалийн нөөц болон доройтсон орчныг нөхөн сэргээхэд зарцуулна.	жилдээ	У.Барсболд Ч.Улаан
	-Дарьгангын тэгш өндөрлөгийн зарим хэсэг болон Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хилийн заагийг өргөтгөх, зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах замаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг 1460 мянган га-гаар нэмэгдүүлнэ.	жилдээ	У.Барсболд
	-Байгалийн нөөцийн экологи, эдийн засгийн үнэлгээний арга зүйг сайжруулах замаар газар, байгалийн зарим нөөц, баялаг ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтооно.	III-IV улирал	У.Барсболд Ч.Улаан
	-Бүрэн шаталттай, түлш хэмнэдэг гэрийн зуухны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, нийслэл хотын агаарын бохирдлын түвшин, утааны нягтрал, газар зүйн байршил, ноёлох салхины чиглэл зэрэгт үнэлгээ өгөх үндсэн дээр 20 мянган айл өрхийг шинэ загварын зуухаар хангана.	жилдээ	У.Барсболд Ш.Батбаяр Нийслэлийн Засаг дарга
	-Уул уурхайн ашиглалтын явцад доройтсон орчныг аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн сэргээлгэх эрх зүй, эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлнэ.	жилдээ	У.Барсболд Ч.Ганзориг
	-Ховор амьтдыг өсгөн үржүүлэх чиглэлээр буга болон хүдрийн аж ахуй байгуулах арга хэмжээг өргөтгөнө.	жилдээ	У.Барсболд
	-Цөлжилтийн явц байдлыг тодорхойлох, түүнтэй тэмцэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулна.	III-IV улирал	У.Барсболд

1	2	3	4
	- Элсний нүүлтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах зорилгоор говь хээрийн бүсэд ногоон байгууламжийн талбайг 300 га–гаар нэмэгдүүлнэ.	II-III улирал	У.Барсболд холбогдох аймгийн Засаг дарга
	-Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялгаж, зориулалтын хогийн цэгт хаядаг технологи, журмыг боловсруулж нэвтрүүлнэ.	I-II улирал	У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд хуваалдаалах эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль орчны салбарын хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	жилдээ	У.Барсболд Ц.Нямдорж
	-Байгаль орчны статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, байгаль орчны мэдээллийн сан, сүлжээг өргөтгөнө.	I-III улирал	У.Барсболд
	-Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, байгаль хамгаалагчид болон байцаагчдын эрх, үүргийг өргөтгөн, тэдний хариуцлагыг дээшлүүлэх, уналга, дүрэмт хувцас, бие хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ авна.	жилдээ	У.Барсболд
	Дөрөв. Хүний хөгжил, нийгмийн бодлогын хүрээнд:		
	Хүний хөгжлийн тэгш орчныг бүрдүүлэх, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.		
1.Төрөөс баримтлах хүн амын бодлогын хүрээнд зохион байгуулах ажлыг өргөжүүлнэ.	-НҮБ-ын Хүн амын сантай хамтран "Хүн ам ба хөгжил" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах талаар 2010 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлнэ.	III улирал	Ш.Батбаяр Ч.Улаан П.Нямдаваа А.Цанжид

1	2	3	4
	-Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түүвэр судалгааны дүнд үнэлгээ өгч, шилжих хөдөлгөөний талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.	II улирал	Ш.Батбаяр
	-Эцэг, эхийн хараа хяналтаас гарч, олон жил тэнэмэл амьдралд дассан, гэмт хэрэг, зөрчилд удаа дараа холбогдсон буюу бусад хүүхдэд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүүхдийг тусгайлан хүмүүжүүлэх хөдөлмөр, хүмүүжлийн сургууль байгуулан ажиллуулах асуудлыг судална.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан А.Цанжид
2.Иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулахад чиглэсэн ажлыг эрчимжүүлнэ.	-Орон сууц барих санг бүрдүүлж, зээл олгохтой холбоотой эрх зүйн актуудыг батлан гаргаж, иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.	жилдээ	Б.Жигжид Ч.Улаан
	-Орон сууцны зээлийн сангаас эхний ээлжинд залуу гэр бүл, төрийн албан хаагчдад зээл олгох ажлыг хэрэгжүүлнэ.	жилдээ	Ч.Улаан Б.Жигжид Ш.Батбаяр
	-Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг гэр, орон сууцаар хангах дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	II улирал	Ш.Батбаяр Б.Жигжид
3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах замаар ажилгүйдлийн түвшинг эдийн	-Хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Хөдөлмөрийн тухай, Ажилгүйдлийн даатгалын тухай хуулиудад зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэнэ.	жилдээ	Ш.Батбаяр

1	2	3	4
засгийн идэвхтэй хүн амын 5 хувиас хэтрүүлэхгүй байлгана.	-“Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд гадаадын зээл, тусламжийн ашиглалтыг сайжруулах, түүнийг шинээр ажлын байр бий болгох, өрхийн амьжиргааг тэтгэх, залуу гэр бүл, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд орон сууц барихад нь хөнгөлөлт үзүүлэх, иргэдэд урт хугацааны зээл олгоход чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн албадын чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн хөрөнгийг оновчтой хуваарилах, үр ашигтай зарцуулах ажлыг нэгдсэн удирдлага, хяналтаар хангана.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-“Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд амьжиргааны доод түвшингээс бага орлоготой иргэдийг сургалтад хамруулах, ажлын байртай болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Тахир дутуу, одой иргэдийг зөвлөлгөө, мэдээллээр хангаж, мэргэжлийн сургалтад хамруулах, ажилд зуучлах үйлчилгээг өргөжүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэд, аж ахуйн нэгжид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох замаар 4200-гаас доошгүй ажлын байр бий болгоно.	жилдээ	Ш.Батбаяр

1	2	3	4
	-Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй хүмүүс, тухайн онд ЕБС-ийн 8,10 дугаар анги төгссөн, хугацаат цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй залуучуудаас 11400 гаруй хүнийг мэргэжил олгох болон давтан сургах сургалтад хамруулна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан 23000-аас доошгүй хүнийг ажилд зуучлан оруулна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Дэд бүтэц, байгаль хамгаалал, экологийн чиглэлээр нийтийг хамарсан ажил зохион байгуулж, нийгмийн эмзэг бүлгийн 9000 гаруй иргэдийг ажлын түр байраар хангах ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ш.Батбаяр Б.Жигжид У.Барсболд Д.Насанжаргал
	-Мэргэжлийн ажилчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, гадаадад ажиллах хүний тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Гадаадад ажиллаж байгаа иргэдийн эрхийг хамгаалах, гадаадад ажиллах хүч гаргах боломжийг нэмэгдүүлэх замаар 350-иас доошгүй иргэдийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гадаадад ажиллуулах, үйлдвэрлэлийн дадлага эзэмшүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр Л.Эрдэнэчулуун
	-Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн хүрээнд Монгол Улсын иргэдийн оролцоог хангах замаар 2500-аас доошгүй хүнийг ажлын байраар хангана.	жилдээ	Ш.Батбаяр Б.Жигжид

1	2	3	4
	-Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн дадлага хийх таатай нөхцөл бүрдүүлэх асуудлаар ОХУ, БНЧУ, БНУУ, Япон улсуудтай хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулах, түүнчлэн байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр Л.Эрдэнэчулуун
	-Гадаадаас ажиллах хүч авч байгаа аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр тавих хяналтыг сайжруулж, аж ахуйн нэгж, байгууллагын аттестатчиллыг эхлүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр
	-Нийгмийн зөвшлийн харилцааг хөгжүүлэх бодлогын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2000-2001 оны хэлэлцээрийг дүгнэж, 2002-2003 оны хэлэлцээрийг байгуулж ажиллана.	I улирал	Ш.Батбаяр Ч.Улаан
4.Хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл, судалгааг өргөжүүлж, мэргэжлийн сургалтын тогтолцоог бэхжүүлнэ.	-Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн талаар судалгаа явуулж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Албан ба албан бус хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сүлжээний ашиглалтыг сайжруулна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах бодлогын хүрээнд Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	А.Цанжид Ш.Батбаяр

1	2	3	4
	-Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчнийг сургах, дадлагажуулах арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр А.Цанжид
	-Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн ажлын үр дүнг тэдгээрийн төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, ажил, хөдөлмөр эрхлэлтийн түвшингээр дүгнэх журам боловсруулж мөрдүүлнэ.	жилдээ	А.Цанжид Ш.Батбаяр
5.Өрхийн амьжиргаа дэмжих, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх замаар хүн амын орлогыг нэмэгдүүлнэ.	-Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх болон эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас жижиг зээл олгох журмыг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь үргэлжлүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Дэлхийн банкны санхүүгийн тусламжтайгаар хэрэгжүүлэх "Тогтвортой амьжиргаа дэмжих" төслийг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч.Улаан Ш.Батбаяр
	-Шведийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Ядуурлын судалгаа ба хөдөлмөр эрхлэлтийг идэвхжүүлэх" төслийг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ч. Улаан Ш.Батбаяр
	-Нийгмийн халамжийн тэтгэвэр, хүүхэд асарсны тэтгэмжийг амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэмжийг амьжиргааны түвшингийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан

1	2	3	4
	-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг дунджаар 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	IY улирал	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.	IY улирал	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Тэтгэврийн насанд хүрээгүй нөхөн олговор авагч иргэдийн нөхөн олговрын хэмжээг тэтгэврийн доод хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	IY улирал	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Төсвийн байгууллагын ажилтны цалин хөлсийг дунджаар 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	IY улирал	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Төсвийн байгууллагад ажиллагчдын орлогыг нэмэгдүүлэхийн тулд жижиг үйлдвэрлэл, мал аж ахуй эрхлэх, жимс, хүнсний ногоо тариалах, байгалийн өгөөжийг ашиглах боломж бүрдүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хуульд нийцүүлэн зохион байгуулна.	жилдээ	Ш.Батбаяр
	-Төсвийн байгууллагын ажиллагчдын бүтээл, ажлын чанар, үр дүнг харгалзан цалин хөлс олгох шинэ журмыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудад туршин нэвтрүүлнэ.	жилдээ	Ч.Улаан Ш.Батбаяр
6.Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, чадавхийг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна.	-Азийн хөгжлийн банктай хамтран Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Тэтгэврийн даатгалын нэрийн данс заавал нээлгэх даатгуулагчдын хамралтыг 95 хувьд хүргэж, нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ, хүүг даатгуулагчдад мэдээлэх тогтолцоог бүрдүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан

1	2	3	4
	-Үр хүүхэд, гэр бүл, төрөл төрөгсдөө нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулдаг гадаад орны туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирох хувилбарыг сонгон хэрэгжүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр
	-Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын тусгай хэлбэр буюу заавал даатгалд хамруулах боломжийг судалж, зохистой хувилбарыг сонгон хэрэглэх зөвшилцөлд хүрнэ.	жилдээ	Ш.Батбаяр
	-Ахмад зүтгэлтэн, улсын болон хөдөлмөрийн баатруудад нэг удаагийн бүцалтгүй тусламж олгож байх журам гаргаж, амьдрал ахуйд нь дэмжлэг үзүүлнэ.	жилдээ	Ш. Батбаяр Ч. Улаан
	-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрлүүлнэ.	жилдээ	Ш.Батбаяр Ц.Нямдорж
	-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, шимтгэлийн өр, авлагыг барагдуулах ажлыг зохионо.	жилдээ	Ш.Батбаяр Ч.Улаан
	-Нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээний хэлбэрийг туршиж эхэлнэ.	жилдээ	Ш.Батбаяр
7.Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нөөцийг хуваарилах, үр ашигтай зарцуулах тогтолцоог боловсронгуй болгоно.	-Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр төсөл боловсруулж, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	жилдээ	П. Нямдаваа Ч. Улаан
	-Нийгмийн эмзэг бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,үзүүлэх журам боловсруулж мөрдөнө.	II улирал	П.Нямдаваа Ш.Батбаяр Ч.Улаан

1	2	3	4
	-Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эмчилгээ, оношилгооны жагсаалт, төлбөрийн тариф, холбогдох журмыг шинэчлэн боловсруулж мөрдөнө.	жилдээ	П. Нямдаваа Ш. Батбаяр Ч. Улаан
8.Эрүүл мэндийн суурь тусламж /ЭМСТ/-ийг өрхийн эмнэлгээр үзүүлэх тогтолцоонд шилжүүлнэ.	-Өрхийн болон сумын эмнэлгийн түвшинд эрүүл мэндийн багц суурь тусламж үзүүлэх тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	П.Нямдаваа
	-Эрүүл мэндийн суурь тусламжийн багцын өртөг зардлыг тогтоож, санхүүжүүлэх стандарт боловсруулна.	жилдээ	П.Нямдаваа
	-Өрхийн болон сумын эмнэлгийг нэг хүнд ногдох зардлаар санхүүжүүлэх ажлыг өргөжүүлнэ.	жилдээ	П.Нямдаваа
9.Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулах арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	жилдээ	П. Нямдаваа холбогдох аймгийн Засаг дарга
	-Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхэлнэ.	II улирал	П. Нямдаваа
	-Хөдөөгийн эмнэлгүүдийг тоног төхөөрөмж, эмч, мэргэжилтнээр хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжил, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	П. Нямдаваа аймгийн Засаг дарга
	-Сумын эмнэлгийн түргэн тусламжийн автомашины 10 хувьд, аймаг, нийслэлийн түргэн тусламжийн автомашины 20 хувьд парк шинэчлэлт хийнэ.	жилдээ	П. Нямдаваа аймаг, нийслэлийн Засаг дарга
10.Тарилгаар урьдчилан сэргийлэгдэх халдварт өвчний тархалтыг шат дараалан бууруулах ажлыг зохион байгуулна.	-Халдварт өвчин судлалын үндэсний төвийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах төслийг Япон Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	П. Нямдаваа

1	2	3	4
	-Тарилгатай халдварт өвчнийг тандах идэвхтэй тандалтын иж бүрэн сүлжээ нэвтрүүлж эхэлнэ.	жилдээ	П. Нямдаваа
	-Халдварт саа өвчний устгалыг баталгаажуулах арга хэмжээ авна.	II улирал	П. Нямдаваа
	-Сурьеэ өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх стратегийг шинэчлэн боловсруулна.	II улирал	П. Нямдаваа
	-Халдварт өвчнийг бууруулах стратеги, үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулж мөрдөнө.	жилдээ	П.Нямдаваа
11.Эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг багасгах арга хэмжээ авна.	-Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах төслийг хандивлагч орнуудтай хамтран хэрэгжүүлнэ.	жилдээ	П.Нямдаваа
	-Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, баг, сумын хүн эмнэлгийг оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн багаж, хэрэгслээр хангах арга хэмжээ авна.	жилдээ	П. Нямдаваа
	-Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх болон гэр бүл төлөвлөлтийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	П. Нямдаваа
	-Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, уг хөтөлбөр болон “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	П. Нямдаваа
	-Хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй өвчнүүдийн оношилгоо, эмчилгээний жишгийг батлуулж мөрдүүлнэ.	I улирал	П.Нямдаваа
	-Хүүхдийн өвчний цогц удирдлага хөтөлбөрийг хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах үндэсний стратеги болгон шинэчилнэ.	II улирал	П.Нямдаваа

1	2	3	4
12.Эрүүл мэндийн технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.	-"Эрүүл мэндийн технологи" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	жилдээ	П. Нямдаваа
	-Эрүүл мэндийн байгууллагуудын технологийн стандартыг боловсруулж, мөрдөнө.	II улирал	П. Нямдаваа
	-Эмийн үндэсний бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	П. Нямдаваа
	-Люксембургийн тусламжтайгаар зүрх, судасны оношилгоо, эмчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	П. Нямдаваа
	-Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, клиникийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулж баталж мөрдөнө.	I улирал	П. Нямдаваа
	-Аймаг, сумын эмнэлгүүдэд магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг эхлүүлнэ.	II улирал	П. Нямдаваа
13.Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, зуны олимпийн эзэлжит наадамд бэлтгэх ажлыг эрчимжүүлнэ.	-Олимпийн эзэлжит наадамд оролцох эрх авахын төлөө спортын гол төрлөөр байнгын бус шигшээ баг бүрдүүлж, бэлтгэл сургуулилтыг хангуулах ажлыг эхлүүлнэ.	жилдээ	П.Нямдаваа
	-Дэлхийн олуутны шатрын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна.	жилдээ	П.Нямдаваа
	-Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлнэ.	II улирал	П.Нямдаваа
	-Төв, орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаа явуулж, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээг боловсронгуй болгох арга хэмжээ авна.	III-IV улирал	П.Нямдаваа

1	2	3	4
14. Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, материаллаг баазыг бэхжүүлэн бүх шатны сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлнэ.	-Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан батлуулна.	II улирал	А. Цанжид
	-Бага, дунд боловсролын агуулгын стандартыг шинэчлэн мөрдүүлэх бэлтгэлийг хангана.	жилдээ	А.Цанжид
	-Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлнэ.	III улирал	А.Цанжид
	-Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг дүгнэж, дараагийн шатны зорилт, арга хэмжээнд зарим тодотгол оруулах саналыг боловсруулан, шийдвэрлүүлнэ.	II улирал	А. Цанжид
	-Хөдөөгийн сургуулиудыг мэргэжлийн багшаар хангах төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.	III улирал	А.Цанжид
	-Зохих нөхцөл, бололцоо бүрдсэн сургуулиудад мэдээлэл зүйн хичээлийг 8 дугаар ангиас судлуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	IV улирал	А.Цанжид
	-Бүх шатны сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэхэд анхаарна.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
	-Ачаалал ихтэй сургуулийн барилгыг өргөтгөх, шинээр барих хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөөгийн засварлах шаардлагатай сургуулиудын хичээлийн болон дотуур байрны барилгын 15-аас доошгүй хувийг засварлаж, сургалтын орчныг сайжруулна.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
	-"Боловсрол-XXI" төсөл боловсруулан баталж, хандивлагч орнуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	I улирал	А. Цанжид
	-Бүх шатны сургуулиудыг компьютержүүлэх ажлыг өргөжүүлж, ЕБС-ийн 20 хүртэл хувийг электрон шуудантай болгоно.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан

1	2	3	4
	-Эмзэг бүлгийн болон олон хүүхэд нь зэрэг сурадцдаг өрхийн 3-аас дээшхи хүүхдэд хичээлийн хэрэгслийг үнэ төлбөргүй олгох ажлыг үргэлжлүүлнэ.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
	-Хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг бүрэн ашиглах, бага насны хүүхдийн хөгжлийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэн, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог 41 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.	жилдээ	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Их сургууль, коллежид суралцаж байгаа нэн ядуу өрхийн нэг, 2-оос дээш хүүхэд нь зэрэг суралцаж байгаа өрхийн нэг, богд шилжүүлснээр 500 хүртэл толгой малтай малчин өрхийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
	-Ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар анги төгсөгчдийн 70-аас доошгүй хувийг 9 дүгээр ангид элсүүлэн сургахын зэрэгцээ 8, 10 дугаар анги төгсөөд ажил, сургуульгүй үлдсэн хүүхдийг мэргэжлийн сургалтад хамруулах, мэргэжлийн анхан шатны боловсрол олгох арга хэмжээг ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж эхэлнэ.	II-III улирал	А.Цанжид аймаг, нийслэлийн Засаг дарга
	-Дээд боловсролын тухай хуульд нийцүүлэн төрийн их сургууль, коллежийн нэг оюутанд ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох нормативыг боловсруулна.	III улирал	А.Цанжид Ч.Улаан
	-Засгийн газрын шугамаар гадаад орнуудад суралцуулах оюутны тоог нэмэгдүүлж, АНУ, Англи, Франц, ХБНГУ зэрэг орнуудад оюутан суралцуулах талаар санал боловсруулна.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан

1	2	3	4
	-Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар төрийн өмчийн зарим их сургуулийг менежментийн гэрээгээр ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлж эхэлнэ.	жилдээ	А.Цанжид
	-Их сургууль, коллежийг аттестатчилах ажлыг хэрэгжүүлнэ.	жилдээ	А.Цанжид
	-Дээд боловсролын сургалтын гол чиглэлүүдээр агуулгын цөм стандарт боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	жилдээ	А.Цанжид
	-Дээд боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэн боловсронгуй болгоно.	жилдээ	А.Цанжид
	-Сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж төгссөн хүмүүсээс орон нутаг, түүний дотор суманд очиж, дутагдаж буй мэргэжлээр ажилласан тохиолдолд орон нутгийн алслагдсан байдлыг харгалзан зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөх, одоогийн мөрдөж буй журамд заасан хугацааг богиносгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
15.Хөдөөгийн соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүл-нэ.	-Соёл, урлагийн салбарыг 2010 он хүртэл хөгжүүлэх стратеги, ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	III улирал	А.Цанжид
	-Хөдөөгийн соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцаа, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх санал боловсруулна.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
	-Хүүхдийн номын ордон байгуулах ажлыг судалж шийдвэрлэнэ.	жилдээ	А.Цанжид

1	2	3	4
	-Сумдын соёлын төвийн үйл ажиллагаа, хөдөөгийн хүн амын кино үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.	жилдээ	А.Цанжид аймгийн Засаг дарга нар
	-Соёл, урлагийн байгууллагын ажилтан, уран бүтээлчдийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлнэ.	жилдээ	А.Цанжид Ч.Улаан
16.Шинжлэх ухаан, технологийн хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зэрчимжүүлнэ.	-Шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эхэлнэ.	жилдээ	А.Цанжид
	-ШУТ-ийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлж, эрдэм шинжилгээний байгууллагуудыг "Эрдэмнэт" сүлжээнд холбох ажлыг өргөжүүлнэ.	жилдээ	А.Цанжид
	-Шинжлэх ухаан, технологийн төсөлт ажилд зарцуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	жилдээ	А.Цанжид Ч.Ганзориг Д.Насанжаргал
	-Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, технологийн төслийн захиалга, санхүүжилт, гүйцэтгэлийн үр дүнд тавих хяналтыг сайжруулна.	жилдээ	А.Цанжид
	-Эрдэм шинжилгээний ажилтны эрх зүйн байдлын асуудлаар хуулийн төслийг боловсруулан батлуулна.	IV улирал	А.Цанжид Ц.Нямдорж
	-Оюуны бүтээлийг үнэлэх, урамшуулах журмыг шинэчлэн боловсруулна.	III улирал	А.Цанжид Ц.Нямдорж Ш.Батбаяр

1	2	3	4
	Тав. Батлан хамгаалах, гадаад боддогын хүрээнд:		
Цэргийн шинэтгэлийг гүнзгийрүүлж, улс орны ашүүгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах гадаад идэвхтэй бодлого явуулна.			
1. Батлан хамгаалах тоотол-цооны эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, орон нутгийн хамгаалалтын тоотолоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	-Цэргийн албан хаагчид гадаад орон болон улсын байгуулагад үүрэг гүйцэтгэх тухай, Цэргийн албан хаагчдад эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай, Агаарын орон зайн тухай, Аврагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах замаар батлан хамгаалах тоотолоог бүрдүүлэх ажлыг гүнзгийрүүлнэ. -Орон нутгийн хамгаалалтын тоотолоог бүрдүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авна. -Монгол улсын дайчилганы нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө. -Цэргийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, улс орны ашүүгүй байдлыг хангах зорилгоор Төрийн цэргийн бодлогын үндэс бичиг нийгмүүлэн Батлан хамгаалах тухай хуулья нэмэлт, өөрчлөлт оруулж, Зэвсэгт хүчний тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулна. -Ази, Номхон далайн бүс нутгийн хүрээнд зохион байгуулдаг олон талт арга хэмжээнд идэвхтэй оролцож, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл хэрэгт хувь нэмэр оруулна. -Монгол Улсын ашүүгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах хүрээнд цэрэг-дипломатын идэвхтэй үйл ажиллагаа явуулна.	жилдээ жилдээ жилдээ жилдээ	Ж.Гуррагчаа Ж.Гуррагчаа Ж.Гуррагчаа Ж.Гуррагчаа

1	2	3	4
	-Энхийг сахиулах хүчний олон улсын хэрэгцээ сургуулийг Монгол Улсад явуулах бэлтгэлийг үе шаттайгаар хангана.	жилдээ	Ж.Гүррагчаа
	-Цэргийн удирдлагын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээ байгуулах ажлын эхний ээлжийг дуусгана.	жилдээ	Ж.Гүррагчаа
	-Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.	жилдээ	Ж.Гүррагчаа
2.Иргэний хамгаалалтын үйл ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн чадавхийг бэхжүүлнэ.	-Орон нутгийн иргэний хамгаалалтын албаны гүйцэтгэх үүргийг тодотгох чиглэлээр Иргэний хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан батлуулна.	II улирал	Ж.Гүррагчаа
	-Иргэний хамгаалалтын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлнэ.	III улирал	Ж.Гүррагчаа
	-Иргэний хамгаалалтын зарлан мэдээллийн сүлжээг сайжруулна.	жилдээ	Ж.Гүррагчаа
	-Орон нутгийн аврах салбарыг бэхжүүлэх арга хэмжээ авна.	жилдээ	Ж.Гүррагчаа
3.Улс төр, эдийн засгийн гадаад харилцаат эрчимжүүлж, үндэсний хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлнэ.	-ОХУ, БНХАУ-тай өндөр, дээд хэмжээний айлчлал, яриа хэлэлцээг үргэлжлүүлж, өмнө хүрсэн тохиролцоог хэрэгжүүлэх, хил орчмын бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллана.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-АНУ, Япон, БНСУ, БНЭУ зэрэг улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, худалдааг өргөжүүлэх эрх зүйн орчныг бататгах чиглэлээр хийж буй ажлыг үргэлжлүүлнэ.	жилдээ	Л.Эрдэнэчулуун

1	2	3	4
	-ХБНГУ, Их Британи, Франц, Итали зэрэг оронтой түншийн харилцааг өргөжүүлэхийн сацуу Испани, Австри, Канад зэрэг улстай тогтоосон харилцаат гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллана. -АСЕАН-ы гишүүн орнуудтай харилцааны түвшинг ахиулах зорилгоор хоёр талын эвлэлдэх уулзалтыг зохион байгуулах чиглэлээр ажиллана. -Ази, Номхон далайн бүс нутагт идэвхтэй гадаад бодлого явуулж, хоёр болон олон талын хамтын ажиллагаа хөгжүүлж, бүс нутгийн олон талт үйл явц, ярианд хэлэлцээнд идэвхтэй оролцоно. -Латин Америкийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломжийг судалж, харилцааны эрх зүйн үндсийг тавих чиглэлээр ажиллана. -Гадаад эдийн засгийн хамтын ажиллагаанд зээл, туслалжийн үр өгөөжийг дээшлүүлэх явдлыг бодлогын гол чиглэл болгож, цаашид авах зээл, туслалжийг улс орны хөгжлийн зорилтод илүү чиглүүлнэ. -Дэмжин өнгөрөх тээврийн асуудлаар ОХУ, БНХАУ-тай гурван талын хэлэлцээр байгуулах ярианд хэлэлцээгээ НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын дэмжлэггүй үргэлжлүүлнэ. -Өөрийн орныг гадаад орнуудтай таниулах, хамтын ажиллагаг өргөжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, Монгол Улсын үндэсний хөгжлийн тактай гадаад орчныг бүрдүүлэхэд чиглэсэн "Гадаад суртачилгааны үзэл баримтлал"-ыг боловсруулан батлуулна.	жилдээ жилдээ жилдээ жилдээ жилдээ жилдээ	Л.Эрдэнэчулуун Л.Эрдэнэчулуун Л.Эрдэнэчулуун Л.Эрдэнэчулуун Ч.Улаан Л.Эрдэнэчулуун Л.Эрдэнэчулуун Б.Жигжид Л.Эрдэнэчулуун

1	2	3	4
4.НҮБ, Олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд тэдгээрийн нөөц бололцоог өргөн ашиглана.	-НҮБ, Олон улсын бусад байгууллагаар дамжуулан улс орны ашуулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийн зорилтыг шийдвэрлэхэд тус дэмжлэг авах чиглэлээр бодлого, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-Цөмийн зэвсэггүй статусаа олон улсын хэмжээнд хуульчлан баталгаажуулах талаарх хүчин чармайлтыг үргэлжлүүлнэ.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-Олон улсын алан хядах үйл ажиллагаатай тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлтыг тууштай дэмжин, энэ асуудлаар тусгай чуулган хийлгэх саналаа урагшлуулах үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-"Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн", "77-гийн бүлэг"-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, нийтлэг бөгөөд Монгол Улсын ашиг сонирхолд нийцсэн асуудлаар хамтран ажиллана.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
5. Хилийн чанадад Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаадад зорчих, суралцах, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	-Эрүүгийн эрхийн салбарт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээг АНУ, Их Британитай байгуулж, ийм төрлийн гэрээг бусад улсуудтай байгуулах боломжийг судална.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-Монгол Улсын өргөмжит консулын төлөөллийг өргөтгөх чиглэлээр ажиллана.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	-Тувагийн нийслэл Кызыл хотод Монгол Улсын Ерөнхий консулын газрыг албан ёсоор нээж, Хятадын зарим хотод Ерөнхий консулын газрыг нээх боломжийг судлана.	жилдээ	Л.Эрдэнэчулуун

1	2	3	4
	-Монгол Улсын иргэд гадаад оронд аюулгүй амьдрах, хөдөлмөр эрхлэх, суралцахад таатай нөхцөл, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хоёр болон олон талын гэрээ хэлэлцээр байгуулах чармайлтыг үргэлжлүүлнэ.	жилдээ	Л.Эрдэнэчулуун
	Зургаа. Эрх зүйн шинэтгэл, засаглалын бэхжилт, хил хамгаалалтын хүрээнд:		
	Хүний эрх, эрх чөлөөг хангаж, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэд амгалан тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.		
1.Эрх зүйн шинэтгэл, хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгана.	-"Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д заасан хуулийн төслүүдийг хугацаанд нь боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ц. Нямдорж
	-Эрүүгийн болон иргэний эрх зүйн харилцаа, процессын үйл ажиллагаат зохицуулсан хуулиудыг батлуулан, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ц.Нямдорж
	-Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	III улирал	Ц. Нямдорж
	-Монгол-Оросын хил орчмын нутаг дэвсгэрт ой хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулахаар ажиллана.	II улирал	Ц.Нямдорж Л.Эрдэнэчулуун
	-Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг судлах тогтолцоог боловсронгуй болгоно.	жилдээ	Ц. Нямдорж
	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд тавих санхүүгийн бүртгэл, хяналтыг сайжруулна.	жилдээ	Ц.Нямдорж
	-Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зориулсан хууль зүйн гарын авлагын хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.	жилдээ	Ц.Нямдорж

1	2	3	4
2.Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	-Шүүгчдийг томилох, эгүүлэн татах, огцруулах, тэдэнд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгоно.	жилдээ	Ц.Нямдорж
	-Шүүгчийн ёс зүйн дүрэм боловсруулан батлуулж, мөрдөнө.	II улирал	Ц.Нямдорж
	-Шүүх засаглалын стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан АНУ-аас үзүүлэх тусламжийг үр дүнтэй ашиглах ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ц.Нямдорж
	-Шүүхийн ажлын нөхцөл, албан өрөө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах арга хэмжээ авна.	жилдээ	Ц.Нямдорж
	-Шүүгчийн нийгмийн баталгаа, орон сууцны хангамжийг сайжруулах хөтөлбөр боловсруулан батлуулна.	III улирал	Ц.Нямдорж
3.Төрийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааны нь үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.	-"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжүүлэлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн "Хуний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Ө.Энхтүвшин
	-Төрийн захиргааны байгууллагыг бэхжүүлэх, удирдлагын арга барилыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.	II-IV улирал	Ө.Энхтүвшин
	-Засгийн газрын агентлагуудын үйл ажиллагаа /бизнес/-ны стратеги, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.	I-III улирал	Ө.Энхтүвшин
	-Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулахын хамт ажлаа тайлагнах, хариуцлага тооцох, үйл ажиллагааных нь үр дүнг үнэлж, дүгнэх стандарт боловсруулж мөрдүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин

1	2	3	4
	-Гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааны эрх зүйн нэгдсэн шинэ тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулж, Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулна.	жилдээ	Ө.Энхтүвшин
	-Төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд оруулна.	I-II улирал	Ө.Энхтүвшин
	-Аймаг, сум, багийн бүтэц зохион байгуулалтыг хянан үзэж, санал, дүгнэлт боловсруулна.	жилдээ	Ө.Энхтүвшин
	-Хэвлэл мэдээллийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох асуудлыг судлан шийдвэрлүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин
	-Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ хэрэгжүүлнэ.	жилдээ	Ө.Энхтүвшин
4. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах, урьдчилан сэргийлэх ажлын цар хүрээг өргөжүүлнэ.	-Зохион байгуулалттай, онц ноцтой гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээг эрчимжүүлнэ.	жилдээ	Ц. Нямдорж
	-Ой, хээрийн түймэр гарах магадлал өндөртэй Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Архангай, Булган аймгуудыг гал унтраах техник, багаж, хэрэгслээр эхний ээлжинд хангана.	жилдээ	Ц.Нямдорж Ч.Улаан
	-Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх арга хэмжээг өргөжүүлнэ.	жилдээ	Ц. Нямдорж аймаг, нийслэлийн Засаг дарга

1	2	3	4
	-Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын эхний үе шатны ажлын хэрэгжилтийг дүгнэж, дараагийн үе шатны ажлыг хэрэгжүүлж эхлэнэ.	I улирал	Ц.Нямдорж
	-Цагдаагийн криминалистикийн шинжилгээний төв лабораторийг шинэчлэх төслийг боловсруулж, хандивлагч орнуудын туслалцаатайгаар санхүүжүүлэх арга хэмжээ авна.	III улирал	Ц.Нямдорж
5.Хилийн цэргийн чадавхийг бэхжүүлэх, хил хамгаалалтын дэглэмийг чангатгах ажилд түлхүү анхаарна.	-"Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" баримт бичгийн төслийг боловсруулан батлуулж мөрдөнө.	II улирал	Ц.Нямдорж Л.Эрдэнэчулуун
	-Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	жилдээ	Ц.Нямдорж
	-Увс, Завхан, Говь-Алтай аймгийн хилийн хэсгийг инженерийн байгууламжаар тоноглох, Дорнод, Сүхбаатар аймгийн хилийн хэсэгт хамгаалалтын хашааны шонг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.	жилдээ	Ц.Нямдорж
	-Хилийн хяналт, шалгалтын болон дохиоллын орчин үеийн техник хэрэгслээр хилийн боомт, гол чиглэлийн анги, салбаруудыг хангана.	жилдээ	Ц.Нямдорж Ч.Улаан
	-Хил хамгаалалтын хүч хэрэгслүүдийг нэмэгдүүлэн хилийн зөрчил ихтэй чиглэлүүдэд хүчийг төвлөрүүлэх, хилчдийг найдвартай холбоо, техник хэрэгсэл, уналгаар хангах арга хэмжээ авна.	жилдээ	Ц.Нямдорж
	-Хилийн цэргийн бие бүрэлдэхүүний хувийн сахилга, хариуцлага, албаны дэг, ёсыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.	жилдээ	Ц.Нямдорж

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2002 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Төв банк / Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2002 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлалсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дунг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /О.Чулуунбат/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2001 оны 85 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2002 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрөөс 2002 онд мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, сүүлийн жилүүдэд гарсан үнэ, ханшийн тогторжилтыг батагтан, санхүүгийн салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх замаар тус салбарын сэргэлтийг гүнзгийрүүлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн дараахь харьцааг хангахад чиглэгдэнэ:

- инфляцийн түвшинг 6-8 хувьд хадгалах;
- төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшны уналтыг 3 хувиас хэтрүүлэхгүй байх;
- улсын гадаад валютын цэвэр албан нөөцийг 13 долоо хоногийн импортын хэрэгцээг хангах түвшинд хүргэх.

Дээрхи зорилтын хүрээнд Монголбанк, Засгийн газраас олон улсын санхүүгийн байгууллагатай тохиролцон хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн орчныг бүрдүүлэх, мөнгөний шууд бус удирдлагын тогтолцоонд шилжих, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

Нэг. Мөнгөний бодлогын талаар

Мөнгөний бодлогын дэвшилтэт хэлбэр-мөнгөний шууд бус удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор нөөц мөнгөний хөтөлбөрийг Монголбанк нэвтрүүлнэ.

Инфляцийн түвшинтэй уялдсан уян хатан хүүгийн бодлогыг Төв банкны үнэт цаасны хүүгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

Эдийн засаг, санхүүгийн суурь судалгааг эрчимжүүлэн, түүний үр дүнг бодлогын чанартай асуудлаар оновчтой шийдвэр гаргахад ашиглана.

Дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих, банкнаас гадуур байгаа мөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор дотоодын, төлберийн чадвар сайтай аж ахуйн нэгжийн өрийн бичгийг арилжааны болон Төв банкны дахин санхүүжилтийн зарчмаар хямдруулан арилжих боломжоор судлана.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг улс орны эдийн засагт ергөн хүрээтэй нэвтрүүлэх стратегийг доноруудтай хамтран Монголбанк боловсруулна.

Банкны бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгийг хоёрдогч зах дээр арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, мөнгөний бодлогын арга хэрэгсэл болгон ашиглах талаар Засгийн газар, Монголбанк хамтран ажиллана.

Банк хоорондын төгрөгийн болон валютын захыг хөгжүүлэх, түүний харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Хөрш орнуудтай хийж байгаа хил орчмын төлбөр тооцоонд банкны үйлчилгээг хүргэх боломжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Дотоодын алтны зах зээлийг чөлөөлнө.

Тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжиж, санхүүгийн үйлчилгээг идэвхжүүлнэ.

Хоёр. Бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх замаар санхүүгийн салбарын сэргэлтийг гүнзгийрүүлэх талаар

Банк, банк бус санхүүгийн байгууллагад Төв банкнаас тавих хяналт болон банкны дотоод

хяналтыг банкны үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлох, учирч болзошгүй эрсдлийг үнэлэн, түүнээс сэргийлэхэд чиглүүлж, Төв банкны нэгдсэн хяналтын зарчмыг нэвтрүүлнэ. Хяналт шалгалтын ажилд олон улсын практикт хэрэглэж байгаа шинэлэг арга хэлбэрийг ашиглана.

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай банк, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, зээлдүүлэгчийн өрсөлдөөнт орчныг бий болгох арга хэмжээ авна.

Иргэдийн хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх арга замыг олон улсын санхүү, банкны байгууллагатай хамтран судлана.

Санхүүгийн ажил үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/-аар дамжуулан нийтэд хүртээмжтэй болгох, санхүүгийн зуучлалыг олон улсын стандартын дагуу сонгодог утгаар нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх, бус нутагт энэ хэлбэрийн байгууллага хөгжих нөхцөлийг бий болгох эрх зүйн орчныг нь бүрдүүлэх үүднээс эдгээр байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзаж зохицуулсан хуулийн төслийг боловсруулж батлуулах.

Цахим төлбөр тооцооғоор санхүүгийн үйлчилгээ эрхлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг Монголбанк бүрдүүлнэ.

Санхүүгийн салбар дахь эрсдлийг бууруулах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллагуудын активын чанарыг сайжруулах, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг харилцан солилцох механизмыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

Зээлдэгч аж ахуйн нэгжүүдэд зөрөглэл тогтоон хэвшүүлж, банкуудыг зээлийн мэдээллийн сантай болгож, уг санг зээлийн барьцааны бариулсан үл хөдлөх эд хөрөнгийн болон бусад мэдээллээр өргөтгөнө.

Банкны үйл ажиллагаанд тавих дотоод, гадаад аудиторуудын хяналт, тэдгээрийн уялдаа, хамтын ажиллагааг сайжруулна.

Банкны үйл ажиллагаа, удирдлагад тавих шат дараалсан хяналтыг боловсронгуй болгох үүднээс олон улсын жишгийн дагуу компанийн зохистой засаглалын зарчмыг банкуудад мөрдүүлнэ.

Гурав.Төв банкны дотоод үйл ажиллагаа, хяналтыг бэхжүүлэх талаар

Төв банкны бодлогыг нээлттэй, ил тод байлгах үүднээс Монголбанкнаас гаргах шийдвэр, эрхийн актууд, судалгааны ажлыг хэвлэл, мэдээлэл болон интернетээр тогтмол сурталчилна.

Монголбанкны дүрмийн санг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Монголбанкны төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлтийг эрчимжүүлэх ажлыг зарим газар, хэлтэс, албадын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн туршина.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримталлтай уялдуулан Монголбанкны орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох шат дараалсан арга хэмжээ авна.

Монголбанкны ажилтнуудын нийгмийн хангамж, сургалт болон ажиллах нөхцөл, болорцоог сайжруулахад чиглэсэн цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 90 **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад байгаа гаалийн албан татварын "7" гэсэн хувь, хэмжээг "5" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 51 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн "хавсралтад байгаа гаалийн албан татварын "5" гэсэн хувь, хэмжээг "7" гэж, мөн" гэснийг хассугай.

3. Энэ тогтоол 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

(Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоол болон тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн түрүүчийн дугаарт нийтлэгдсэн)

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратеги №	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа	Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилт /сая .төг/		
						бүгд	эх үүсвэртэй	шаардлагатай
Нэг. Хүнсний хангамжийн чиглэлээр								
1.1. Арга хэмжээ: Хот, суурин газрын хүн амыг эрүүл ахуй, ариун цэврийн аюулгүй байдалд бэлтгэгдсэн мах, махан бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх								
1.1.1	"Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах Үндэс-ний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. Махны чиглэлийн арвин ашиг шимт мал үржүүлэх төслүүдийг шалгаруулж дэмжих	ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Малчид, мал бүхий иргэд малын тооноос чанарт илүү анхаардаг болно.	Нэг малаас ашиглах мах, сүүний гарц нэмэгдэнэ	500.0		500.0
1.1.2	"Малын эрүүл мэнд хөтөлбөр"-ийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх	ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Мал сүрэг эрүүлжих нөхцөл бүрдэж халдварт болон паразит өвчний гаралт багасна.	Малын өвчний гаралт, малын хорогдлын бууралт	20000.0	5000.0	15000.0
1.1.3	Эрүүл ахуй, ариун цэврийн хувьд MNS 2001 "Мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдал, техникийн шаардлага" –ыг мөрдөх	ХХААЯ, ХАБХААУХА	2001 оноос	Эрүүл ахуйн баталгаатай мах, махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.	Мах, махан бүтээгдэхүүн дэх хүнд металл, цацраг идэвхит болон хорт бодис, бактерологийн үзүүлэлт	10.0	10.0	-
	1.1. Дүн					20510.0	5010.0	15500.0
1.2. Арга хэмжээ: Махны үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, хямд төсөр олон нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулалтын сүлжээ бүрдүүлэх								
1.2.1	Мах, махан бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, технологийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах,хуваарилах нөхцөлийг нийслэл, хот, суурин газарт бүрдүүлэх	ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2003	Мах, махан бүтээгдэхүүний чанарын хамгаа-палт дээшилнэ.	Хүнсний зах, тээвэр, агуулах, зоорь, дэлгүүрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын түвшин	50.0	50.0	-
1.2.2	Махыг шүлж ангилах, вакум аргаар савлах, бүрэн утлагат хиам, бусад бэлэн бүтээгдэхүү-ний шинэ технологи нэвтрүүлэх	ХХААЯ, ХТК, Мах боловс-руулах үйлдвэрүүд	2001-2005	Бүтээгдэхүүний ча-нар, эрүүл ахуйн хамгаалалтыг сайж-руулж хадгалалтын нөхцөлийг хямд төсөр болгоно.	Бүтээгдэхүүний стандартад заасан хугацаанд чанараа хадгалах чадвар	15.0	15.0	-

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2001 он, №47 (234)

1.2.3	Мах, махан бүтээгдэхүүний борлуулалтын зохистой сүлжээг бөөний худалдаа, төрөлжсөн зах, дэлгүүрийн хэлбэрээр зохион байгуулах	ХХАА,ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Амьтны гаралтай бүтээгдэхүүний зохистой шаардлагын дагуу тээвэрлэх, худалдах нөхцөл бүрдэнэ.	Төрөлжсөн аж ахуйн нэгж, зах, дэлгүүрийн эрүүл ахуйн үзүүлэлт, хүн амын хэрэглээний түвшин	150.0	-	150.0
1.2.4	Дотор мах, цус, бусад дайвар бүтээгдэхүүн, сүүний уургийн бэлдмэл зэрэг түүхий эдэд тулгуурлан уламжлалт болон шинэ төрлийн ертөг хямдтай бүтээгдэхүүний технологийг боловсруулж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ХХАА, "Хүнстех" корпораци, мах боловсруулах үйлдвэрүүд	2001-2005	Хэрэглэгчдийн худалдан авах чадвартай уялдсан ертөг бүхий сайн чанарын бүтээгдэхүүн бий болно.	Хиам, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ертөг хямдтай бүтээгдэхүүний эзлэх хувийн жин	10.0	-	10.0
	1.2. Дүн					225.0	65.0	160.0
1.3. Арга хэмжээ: Махны үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд чиглэсэн "Махны экспорт" төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх								
1.3.1	Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг Засгийн газраар батлуулж дотоодын болон олон улсын холбогдох байгууллагуудын оролцоог зохицуулах	ХХАА, ҮХЯ	2001 оноос	Төслийн хэрэг-жилт эрчимжиж тоосгон үр дүнд хүрнэ.	Бүтээгдэхүүний ханган, махны экспортын өсөлт	10000.0		10000.0
	1.3. Дүн					10000.0		10000.0
1.4. Арга хэмжээ: "Цагаан хувьсгал" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих буй арга хэмжээг дүгнэж, эрчимжүүлэх								
1.4.1	Цагаан хувьсгал үндэсний хөтөлберт тусгагдсан холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх. Сүүний чиглэлийн арвин ашиг шимт мал үржүүлэх чиглэлийн төслүүдийг шалгаруулж дэмжлэг үзүүлэх	Хөтөлберт заасан байгууллагууд	2001-2004	Сүү, цагаан идээний үйлдвэрлэлт, борлуулалтын түвшин дээшилж, хүн амын хүнсний хангамжид ахиц гарна	Сүү, цагаан идээний үйлдвэрлэл, хэрэглээний өсөлт	5000.0		5000.0
	1.4. Дүн					5000.0		5000.0
1.5. Арга хэмжээ: Төв, суурин газрын хүн амын сүү, цагаан идээний өдөр тутмын хангамж, ялангуяа нялхас, бага насны хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрлэлийг ашуулгуй, цэвэр түүхий эдээр хангах цогц арга хэмжээ авах								
1.5.1	Стандартын шаардлага хангасан сүү, цагаан идээг зах зээлд тогтвортой нийлүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдийг урамшуулах, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих	ХХАА, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001-2005	Иргэд, аж ахуйн нэгжүүдээс сүү, цагаан идээ боловсруулж, зах зээлд нийлүүлэх сонирхол нэмэгдэнэ	Жишсэн дундаж нэг хүний сүү, цагаан идээний хэрэглээний өсөлт	100.0		100.0
1.5.2	Төв, суурин газрын хэрэгцээг эвдхэн мал эмнэлгийн баталгаатай үйлдвэрлэлийн аргаар боловс-руулсан сүүгээр хангах зорилгоор фермийн аж ахуйд сүүг шүүж хөргөх, ариутган савлах технологийг нэвтрүүлэх	ХХАА, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001-2005	Сүү, цагаан идээ-ний эрүүл ахуй ашуулгүй байдал хангагдана.	Хэрэгцээнд нийлүүлсэн сүү, цагаан идээний чанар, эрүүл ахуйн үзүүлэлт	400.0		400.0
1.5.3	Нийслэл, аймгийн төвүүдийн ойролцоох фермерийн аж ахуй, иргэдийн мал сүргэт	ХХАА,	2001-	Нярай болон бага насны хүүхдийн сүү,	Сүү, цагаан идээний бодит хэрэглээ, эрүүл	100.0		100.0

	мал эмнэлгийн үзлэг хийж хүүхдийн хоол, тэжээлийн үйлдвэрлэлд сүү нийлүүлэх бүс нутаг, аж ахуйг шалгаруулж дэмжлэг үзүүлэх	аймаг, нийслэлийн ЗДТГ	2005	цагаан идээний хангамж дээшилж, ажуулпүй байдал хангагдана.	ахуй, аюулгүй байдлын үзүүлэлт			
						600.0		600.0
	1.5. Дүн							
1.6. Арга хэмжээ: Сүү, сүүн бүтээгдэхүүний тэвэрлэлт, хадгалалт, борлуулалтын зохистой сүлжээг бий болгох								
1.6.1	Сүү, цагаан идээ борлуулалтын зохистой сүлжээг бөөний худалдаа, төрөлжсөн зах, дэлгүүрийн хэлбэрээр зохион байгуулах	ХХАА,ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Амьтны гаралтай бүтээгдэхүүний зохих шаардлагын дагуу тээвэрлэх, худалдах нөхцөл бүрдэнэ.	Төрөлжсөн аж ахуйн нэгж, зах, дэлгүүрийн эрүүл ахуйн үзүүлэлт, хүн амын хэрэглээний түвшин	150.0	-	150.0
1.6.2	Нийслэл, аймгийн төвийн ойролцоо фермер дундын сүү хөргөлтийн цехүүдийг бий болгох	ХХАА, аймаг,нийслэлийн Засаг дарга	2001-2005	Хот, суурин газрын сүүний хангамж сайжирна.	Үйлдвэрлэл, хэрэглээнд нийлүүлэгдэж буй сүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлт	100.0		100.0
						250.0		250.0
	1.6. Дүн							
1.7. Арга хэмжээ: "Ногоон хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх								
1.7.1	"Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөрийн холбогдох заал-туудыг хэрэгжүүлэх	Хөтөлберт заасан байгууллагууд	2001-2004	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалт нэмэгдэж хүн амын хүнсний хангамж дээшилнэ.	Тариалангийн аж ахуй эрхэлдэг ерхийн тоо	600.0		600.0
						600.0		600.0
	1.7. Дүн							
1.8. Арга хэмжээ: Хүн амын төмс, хүнсний ногооны физиологийн хэрэгцээний хангалтын түвшинг дээшлүүлэх, улмаар бүрэн хангахтай холбогдсон арга хэмжээг дэмжин дэлгэрүүлэх								
1.8.1	Төмсийг хатаах, шарах зэргээр хадгалах хугацааг нь уртасгах, шилэн болон нийлэг хальсан хүрэмж, туналь ашиглах замаар шинэ төмс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх	ХХАА, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001 оноос	Монгол улсад энэ чиглэлийн төрөлжсөн аж ахуйнууд шинээр бий болно.	Шинэ ургацын төмс, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	100.0		100.0
1.8.2	Монгол улсад тариалах хүнсний ногооны нэр төрлийг олшруулах	ХХАА, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгж, иргэд	2001 оноос	Монгол хүний хүнсний бүтцэд эрэлт гарч, амин дэм, шимт бодисоор баялаг хүнс-ний бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэнэ.	Хүн амын хэрэглэсэн ногооны нэр төрөл			
1.8.3	Монгол орны хөрс, уур амьсгалд тохирох таримал жимс, жимсгэний сорт төрлүүдийг нутагшуулах, тэдгээрийн тарьц суулгац, залгагдас залгуурыудыг өөрийн үйлдвэрлэлээр хангах эх цэцэр-лэг бий болгох.	ХХАА, ХААИС, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001-2005	Монгол улсын хэрэгцээт жимс, жимсгэний 15 хувиас доошгүйг дотоодын үйлд-вэрлэлээр хангана.	Жишсэн нэг хүнд ноогдох жимс, жимсгэний хэрэглээ	64.1	64.1	-

	1.8. Дүн					164.1	64.1	100.0
1.9. Арга хэмжээ: Өрх гэр, аж ахуйн нэгж, улсын нөөцийн үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн хэрэгцээг хангахад хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар дэмжих								
1.9.1	Буудай, төмсний үрийн чанар хангамжийг сайжруулах "Үр" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	ХХААЯ	2001-2006	Үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэл өмчийн бүх төрлийн хэвшлийн хэлбэрээр хөгжинө.	Үндэсний үрийн үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан байх.	1048.8	1048.8	-
1.9.2	Японы Засгийн газрын туслам-жаар "Төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг нэмэг-дүүлэх" төслийг хэрэгжүүлэх	ХХААЯ, Дарханы УГТЭШХ	2003-2005	Сайн чанарын үрийн үйлдвэрлэл хөгжинө.	Үрийн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж экспортлох хэмжээ	8000.0	8000.0	-
	1.9. Дүн					9048.8	9048.8	-
1.10. Арга хэмжээ: Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тарих, хадгалах, боловсруулах үйл ажиллагааг дэмжих, сургалт явуулах, зөвлөх хэрэглээнд сургах								
1.10.1	Төмс, хүнсний ногоо хадгалах бага оврын зоорь, агуулах барих арга-гаар сургах, материалын дэмжлэг үзүүлэх	ХХААЯ, ХААИС	2001-2004	Жижиг аж ахуйн нэгжүүд, өрхийн хэмжээнд төмс, ногоо хадгалах боломж нэмэгдэнэ.	Өрхийн жижиг зоорь агуулахын тоо, багтаамжийн өсөлт	10.0	10.0	-
1.10.2	Сумын түвшинд агропаркуудыг байгуулж, хүн амын дунд явуулах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх	ХХААЯ, ХААИС аймгийн ЗДТГ	2001-2004	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тарих, хадгалах, боловсруулах талаар хүн амын дунд сургалт, дадлага, сур-талчилгаа өргөжинө.	Одоо ажиллаж байгаа агропаркийн тоо 10 хүвиар нэмэгдэнэ.	144.0	144.0	-
1.10.3	Жимс, жимсгэний аж ахуйнуудыг сэргээх, шинээр байгуулах үзүүлэх сургалтуудыг зохион байгуулах	ХХААЯ, ХААИС аймгийн ЗДТГ	2002-2010	Жимс, жимсгэний аж ахуй хөгжинө.	Хураараа авсан жимс, жимсгэний хэм-жээний өсөлт	200.0	100.0	100.0
1.10.4	Байгалийн болон таримал жимс, жимсгэний боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох, сургалт, сурталчилгаа явуулах	ХХААЯ, ХААИС, Хүнстех корпораци, аймгийн ЗДТГ	2002-2010	Жимс, жимс-гэнийг хүнсний үйлдвэрлэлд өргөн ашиглаж, төрөлжсөн үйлд-вэрлэл бий болно.	Энэ төрлийн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хэмжээний өсөлт	500.0	100.0	400.0
	1.10. Дүн					854.0	354.0	500.0
2.1. Арга хэмжээ: Улаан буудай, бусад үр тарианы дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх								
2.1.1	"Газар тариалангийн үйлдвэрлэ-лийг сэргээх" хөтөлбөрийн хол-богдох заалтуудыг хэрэгжүүлэх	ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Үр тарианы үйлд-вэрлэл нэмэгдэнэ.	Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлд-вэрлэлт, хэрэглээ	45.0		45.0

2.1.2	Уринш хийх талбайн хэмжээг нэмэгдүүлж уриншийн чанарыг сайжруулах замаар улаан буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2005	Улаан буудайн үйлдвэрлэл нэмэгдэнэ.	Бэлтгэл уринш 370 мянгаас доошгүй га-д хүрнэ	36.0	25.0	11.0
2.1.3	Арвай, бог будаа, хөх тариа, хошуу будааны үйлдвэрлэл эрхлэх сонирхол, боломжийг нэмэгдүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх	ХХААЯ, "Хүнстех" корпораци	2002-2005	Үр тарианы үйлдвэрлэл нэмэгдэнэ.	Хүн амын хүнсний хэрэглээний бүтцийн өөрчлөлт сайжирна.	50.0		50.0
	2.1. Дүн					131.0	25.0	106.0
2.2. Арга хэмжээ: Гурилын үйлдвэрүүдийн жигд ажиллагааг хангах, улаан буудайнаас бусад үр тарианы боловсруулах технологи нэвтрүүлэхийг дэмжих								
2.2.1	Улаан буудайнаас бусад үр тариагаар ерөнхий хэрэглээний болон тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	ХХААЯ, "Хүнстех" корпораци	2001-2005	Гурилын нөөц нэмэгдэж, хоол тэжээлийн бүтэц сайжирна.	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	10.0	2.0	8.0
2.2.2	Гурилыг хүнд шаардлагатай зарим бичил бие мах бодь, аминдэмээр баяжуулах технологийг туршиж, нэвтрүүлэх	ХХААЯ, ЭМЯ, "Хүнстех" корпораци	2001-2003	Хүн амыг бичил махбодийн дут-лаас сэргийлнэ.	Баяжуулсан гурилын үйлдвэрлэлийн хэмжээ, өсөлт	500.0	500.0	-
	2.2. Дүн					510.0	502.0	8.0
2.3. Арга хэмжээ: Талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэдгээрийн дотоодын зах зээлд эзлэх хувийг өсгөж, хот, хөдөөд хангамжийг жигд болгох								
2.3.1	Шинэ техник, технологийг нэвт-рүүлэх замаар талх, гурилан бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлнэ.	ХХААЯ,эрдэм шинжилгээний байгууллагууд	2001-2005	Гурилын нөөц нэмэгдэж, хоол тэжээлийн бүтэц сайжирна.	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	50.0		50.0
2.3.2	Хагас бэлэн бүтээгдэхүүн, гоймонгийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх	ХХААЯ	2001-2005	Хэрэглэгчдийн цаг, хөдөлмөр хэмнэг-дэж, үйлчилгээний соёл дээшилнэ.	Бүтээгдэхүүний нэр төрлийн өөрчлөлт	40.0		40.0
2.3.3	Хүнсний бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын сүлжээг аймаг, сумдад бий болгох	аймгийн Засаг дарга	2002-2005	Хүнсний хангамж, хүрэлцээ жигдэрч сайжирна.	Тухайн орон нутгийн хүнсний хангамжийн үзүүлэлт, өсөлт	2100.0		2100.0
	2.3. Дүн					2190.0		2190.0
3.1. Арга хэмжээ: Хүнсний бүтээгдэхүүнийг ариутгах, аюулгүй байдлыг хамгаалах технологи, дэвшилтэт сав, баглаа боодлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх								
3.1.1	Монгол орны нөхцөлд нэвтрүүлэн ашиглах дэвшилтэт технологийг сонгох, нутаг-шуулах талаар судалгаа хийж, цаашдын үзэл баримтлал, чиг хандлагыг тогтоох	ХХААЯ, "Хүнстех" корпораци, ШУТИС	2002-2003	Дэвшилтэт тех-нологи зээмших, нутагшуулах зорилт, бодлого тодорхой болно.	Уг технологийн үндсэн үзүүлэлт	150.0	100.0	50.0

3.1.2	Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг сайжруулах талаар шинжлэх ухаан, технологийн төсөл захиалан хэрэгжүүлэх	ХХААЯ	2002-2004	Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюул-гүй байдлын хам-гаалалт сайжирч, үйлчилгээний соёл дээшилнэ	Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд жижиглэн савлаасан бүтээгдэхүүний эзлэх хувийн жин	200.0	100.0	100.0
3.1.3	Дээр дурдсан арга, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эхлэл, санаачилгыг санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих	ХХААЯ, ҮХЯ	2003-2010	Хүнсний бүтээгдэхүүний техно-логи боловсронгуй болно	Технологийн түвшин	10.0		10.0
3.1.4	Шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлж, цэнгэг ус, үргамал, жимсэнийн ханд, бэлдмэлийг үйлдвэрлэх, тэдгээрийг ундааны үйлдвэрлэлд ашиглах	ХХААЯ, БСШУЯ,эрдэм шинжилгээний байгууллагууд	2001-2005	Экологийн цэвэр ханд, бэлдмэл бүхий ундааны үйлдвэрлэл нэмэгдэнэ	Бүтээгдэхүүний нэр төрлийн тоо, үйлдвэрлэлтийн хэмжээ	150.0	100.0	50.0
	3.1. Дүн					510.0	300.0	210.0
3.2. Арга хэмжээ: Улаан буудайн цэвэр спирт, өндөр хатуулагтай цагаан архины дэвшилт технологийг нэвтрүүлж сав, баглаа боодлыг сайжруулах замаар экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх								
3.2.1	Спирт, цагаан архи экспортлох зах зээлийн судалгааны үндсэн дээр технологийг боловсронгуй болгон зах зээлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэр-лэх, экспортлох арга хэмжээг хэрэгжүүлэх	ҮХЯ, ХХААЯ, "Спирт бал бурам" ХХК, "АПУ" ХК, бусад аж ахуйн нэгж	2001-2003	Дэвшилтэт технологи нэвтэрч, экспортын орлого нэмэгдэнэ	Технологийн түвшин, экспортлосон бүтээгдэхүүний хэмжээ, үнийн дүн	1500.0	1400.0	100.0
3.2.2	Экспортын зориулалтаар үйлд-вэрлэх бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгыг зах зээлийн эрэлт сонирхолд нийцүүлэн сайжруулах, бүтээгдэхүүнийг суртал-члан таниулах арга хэмжээг эрчимтэй зохион байгуулах	ҮХЯ, ХХААЯ, "Спирт бал бурам" ХХК, "АПУ" ХК	2001-2003	Дэвшилтэт техно-логи нэвтэрч, экспортын орлого нэмэгдэнэ	Технологийн түвшин, экспортлосон бүтээгдэхүүний хэмжээ, үнийн дүн	50.0		50.0
	3.2. Дүн					1550.0	1400.0	150.0
3.3. Арга хэмжээ: Үргамлын тос, загас, өндөг зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дотоодод бий болгож хөгжүүлэхэд онцлон анхаарах, найдвартай импортлогчдыг дэмжих								
3.3.1	Үргамлын тос, саахарын үйлдвэр байгуулах талаар зохиосон ажлын үр дүнг нэгтгэж, боломжийг судлах	ХХААЯ, ҮХЯ, СЭЗЯ	2001-2002	Үргамлын тос, саахарын үйлдвэр бий болох болом-жийг тодорхойлно.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ	2500.0	1000.0	1500.0
3.3.2	Гол, мөрөн, цэнгэг нуурын загасыг устах, давслах, хөлдөөх, хатаах,	ХХААЯ, БОЯ,	2001-2005	Хүн амын хүнсний бүтээгдэхүүний	Нэг хүнд ноогдох хэрэглээний бодит	130.0		130.0

	нөөшлөх зэрэг боловс-руулалтын технологи боловс-руулж, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. Энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлэх	ШУТИС		хэрэглээний бүтэц сайжирна.	хэмжээ			
3.3.3	Шувууны аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан тахианы мах, өндөгөөр хүн амыг хангах	ХХААЯ, ХАБХААУХА	2002 оноос	Хүнсний аюулгүй байдлын баталгаа хангагдаж, шинэ-лэг бүтээгдэхүү-ний хэрэглээ нэмэгдэнэ	Нэг хүнд ноогдох хэрэглээний бодит хэмжээ	100.0		100.0
3.3.4	Нэр бүхий өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнийг импортлогчдын дунд сонгон шалгаруулалт явуулж үйл ажиллагааг нь дэмжих.	ҮХЯ, ХХААЯ, УГЕГ, СХЗҮТ	2002 оноос	Аюулгүй байдлын шаардлага хангасан хямд бүтээгдэхүү-нээр хангана	Нэг хүнд ноогдох хэрэглээний бодит хэмжээ	1.0		1.0
						2731.0	1000.0	1731.0
	3.3. Дүн					54 873.9	17768.9	37105.0
	Нэгдүгээр бүлгийн бүгд дүн							
	Хоёр. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр							
4.1. Арга хэмжээ: Хүнсний хяналтын салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах								
4.1.1	Хүнсний аюулгүй байдлын хяналтын үйл ажиллагаат холбогдох байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан оновч-той зөв тодорхойлж, хүнсний аюулгүй байдлын хуульд эрх зүйн орчныг боловсронгуй болгох	ХХААЯ, ЭМЯ, БСШУЯ, ҮХЯ, ХЗДХЯ	2001-2002	Хяналтын байгууллагуудын үүрэг хариуцлага, зааг тодорхой болж хариуцлага сайжирна	Агентлаг бүрийн ажлын хариуцлага дээшилнэ	1.0		1.0
4.1.2	Монгол улсад жилд үйлдвэрлэх, импортлох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гарган хяналтад хамруулах	ХАБХААУХА, ЭМХУА, УГЕГ, ҮХУХА	2001-2010	Дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна	Бүтээгдэхүүний нэр төрөл	1.0		1.0
4.1.3	Импорт, экспортын бүтээгдэхүүнд гэрчилгээ олгох тогтолцоог бүрдүүлэх	ЭМУХА, ХАБХААУХА, УГЕГ, ҮХУХА	2003-2010	Импорт, экспор-тын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулна.	Хилийн хяналтын тогтолцоо сайжирсан байдал, үр дүн	10.0		10.0
4.1.4	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	ҮХЯ, ХХААЯ, УГЕГ, СХЗҮТ	2002-2010	Салбар хоорон-дын мэдээллийн тогтолцоо сайжирна.	Мэдээллийн үзүүлэлт, хангалт	1.0		1.0
	4.1. Дүн					13.0		13.0
4.2. Арга хэмжээ: Хүнсний аюулгүй байдлын хяналт болон эрсдэлийн шинжилгээний стандарт аргуудыг боловсруулах								

4.2.1	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, сав, баглаа боодолд хэналт тавих, шинжилгээ, сорц авах үйл ажиллагаа, статис-тикийн арга, гэрчилгээ зөвшөөрөл олголт, тавигдах шаардлага зэргийг олон улсын стандартад нийцүүлэн мөрдүүлэх	УХЯ, ХХААЯ, ЭМЯ, ДЭМБ, ДХХААБ	2002-2006	Олон улсад зөвшөөрөгдөн, орчин үеийн эрүүл ахуйн хэналт тогтооно	Олон улсын стандартуудад нийцүүлсэн байдал	22.0	22.0
4.2.2	Эрсдэлийн менежмент, стандартыг тодорхойлох үнэлгээ,	ХХААЯ, ЭМЯ, ДЭМБ, ДХХААБ	2002-2006	Эрсдэлийн менеж-мент, үнэлгээ, стандарт үйл ажиллагаатай болно.	Эрсдэлийн дүн шинжилгээний үйл ажиллагааны баримт бичиг	20.0	20.0
4.2.3	Олон улсад хүлээн зөвшөөрөгдөн эрсдэлийн үнэлгээний арга ашиглан онцгой тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийх.	ХАБХААУХА, ЭМУХА	2005-2010	Эрсдэлийн үнэлгээг хийдэг болно	Эрсдэлийг тогтоож урьдчилан сэргийлэх арга хэмжээний дүн.	10.0	10.0
4.2.4	Хүнсний үйлдвэрлэлийн байгууламж, тоног төхөөрөмжүүд шаардлага хангаж буй эсэхэд тавих хэналтын тогтолцоог сайжруулах	ХХААЯ, УХЯ, ЭМЯ, СЗЗЯ, ЗХУГ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2002-2010	Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангах байдал нэмэгдэж, мэдээллээр хангагдана	Тоног төхөөрөмжийн ашиглалт, шинэ техник нэвтрэлт	100.0	100.0
4.2.5	Хүнсний нэмэлт, мал эмнэлгийн эм, биобэлдмэл, пестицидийн үлдэгдэл, хүнд металл, хор, өвчин үүсгэгч бичил биетүүд зэрэг бохирдлыг хэнах хөтөлбөр боловсруулах ба олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох	ЭМУХА, ХАБХААУХА	2005-2010	Хөтөлбөр хэрэгжинэ. Хэналтын ур чадвар, нэр хүнд дээшилнэ.	Хөтөлбөрийн үзүүлэлтүүд	50.0	50.0
4.2.6	Хоол, хүнсний гаралтай өвчнийг хэнах, таңдах, судлах ур дүнтэй тогтолцоог бий болгох	ЭМЯ, ЭМУХА	2002-2005	Хоол хүнсний гаралтай өвчнийг хэнах хүчин чадал нэмэгдэнэ	Хоол хүнсний гаралтай өвчний хандлага, авч буй арга хэмжээний ур дүн	40.0	40.0
4.2.7	Хүнсний үйлдвэр, үйлчилгээнд эрүүл ахуйн дадлага эзэмшүүлэх сургалтын системийг нэвтрүүлэх	худалдаа, зохистой ажиллагааны журам, ХАБХААУХА, ЭМУХА, хүнсний үйлдвэрийг улсын хэмжээнд холбогдох байгуулагатай	2002-2010	Хүнсний үйлдвэр-лэлийн бүх шатанд эзэгтэй сургалт явагдаж, тодорхойлсон сэргийлэх арга хэмжээ авагдана	Эзэгтэй цэгийн хэналтын ур дүн	30.0	30.0

4.2.8	"Эрүүл зах" хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, өргөжүүлэх, хянах	ЭМУХА, орон нутгийн засаг захиргаа	2001-2005	Одоогийн "Эрүүл зах" хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна	Эрүүл захын тоо, "Эрүүл зах" хөтөлбөрийн үзүүлэлт	500.0	230.0	270.0
4.2.9	Эрсдэлийн байдлаар хүнсний байгууллагуудад хяналт тавих, стандарт тогтоох	ХАБХААУХА, ЭМУХА, СХЗҮТ, ҮХУХА	2005-2010	Аюулгүй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.	Стандартын тоо, хэрэгжилт	10.0		10.0
4.2.10	Орон нутгийн засаг захиргаа-наас хүнсний аюулгүй байдлыг сайжруулахаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд техник, хүн хүч, санхүүгийн дэмжлэг үзүүлж хяналтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх	ЭМУХА, ХАБХААУХА, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албад	2003-2010	Орон нутагт хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүд сайжирна.	Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлт-түүдийн бууралт	100.0		100,0
4.2.11	Хилийн мал, амьтан, ургамлын хорио цээрийн хяналтын /буфер/ бүс байгуулах	ХАБХААУХА, ЭМУХА	2002-2005	Хор хөнөөлт шавьж, өвчин тархахаас сэргийлнэ	Хорио цээрийн бусийн тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ	450.0		450.0
4.2.12	Мал эмнэлэг, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд импортын эрсдэлийн үнэлгээ явуулах	ХАБХААУХА, ЭМУХА	2005-2010	Хүн ам, нутаг дэвсгэр дэх мал, амьтан, ургамлын гаралтай өвчний тархалтаар тооцно.	Импортын эрсдэлийн үнэлгээний тоо, өсөлт, үр дүнгийн үзүүлэлт	150.0		150.0
4.2.13	Мал бэлтгэл, туувараллт, махны үйлдвэрлэлд мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн хяналтыг эрх зүйн холбогдох бичиг баримтын дагуу хэрэгжүүлэх	ХАБХААУХА, орон нутгийн мал эмнэлгийн салбар	2002-2010	Зөвхөн мал эмнэлгийн батал-гаатай мал, махыг хүнсний зориулалтаар бэлтгэнэ	Махны хяналтын улсын байцаагчийн үнэлгээгээр	150,0		150,0
	4.2. Дүн					1632,0	230,0	1402,0
4.3. Арга хэмжээ: Хүнсний аюулгүй байдлын асуудлаар хөрш зэргэлдээ болон бусад орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хөгжүүлэх								
4.3.1	Хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, ургамал хамгаллын асуудлаар ОХУ, БНХАУ болон бусад улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх	ХАБХААУХА, ЭМУХА, УГЕГ	2001-2010	Харилцан ойл-голцол, итгэлцлийг бий болгох замаар худалдаагаа хялбарчилна.	Оролцогч орнуудын тоо, мэдээллийн хэмжээ	70.0		70.0
4.3.2	Олон улсын хурал, семинар, сургалтад оролцож, мэдээлэл туршлага солилцох	ХАБХААУХА, ҮХУХА, ЭМУХА, УГЕГ	2001-2010	Эрсдэлийг үнэлэгч, ме-нежерүүд болон хүнс-ний байцаагчдын мэд-лэг чадвар нэмэгдэнэ.	Оролцогчдын тоо, мэдээллийн хэмжээ	24.0		24.0

4.3.3	Хүнсний аюулгүй байдлын талаар үндэсний бага хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах	ХХААЯ, ЭМЯ, ҮХЯ, ДЭМБ, ДХХААБ	2002-2010	Үндэсний хэм-жээнд хүнсний аюулгүй байдлын мэдлэг, хандлага дээшилнэ.	Семинар, хурал, үзэсгэлэнгийн тоо, үр дүн	15.0		15.0
4.3.4	ДЭМБ, ДХХААБ, ДХБ зэрэг олон улсын байгууллагуудтай хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, ургамал хамгаллын асуудлаар хамтын ажиллагаагаа өргөжүүлэх	ЭМЯ, ХХААЯ, ҮХЯ, УГЕГ	2001-2010	Хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, ургамал хамгаллын асууд-лаар олон улсын стандартыг хэрэг-жүүлнэ.	Олон улсын байгуул-лагуудтай хамтран явуулсан үйл ажиллагааны тоо, үр дүнгийн үзүүлэлт	56.0		56.0
	4.3. Дүн					165.0		165.0
4.4. Арга хэмжээ: Хүнсний хууль эрх зүйн хорооны зөвлөмжийн дагуу үндэсний хууль эрх зүйн хороо (техникийн хороо)-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх								
4.4.1	Үндэсний хууль эрх зүйн хороо байгуулах	ХХААЯ, ЭМЯ, ҮХЯ, УГЕГ	2001-2002	Агентлагуудын үйл ажиллагаат зохи-цуулах хууль эрх зүйн хороо байгуу-лагдаж олон улсын асуудалд нэг байр суурьтай хандана	Хууль эрх зүйн хороотой болсон байх, үр дүн	1,0		1,0
	4.4. Дүн					1.0		1.0
5.1. Арга хэмжээ : Лабораториудыг хөгжүүлэх төсөл боловсруулан хэрэгжүүлэх								
5.1.1	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болон бусад лабораторийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, чиг үүргийн дагуу шинэчлэн сайжруулах	ХАБХААҮХА, ЭМҮХА, УГЕГ, СХЗҮТ, БСШҮЯ аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албад	2002-2003	Хяналтын хүрээ, арга сайжирч аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ	Лабораториудын аж-лын чиглэл, хамтын ажиллагааны тогтолцоо, үр дүн	200.0		200.0
5.1.2	Лабораториудыг олон улсын итгэмжлэлд хамруулах	ХАБХААҮХА, ЭМҮХА, УГЕГ, СХЗҮТ ОУЛИБ, Ази, Номхон далайн ЛИБ	2005-2010	Лабораторийн үйл ажиллагаа олон улсад хүлээн зөвшөөрөгдөнө	Олон улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн байдал	50.0		50.0
5.1.3	Хяналтын лабораториудын үйл ажиллагааны болон шинжилгээний аргуудын стандарт боловсруулж мөрдүүлэх	СХЗҮТ, стандартын техникийн хороод, холбогдох олон улсын байгууллага	2003-2005	Хүнсний хяналтын лабораториудын үйл ажиллага, шинжилгээний аргууд стандарт-чилагдана	Үйл ажиллагааны гарын авлага,жишиг тогтоох, дээж авах, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартууд	22.0		22.0
	5.1. Дүн					272,0		272,0

5.2. Арга хэмжээ: Хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэн мэргэшүүлэх								
5.2.1	Лабораторийн ажилтны шинжилгээ, судалгаа хийх болон хяналтын мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	ХАБХААУХА, ЭМУХА, УГЕГ, СХЭҮТ, НЭМХ	2002-2010	Хяналт явуулахад боловсон хүчний мэдлэг, ур чадвар нэмэгдэнэ	Зохих хэмжээнд бэлтгэгдсэн болов-сон хүчний тоо, ажлын үр дүн	100,0		100,0
5.2.2	Их, дээд сургуулийн хүнсний мэргэжлийн салбаруудын сургалтын хөтөлберт хүнсний аюулгүй байдал, эгзэгтэй цэгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах сэдвүүдийг оруулах	БСШУЯ, ЭМУХА, ХАБХААУХА, УГЕГ	2001-2010	Мэргэшсэн ажилтан бэлтгэгдэнэ	Тусгагдсан байдал	50,0		50,0
5.2.3	Их, дээд сургууль, ЕБС-ийн хичээлийн программд аюулгүй, эрүүл хүнсийг зохистой хэрэглэх талаар тусгаж сургалт явуулах	БСШУЯ, ЭМЯ, ХХААЯ	2001-2010	Суралцагчдын хүнсний аюулгүй байдлын талаархи мэдлэг, хандлага дээшилнэ.	Тусгагдсан байдал	10,0		10,0
	5.2. Дүн					160,0		160,0
6.1. Арга хэмжээ: Хүнсний үйлдвэрлэл, гудамжны худалдаа, үйлчилгээнд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулж хүн амыг зохистой хэрэглээний дадал заншилд сургах								
6.1.1	Гудамжны хоол, хүнсний худалдаа, үйлчилгээний хяналтыг олон улсын стандартад нийцүүлэх	ЭМУХА, мэргэжлийн хяналтын албад	2003-2010	Хүнсний аюулгүй байдлыг хангана	Хоол, худалдаа эрхлэгчдэд тавих хяналт, үр дүн	100.0		100.0
6.1.2	Гудамжны хоол үйлдвэрлэгчдийг хотын нэгдсэн төлөвлөгөө, хүн амын байршилтай уялдуулан зохицуулах	ХАБХААУХА, ҮХУХА, ЭМУХА	2002-2010	Гудамжны худалдаа, үйлчилгээний зохистой хэлбэр бий болох	Гудамжны хоол, худалдаа эрхлэгчдэд тавих хяналт, үр дүн			
6.1.3	Зөв зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдлын сургалт, сурталчилгаа, хяналтад олон нийтийн байгууллага, иргэдийг идэвхтэй оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх	ХЭАХН, ХАБХААУХА, ЭМУХА, НЭМХ	2002-2010	Хүнсний аюулгүй байдлын талаар хүмүүсийн мэдлэг сайжирна.	Хүнс, хоолоор дамжих өвчлөл буурна	10,0		10,0
6.1.4	Төвлөрсөн хотуудад гудамжны хоол үйлдвэрлэлийн "загвар" үйлчилгээ бий болгож, хоол үйлдвэрлэгчдийг нэгдсэн сургалтад хамруулах	ҮХУХА, ХАБХААУХА, ЭМУХА	2002-2010	Хүнсний аюулгүй байдлын баталгаат хангах	Загвар үйлчилгээний тооны өсөлт, сургалтын тоо, хамралт	10,0		10,0
	6.1. Дүн					120,0		120,0
	Хөөрдүгаар бүлгийн бүгд дүн					2362,0	230,0	2132,0
7.0. Арга хэмжээ: Усны хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах								
7.1	Хэрэглэгчдийг чанартай, хүрэл-цээтэй усаар найдвартай ханга-хад чиглэгдсэн усны эх үүсвэрийн хайгуул.	ХХААЯ, ҮХЯ, аймаг, нийслэлийн	2001 - 2005	Хүн амыг чанар-тай, хүрэлцээтэй усаар найдвартай хангах	Нэг хүнд оногдох усны хэрэглээний үзүүлэлт	800.0	150.0	650.0

	судалгааг хийж нөөцийг тогтоох	ЗДТГ		арга хэмжээ авагдана.			
7.2	Хүн амын ундны усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож паспортжуулах, усны нөөц нь ундны усны чанарын стандартын шаардлага хангадаггүй сум, суурин газруудад ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ, ХХААЯ, ДБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001-2003	Эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, сум, суурин газруудын ундны усны чанар сайжирна	Хамгаалалтын бүстэй ундны усны эх үүсвэрийн тоо, паспортжуулсан эх үүсвэрийн тоо, ус зөөлрүүлэх, цэнэгжүүлэх төхөөрөмжтэй сум, суурингийн тоо	300.0	-	300.0
7.3	Томоохон хотуудын ус хангам-жийн эх үүсвэр-газрын доорхи усны горимын өөрчлөлт, бохирд-лыг хянах хэмжилтийн сүлжээг томоохон ай савуудаар байгуулж эхлэх	БОЯ, ДБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2001 - 2010	Хэрэглэгчдийн ус хангамжийн аюулгүй байдлын түвшин дээшилнэ.	Усны горимын үзүүлэлт, бохирдлын хяналтын түвшин	2000.0	-	2000.0
7.4	Одоо мөрдөгдөж байгаа Усны тухай болон Ус, рашаан ашигласны төлберийн тухай хуулиуд, эрх зүйн актуудыг боловсронгуй болгох	БОЯ, ХХААЯ, ДБЯ, СЭЗЯ, ЭМЯ	2001 - 2002	Эрх зүйн орчин сайжирна.	Шинэчлэж, боловс-руулсан хууль эрхийн актын тоо			
	7. Дүн					3100.0		3100.0
	Гурав. Хоол, тэжээлийн чиглэлээр							
	8.1. Арга хэмжээ : Хоол, тэжээлийн үндэсний лавлагаа, норм хэмжээ, зөвлөмжүүдийг хянан шинэчлэх							
8.1.1	Монгол хүний хоол, тэжээлийн бодисуудын зөвлөмж, хэмжээг шинэчилнэ.	ЭМЯ, НЭМХ, ДЭМБ, НҮБ-ын ХС,	2002-2005	Хүн амын хүнсний хэрэглээний норм, хэмжээ шинэчлэн тогтоогдож мөрдөгдөнө.	Шинэчилсэн зөвлөмж, хэмжээний тооны өсөлт	10.0		10.0
8.1.2	Хүнсний үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн хоногийн хэрэгцээг тодорхойлно.	ЭМЯ, НЭМХ, ДЭМБ, НҮБ-ын ХС,	2005		Шинэчилсэн зөвлөмж, хэмжээний тооны өсөлт	10.0		10.0
8.1.3	Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын эмхтгэлийг шинэчилнэ.	ЭМЯ, НЭМХ, ДЭМБ, НҮБ-ын ХС,	2003-2005		Шинэчилсэн зөвлөмж, хэмжээний тооны өсөлт	5,0		5,0
8.1.4	Олон нийт, өвөрмөц бүлгийн хоол, тэжээлийн лавлагаа хэмжээг шинэчлэн, зөвлөмж гаргана. Тухайлбал: а/үйлчилгээний албан хаагчид (арми, нисэх хүчин, далайчид); б/асрамж, халамжийн төвүүдэд асруулагчид; в/хоригдол, ялтнууд; г/ЕБС, их дээд сургуулиудын цайны газар, сургуулийн дотуур байр.	ЭМЯ, НЭМХ, ДЭМБ, НҮБ-ын ХС,	2003-2005		Зориулалтын хүнс хэрэглэгчдийн хоол тэжээлийн норм хэмжээний хэрэг-жилтийн үзүүлэлтүүд	100.0		100.0

8.1.5	Эмчилгээ, сувилын хөлсний байгууламтыг боловсронгуй болгож, эмчилгээний хөлсийг нийлэгээ, зохистой харьцаг шинэчлэн гаргана.	ЭМЯ, НЭМХ, ДЭМБ, НҮБ-ын ХС.	2005-2008	Зохистой харьцааны үзүүлэлтүүд	10.0	10.0
					135.0	135.0
	8.1. Дүн					
8.2. Арга хэмжээ: Хүн амын эрүүл мэндийг дэмжих зохистой хооллолтын талаар үндэсний зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх						
8.2.1	Монгол хүний эрүүл хооллолт болон амьдралын хэв маягийг хангах зохистой холлох үндэсний зөвлөмж боловсруулж түгээнэ.	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, ШУА	2002-2005	Хүн амын хоол-лолтын дэлгэм зөрэгээр өөрчлөгдөх эхлэл тавигдана	Зөвлөмжийн үзүүлэлт	6.0
8.2.2	Эрүүл хоолны цуврал цэс, жор боловсруулж гаргана	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, ШУА	2002-2005	- " -	Хоолны цэс, жор, стандарт 160-аас доошгүй гаргана	4.0
8.2.3	Хоол, тэжээлтэй холбоотой архаг өвчин үүсгэх халгаат хүчин зүйлсийн судалгаа хийж, зөвлөмж аргачлал гаргаж нэвтрүүлнэ	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, ШУА	2002-2005	Хүн амын хоол-лолтын дэлгэм зөрэгээр өөрчлөгдөх эхлэл тавигдана	Зөвлөмж, аргачлалын үзүүлэлт	15.0
					25.0	25.0
	8.2. Дүн					
8.3. Арга хэмжээ: Цэцэрлэгийн насны болон өсвөр үеийн хүүхдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх						
8.3.1	Оюутан, өсвөр үеийнхний хоол, тэжээлийн өнөөгийн байдлыг судлан үнэлгээ өгч зөвлөмж, аргачлал боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, БСШУ-ны ОУБ	2002-2010	Зөвлөмж гарч хэрэгжинэ	Зөвлөмж, аргачлал хэрэгжүүлж буй байгууллагын тооны өсөлт	125.0
8.3.2	Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, коллежуудын дэргэдэх үүнэ, цайны газарт мөрдөгдөх хоолны технологийн жор боловсруулан гаргаж мөрдүүлнэ	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ	2002-2010	Сургуулийн дэргэдэх гуанз, цайны газар зөвлөмж жор мөрдөгдөнө	Зөвлөмж хэрэгжүүлж буй байгууллагын тооны өсөлт	5.0
8.3.3	Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, коллежуудын дэргэдэх гуанз, цайны газрын үйл ажиллагаанд жил бүрийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнаж байна.	ЭМЯ, НЭМХ, ЭМҮХА	Жил бүрийн	Үр дүнгийн тайлан гарна	Тайлангийн дүн	10.0
8.3.4	Цэцэрлэгийн өдрийн хоол, хүнсний хангамжийн байдалд үнэлгээ өгч зөвлөмж, аргачлал боловсруулан хэрэгжүүлнэ	ЭМЯ, НЭМХ,	2002-2003	Зөвлөмж, аргачлал гарч хэрэгжинэ	Зөвлөмж, аргачлал хэрэгжүүлж буй цэцэрлэгийн тооны өсөлт	7.0
					147.0	147.0
	8.3. Дүн					
8.4. Арга хэмжээ: Хүн амын хоол, тэжээлийн асуудлыг шийдвэрлэхэд нийгэм, сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх. нийгмийн эрүүл мэндийн түгшүүлэгч хүчин зүйлсийг тогтоох, тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгоно						

8.4.1	Хүн амын хоол, тэжээлийн байдлыг судлах, мэдээлэх, хяналт-шинжилгээний ажлын санхүүжилтийг улсын төсөвт тусгах	ЭМЯ, ХХААЯ, СЗЗЯ	2002-2010	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэнэ	Хяналт үнэлгээний дүн	200,0		200,0
8.4.2	Хүн амын эмзэг бүлгийн хоол, тэжээлийн байдалд дэмжлэг үзүүлэхэд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгах.	ЭМЯ, ХХААЯ, СЗЗЯ	Жил бүр	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэнэ	Хоол, тэжээлийн хангамж, хэрэглээний үзүүлэлтүүд	200,0		200,0
	8.4. Дүн					400,0		400,0
9.1. Арга хэмжээ: Эмзэг бүлгийн хүн амын хоол, тэжээл, амьдралын хэв маягийг дээшлүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа сайжруулах.								
9.1.1	Амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой эхчүүд, хүүхдийн хоол, тэжээлийг сайжруулах төсөл боловсруулж Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газартай хамтран ажиллана.	ЭМЯ, НЭМХ, ХХААЯ, БСШУЯ, ӨАЧДХГ, МЭХ	2002-2010	Эмзэг бүлгийн хоол, тэжээлийн байдал сайжирна	Хоол, тэжээлийн хангамж, хэрэглээний үзүүлэлтүүд	60.0		60.0
9.1.2	Амьдралын баталгаат түвшин-гээс доогуур орлоготой ядуу айл өрхийн жирэмсэн ба хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн хоол, тэжээлийн асуудлыг шийдвэрлэх орон нутгийн сан байгуулж ажиллуулах	ЭМЯ, ХХААЯ, СЗЗЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2002-2010	Сан байгуулагдана	Байгуулагдсан сангийн тоо, үйл ажиллагааны үзүүлэлтүүд	200,0		200,0
	9.1. Дүн					260,0		260,0
9.2. Арга хэмжээ: Нялхас, 06-24 сартай хүүхдүүдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах, нэмэгдэл хоолны тэжээллэг чанар, асран хамгаалахуйн зөрэг дадлыг дэмжих								
9.2.1	Нялхсын зохистой хооллолтын талаар эхчүүдэд мэдээллээр хангах замаар тэдний мэдлэгийг дээшлүүлж хандлагыг өөрчлөх	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ХХААЯ, ТББ	2002-2010	Мэдлэг, хандлага сайжирна.	6 сар хүртэл дан хөхөөр хооллож буй хүүхдийн тоо	200,0	200,0	
9.2.2	Олон нийт, албан байгууллагуудад эх, хүүхдэд эзэлтэй орчин бий болгох санаачилгыг өрнүүлж, дэмжих	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ТББ	2002-2010	Хүүхдэд эзэлтэй байгуулагууд бий болно	Байгууллагуудын тооны өсөлт	100,0	100,0	
9.2.3	Хүүхдэд эзэлтэй эмнэлгийн давтан үнэлгээний журмыг боловсронгуй болгох замаар байнга хяналт үнэлгээ хийж, мэдээлэх үйл ажиллагааг хэвшүүлнэ	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС	Жил бүр	Хүүхдэд эзэлтэй эмнэлгийн үйл ажиллагаа тогтмолжино	Үйл ажиллагааны үзүүлэлтүүд	120,0	120,0	

9.2.4	Бага насны хүүхдийн асран хамгаалахуй, хоол, тэжээлийн талаархи сургалтын хөтөлбөр боловсруулах, эмнэлгийн ажилтан, залуу эхчүүд, эмэгтэйчүүдэд системтэй сургалт явуулна.	ЭМЯ, БСШУЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС, алсын зайн сургалтын төвүүд	Жил бүр	Мэдлэг, хандлага сайжирна	Сургалтын тоо, хамрагдсан хүний тооны өсөлт	200,0	150,0	50,0
9.2.5	Орон нутагт олдоцтой хүнсний бүтээгдэхүүн, байгалийн баялгийг ашиглан гэрийн нөхцөлд хүүхдийн анхны нэмэгдэл хоол бэлтгэх, тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх жор технологийг боловсруулан түгээнэ.	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС	2003	Хоолны жор технологийн гарын авлагыг мөрдүүлнэ	Боловсруулсан жор, технологийн тооны өсөлт, мөрдөх байгууллагын тооны өсөлт	5,0		5,0
9.2.6	Бага насны хүүхдийн хооллолтын уламжлалт эрэг дадал заншилд тулгуурлан сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногоог түлхүү хэрэглэх дадалд сургахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ХХААЯ, ТББ	2002-2010	Мэдлэг, хандлага сайжирна.	Хоол тэжээлийн үзүүлэлт, оролцсон байгууллагын тооны өсөлт	150,0	100,0	50,0
9.2.7	Төв, орон нутгийн хүүхдийн сувилал, эмнэлгийн үйл ажиллагаат түшиглэн бага насны хүүхдийн хоол, тэжээлийн цех, тасаг байгуулна.	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын ХС, аймаг, нийслэлийн Засаг дарга	2002-2010	Нэмэгдэл хоолны цех, тасаг байгуулах хөдөл-гөөн өрнүүлнэ	Байгуулагдсан цех, тасгийн тооны өсөлт	200,0		200,0
9.2.8	Хөхний сүү орлуулагчийн зах зээлийг зохицуулах хууль зүйн орчин бүрдүүлнэ.	ЭМЯ, НЭМХ	2003-2004	Монгол Улсын хууль гарна	Хуулийн хэрэгжилт	15,0	10,0	5,0
	9.2. Дүн					990,0	680,0	310,0
9.3. Арга хэмжээ : Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах								
9.3.1	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн хоол, тэжээлийн өнөөгийн байдлыг судалж үнэлгээ өгөх ба зөвлөмж гаргаж хэрэгжүүлнэ	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын ХС, ДЭМБ	2002-2010	Зөвлөмж хэрэгжинэ	Жирэмсэн ба хөхүүл эхчүүдийн цус багадалтын тархалтын бууралт	45.0	25.0	20.0
9.3.2	Эх, хүүхдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулахад төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжинэ	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ТББ-ууд	2002-2010	Төрийн бус байгуулагуудын оролцоо нэмэгдэнэ	Оролцогч байгууллагуудын тооны өсөлт	20,0	10,0	10,0
	9.3. Дүн					65,0	35,0	30,0

9.4. Арга хэмжээ: Бага насны хүүхдийн өсөлтийг хянах болон дэмжих тогтолцоог бүрдүүлэх								
9.4.1	Хүүхдийн өсөлтийн хүснэгтийг хөтлөх, хэрэглэх талаар сургалт зохион байгуулна.	ЭМЯ, НЭМХ, ҮСГ, НҮБ-ын ХС, ДЭМБ	2002-2005	Сургалт зохион байгуулагдаж хэвшинэ	Сургалтын тооны өсөлт, хамрагдагсдын тооны өсөлт	100.0	50.0	50.0
9.4.2	Хүүхдийн өсөлтийн хүснэгтийг хэрэглэх, мэдээлэл цуглуулах ба үр дүнг тайлагнах, мэдээлэх журмыг гаргаж, хүүхдийн өсөлтийн талаар үндэсний мэдээллийн сан бий болгоно.	ЭМЯ, НЭМХ, ҮСГ, НҮБ-ын ХС, ДЭМБ, МЭХ, ТББ-ууд	2002	Мэдээллийн сан бүрдэнэ.	Сангийн үйл ажиллагааны үзүүлэлт	15,0	10,0	5,0
9.4.3	Хүүхдийн өсөлтийг хянах ба дэмжихэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, өсөлтийг хянах хүснэгтээр хангана.	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын ХС, ДЭМБ	2002-2003	Өсөлтийг хянах багаж, тоног төхөөрөмжөөр хангагдана	Хангалтын түвшин, тооны өсөлт	90,0	60,0	30,0
	9.4. Дүн					205,0	120,0	85,0
9.5. Арга хэмжээ : Бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг Д аминдэмийн дутал, төмөр дутлын цус багадалтаас урьдчилан сэргийлэх ба хянах үйл ажиллагаат сайжруулах								
9.5.1	Жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн Д аминдэмийн дутал, төмөр дутлын цус багадалтыг хянах ба урьдчилан сэргийлэх арга-члал боловсруулж, хэрэгжүүлнэ..	ЭМЯ, НЭМХ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ДЗ-М, ТББ-ууд	2002-2005	Аргачлал хэрэгжинэ.	Хяналт үнэлгээний үзүүлэлтүүд	50.0	35.0	15.0
9.5.2	Жирэмсэн болон хөхүүл эхчүүд, төрөх насны эмэгтэйчүүд, өсвөр насны охид, бага насны хүүхдийг Д аминдэм, төмрийн бэлдмэлээр хангах, түүний үр дүнг судлах, хянах, мэдээлэх үйл ажиллагаат сайжруулна.	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ДЗ-М	2002-2010	Д аминдэм, төмрийн бэлдмэлийн хангамж сайжирна. Мэдээллийн тогтолцоо бүрдэнэ.	Д аминдэмийн дутал, төмөр дутлын цус багадалтын мэдээ, мэдээлэл, судалгаа	140.0	75.0	65.0
	9.5. Дүн					190,0	110,0	80,0
9.6. Арга хэмжээ : Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлберийг хянан, нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх								
9.6.1	Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлберийг шинэчлэн хэрэгжүүлнэ	ЭМЯ, НЭМХ, ХХААЯ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ЖАЙКА, ТББ-ууд	2002-2005	Хүн амын дундах бамбайн бах-луурын тархалтын хувь буурна	Бахлуурын тархалтын мэдээ, мэдээлэл, судалгаа	300.0	300.0	0.0
9.6.2	Өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх.	ЭМЯ, НЭМХ, ХХААЯ, МЭХ, НҮБ-ын ХС, ДЭМБ, ЖАЙКА, ТББ-ууд	2002-2010	Иоджуулсан давс-ны хангамж, чанар сайжирна	Өрхийн иоджуулсан давсны хэрэглээ 70 хувьд хүрнэ	100,0	100,0	0.0

	9.6. Дүн						400.0	400.0	
10.1	Арга хэмжээ: Хүн амд, олон нийтийн зев зохистой хооллолтын талаар мэдээлэл, сургалт, суртачилгааны ажлыг эрчимжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийг оролцуулан салбар хоорондын хамтын ажиллагааны сүлжээг бий болгоно								
10.1.1	Хүн амын хоол тэжээлийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж үнэлэх	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, УСГ	2003-2010	Судалгааны тайлан гарна	Цаашид авах арга хэмжээний үндэслэл	15.0			15,0
10.1.2	Үндэсний болон орон нутгийн түвшинд хоол тэжээлийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, суртачилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, зайн сургалт, төрөл бүрийн арга хэрэглэн явуулах	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, ХХААЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, НҮБ, ТББ-уд	2002-2010	Эрүүл, зохистой хооллолт ба амьдралын хэв маягийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага дээшилнэ	Хоол тэжээлтэй холбоотой евчлөлийн мэдээ, судалгаа	10,0			10,0
10.1.3	Хүн амд зев зохистой хооллох дадал заншлыг эзэмшүүлэхэд олон нийт, хамт олны оролцоог нэмэгдүүлэх, уламжлалт зөрэг дадал заншлыг арга зүйн талаас дэмжин суртачлах	ЭМЯ, НЭМХ, БСШУЯ, ХХААЯ, МРТ, аймаг, нийслэлийн Засаг дарга, НҮБ, ТББ-ууд	2002-2010	Эрүүл, зохистой хооллолт ба амьдралын хэв маягийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага дээшилнэ	Хоол, тэжээлтэй холбоотой евчлөлийн мэдээ, судалгаа	10,0	5,0		5,0
10.1.4	Сургалт, суртачилгааны материаллаг баазыг бэхжүүлж, дүүрэг, орон нутагт хоол тэжээлийн зевлөлгөө өгөх төвүүдийг бий болгоно	ЭМЯ, НЭМХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, НҮБ	2003-2010	Зевлөлгөө өгөх төв дүүрэг, аймгийн төвүүдэд бий болно	Зевлөлгөө өгөх төвүүдийн тоо, үйлчилгээний хүрээ, хамралт	100,0			100,0
10.1.5	Хүн амын хоол, тэжээлийн байдлыг сайжруулахад хоол, тэжээл, эрүүл мэндийн боловсролын талаар төрийн болон төрийн бус байгууллагуудад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнд хамтран ажиллана.	ЭМЯ, НЭМХ, аймаг нийслэлийн Засаг дарга, НҮБ, ТББ-уд	2002-2010	Төрийн ба төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдэнэ	Оролцоч байгууллагуудын тоо	30,0	20,0		10,0
	10.1. Дүн					165.0	25.0		140,0
11.1	Арга хэмжээ: Хүнсийг баяжуулах ялангуяа гурил, гурилан бүтээдэгхүүний: Д аминдэм болон төмөрөөр баяжуулах орчин үеийн технологийг нэвтрүүлэх								
11.1.1	Өрөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний /*бүдээн гурил, гурилан бүтээгдэхүүн/* хүн амын хоол тэжээлд дутагдаж буй төмөр, Д аминдэмээр баяжуулах боломжит технологийг судлан шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудтай хамтран зевшилцөнө. Хүнсний бүтээгдэхүүний баяжуулах техник технологийн зөвшөөрөл бичгийг	ХХААЯ, ЭМЯ, ДЭМБ, АХБ, НҮБ-ын ХС	2002	Үйлдвэрлэлийн технологийн горим боловсргодно.	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологийн үзүүлэлт	10.0	10.0		0.0

	боловсруулах							
11.1.2	Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулахад хэрэглэгдэх төмөр, Д аминдэмээр хангах эх үүсвэрийг тодруулж, нөөцтэй болох.	ХХААЯ, ЭМЯ, ДЭМБ, АХБ, НҮБ-ын ХС, ДЗ-м	2002	Түүхий эдийн нөөц бий болно	Нөөцийн хэмжээгээр	400,0	400,0	
11.1.3	Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах, түүний хэрэглээний үр нөлөөг үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.	ХХААЯ, ЭМЯ, ДЭМБ, АХБ, НҮБ-ын ХС, ДЗ-м	2002-2003	Үнэлгээний тогтолцоо бүрдэнэ	Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдээр	100,0	100,0	
	11.1. Дүн					510,0	510,0	
	Гуравдугаар бүлгийн бүгд дүн					3492,0	1880,0	1612,0
	Дөрөв. Нийтлэг зорилтын хүрээнд							
12.1. Арга хэмжээ: Онцгой байдал, гамшгийн үеийн хүнс, хоол, тэжээлийн хангамж, аюулгүй байдлыг үнэлэх, хянах, мэдээлэх, нэрвэгдэгсдэд туслах тогтолцоо бүрдүүлэх								
12.1.1	Онцгой байдал, гамшгийн үед хүн амын хоол, тэжээлийн байдлыг судалж үнэлгээ өгөх, хянах, мэдээлэх, аюулгүй хүнсэр хангах тогтолцоо бүрдүүлэх	УБОК, БХЯ, ИХГ, БОЯ, ЭМЯ, ХХААЯ, МЭХ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, ТББ-уд	2002-2003	Тогтолцоо бүрдэнэ	Гамшгийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан, судалгааны үзүүлэлт	30,0		30,0
12.1.2	Хоол, тэжээлийн зөвлөмжид тулгуурлан орон нутагт олдоцтой бүтээгдэхүүнээр онцгой байдлын үед хэрэглэх өндөр илчлэгт хүнсийг бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх	ХХААЯ, ЭМЯ, НЭМХ, ҮХЯ, СЭЗЯ	2002-2005	Онцгой байдлын үед хэрэглэх хүнсний нөөц бүрдсэн байна	Нөөцийн хэмжээ	15,0		15,0
	12.1. Дүн					45,0		45,0
13.1. Арга хэмжээ: Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх								
13.1.1	Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх, хяналт шинжилгээ, мэдээлэх аргачлал боловсруулна.	ЭМЯ, ХХААЯ, НЭМХ, ҮСГ, ЭМУХА, ХАБХААУХА, ҮХУХА	2002-2010	Аргачлал гарна	Үнэлэх, хянах, мэдээлэх шалгуур үзүүлэлтүүдээр	2,0		2,0
13.1.2	Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг салбар, чиглэл тус бүрээр үнэлэх ба мэдээллийг хамтран аэзмших, тайлагнах үндэсний мэдээллийн сан бий болгоно.	ЭМЯ, НЭМХ, ҮСГ, ЭМУХА, ХАБХААУХА, ҮХУХА, ДЭМБ, НҮБ-ын ХС, ЖАЙКА, ТББ	2002-2010	Жил тутмын үнэлгээний дүн гарна. Мэдээллийн сан бүрдэнэ	Үнэлгээний сангийн үзүүлэлтүүд	200,0		200,0
	13.1. Дүн					202,0		202,0
14.1. Арга хэмжээ : Хоол тэжээлийн чиглэлийн боловсон хүчний мэргэжлийн чадавхийг сайжруулах								
14.1.1	Төв, орон нутгийн хоол судлалын	ЭМЯ, НЭМХ,	2002-	Хоол судлалын	Бэлтгэгдсэн	100.0	50.0	50.0

	мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг олон улсын мэргэжилтэн, зөвлөхүүдийн оролцоотой боловсруулж хэрэгжүүлнэ.	НҮБ-ын төрөлжсөн байгууллага, ТББ-уд	2010	салбарын мэргэжилтнүүдийн чадавхи дээшлэнэ	мэргэжилтний тооны өсөлт, аттестатчилал			
14.1.2	Мэргэжилтнүүдийн ур чадварыг бүрэн дүүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх, багаж, тоног төхөөрөмжөөр хангана.	ЭМЯ, НЭМХ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, ТББ-уд	2002-2010	Ажлын бүтээмж дээшлэнэ	Багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын үзүүлэлт	200,0	100,0	100,0
	14.1. Дүн					300,0	150,0	150,0
14.2. Арга хэмжээ : Үндэсний боловсон хүчний "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл"-ийн талаархи мэдлэг, хандлага, чадавхийг дээшлүүлэх								
14.2.1	Анагаах ухааны их, дээд сургууль, коллежууд болон төгсөлтийн дараахь сургалтын хөтөлберт хүнсний аюулгүй байдал, хүн амын болон эмчилгээний хоол судлалын чиглэлээр хичээл оруулах	ЭМЯ, БСШУЯ, НЭМХ	2002-2003	Эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг дээшлэнэ	Сургалтын хөтөлберийн үзүүлэлт			
14.2.2	Хүнсний үйлчилгээний болон эмнэлгийн хоолны мэргэжилтнүүдийн сургалт дамжаа зохион байгуулна.	ЭМЯ, БСШУЯ, ХХААЯ, НЭМХ, МХХ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, ТББ-уд	2002-2005	Хүнсний үйлчил-гээний ажилтнууд болон эмнэлгийн тогооч нарын мэдлэг дээшлэнэ	Сургалтын хөтөлберийн үзүүлэлт	10,0		10,0
14.2.3	Багш бэлтгэдэг коллеж, их сургууль, Хүнсний технологийн дээд сургууль, ХААИС, хүнсний коллежуудын сургалтын хөтөлберт хоол, тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудлыг оруулна.	ЭМЯ, ХХААЯ, БСШУЯ, НЭМХ, МХХ, "Хүнстех" корпораци	2002-2003	Мэргэжилийн боловсон хүчний нөөц, мэргэжилтний чадавхи дээшлэнэ	Сургалтын хөтөлберт тусгасан байдал			
14.2.4	Хүнсний салбарын боловсон хүчний нөөцийг судалж, мэргэжилтний чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулна.	ЭМЯ, ХХААЯ, БСШУЯ, НЭМХ, МХХ	2002-2005	Хүнсний салбарын ажилтнуудын мэдлэг, чадавхи дээшлэнэ	Сургалтын хөтөлберийн үзүүлэлт	10,0	5,0	5,0
14.2.5	Салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд, судлаачдын мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх талаар бусад салбар, олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.	ЭМЯ, ХХААЯ, БСШУЯ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага	2002-2010	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилтнуудын мэдлэг, чадавхи сайжирна	Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, судалгаа, шинжилгээний тайлан, мэдээ	5,0		5,0
	14.2. Дүн					25,0	5,0	20,0
	Дэревдүгээр бүлгийн бүгд дүн					572,0	155,0	417,0
	Хөтөлберийн нийт зардал					64 399,9	20 033,9	44 366,0

Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХООЛ ТЭЖЭЭЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ "САЛБАР ХООРОНДЫН ҮНДЭСНИЙ ХОРОО"-НЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Орлогч дарга -Эрүүл мэндийн дэд сайд

Гишүүд:-Үйлдвэр, худалдааны дэд сайд;

-Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны дарга;

-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн захирал;

-Үйлдвэр,худалдааны улсын хяналтын албаны дарга;

-Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газрын дарга;

-Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын хяналт хариуцсан дэд дарга;

-Эрүүл мэндийн улсын хяналтын албаны эрүүл ахуй, халдвар судлал хариуцсан дэд дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнсний хэлтсийн дарга;

-Монголын Хүнсчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга: -Хүнс, хөдөө аж ахуйн яамны холбогдох ажилтан.

Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХООЛ ТЭЖЭЭЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ "САЛБАР ХООРОНДЫН ҮНДЭСНИЙ ХОРОО"-НЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. "Салбар хоорондын үндэсний хороо" (цаашид "Хороо" гэх) нь Хүнсний хууль болон "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих, хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын асуудлыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Хороо нь үйл ажиллагаандаа Хүнсний тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Хороо нь тогтоол, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны тамга, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Хорооны удирдлага, бүтэц зохион байгуулалт

4. Хорооны бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

5. Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Хороо нь хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал, хоол, тэжээлийн асуудлаар тэмдэглэл, зөвлөмж гаргаж болно. Хорооноос гаргасан тогтоол, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд хариу мэдэгдэнэ.

6. Хорооны хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулж холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилт, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах талаар зохиож байгаа ажлын явц, үр дүнг хэлэлцэнэ.

7. Хурлын дэгийг Хорооны хурлаар хэлэлцэн батална. Хурлыг Үндэсний хорооны дарга, түүнийг эзгүйд орлогч дарга удирдана.

8. Хорооны нарийн бичгийн дарга нь хорооны хуралдааны бэлтгэлийг ханган, хуралдаанаас гарсан шийдвэрийг яам, холбогдох газруудад хүргүүлж биелэлтэд хяналт тавих болон хүнсний аюулгүй байдлын салбар дундын зохицуулалтын өдөр тутмын ажлыг зохицно. Нарийн бичгийн дарга нь Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ажиллана.

9. Хорооны гишүүд нь тухайн салбарын хөтөлбөрт тусгагдсан болон хүнсний аюулгүй байдлын зохицуулалтын асуудлыг эрхлэн хариуцна.

10. Хорооны шийдвэрээр холбогдох яам, агентлагийн газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан тодорхой асуудлаар төслийн баг, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

11. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл зохицуулна.

12. Орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг Хороо батална.

Гурав. Хорооны эрх, үүрэг

13. Хороо нь дараахь эрх эдэлнэ:

а/яам, агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргаас хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар зохиосон ажлын тайланг гаргуулан авах, нэгтгэн дүгнэлт гаргах;

б/хүнсний аюулгүй байдалтай холбогдсон хууль тогтоомж, Хорооны шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг яам, агентлаг, аймаг, нийслэлд хянан шалгаж тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Хорооны хуралдаанаар хэлэлцэн чиглэл өгөх, шаардлагатай мэдээ материалыг гаргуулах;

в/хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилтийн явц, зарцуулсан хөрөнгийн талаархи тайланг холбогдох байгууллагаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч дүгнэлт хийх;

г/холбогдох эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчийг тодорхой ажилд татан оролцуулах;

д/эрх хэмжээнийхээ асуудлаар улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөгөөн, семинар, ярилцлага зохион байгуулах;

е/хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;

ж/хорооны шийдвэр, зөвлөмжийг биелүүлээгүй албан тушаалтны талаар удирдлагад нь албан ёсоор мэдэгдэж зохих хариуцлага хүлээлгүүлэх.

14. Хороо нь дараахь үүргийг хэрэжүүлнэ:

а/"Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгдмэл удирдлагаар хангаж, салбар хоорондын асуудлыг уялдуулан зохицуулах;

б/хүнсний мэргэжлийн хяналтын агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, үйлдвэрлэл, борлуулалтын бүх шатанд чанар, аюулгүй байдлын дотоод хяналтыг бий болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах;

в/хүнсний аюулгүй байдлын талаархи шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

г/орон нутгийн салбар хороодыг удирдлага, зөвлөлгөөгөөр хангаж тэдний ажлыг шалгаж дүгнэх;

д/хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол хүнсний талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, хүсэлтийг судлан түүний мөрөөр асуудал боловсруулж шийдвэрлүүлэх;

е/хүнсний хангамжийг сайжруулж, аюулгүй байдлыг хангах талаар иргэд, төрийн бус байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжин тэдгээрийг энэ ажилд өргөнөөр оролцуулан үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;

ж/хүнсний аюулгүй байдлын асуудлаар хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах;

з/хүнсний хангамж, аюулгүй байдлын чиглэлээр гарч байгаа зөрчил, түүний шалтгаан нөхцөлийн талаарх судалгаа, мэдээ, мэдээллийг солилцох;

и/хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол, тэжээлийн чиглэлээр холбогдох эрдэм шинжилгээний байгууллага болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажлын хэсэг байгуулж ажиллах;

к/хорооноос зохиож буй ажлын явц, үр дүн болон хэрэглэгчдэд ухаалаг хэрэглээний боловсрол эзэмшүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Бусад зүйл

15. Хорооны үйл ажиллагааны зардлыг тухайн хорооны хурлаар хэлэлцэн ямдаас харилцан тохиролцож гаргана. Хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулсан яам, агентлаг холбогдох материалыг Хорооны гишүүдийн тоогоор олшруулж Хорооны нарийн бичгийн даргад өгнө.

16. Хороо нь ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

17. Хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 48 (235)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, цйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай*
- *Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, цйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай*
- *Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арванхоёрдугаар сарын 13 №48 (235)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

588. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай (2001-11-22-ны хууль) 1138
589. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2001-11-22-ны хууль) 1140
590. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн тухай (2001-11-23-ны хууль) 1141
591. Засгийн газарт эрх олгох тухай (2001-11-30-ны хууль) 1142
592. Зарим төрлийн бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй байх тухай (2001-11-30-ны хууль) 1142

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

593. Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх,орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай Дугаар 91 1142

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

594. Гомбожавын Гомбосүрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 81 1152
595. Навааны Жамбалд Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай Дугаар 82 1152
596. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 83 1152
597. Гомбосүрэнгийн Оттонжаргалыг “Шударга журам” медалиар шагнах тухай Дугаар 84 1153
598. Балдангийн Борхүүг “Шударга журам” медалиар шагнах тухай Дугаар 85 1153
599. Бадамсамбуугийн Гансүх, Баттөмөрийн Нямжав нарыг “Шударга журам” медалиар шагнах тухай Дугаар 86 1153
600. Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөл байгуулах тухай Дугаар 88 1153

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

601. Түлш, эрчим хүчний талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 244 1157
602. Журам батлах тухай Дугаар 245 1157
603. Журам батлах тухай Дугаар 246 1159
604. Академийн гишүүдийн тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай Дугаар 247 1163
605. Барилга худалдах тухай Дугаар 249 1163
606. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай Дугаар 250 1164
607. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 251 1164
608. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 252 1164

2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

(Шинэчлэсэн найруулга)

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хууль тогтоомж

2.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар /цашид "албан татвар" гэх/-ын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Албан татвар төлөгч

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй төрөл бүрийн ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон тур оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/ албан татвар төлөгч байна.

4 дүгээр зүйл. Албан татвар ногдуулах ажил, үйлчилгээ

4.1. Иргэний зөвхөн хувираа эрхэлж байааа дараахь ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулна:

4.1.1. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ;

4.1.2. аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй бусад ажил, үйлчилгээ.

5 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

5.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэнд сар тутам дор дурдсан хэмжээгээр албан татвар ногдуулна:

	Ажил, үйлчилгээний төрөл	Улаанбаатар хотод	Налайх, Багануур, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумдад болон байнгын ажиллагаатай бооттой сумдад	Бусад аймгийн төвийн сумдад	Бусад газарт
	А	1	2	3	4
1.	Уран зураг, баримал, сийлбэр, бэлэг дурсгалын зүйл, гоёлын зүйл, төрөл бүрийн тогломж хийж худалдах	3000	2000	1000	500
	Чимэглэлийн болон тасалгааны ургамал, цэцэг тарьж худалдах	1200	900	600	200
	Бэлэг дурсгалын зүйлд дурсгалын үг бичих, засал хийх	2400	2000	1000	200
2.	Гэр ахуйн зориулалттай техник, багаж хэрэгсэл, эд хогшил засварлах	4500	3500	2500	1500
	Радио, телевиз засварлах	6000	4000	2000	1000

	Цаг засварлах	3000	2000	1000	500
3.	Дарханы үйлчилгээ: - алт, мөнгөний - бусад	16000 8000	14000 7000	12000 6000	10000 5000
4.	Багшлах, давтлага өгөх, дасгалжуулах, эх бэлтгэх, материал олшруулах	2000	1600	1200	1000
5.	Гэрэл зургийн үйлчилгээ, захиалгаар кино зураг авах, дүрс бичлэг хийх, видео киноны хальс төлбөртэйгээр ашиглуулах, видео кино үзүүлэх	7000	5500	4000	2000
	Дуу бичлэгийн хальс төлбөртэйгээр ашиглуулах	2400	2000	1600	1000
	Видео, аудио бичлэг хуулж худалдах	10000	6000	4000	1000
6.	Төлбөрт тоглоом тоглуулах /билльярдаас бусад/	12000	9000	4500	3000
7.	Гутал, хувцасны засвар, үйлчилгээ: - засварлах, будах - оёж худалдах - гутал тослох	4000 6000 900	2800 4000 400	2400 3000 200	2000 2500 100
8.	Автомашин угаах	3000	2000		
9.	Ачаа тээш боох, ачиж буулгах, зөөж хүргэх үйлчилгээ	2800	2000	1200	
	Ердийн хөсгөөр үйлчилгээ үзүүлэх	5000	3000	1500	1000
10.	Бараа, түүхий эд хадгалах	15000	10000		
11.	ТҮЦ-д худалдаа хийх	6000	4000	2000	1000
12.	Лангуугаар худалдаа хийх (1 метр тутмаас)	6000	4000	2000	1000
13.	Валютын худалдаа эрхлэх	25000	15000	10000	5000
14.	Мэрэг төлөг үзэх	1200	1000	800	400
15.	Жижиг худалдаа хийх /самар, жимс, сүү, тараг, айраг, зайрмаг, ном, сонин, сэтгүүл, түлээ, нүүрс, техникийн тос г.м./	2400	2000	1600	600

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан ажил, үйлчилгээг нэг сар хүртэл хугацаагаар эрхлэх тохиолдолд сард ногдуулах албан татварын хэмжээг тухайн сарын хуанлийн хоногт хуваах, дунг ажил, үйлчилгээ эрхлэх хоногийн тоогоор үржүүлэн ногдох албан татварын хэмжээг тодорхойлно.

5.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний албан татвар ногдуулах орлогыг жишгээр тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:

5.3.1. автомашин болон тээврийн бусад хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийх;

5.3.2. барилгын засал, чимэглэл, засвар, үйлчилгээ хийх, зураг төсөл зохиох;

5.3.3. билльярд тоглуулах;

5.3.4. гуанз, цайны газар, буфет, кафе, зуушны газар ажиллуулах;

5.3.5. чингэлэг, тээврийн хэрэгсэл дээрээс худалдаа хийх;

5.3.6. эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмийн худалдаа хийх;

5.3.7. төрөл бүрийн хүнсний зүйл үйлдвэрлэх, худалдах;

5.3.8. хот, сумын дотор автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх;

5.3.9. сум, аймаг, хот, улс хооронд автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх;

5.3.10. авто зогсоол ажиллуулах;

5.3.11. малын арьс шир, ноос, ноолуур болон бусад түүхий эдийг зуучлан цуглуулж, худалдах;

5.3.12. цахилгаан ба хийн гагнуурын үйлчилгээ;

5.3.13. хөрөө рам ажиллуулах;

5.3.14. терөл бүрийн гар утасны худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэх;

5.3.15. тээврийн хэрэгсэл, сэлбэгийн худалдаа хийх;

5.3.16. интернетийн үйлчилгээ;

5.3.17. нүдний шилний худалдаа, засвар, үйлчилгээ.

5.4. Энэ хуулийн 5.3-д заасан ажил, үйлчилгээний татвар ногдуулах орлогод Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулна.

6 дугаар зүйл. Албан татвар төлөгчийг бүртгэх, гэрчилгээ олгох

6.1. Энэ хуулийн 5.1-д заасан ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, албан татварыг бэлнээр буюу бэлэн бусаар төлж, энэ тухай гэрчилгээ авна.

6.2. Энэ хуулийн 5.3-д заасан ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, 10000 төгрөгийг сар бүр бэлнээр буюу бэлэн бусаар урьдчилгаа хэлбэрээр төлж, албан татвар төлөгчийн гэрчилгээ авч тэмдэглүүлэн татварын тайлангаар дараа тооцоо хийж байна.

6.3. Энэ хуулийн 6.1, 6.2-д заасан гэрчилгээний загварыг Үндэсний татварын ерөнхий газар батална.

6.4. Албан татвар төлөгч нь энэ хуулийн 6.1, 6.2-д заасан гэрчилгээг ажил, үйлчилгээ хийх үед ажлын байр болон тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулж, тогтоосон гудамж, талбайд болон хилийн боомтоор нэвтрэх үед биедээ авч явна.

6.5. Энэ хуулийн 5.3.9-д зааснаас бусад ажил, үйлчилгээнд ногдох албан татвар төлсөн тухай гэрчилгээ нь нийслэл болон тухайн сумын нутаг дэвсгэр дээр хүчинтэй байна.

6.6. Энэ хуулийн 6.1-д заасан гэрчилгээнд заасан хугацааны ажил, үйлчилгээний орлогыг Хүн амын орлогын албан татварын хуулийн 10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмаар орлого, татвар тодорхойлох хуудсаар тооцох жилийн орлогын дүнд оруулахгүй.

6.7. Гэрчилгээ авалгүйгээр ажил, үйлчилгээ эрхэлж, энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол түүнд татварын болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7 дугаар зүйл. Албан татвар төсөвт төлөх, тайлагнах

7.1. Энэ хуулийн 6.2-д заасан урьдчилгаа татварыг дараа сарын 15-ны дотор, 5.4-д заасан татварыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор тус тус төсөвт төлнө.

7.2. Улирал, жилийн эцсийн татварын тооцоогоор албан татвар төлөгчийн төлсөн урьдчилгаа татвар нь энэ хуулийн 5.4-д заасан татварын дүнгээс их байвал Үндэсний татварын алба дараа улирал, жилд төлөх энэ төрлийн татварт суутган тооцно.

7.4. Энэ хуулийн 5.3-д хэсэгт заасан ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэн улирлын албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд тушаож, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс батлагдан аргачлалын дагуу албан татвар ногдуулах орлогоо тодорхойлж, албан татварын эцсийн тооцоо хийнэ.

8 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

8.1. Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч иргэний орлогын албан татварын хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2002 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

/мянган төгрөгөөр/

1 дүгээр зүйл. Монгол улсын 2002 оны төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар батална сугай:

1.1. ОРЛОГО-БҮГД	**356.035.925.3**
1.1.1. Албан татварын орлого	285.212.777.3
1.1.1.а. орлогын албан татвар	56.440.209.2
1.1.1.б. нэмэгдсэн өртгийн албан татвар	85.015.045.4
1.1.1.в. онцгой албан татвар	49.671.024.6
1.1.1.г. автобензин, дизелийн түлшний албан татвар	4.839.600.0
1.1.1.д. гаалийн албан татвар	24.376.100.0
1.1.1.е. бусад албан татвар	3.917.787.4
1.1.1.ж. нийгмийн даатгалын шимтгэл хураамж	60.953.010.7
1.1.2. Татварын бус орлого	62.823.148.0
1.1.2.а. хувьцааны ногдол ашиг	8.882.878.0
1.1.2.б. бусад орлого	9.158.570.0
1.1.2.в. түрээсийн орлого	8.448.000.0
1.1.2.г. газрын төсны орлого	500.000.0
1.1.2.д. төсөвт байгууллагын өөрийн орлого	18.333.700.0
1.1.2.е навигац /өнгөрөлт/-ын орлого	12.500.000.0
1.1.2.ж. Монголбанкаас орох орлого	5.000.000.0
1.1.3. Гадаад тусламжийн орлого	8.000.000.0

2 дугаар зүйл. Монгол Улсын 2002 оны төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төсөв төвлөрүүлэн захирагчдын санхүүжилт, тэтгэврийн даатгалын санд өгөх татаасын дээд хэмжээг дор дурдсанаар батална сугай:

2.1. ЗАРЛАГА-БҮГД	**435.727.760.2**
2.1.1. Цалингийн сан	31.207.988.6
2.1.2. Хөрөнгө оруулалт	27.968.100.0
Үүнээс: шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг	24.034.800.0
Үүний дотор: -2002 онд санхүүжүүлэх объектын төсөвт өртөг	7.301.600.0
2.1.3. Батлан хамгаалах арга хэмжээний зардал	27.266.446.0
2.1.4. Улсын Их Хурлын төсөв	2.356.887.3
2.1.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	640.718.1
2.1.6. Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	152.673.7
2.1.7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	76.693.0
2.1.8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	256.944.9
2.1.9. Улсын дээд шүүхийн төсөв	151.868.1
2.1.10. Орон нутгийн шүүхийн төсөв	1.585.780.8
2.1.11.Прокурорын байгууллагуудын нэгдсэн төсөв	1.327.675.8
2.1.12. Тагнуулын ерөнхий газрын төсөв	2.337.847.6
2.1.13. Тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	24.422.288.0

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс аймгуудын төсөвт олгох санхүүжилтийн дээд хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

3.1.САНХҮҮЖИЛТИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ **48.831.559.8**

3.1.1. Архангай	2.273.581.6	3.1.11. Өмнөговь	1.954.485.1
3.1.2. Баян-Өлгий	3.100.180.5	3.1.12. Сүхбаатар	2.486.135.8
3.1.3. Баянхонгор	2.622.069.9	3.1.13. Сэлэнгэ	3.339.228.7
3.1.4. Булган	2.206.005.1	3.1.14. Төв	2.461.424.5
3.1.5. Говь-Алтай	3.204.753.9	3.1.15. Увс	2.845.330.7
3.1.6. Дорноговь	1.953.533.4	3.1.16. Ховд	2.794.182.4
3.1.7. Дорнод	2.319.162.3	3.1.17. Хөвсгөл	3.118.608.6
3.1.8. Дундговь	1.612.609.7	3.1.18. Хэнтий	2.404.935.6
3.1.9. Завхан	2.800.549.2	3.1.19. Дархан-Уул	2.025.612.7
3.1.10. Өвөрхангай	2.545.145.5	3.1.20. Говь-Сүмбэр	764.024.5

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр — **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хаврын тариалалтад зориулж импортлох үрийн буудай болон хүнсний буудайн гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөн зохицуулах эрхийг Засгийн газарт олгосугай.

2 дугаар зүйл. Энэ хууль 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр — **Улаанбаатар хот**

ЗАРИМ ТӨРЛИЙН БАРААНД НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХГҮЙ БАЙХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд импортын үрийн буудайнд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулахгүй байсугай.

2 дугаар зүйл. Энэ хууль 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр — **Дугаар 91** — **Улаанбаатар хот**

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, төрийн өмчийн эд хөрөнгийн 2001 оны улсын нэгдсэн үзлэг, тооллогын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор батлэсугай.

2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн 2 дугаар хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй.

3.Батлан хамгаалах яамны харьяа зэвсэгт хүчний 137 дугаар ангийн барилга байгууламж /эд хөрөнгө/-ийг орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг төсөв холбогдох зардлын хамт цогцолбороор судлан, боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай тохиролцон Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосугай

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1.Архангай аймаг

2001 он А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө /мян.төг/

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Эрдэнэбулган	Статистикийн хэлтэс	4189.9
2	Эрдэнэбулган	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар	30893.3
	ДҮН		**35083.2**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Жаргалант	400 суудалтай сургуулийн барилга	145000.0
2	Цахир	240 суудалтай сургуулийн барилга	200000.0
3	Эрдэнэбулган	Шивэртийн рашаан сувиллын газар дахь 140 хүүхдийн цэцэрлэг-яслийн барилга	4800.0
	ДҮН		**349800.0**

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Чулуут	Дизель станц	77360
2	Хангай	Дизель станц	76889.5
3	Эрдэнэбулган	Монгол даатгал компаниас шилжүүлэн өгсөн Оёдлын цех	2750.0
4	Эрдэнэбулган	3 хүний халуун ус	37000.0
	ДҮН		**193999.5**

Г.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Эрдэнэбулган	Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс	11404.2
	ДҮН		**11404.2**
	НИЙТ ДҮН		**590286.9**

2.Баян-Өлгий аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Өлгий	Хэвлэл мэдээллийн төв	7929.7
2	Өлгий	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар	69746.53
	ДҮН		**77676.23**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Өлгий	Шүүх, прокурорын контор /40хүн/	9200.00
2	Өлгий	Хүнсний их дэлгүүр	2500.00
3	Өлгий	850 тонныи ногооны зоорь	
4	Өлгий	Цэмбэний үйлдвэр	60000.00
	ДҮН		**71700.0**

В.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Өлгий	Хорих анги	18254.5
	ДҮН		18254.5
	НИЙТ ДҮН		167630.7

3.Баянхонгор аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Баянхонгор	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар	25795.75
2	Баянхонгор	Эрчим хүчний үйлдвэр	1487632.1
	ДҮН		1513427.85

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Баянцагаан	Сургуулийн спорт заал	2386.6
2	Баянхонгор	Гоц халдвартын станцын барилгын гол корпус	4766.6
3	Баянхонгор	Нэгдсэн больниц /120 ортой/	4721.6
4	Бумбат	Механижсан ферм /200 үнээний/	16641.6
	ДҮН		28516.4

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Эрдэнэцогт	Халуун ус	12260.0
2	Галуут	8 айлын орон сууцны барилга /соёлын өргөө болсон/	7900.0
	ДҮН		20160.0
	НИЙТ ДҮН		1562104.3

4.Булган аймаг

А.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Булган	Хорих анги	29866.3
	ДҮН		29866.3

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Бугат	15 ортой эмнэлэг	1244.8
	ДҮН		1244.8
	НИЙТ ДҮН		31111.1

5.Говь-Алтай аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Есөнбулаг	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар	24860.92
	ДҮН		24860.92

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Есөнбулаг	Гаалийн конторын барилга	35000.0
	ДҮН		35000.0
	НИЙТ ДҮН		59860.9

6.Говьсүмбэр аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Сүмбэр	Нийгмийн халамжийн газар	10145.3
	ДҮН		10145.3

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ /2001 он/
1	Шивээговь	Дулааны шугамын шинэчлэлт	65170.0
	ДҮН		65170.0
	НИЙТ ДҮН		75315.3

7.Дархан-Уул аймаг

А.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Дархан	ХАА-н машин засварын завод /4500 трактор/	61119.0
2	Дархан	Уурын зуух	7628.0
3	Дархан	Цахилгаан дулааны сантехникийн барилга	62024.0
4	Дархан	Цахилгаан дулааны сантехникийн барилга	57800.0
5	Дархан	XXI хороолын 29 айлын сууц	
6	Дархан	Тахианы байр	34373.0
7	Дархан	Хүнсний комбинатын өргөтгөл	8460.0
8	Орхон	Хүний эмчийн салбар /30 ортой/	2430.0
	ДҮН		233834.0
	НИЙТ ДҮН		233834.0

8.Дорнод аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Баян-Уул	Ойн аж ахуй	12828.8
2	Хэрлэн	Статистикийн хэлтэс	3701.4
	ДҮН		16530.2

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Чойбалсан	Цэвэрлэх байгууламж	18500.00
2	Халхгол	500 тонны хөргүүртэй зоорь, мал нядалгааны газар	2385.10
3	Баян-Уул	75 тракторын засварын газар	2661.00
4	Тамсагбулаг	"Ялалт" нэгдлийн төв /23 объект/	31605.70
5	Хэрлэн	Уурын зуух	9830.80
6	Хэрлэн	4 машины гараж	1179.20
	ДҮН		66161.8

В.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Хэрлэн	Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс	10845
	ДҮН		10845.0
	НИЙТ ДҮН		93537.0

9.Дорноговь аймаг

А.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Сайншанд	Зүүнбаян дахь цэвэрлэх байгууламж	8070.0
	ДҮН		**8070.0**

Б.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Сайншанд	Дулааны шугамын шинэчлэлт	142000.0
	ДҮН		**142000.0**
	НИЙТ ДҮН		**150070.0**

10.Дундговь аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Мандалговь	Аймгийн тээврийн газар	13708.6
2	Мандалговь	ХАА-н газар	49605.9
3	Сайнцагаан	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	3489.8
	ДҮН		**66804.3**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Дундговь	Засварын газар	98.0
2	Дундговь	Халуун усны барилга	26.6
3	Дэлгэрхангай	Контор	118.0
4	Гурвансайхан	Сумын контор	847.3
	ДҮН		**1089.9**
	НИЙТ ДҮН		**67894.2**

11.Завхан аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Улиастай	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	16326.4
	ДҮН		**16326.4**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Улиастай	120 ортой хүүхдийн больницын барилга	7200.0
2	Цэцэн-Уул	100 хүүхдийн дотуур байрны хоолны газар	
	ДҮН		**7200.0**
	НИЙТ ДҮН		**23526.4**

12.Орхон аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Орхон	Нийгмийн халамжийн газар	30540.1
2	Орхон	Орхон бүс трейд УҮГ	204396.0
3	Орхон	Төрийн захиргаа удирдлагын хөгжлийн төв	19866.3
	ДҮН		**254802.4**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Баян-Өндөр	Говил дахь спорт заал	660.0
	ДҮН		660.0
	НИЙТ ДҮН		255462.4

13.Өвөрхангай аймаг.

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Арвайхээр	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	16031.6
	ДҮН		16031.6

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Арвайхээр	200 хүний спорт заал	840.0
	ДҮН		840.0

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Гучин ус	3 хүний халуун ус	24000.0
2	Хар хорин	10000 тонны агуулах	5900.0
	ДҮН		29900.0
	НИЙТ ДҮН		46771.6

14.Өмнөговь аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Даланзадгад	Статистикийн хэлтэс	3239.3
2	Даланзадгад	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	14756.1
3	Даланзадгад	Хөгшөө УҮГ /Дизель станц/	12025.9
	ДҮН		30021.3

Б.Дуусаагүй барилга

	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
№	Даланзадгад	Хүрмэн блокийн цех	
1	Даланзадгад	Хүүхэд залуучуудын соёлын төв /400 суудалтай/	40000.0
2	Даланзадгад	4 дүгээр цэцэрлэгийн барилга	
3	Цогт-Овоо	15 ортой эмнэлэг	8200.0
	Дүн		48200.0
	НИЙТ ДҮН		78221.3

15.Сэлэнгэ аймаг

А.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Сүхбаатар	Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс	14477.3
	ДҮН		14477.3
	НИЙТ ДҮН		14477.3

16.Сүхбаатар аймаг

А.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Баруун-Урт	60 айлын орон сууц	5200.0

2	Баруун-Урт	Сумын театр	6400.0
3	Баруун-Урт	560 хүүхдийн сургууль	
4	Баруун-Урт	Халуун ус	
5	Баруун-Урт	Төмөртэйн цайрын уурхайн ордны дэргэдэх 8 ш дуусаагүй барилга	
	ДҮН		11600.0

Б.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Баруун-Урт	Халуун ус	34000.0
2	Баруун-Урт	Холбооны салбарын хуучин барилга	
	ДҮН		34000.0
	НИЙТ ДҮН		45600.0

17.Төв аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Зуун мод	Ус суваг орон сууцны Чандмань компани	320105.5
	ДҮН		320105.5

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Архуст	Соёлын төв	1120.0
2	Зуунмод	Вааран эдлэлийн үйлдвэр	14540.00
3	Зуунмод	29 айлын үгсармал сууц	1560.00
4	Зуунмод	30 хүний халуун ус	1930.00
5	Жаргалант	Конторын барилга /20 хүн/	20530.00
	ДҮН		39680.0

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Баян-Өнжүүл	Халуун ус	6600.0
2	Төв	Англи хэлний сургуулийн барилга	1250.0
3	Төв	Кино үзвэрийн газар /үлдэгдэл хөрөнгө/	
4	Зуунмод	Богд уул компани /үлдэгдэл хөрөнгө/	150.0
	ДҮН		8000.0
	НИЙТ ДҮН		367785.5

18.Увс аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Улаангом	Статистикийн хэлтэс	4091.0
2	Улаангом	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	28384.5
3	Улаангом	Номын сан музей	10880.8
	ДҮН		43356.3

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Давст	300 суудалтай соёлын төв	2350.0
2	Завхан	350 суудалтай соёлын төв	3600.0
3	Тариалан	Сумын соёлын төв	2100.0
4	Өмнөговь	56 айлын 2 орон сууц	
5	Улаангом	50 ортой төрөх	3860.0
	ДҮН		11910.0
	НИЙТ ДҮН		55266.3

19.Ховд аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Жаргалан	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	56870.6
	ДҮН		**56870.6**

Б.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Жаргалан	Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс	7739.9
2	Жаргалан	Хорих анги	27568.7
	ДҮН		**35308.6**
	НИЙТ ДҮН		**92179.2**

20.Хөвсгөл аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Мөрөн	Нийгмийн халамжийн газар	17717.2
2	Мөрөн	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	21412.3
3	Мөрөн	Хөвсгөлийн долгион / радио редакц/	680.8
	ДҮН		**39810.3**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Ринчинлхүмбэ	440 хүүхдийн хичээлийн байр	3589.0
2	Мөрөн	24 айлын сууц	6000.0
3	Арбулаг	Шинэ төв	6252.0
4	Мөрөн	Аммиакан хөргүүртэй зоорь	
5	Эрдэнэбулган	Соёлын төв	2500.0
	ДҮН		**18341.0**
	НИЙТ ДҮН		**58151.3**

21.Хэнтий аймаг

А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Хэрлэн	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	23241.8
2	Биндэр	Ойн аж ахуй	27073.0
3	Хэрлэн	Статистикийн хэлтэс	2557.7
	ДҮН		**52872.5**

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Хэрлэн	36 айлын сууц	17760.0
2	Хэрлэн	300 тоннын аммиакан хөргүүртэй зоорь	390.0
	ДҮН		**18150.0**

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Хэрлэн	Цэвэрлэх байгууламж	163000.0
2	Хэрлэн	Халуун ус	38800.0
3	Хэрлэн	Төмөр бетон полигон цех /тоног төхөөрөмж/	6360.0
	ДҮН		**208160.0**

Г.Байгууллагын эзэмшилд байгаа бусад эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Хэрлэн	Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс	10058.0
	ДҮН		10058.0
	НИЙТ ДҮН		289240.5

22.Улаанбаатар хот
А.Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн
1	Багануур	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	33220.39
2	Баянзүрх	Дохиолол хамгаалал УҮГ	41320.9
3	Сонгинохайрхан	Хатантуул ХХК /Төрийн 51 хувь/	12668.5
4	Сонгинохайрхан	Тахилт УҮГ	84712.4
5	Сонгинохайрхан	Байгалийн голомтот халдварт өвчтэй тэмцэх газар	356339.6
6	Хан-Уул	Жолоо УҮГ	8191.6
7	Хан-Уул	Спорт сургалтын төв	2434.9
8	Чингэлтэй	Монмосбарилга /Төрийн 33 хувь/	18057.0
	ДҮН		556945.29

Б.Дуусаагүй барилга

№	Сумын нэр	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал	Зарцуулсан хөрөнгө
1	Баянзүрх	30 машины гараж	3800.0
2	Баянзүрх	Засвар үйлдвэрлэлийн байр	2500.0
3	Налайх	Цэвэрлэх байгууламж	11693.0
4	Сонгинохайрхан	Гэр хорооллын 320 хүүхдийн сургууль	1483.8
5	Сонгинохайрхан	Гэр хорооллын "БЗУ-100" уурын зуух	1710.0
6	Хан-уул	Туул хорооны 29 айлын орон сууц	8650.0
7	Хан-уул	Туул хороо 5-н 28 айлын орон сууц	8647.0
8	Хан-уул	Өлзийт хорооны орон сууц	2340.0
9	Хан-Уул	Эмнэлгийн дуусаагүй барилга	
	ДҮН		40823.8

В.Үл хөдлөх хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн анхны үнэ
1	Хан-Уул дүүрэг	35-р цэцэрлэгийн барилга	9230.3
2	Хан-уул	Хуванцар эдлэл УҮГ /үлдэгдэл хөрөнгө/	176.4
3	Хан-уул	Улсын нотариатын танхим /хуучнаар/ /үлдэгдэл хөрөнгө/	376.2
	ДҮН		9782.9
	НИЙТ ДҮН		607,552.01
	БҮГД		4,965,878.18

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭН ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭН АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1.Дорноговь аймаг

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Орон нутгийн өмчийн хувь	Нийт хөрөнгийн дүн /2001 он/
1	Замын-Үүд	Хилийн эрүүл ахуй халдвар судлалын төв	100	23221.80
2	Сайншанд	Радио өргөн нэвтрүүлгийн станц	100	13275.10
	Дүн			**36496.90**

2.Өмнөговь аймаг

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Орон нутгийн өмчийн хувь	Нийт хөрөнгийн дүн /2001 он/
1	Даланзадгад	Эрчим хүчний нэгдсэн үйлдвэр	100	558636.10
	Дүн			**558636.10**

3.Сүхбаатар аймаг

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Орон нутгийн өмчийн хувь	Нийт хөрөнгийн дүн /2001 он/
1	Баруун-Урт	Талын зам компани	100	15172.50
	Дүн			**15172.50**

4.Хэнтий аймаг

№	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Орон нутгийн өмчийн хувь	Нийт хөрөнгийн дүн /2001 он/
1	Хэрлэн	Харгуй /замын компани/	100	114495.51
	Дүн			**114495.51**
	Нийт дүн			**724801.01**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21–ний өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

Гомбожавын Гомбосүрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж өөрийн орны болон дэлхийн сонгодог жүжиг, киноны гол, туслах дүрийг үзэгчдийн сэтгэлд хоногштол чадварлаг бүтээж, манай улсад орчин цагийн тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэх үйлст оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь үнэлж Үндэсний жүжгийн академик театрын ахмад жүжигчин Гомбожавын Гомбосүрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21–ний өдөр **Дугаар 82** **Улаанбаатар хот**

Навааны Жамбалд Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн байгууллагад он удаан жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эмнэлгийн практикт эмчилгээ, оношлогооны дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэн, хөдөөгийн хүн амд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үзүүлэх, гэр бүл төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн кабинетын их эмч Навааны Жамбалд Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21–ний өдөр **Дугаар 83** **Улаанбаатар хот**

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Хөдөө аж ахуй, урлаг, эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс орныхоо хөгжилд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

Монгол Улсын гавьяат малчин цолоор:

1. Самбуугийн Галсандагва - Завхан аймгийн Сантмаргац сумын Баяннуур багийн малчин
2. Тогмидын Чулуунбаатар - Ховд аймгийн Мянгад сумын Баян-булаг багийн малчин

Монгол Улсын гавьяат жүжигчин цолоор:

Заяатын Жарантав - Үндэсний жүжгийн академик театрын зохион байгуулах ангийн дарга, менежер

Монгол Улсын хүний гавьяат эмч цолоор:

Пүрэвийн Молом - Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 84 | Улаанбаатар хот

Гомбосүрэнгийн Отгонжаргалыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн уснаас хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Хэнтий аймгийн Биндэр сумын малчин Гомбосүрэнгийн Отгонжаргалыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

Балдангийн Борхүүг " Шударга журам" медалиар шагнах тухай

Авхаалж самбаа, энэрэнгүй сэтгэл гарган орон сууцны найман давхрын тагтнаас унасан хүүхдийг тосч аван амийг нь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн Балдангийн Борхүүг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

Бадамсамбуугийн Гансүх, Баттөмөрийн Нямжав нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Бохир усны сувагт унаж живсэн хүнийг авхаалж самбаа гарган уснаас авч, амийг нь аварсан Нийслэлийн байгалийн гамшгаас аврах ангийн аврагч-шүхэрчин Бадамсамбуугийн Гансүх, Баттөмөрийн Нямжав нарыг "Шударга журам" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 88 | Улаанбаатар хот

Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөл байгуулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийг шинэчлэн байгуулсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийн ажиллах журмыг 1 дүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 88 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ЭРДЭМТЭН, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийн зөвлөл нь /цаашид зөвлөл гэх/ төрөл бүрийн салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдээс бүрдсэн орон тооны бус бүтэц мөн.

1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, соңгуулийн хөтөлбөрөө биелүүлэхэд туслах нь зөвлөлийн зорилго мөн.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны зарчим

2.1. Зөвлөлийн үйл ажиллагаа дараах зарчимд үндэслэнэ. Үүнд:

а/ төрийн бодлогын аливаа асуудалд шинжлэх ухааны үүднээс хандах;

б/ Төрийн хууль тогтоомж, эрхийн бусад актын хүрээнд ажиллах;

в/ баримт бичгийн төсөл боловсруулахдаа Ерөнхийлөгчийн хөтөлбөрийн үзэл санааг үндэс болгох;

г/ төрийн бодлогын аливаа асуудлаар санал боловсруулахдаа улс терийн нам, эвсэл, холбоодын үр ашигтай санал, оновчтой баримтлалыг тунгаан тусгах;

д/ баримт бичгийн төслийн нууцлалыг хадгалах.

Гурав. Зөвлөлийн зохион байгуулалт, удирдлага

3.1. Зөвлөл салбар зөвлөлүүдтэй байна. Үүнд:

а/ эдийн засгийн бодлогын салбар зөвлөл;

б/ нийгмийн бодлогын салбар зөвлөл;

в/ хууль зүйн бодлогын салбар зөвлөл;

г/ түүхэн уламжлал, ёс заншлын салбар зөвлөл;

д/ цэргийн бодлогын салбар зөвлөл;

е/ бизнесийг хөгжүүлэх бодлогын салбар зөвлөл;

ж/ хэвлэл, мэдээллийн бодлогын салбар зөвлөл;

з/ гадаад бодлогын салбар зөвлөл.

3.2. Салбар зөвлөл тус бүр 9-15 гишүүнтэй байна. Бизнесийг хөгжүүлэх бодлогын болон Хэвлэл, мэдээллийн бодлогын салбар зөвлөл 20 хүртэл гишүүнтэй байж болно.

3.3. Салбар зөвлөлийн гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилж, чөлөөлнө.

3.4. Зөвлөлийн гишүүдээд Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий үнэмлэх олгоно.

3.5. Зөвлөлийн ахлагч нь Тамгын газрын дарга байна.

3.6. Зөвлөлийн ахлагчийн эзгүйд түүнийг Ерөнхийлөгчийн аль нэг зөвлөх орлоно.

3.7. Салбар зөвлөлүүдийн ахлагчаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, зөвлөхүүд, Ерөнхийлөгчийн хэвлэлийн нарийн бичгийн дарга ажиллана.

Дөрөв. Зөвлөлийн ажиллах хэлбэр

4.1. Зөвлөл нь салбар зөвлөлүүдээрээ дамжуулан үйл ажиллагаагаа явуулна.

4.2. Салбар зөвлөлүүд жил бүрийн төлөвлөгөөтэй ажиллана.

4.3. Салбар зөвлөлийн бичиг хэргийг ахлагч, нарийн бичгийн дарга бүрдүүлж, шаардлагатай баримт бичгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын архивт хадгална.

4.4. Салбар зөвлөл дараах чиглэлээр ажиллана. Үүнд:

а/ төрийн бодлогын чухал асуудлаар санал солилцох

б/ баримт бичгийн төсөл боловсруулах

в/ Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаагаа тайлбарлах, суртачлах.

г/ Ерөнхийлөгчийн даалгасан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж Ерөнхийлөгчид толилуулах.

Тав. Зөвлөлийн гишүүдийн үүрэг

5.1. Зөвлөлийн гишүүд дараахь үүрэгтэй. Үүнд:

а/ шаардлагатай үед үндсэн ажлаа зохицуулж, тодорхой хугацаагаар зөвлөлд ажиллах;

б/ зөвлөл дээр тохирсон үүргээ тогтоосон хугацаанд нь чанартай биелүүлэх;

в/ зөвлөлийн гишүүний нэр төр, ёс зүйг эрхэмлэн сахих.

Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны зардал

6.1. Зөвлөлийн ажиллах нөхцлийг Тамгын газар хангана.

6.2. Зөвлөлийн зардлыг жилээр төлөвлөж, Тамгын газрын төсөвт тусгана.

6.3. Зөвлөлийн зардлыг Тамгын газрын дарга батална.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ЭРДЭМТЭД, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

а/ Эдийн засгийн бодлогын салбар зөвлөл

1. Д. Готов -Салбар зөвлөлийн ахлагч, Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх, доктор
2. Г. Даваасамбуу - Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт, дэд доктор
3. А. Бакей - ХААИС-ийн проректор, дэд доктор, дэд профессор
4. Д. Балдан-Очир - "Мандал трейд" ХХК-ийн ерөнхий захирал, дэд доктор
5. А. Батсүх - Монгол банкны тэргүүн дэд захирал
6. Н. Дашзэвэг - Үндэсний үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч, дэд доктор
7. Л. Дондог - Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн ерөнхийлөгч, дэд доктор
8. Т. Намжим - Академич, доктор, профессор
9. Д. Нарандэлгэр - Удирдлагын академийн тэнхмийн эрхлэгч, дэд доктор
10. С. Нямзагд - Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн захирал, дэд доктор, дэд профессор
11. Г. Пүрэвбаатар - МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор
12. П. Шүрчулуу - Үндэсний бүтээмж, хөгжлийн төвийн захирал, доктор
13. Л. Энхтайван - Санхүү эдийн засгийн дэд сайд, доктор, профессор

б/ Нийгмийн бодлогын салбар зөвлөл

1. Л. Лхагва - Салбар зөвлөлийн ахлагч, Ерөнхийлөгчийн нийгмийн бодлогын зөвлөх, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
2. Б. Болдбаатар - Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт, дэд доктор
3. Д. Бадарч - Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор, доктор, профессор
4. Р. Бандий - "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх албаны гүйцэтгэх захирал, дэд доктор, дэд профессор
5. Ж. Дулмаа - Ахмадын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны дарга
6. Д. Жанцан - Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга
7. Н. Жанцанноров - Төрийн хошой шагналт, хөгжмийн зохиолч
8. Д. Загдсүрэн - МҮОХ-ны ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, Олимпийн үндэсний академийн ерөнхийлөгч, дэд доктор
9. Д. Мөнхөө - "Гал голомт" хөдөлгөөний тэргүүн
10. Ц. Содномпил - ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, дэд доктор
11. М. Тогтохнэм - Монголын хүүхдийн төлөө үндэсний хорооны дарга
12. Б. Чулуундорж - Хүмүүнлэгийн их сургуулийн ректор, доктор, профессор
13. Б. Энхтүвшин - ШУА-ийн дэд ерөнхийлөгч, доктор, профессор
14. Л. Эрдэнэчимэг - БСШУЯ-ны соёл урлагийн газрын дарга, дэд доктор

в/ Хууль зүйн бодлогын салбар зөвлөл

1. Г. Баясгалан - Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, салбар зөвлөлийн ахлагч
2. Г. Аюурзана - Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
3. Д. Батсайхан - Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч
4. Д. Баярсайхан - МУИС-ийн багш, дэд доктор
5. С. Дамдин - Улсын мөрдөн байцаах газрын дэд дарга, гавьяат хуульч
6. Ц. Жамъянсэнгээ - Улсын ерөнхий прокурорын орлогч
7. Д. Зумбэрэллхам - Хуульчдыг давтан сургах төвийн багш, дэд доктор
8. Н. Лундэндорж - МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэд захирал, дэд доктор
9. С. Нарангэрэл - МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн захирал, академич
10. Д. Наранчимэг - "Отгонтэнгэр" их сургуулийн захирал, дэд профессор
11. Б. Пүрэв - Хууль зүйн ухааны дэд доктор
12. Б. Цэрэндорж - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
13. С. Цэрэндорж - Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, дэд доктор
14. Ж. Чойжанцан - Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга

г/ Түүхэн уламжлал, ёс заншлын салбар зөвлөл

1. Я. Долгоржав - Салбар зөвлөлийн ахлагч, Ерөнхийлөгчийн улс төрийн бодлогын зөвлөх, дэд доктор, профессор
2. С. Одхүү - Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, ЕТГ-ын ОНХА-ны дарга, дэд доктор, дэд профессор
3. Ж. Бат-Ирээдүй - МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн захирал, дэд доктор
4. Ж. Болдбаатар - МУИС-ийн Түүхийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор
5. Ч. Далай - ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, академич, доктор, профессор
6. Д. Дашжамц - ШУА-ийн ФСЭХ-ийн орлогч захирал, дэд доктор, дэд профессор
7. Л. Мэндсайхан - Улсын төв архивын хэлтсийн дарга, дэд доктор
8. Н. Ням-Осор - "Их засаг" дээд сургуулийн захирал, дэд доктор, дэд профессор
9. Г. Очирбат - Ахмад зүтгэлтэн, дэд доктор
10. Ж. Сэржээ - Улсын төв номын сангийн захирал, дэд доктор
11. Л. Түдэв - "Хаадын сан"-гийн Ерөнхийлөгч, доктор
12. Н. Хавх - МУИС-ийн "Буддын соёл судлал" төвийн захирал, "Өв уламжлал, ёс заншил" хөдөлгөөний тэргүүн, доктор, профессор
13. Л. Хүрэлбаатар - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор, профессор
14. Д. Цогтсайхан - Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш

д/ Бизнесийг хөгжүүлэх бодлогын салбар зөвлөл

1. Б. Батхишиг - Салбар зөвлөлийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
2. Г. Цацрал - Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт
3. Ч. Амарбаатар - "Барс" группийн ерөнхийлөгч
4. Ц. Балдорж - " Монгол ньюс" ХХК-ийн захирал
5. Р. Батмэнд - "Мобиком" корпорацийн захирал
6. Ш. Баярсайхан - "Номин трейд" ХХК-ийн захирал
7. П. Болд - "Ёсөн од" ХХК-ийн захирал
8. Д. Ганхуяг - "Бридж" группийн захирал
9. С. Даваа - "Анод" банкны ТУЗ-ийн дарга
10. Н. Даш-Өлзий - "Өлзийт төв" ХХК-ийн захирал
11. С. Дэмбэрэл - Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга
12. Б. Жаргалсайхан - "Буян" ХХК-ийн захирал
13. Ц. Оргодол - "Өндөр дов" ХХК-ийн захирал
14. Ж. Оюунгэрэл - "Петровис" ХХК-ийн захирал
15. Ш. Сайхансамбуу - "Нарантуул" олон улсын худалдааны төвийн захирал
16. А. Сүхдорж - "BSB" ХХК-ийн захирал
17. Д. Сэргэлэн - "Эрэл" ХХК-ийн захирал

е/ Хэвлэл, мэдээллийн бодлогын салбар зөвлөл

1. Д. Халиун - Салбар зөвлөлийн дарга, Ерөнхийлөгчийн хэвлэлийн нарийн бичгийн дарга, Хэвлэл, мэдээллийн албаны дарга
2. Ш. Төмөрбаатар - Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт
3. А. Авирмэд - "MN-25-р суваг" телевизийн редактор
4. Т. Баасансүрэн - "МОНЦАМЭ" агентлагийн ерөнхий захирал
5. Л. Балхжав - "UBS" телевизийн захирал
6. Ц. Бат-Орших - Монголын сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч
7. Т. Батжаргал - "Батсан" продакшны захирал, фото зурагчин
8. С. Баярмөнх - "Сэрүүлэг" сонины эрхлэгч
9. Л. Болормаа - "Өнөөдөр" сонины орлогч эрхлэгч
10. Ц. Ганбат - "Үнэн" сонины эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч
11. Ц. Дашдондов - Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч
12. Нанж. Лхагва - "Ардчилал таймс" сонины эрхлэгч
13. А. Мягмаржав - Монгол радиогийн "Хурд" агентлагийн захирал
14. Д. Сандагсүрэн - "Монголын мэдээ" сонины эрхлэгч
15. Я. Сэлэнгэ - "Ийгл" телевизийн гүйцэтгэгч захирал
16. Х. Хадбаатар - "Хүмүүс" сонины эрхлэгч
17. Д. Цэдэн-Иш - Монголын хэвлэлийн хүрээлэнгийн захирал
18. Ц. Цэцэгчулуун - "Зууны мэдээ" сонины ерөнхий эрхлэгч
19. Р. Энхбат - "Admon" ХХК-ийн захирал
20. Б. Эрдэнэбаатар - "Хөх толбо" сонины эрхлэгч

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 244 | Улаанбаатар хот

Түлш, эрчим хүчний талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олон улсын санхүүгийн байгууллагуудаас түлш, эрчим хүчний салбарыг шинэчлэх зориулалтаар авсан хөнгөлөлттэй зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүгийн хэмжээг дахин нягтлаж үзэх, гэрээг шинэчлэн байгуулах чиглэлээр ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

2. Даланзадгадын Дулааны цахилгаан станц, Чойбалсан хот дахь Дулааны цахилгаан станц, "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани, Налайхын Дулааны станцын 2001 оны сүүлийн хагас жилийн санхүүжилтийн эх үүсвэргүй алдагдлыг улсын төсвөөс зохицуулан шийдвэрлэж гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 245 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гаалийн татвар ногдуулахгүй байх, хорогдуулж тооцох, буцаан олгох журам"-ыг хавсралт ёсоор батлосугай.

2. Энэ журмыг 2001 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 245 дугаар тогтоолын хавсралт

ГААЛИЙН ТАТВАР НОГДУУЛАХГҮЙ БАЙХ, ХОРОГДУУЛЖ ТООЦОХ, БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гаалийн тарифын тухай хуулийн 24-27 дугаар зүйлийг үндэслэн гаалийн албан татвар (цаашид "татвар" гэх)-ыг ногдуулахгүй байх, хорогдуулж тооцох, буцаан олгох үйл ажиллагааг зохицуулахад энэ журмыг баримтална.

Хоёр. Татвар ногдуулахгүй байх

2. Гаалийн тарифын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу дор дурдсан бараат гаалийн удирдах төв байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар татвар ногдуулахгүйгээр оруулж болно:

а/олон улсын чанартай үзэсгэлэн яармаг, хурал, зөвлөлгөөн, соёл, боловсрол, шинжлэх ухааны сургалт, судалгаа шинжилгээ, спортын уралдаан тэмцээн, урлагийн тоглолт, төрийн айлчлал болон тэдгээртэй адил бусад арга хэмжээний бараа, тээврийн хэрэгсэл;

б/байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирлыг арилгах зорилгоор оруулж буй техник, тоног төхөөрөмж, шаардлагатай бусад эд зүйл.

3. Энэ журмын дагуу татвар ногдуулалгүйгээр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааны хугацаог сунгах зайлшгүй шаардлага гарвал гаалийн удирдах төв байгууллагаас зөвшөөрөл авна.

4. Мэдүүлэгч бараа, техник, тоног төхөөрөмжийг буцааж гаргахдаа гаалийн байгууллагаас шаардсан бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

5. Энэ журмын дагуу татвар ногдуулалгүйгээр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааны тэдгээрийг буцаан гаргах хүртэл хугацаанд анх гаалийн бүрдүүлэлт хийж оруулсан гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн хаалтын мэдээг гаалийн удирдах төв байгууллагад өгнө.

6. Энэ журмын дагуу оруулсан барааны өөрчлөлт оруулсан, өөр зориулалтаар ашигласан, тоготоосон хугацаанд нь буцаан гаргаагүй бол гаалийн татварыг нөхөн төлүүлэх бөгөөд Гаалийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу торгууль ногдуулна.

7. Гаалийн тарифын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бараат татвар ногдуулахгүйгээр гаалийн нутаг дэвсгэрт буцааж оруулахаар бол гаалийн удирдах төв байгууллагаас батлагдсан журмын дагуу гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

Гурав. Татвар хорогдуулж тооцох

8. Бараа гаалийн хяналтад байх хугацаанд тоо хэмжээ нь дутсан, гэмтэж чанараа алдан зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь эрх бүхий байгууллагаас тогтоосон магадлан шалгалтын акт баримтаар нотлогдсон тохиолдолд тийнхүү дутсан, чанараа алдсан, ашиглах боломжгүй болсон хэсэгт ногдох татварыг хорогдуулан тооцож болно.

Гэхдээ гэрээний нөхцөл зөрчигдсөн (жишээлбэл зориулалтын бус баглаа боодолд савласан гэх мэт)-өөс үүсэн гарсан хохирлын хэсэгт ногдох татварыг хорогдуулж тооцохгүй.

9. Чанараа алдаж ашиглах боломжгүй болсон (татварыг хорогдуулж тооцсон) бараа эрүүл ахуй, байгаль орчинд хор хөнөөлтэй болох нь холбогдох мэргэжлийн албадын дүгнэлтээр батлагдсан тохиолдолд Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу устгана.

10. Хэрэв эвдэрч гэмтсэн, чанарын гологдол гарсан бараг мэдүүлэгч өөр зориулалтаар ашиглах хүсэлт гаргасан бол тухайн зориулалтыг нь харгалзан гаалийн байгууллага дахин үнэлж уг үнээс гаалийн татварыг ногдуулж барагдуулсны дараа олгоно.

Дөрөв. Татвар буцаан олгох

11. Бараа гаалийн хяналтад байх хугацаандаа гэмтсэн, чанараа алдсан, зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон, тоо хэмжээ, жин багассан нь холбогдох бичиг баримтаар нотлогдсон тохиолдолд түүнд ногдох урьдчилан төлсөн татварыг буцаан олгоно.

12. Татварыг нь урьдчилан төлсөн бараг гаалийн байгууллага гаалийн хяналтаас гаргахыг зөвшөөрөхөөс өмнө тухайн бараа татвар ногдуулахгүй горимд шилжсэн, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан тохиолдолд гаалийн татварыг буцааж олгож болно.

13. Энэ журмын 12-т заасны дагуу татвар буцааж олгох тохиолдолд татвар ногдуулахгүй байх горим, татвараас чөлөөлж, хөнгөлөх тухай эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт тусгагдсан барааны код IБараг тодорхойлох, кодлох үялдуулсан системí-ийн кодтой тохирч байгаа эсэхийг гаалийн байгууллага шалган үзэж шийдвэрлэнэ.

14. Гаалийн татварыг ногдуулж барагдуулсны үндсэн дээр гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн бараг хугацаанд нь буцаан нэвтрүүлсэн тохиолдолд тухайн бараг оруулж ирэхэд болон гаргахад бүрдүүлсэн гаалийн мэдүүлэг, татвар тушаасан төлбөрийн баримт, мэдүүлэгчээс гаалийн байгууллагад бичгээр гаргасан хүсэлт, нэхэмжлэлийг үндэслэн буцаан шилжүүлнэ.

15. Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах, засвар үйлчилгээ хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглахаар тур хугацаагаар оруулж ирсэн гадаадын бараг бүцаан гаргаж татварааа бүцаан авах тохиолдолд мэдүүлэгч бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан гадаадын материалын орцын норм, хэвийн хорогдлын хэмжээг тодорхойлон гаргаж гаалийн байгууллагад өгнө (Энэ журам гарахаас өмнө гадаадын захиалагчийн зардлаар оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан аж ахуйн нэгжүүдэд энэ заалт хамаарахгүй).

16. Гаалийн байгууллага энэ журмын 15-д дурдсан орцын норм, хэвийн хорогдлын хэмжээг нягтлан шалгаж, экспортод гаргах бүй бараа, бүтээгдэхүүнд зарцуулагдсан материалын орцын хэмжээнд ногдох гаалийн татварыг бүцаан олгоно.

17. Урьдчилан төлсөн болон тур хугацаагаар оруулж ирсэн барааны гаалийн татварыг тусгай дансанд төвлөрүүлэн бүцаан олголтыг уг данснаас хийнэ.

18. Гаалийн хилээр тур хугацаагаар оруулж ирсэн бараа нь орж ирсэн гаалийн байгууллагаар бүцаан гарах бол тухайн гаалийн газар, хороо татварыг нь бүцааж олгоно. Бараг орж ирснээсээ өөр гаалийн байгууллагаар бүцаан гаргах тохиолдолд төлсөн татварыг Улсын гаалийн ерөнхий газрын дансанд төвлөрүүлж уг данснаас бүцааж олгоно.

19. Гаалийн байгууллага нь улирал, жилийн эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй татварын ногдуулалт, барагдуулалтын тооцоо нийлж баталгаажуулна.

20. Урьдчилан төлсөн, эсхүл тооцоо нийлж тодорхойлогдсон татварын илүү төлөлтийг бүцаан олгох үндэслэлтэй бол тухайн аж ахуйн нэгж, иргэнээс тавьсан хүсэлтийн дагуу импортлох барааны гаалийн татварт суутган тооцож болно.

21. Гаалийн татварыг бүцаан авахтай холбогдсон тооцоог хуурамчаар үйлдэх, будлиантуулах замаар улсад хохирол учруулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 246** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам"-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан бүцалтгүй тусламжаар бий болгосон мөнгөн хөрөнгө болон бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлогыг 2001 оны 11 дүгээр сард багтаан Мал хамгаалах санд төвлөрүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журамд заасан арга хэмжээ, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Мал хамгаалах сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж жил бүрийн 2 болон 8 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны
246 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ХАМГААЛАХ САН БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь Мал хамгаалах сангийн бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мал хамгаалах сангийн удирдлага, зохион байгуулалт

2. Мал хамгаалах сан дараахь зохион байгуулалттай байна:

а/мал хамгаалах улсын нэгдсэн сан;

б/мал хамгаалах аймаг, нийслэлийн сан;

в/мал хамгаалах сумын сан.

3. Мал хамгаалах аймаг, нийслэлийн сан нь мал хамгаалах улсын нэгдсэн сангийн дэд сан, мал хамгаалах сумын сан нь мал хамгаалах аймаг, нийслэлийн сангийн дэд сан байна.

4. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах,сангийн хөрөнгийн бүрдүүлэлт,зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байна. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн орон тооны бус зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна:

Дарга Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд

Гишүүд: -Улсын байнгын онцгой комиссын дэд дарга, Иргэний хамгаалалтын газрын дарга;

-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Дэд бүтцийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга бөгөөд Мал аж ахуй, усжуулалтын хэлтсийн дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын Зарлага санхүүжилтийн хэлтсийн дарга;

-Улаан загалмайн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (тохиролцоноор).

Нарийн бичгийн дарга -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөө аж ахуйн сангийн хэлтсийн дарга.

5. Мал хамгаалах аймаг, нийслэлийн сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн дарга нь аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч, мал хамгаалах сумын сангийн орон тооны бус зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга байх бөгөөд бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар батална ажиллуулна.

6. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөө аж ахуйн сангийн хэлтэс, мал хамгаалах аймаг, нийслэлийн сангийнхыг Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, мал хамгаалах сумын сангийнхыг сумын хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн мэргэжилтэн эрхэлнэ.

7. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн төвлөрүүлэн захирагч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, мал хамгаалах аймаг, нийслэлийн санд аймгийн Засаг дарга, мал хамгаалах сумын санд сумын Засаг дарга байна.

Гурав. Мал хамгаалах сангийн санхүүгийн эх үүсвэр

8. Мал хамгаалах улсын нэгдсэн санг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан буцалтгүй тусламжаар тодорхой нөхцөл болзолтойгоор олгосноос бусад бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлого;

б/гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан буцалтгүй тусламжаар олгосон мөнгөн хөрөнгө;

в/гадаад орон, олон улсын

байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхөд зориулан олгосон зээл;

г/улсын төвлөрсөн төсвөөс хуваарилан олгосон хөрөнгө;

д/иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив, тусламж;

е/сангийн хөрөнгийг энэхүү журамд заасан зориулалтын дагуу бусдад зээлдүүлсний болон банкинд хадгалуулсны хүү;

ж/бусад эх үүсвэр.

9. Мал хамгаалах аймаг, нийслэлийн санг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/хувийн мал бүхий иргэний орлогын албан татварын 30-аас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгө;

б/бэлчээр ашигласны төлбөрийн 50-иас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгө;

в/орон нутгийн төсвөөс хуваарилан олгосон хөрөнгө;

г/мал хамгаалах улсын нэгдсэн сангаас олгосон зээл, тусламж;

д/сангийн чөлөөт хөрөнгийг бусдад зээлдүүлсний болон банкинд хадгалуулсны хүү;

е/иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив, тусламж;

ж/бусад эх үүсвэр.

10. 9 дүгээр зүйлийн "а", "б"-д заасан хөрөнгөөс мал хамгаалах аймгийн болон сумын санд төвлөрүүлэх хэмжээг аймгийн Засаг дарга тогтооно.

Дөрөв. Мал хамгаалах сангийн хөрөнгийг зарцуулах зориулалт

11. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

а/орон нутгаас тавьсан хүсэлтийг үндэслэн мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах, бэлчээрийн даац тодорхойлох, ган, зудын нөхцөл байдал, зэрэглэл, хамрах хүрээг тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх;

б/өвс, тэжээлийн улсын аюулгүйн нөөц бий болгохтой холбогдсон үйл ажиллагааг санхүүжүүлэх;

в/малын тэжээлд зориулж уураг, энергийн агуулламж ихтэй тэжээлийн үрэмал (шар буурцаг, вандуй, эрдэнэ шиш, овьёос, царгас зэрэг)-ыг улсын захиалга, даалгавраар тариалагчдад зээл олгох;

г/хадлан, тэжээл бэлтгэх техник, технологийн шинэчлэл хийх, тэдгээрийн сэлбэг бөөнөөр захиалж ирүүлэх, хадгалах, худалдан борлуулахтай холбогдсон зардал;

д/ган, зудаас үчирсан хохирлыг нөхөх арга хэмжээ болон ган, зудыг хохирол багатай даван туулах зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх, зээл олгох;

е/хаягдсан, эвдэрсэн худгийг сэргээн засваралах, уст цэг шинээр гаргах санхүүжилт, зээл олгох;

ж/гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудтай тэмцэх зориулалтаар авсан зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөр;

з/ган, зудад нэрвэгдсэн аймаг, сумдад дэмжлэг, тусламж үзүүлэх, зээл олгох;

и/сангийн үйл ажиллагаатай холбогдсон зардал.

12. Мал хамгаалах аймаг, нийслэлийн сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

а/бэлчээрийн даац, багтаамжийг тогтоож хамгаалалтад авах, зохистой ашиглахтай холбогдсон зардлыг санхүүжүүлэх, мал сүргийг өөр аймаг, сумын нутагт оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон арга хэмжээнд зээл олгох, тусламж үзүүлэх;

б/өвс, тэжээлийн аймаг, нийслэлийн байнгын нөөц бий болгохтой холбогдсон үйл ажиллагааг санхүүжүүлэх, зээл олгох;

в/өвс, тэжээл бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох;

г/ган, зудаас учирсан хохирлыг нөхөх арга хэмжээг санхүүжүүлэх, зээл олгох;

д/хадлан, тэжээл бэлтгэх техник, технологийн шинэчлэлт хийх аж ахуйн нэгжид зээл олгох;

е/уст цэг шинээр гаргахад зээлийн дэмжлэг үзүүлэх;

ж/Мал хамгаалах улсын нэгдсэн сангаас авсан зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөр;

з/сангийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардал.

13. Мал хамгаалах сумын сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

а/өвс, тэжээлийн сумын аюулаас хамгаалах нөөц бүрдүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх, зээл олгох;

б/хадлан, тэжээл бэлтгэх арга хэмжээнд зээл олгох.

Тав. Мал хамгаалах сангийн хөрөнгийг зарцуулах зарчим

14. Мал хамгаалах сангийн хөрөнгийг тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан энэ журамд заасан зориулалтын дагуу буцалтгүй санхүүжилт болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл хэлбэрээр зарцуулна.

15. Мал хамгаалах сангаас зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх болзол, нөхцөл, төлбөр, тооцоо, хяналтын журмыг Санхүү, эдийн засгийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нар баталж мөрдүүлнэ.

16. Сангийн хөрөнгийг арилжааны аль нэгэн банкны төв, орон нутгийн салбарт байршуулж, тус тусын сангийн орон тооны бус зөвлөлийн шийдвэрээр зарцуулна.

17. Сангийн хөрөнгийн 90-ээс доошгүй хувийг эргэн төлөгдөх зээл олгоход зориулна. Энэ заалтад гадаад орон, олон улсын байгууллагаас тодорхой нөхцөл, болзолтойгоор олгосон тусламжийн хөрөнгө хамаарахгүй.

Зургаа. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн орон тооны бус зөвлөлийн эрх, үүрэг

18. Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн орон тооны бус зөвлөл нь сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

а/Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, аймаг, нийслэлд хөрөнгө хуваарилах, зарцуулах, олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;

б/мал хамгаалах улсын нэгдсэн сангийн хөрөнгийг хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, чиглэл, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх чиглэлтэй нийцүүлэн шийдвэрлэх;

в/мал хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон улсын нэгдсэн болон аймаг, нийслэлийн сангийн санхүүгийн нэгдсэн тайлан, шаардлагатай гэж үзвэл тухайлсан сумын тайланд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх;

г/сангийн үйл ажиллагааны зардлын жилийн төсөв хэлэлцэж батлах;

д/санхүүгийн хөрөнгийг нөхөн бүрдүүлэхтэй холбогдсон асуудал.

19. Мал хамгаалах сангийн талаархи аливаа асуудлыг сангийн орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

20. Сангийн орон тооны бус зөвлөлийн хурлыг гишүүдийн гуравны хоёр хувийн ирцтэй бол хүчин төгөлдөрт тооцно. Хуралд Санхүү, эдийн засгийн яам, Иргэний хамгаалалтын газрын төлөөлөл оролцоогүй бол хурлыг хүчингүйд тооцно.

21. Сангийн орон тооны бус зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

22. Сангийн орон тооны бус зөвлөл шийдвэрлэсэн асуудлаар удирдамж, зөвлөмж гаргана.

Долоо. Мал хамгаалах сангийн орлого, зарлагын тайлан

23. Мал хамгаалах сангийн орлого,

зарлагын тайланг батлагдсан маягтын дагуу улирал, жилээр гаргана.

24. Мал хамгаалах сангийн орлого, зарлагын тайлангийн маягтыг мал хамгаалах улсын нэгдсэн сангийн орон тооны бус зөвлөл батална.

25. Мал хамгаалах сумын сангийн орлого, зарлагын тайланг улирал бүрийн дараа сарын 5-ны дотор гаргаж мал хамгаалах аймгийн санд ирүүлнэ.

26. Мал хамгаалах аймгийн сан нь мал хамгаалах сумын сангаас ирүүлсэн тайланг нэгтгэж, өөрийн орлого, зарлагын тайлангийн хамт, мал хамгаалах нийслэлийн сан өөрийн орлого, зарлагын тайланг тус тус улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Мал хамгаалах улсын нэгдсэн санд ирүүлнэ.

27. Мал хамгаалах сангийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг жилээр гаргах бөгөөд мал хамгаалах сумын сангийн санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 30-ны дотор мал хамгаалах аймгийн санд, аймгийн сан нь сумдын тайланг нэгтгэн, өөрийн санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн хамт, мал хамгаалах нийслэлийн сан өөрийн үйл ажиллагааны тайланг тус тус жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор Мал хамгаалах улсын нэгдсэн санд ирүүлэх бөгөөд улсын хэмжээний нэгдсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор нэгтгэн гаргаж Санхүү, эдийн засгийн яаманд тайлагнаж байна.

28. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад төв, орон нутгийн санхүүгийн хянан шалгах байгууллага жил бүр баримтын шалгалт хийнэ.

Найм. Энэ журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

29. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хувийн зорилгод ашигласан, ашиглуулсан байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Дугаар 247 **Улаанбаатар хот**

Академийн гишүүдийн тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тооны дээд хязгаарыг 70 хүнээр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

Шинжлэх ухааны академийн гишүүдийн

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Дугаар 249 **Улаанбаатар хот**

Барилга худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлалтай Арьсны өвчин судлалын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй уурын зуухны барилгыг дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 3–ны өдөр **Дугаар 250** **Улаанбаатар хот**

Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай

Дэд бүтцийн яам, Төрийн өмчийн хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтын 20-д "Дуудлагын худалдаа" гэснийг "Хаалттай төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 3–ны өдөр **Дугаар 251** **Улаанбаатар хот**

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан "Үралдаант шалгаруулалт (тендер)-ын журам"-ын 12.3,"Худалдаа хөгжлийн банкны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай" Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Үралдаант шалгаруулалт (тендер)-ын журам"-ын 12.3-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 3–ны өдөр **Дугаар 252** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 14 дэх заалт нэмсүгэй:

"14. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол Беларусийн Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг Дарга -Үйлдвэр, худалдааны сайд"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 49 (236)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Гэрээ соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Ерөнхий консулын газрын тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Дүрэм батлах тухай*
- *"Цэргийн цол олгох журам"-ын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арванхоёрдугаар сарын 20 №49 (236)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

609. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-22-ны хууль) 1167
610. Гэрээ соёрхон батлах тухай (2001-12-6-ны хууль) 1169
611. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1169
612. Соёлын тухай хуулийн зарим зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай (2001-11-30-ны хууль) 1169
613. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1169
614. Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1170
615. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1170
616. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1170
617. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1170
618. Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1171
619. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1171
620. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1172
621. Хүнсний тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай (2001-11-30-ны хууль) 1172
622. Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1172
623. Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1173
624. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1174
625. Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1174
626. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1175
627. Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1175
628. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1175
629. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1176
630. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1176
631. Ариун цэврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1177

632. Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1177
633. Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1178
634. Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1178
635. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1178
636. Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1179
637. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1180
638. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1180
639. Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1180
640. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1181
641. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-11-30-ны хууль) 1181

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

642. Ерөнхий консулын газрын тухай Дугаар 92 1182
643. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай Дугаар 93 1182
644. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг буцаах тухай Дугаар 94 1182
645. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай Дугаар 95 1183

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

646. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 87 1183
647. Дүрэм батлах тухай Дугаар 89 1186
648. В.И. Тужилкин, Л.И.Пучкова нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 91 1187
649. "Цэргийн цол олгох журам"-ын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 92 1187
650. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 95 1188
651. Шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 96 1188

2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараахь зүйл, хэсэгт дор дурдсан агуулгатай хэсэг, заалт, өгүүлбэр нэмсүгэй:

1/ 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8 дахь заалт:

"3.1.5."үнэлгээний шинжилгээ" гэж төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд өрөнхий үнэлгээ хийсэн байгууллагын томилсон хөндлөнгийн шинжээчийн гаргасан дүгнэлтийг;

3.1.6."шинжээч" гэж төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий этгээдийг;

3.1.7. "үнэлгээний мэргэжилтэн" гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйл ажиллагаанд тодорхой чиглэлээр оролцон судалгаа хийх, үнэлгээ, үнэлэлт өгөх эрх бүхий этгээдийг;

3.1.8. "төсөл захиалагч" гэж тухайн төслийг санхүүжүүлэгч иргэн, хуулийн этгээдийг."

2/ 4.6.4 дэх заалт:

"4.6.4. холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, техник, технологи нь байгаль орчинд халтай буюу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй төслийг буцаах."

3/ 4.7-ийг 2 дахь өгүүлбэр:

"Шаардлагатай бол үнэлгээний ажилд холбогдох мэргэжилтнийг татан оролцуулж болно."

4/ 4.8 дахь хэсэг:

"4.8. Шаардлагатай бол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 4.6-д заасан хугацаанд сунгаж болно."

5/ 5.4.10 дахь заалт:

"5.4.10. нөхөн сэргээлтийн төсөл."

6/ 6.5, 6.6 дахь хэсэг:

"6.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын өрөнхий үнэлгээ хийсэн байгууллага нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон 6.4-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

6.6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална".

7/ 7.4, 7.5, 7.6 дахь хэсэг:

"7.4.Үнэлгээний шинжилгээ хийх журам, үнэлгээ хийх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан байгууллага түүнийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулна.

7.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар[1] зохицуулна."

8/ 9.12 дахь хэсэг:

"9.12. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үнэлгээний мэргэжилтэнд байгаль орчны үнэлгээ хийх эрх олгох буюу хүчингүй болгоно."

9/ 11.1.3 дахь заалт:

"11.1.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, шаардлагатай бол төслийг үргэлжлүүлэх эсэх талаархи дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тавих."

10/ 12.2.4 дэх заалт:

[1] ***Байгаль орчныг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн***

"12.2.4. өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг бууруу хийсэн нь үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар нотлогдвол үнэлгээг хийсэн аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох."

2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 4.2 дахь хэсэг:

"4.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь ашигт малтмал ашиглах, газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэжүүлж эхлэхийн өмнө хийгдсэн байна."

2/ 6.2, 6.3 дахь хэсэг:

"6.2. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр болон тэдгээрийг хэрэжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага батална.

6.3. Ашигт малтмалынхаас бусад төрлийн төсөл хэрэжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль орчныг хамгаалах сум, дүүргийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил тутам тайлагнана. Ашигт малтмалтай холбогдсон төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлын баталгааг ашигт малтмалын тухай хууль тогтоомжоор зохицуулна."

3/ 7.2, 7.3 дахь хэсэг:

"7.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаж үнэлгээний шинжилгээг хийлгэнэ. Шаардлагатайд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хугацаанд сунгаж болно.

Үнэлгээний шинжилгээг хийлгэхдээ шаардлагатай бол байгаль орчны шинжилгээний итгэмжлэгдсэн лабораториор дүгнэлт гаргуулж болно.

7.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, тухайн төсөл хэрэгжих газрын иргэдийн саналыг харгалзан төслийг хэрэжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ."

4/ 9.2.2 дахь заалт

"9.2.2.үнэлгээний мэргэжилтний тодорхойлолт."

5/ 9.11 дэх хэсэг:

"9.11. Эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг бууруйхийсэн нь үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар нотлогдвол түүнд захиргааны хариуцлага ногдуулах буюу үнэлгээ хийх эрхийг нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүчингүй болгоно. Үнэлгээний мэргэжилтэн үнэлгээг хангалттүй гүйцэтгэсэн нь үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар тогтоогдвол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн мэргэжилтний эрхийг 2 хүртэл жилийн хугацаагаар хасч болно."

3 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.3-т "хуулийн этгээдийг" гэсний өмнө "иргэн,", 4.4-т "техник-эдийн засгийн үндэслэл" гэсний дараа "технологийн шийдэл", 5.4.2-т "төслийн" гэсний дараа "болон технологийн", 5.4.9-д "төслийн" гэсний өмнө "төсөл хэрэгжих газрын соёлт давхарга,", 6.1.2-т "хэлбэр" гэсний дараа "шаардагдах хөрөнгө, зардал", 8.1-д "байгаль орчинд хохирол "гэсний дараа "үүрүүлж байгаа болон", 9 дүгээр зүйлийн гарчигт "эрх олгох" гэсний дараа "хүчингүй болгох", 10 дугаар зүйлийн гарчиг болон 10.1-д "төсөл" гэсний дараа "захиалагч" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4.1-д "хийлгэнэ" гэсний "хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана", 5.4.8.-д "иргэдийн санал" гэсний "иргэд, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэрүүлэгчдийн санал", 5.6-д "хоёр талын байгуулсан" гэсний "төсөл захиалагч эрх бүхий аж ахуйн нэгжтэй байгуулсан", 5.7-д "үнэлгээний ажилд оролцсон мэргэжилтнүүдийн" гэсний "үнэлгээний мэргэжилтний", 7 дугаар зүйлийн гарчигт "үнэлгээний дүгнэлт" гэсний "үнэлгээний шинжилгээ" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 6–ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2001 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан Санхүүгийн салбарын хоёр дахь хөтөлбөрийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн гарчгийн “, үйлдэх зөвшөөрөл”, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгох”, 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын зөвшөөрелгүйгээр Төрийн тугийг кино, уран сайхны бусад арга хэмжээнд зориулан дуурайлган үйлдсэн,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр

Улаанбаатар хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр

Улаанбаатар хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Засгийн газрын” гэсний “соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“20.3.Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаатайгаар гадаадад гаргаж болно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 6 дахь заалт:

"6/ байнга оршин суугчид гадаад төлбөр, тооцоо хийх болон гадаад бэлэн валютаар гүйлгээ эрхлэхэд хязгаалт тавих;"

2/ 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монгол банкинд бүртгүүлнэ."

2 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Монголбанкны зөвшөөрлөөр", 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "заалт, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь заалтын "эсхүл агаарыг зөвшөөрөлгүй савлан, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 17 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагааг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэн явуулна. "

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн 13, 17 дугаар зүйлд дор дурдсан хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Сонирхогч этгээд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

1/ техник, эдийн засгийн үндэслэл;

2/ үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;

3/ үйлчлэх хүрээ, хэзмшлийн зааг;

4/ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

5/ байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

6/ үйл ажиллагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

7/ мэргэжлийн боловсон хүчний талаарх танилцуулга;

8/ галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага, тогтоосон техник, технологийн нөхцөл."

2/ 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/ төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх, салбар зам барих, түүнд өргөтгөл хийх, татан буулгах, төмөр замын техник хэрэгсэл үйлдвэрлэх, төмөр замын обьект ашиглахад тавигдах техник, аюулгүй ажиллагааны шаардлагыг тогтоох."

2 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "11 дүгээр зүйлийн 2, 4, 5, 9" , 3 дахь заалтын "11 дүгээр зүйлийн 2, 9, 10" гэсний дараа ", 11" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2/ төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээ болгох;"

4 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "зөвшөөрөл авна." гэснийг "тавьсан шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ." гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ургамал хамгаалллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дор дурдсан заалт нэмсүгэй:

"6/ ургамал хамгаалахад ашигладаг бодис импортлох, худалдах зөвшөөрөл олгох."

2 дугаар зүйл. Ургамал хамгаалллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь заалтын "ургамал хамгаалах албанаас" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Ургамал хамгаалллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, 8 дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ХИМИЙН ХОРТ БОДИСООС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "худалдах болон худалдан авахад" гэснийг "худалдахад", 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авч бүртгүүлнэ." гэснийг "сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлнэ.", 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис ашиглах" гэснийг "Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь

хэсгийн 1 дэх заалт, 7 дугаар зүйлийн гарчиг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "экспортлох," гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

"4.5. Согтууруулах ундааны үйлдвэрлэл шинээр эрхлэх тусгай зөвшөөрлийг төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр олгоно. Төсөл сонгон шалгаруулах журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад батална.

4.6. Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

4.6.1. согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг;

4.6.2. аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;

4.6.3. үйлдвэрийн байрны талаарх мэргэжлийн хяналтын байгуллагын дүгнэлт. "

2 дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3, 6.1 дэх хэсгээс ", улсын зэрэглэлтэй хотын захирагч" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн 5.1.8, 6.1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аудитын тухай хуулийн 17, 26 дугаар зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

1/ 17 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэг:

"5. Аудитын үйл ажиллагаа явуулах лиценз авах хүсэлт гаргахад мэргэшсэн нягтлан бодогч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

1/ мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний хуулбар;

2/ хуульд заасан бусад баримт бичиг.

6. Аудитын үйл ажиллагаа явуулах лиценз олгоход дараахь нөхцөлийг харгалзана:

1/ мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан байх;

2/ аудитын сургалтанд хамрагдсан байх;

3/ өмнө нь аудитын үйл ажиллагаа эрхэлж байхдаа мэргэжлийн болон ёс зүйн алдаа, дутагдал гаргаагүй байх.

7. Мэргэжлийн зөвлөл дараахь тохиолдолд аудитын үйл ажиллагаа явуулах лицензийг хүчингүй болгоно:

1/ Монгол Улсын хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйн дүрэм зөрчсөнөөс мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг нь хассан;

2/ ауditорын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсхүл мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтанд тэнцээгүй;

3/ хуульд заасан бусад тохиолдол."

8. Аудиторын үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг 14 хоногийн дотор Мэргэжлийн зөвлөл шалгаж, саналаа санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ."

2/ 26 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"3. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө аудитын байгууллагууд тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах тухай хүсэлтээ санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4. Аудитын байгууллагын үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг Нягтлан бодох бүртгэл, магадлагааны хэлтэс, Мэргэжлийн зөвлөл 14 хоногийн дотор хамтран шалгаж, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ."

2 дугаар зүйл. Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Мэрэгшсэн нягтлан бодогч санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөс лицензи авснаар аудитын үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ."

3 дугаар зүйл. Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 1, 2, 14 дүгээр зүйлийн 1, 2, 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 3, 26 дугаар зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 1, 31 дүгээр зүйлийн 1, 2, 32 дугаар зүйлийн 3, 6, 9 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Сангийн сайд" гэснийг "санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн", 35 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Сангийн яам" гэснийг "санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 19.6 дахь хэсэгт дор дурдсан заалт нэмсүгэй:

"19.6.6. үүсгэн байгуулагчийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон ёр, авлага, банкны харилцах, хадгаламжийн үлдэгдлийн талаарх албан ёсны тодорхойлолтууд;

19.6.7. даатгалын үйл ажиллагаа эрхлэх 3 жилийн хугацааны бизнес төлөвлөгөө;

19.6.8. эрхлэх даатгалын төрөл тус бүрээр гаргасан даатгал эрхлэх журам."

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 19.6.5 дахь заалтын "мэргэшлийн" гэсний өмнө "даатгалын" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

"6.2. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, иргэн нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.2.1. үйл ажиллагаандаа ашиглах хэмжилт, боловсруулалтын багаж хэрэгслийн жагсаалт, хувийн дугаар, гэрчилгээ;

6.2.2. мэргэжлийн боловсон хүчин болон тэдний дадлага туршлагын талаарх тодорхойлолт;

6.2.3. заавар, стандарт болон техникийн баримт бичгийн жагсаалт."

2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.4, 6.1.1 дэх заалтын "зөвшөөрөл" гэсний өмнө "тусгай" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, 14.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12.1.1 дэх заалт:

"12.1.1. нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөлгүйгээр хэвлэх;"

2/ 14.2 дахь хэсэг:

"14.2. Энэ хуулийн 12.1.1-д заасныг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль болон Төрийн нууцын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ."

4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.4, 6.1.1 дэх заалтын ", ажил гүйцэтгэх" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

ЭМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эмийн тухай хуулийн 6.2 дахь хэсгийн "үйлдвэрлэх", 6.3 дахь хэсгийн "эмнэлгийн хэрэгслийг" гэсний дараа "худалдах," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйл:

"**8 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох**

8.1. Эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг импортлохыг зөвшөөрнө.

8.2. Эм импортлох зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох төв байгууллагаас эм ханган нийлүүлэх байгууллагад олгоно.

8.3. Зохих байгууллагын зөвшөөрөлгүй эм импортлохыг хоригломо.

8.4. Мэргэжлийн бус байгууллага, иргэн эмийг гадаадаас тусламж, хандиваар авах тохиолдолд тэдгээр нь төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, уг эмийн чанарын баталгаажуулалт, хадгалалт, хэрэглээ, түгээлтийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

8.5. Эмнэлгийн хэрэгслийг импортлоход түүнийг бүтээсэн материалын бүтэц, чанар, тухайн хэрэгслийн техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна.

8.6. Тусгай зөвшөөрлийн бичигт эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн нэр, хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх хугацаа, хилийн боомтыг тодорхой заасан байна."

3 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 18.1 дэх хэсгийн "хэрэглээнд гаргах" гэснийг "худалдах" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эмийн тухай хуулийн 6.2, 6.3 дахь хэсгийн "экспортлох" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Худалдаа, үйлдвэрийн яаманд" гэснийг "Үндэсний татварын ерөнхий газарт", 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдэгдлийг үндэслэн" гэснийг "энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Худалдаа, үйлдвэрийн яамнаас олгосон гэрчилгээг үндэслэн", 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Худалдаа, үйлдвэрийн яамнаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 2, 5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 2, 17 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 5.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5.1. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслийг боловсруулах ажлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж болно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 3.1.5 дахь заалт, 5.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3.1.5 дахь заалт:

"3.1.5. "харуул хамгаалалтын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг."

2/ 5.1 дэх хэсэг:

"5.1. Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т бүртгүүлнэ."

2 дугаар зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчгийг "Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд бүртгүүлэх", 7.1 дэх хэсгийн "үг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл" гэснийг "бүртгүүлэхийг хүссэн өргөдөл", 7.2 дахь хэсгийн "зөвшөөрөл олгох" гэснийг "бүртгэх эсэх", 8.2.1 дэх заалтын "зөвшөөрлийн" гэснийг "бүртгэлийн", 22.1.1 дэх заалтын

"зөвшөөрөлгүйгээр" гэснийг "бүртгүүлэлгүйгээр" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 5.2 дахь хэсэг, 9.1.2 дахь заалт, 23 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авна." гэснийг "дүгнэлт гаргуулна." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 10^1 дүгээр зүйл нэмсүгэй:

"10^1 дүгээр зүйл. Ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл

10^1.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх үйл ажиллагаат тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.

10^1.2. Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар мэргэжлийн хяналтын алба, эрдэм шинжилгээний байгууллага, барилгын чиглэлийн төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй комисс урьдчилан дүгнэлт гаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад танилцуулна.

10^1.3. Тусгай зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10^1.2 дахь хэсэгт заасан дүгнэлтийг үндэслэн олгоно.

10^1.4. Комисс нь дүгнэлтээ гаргахдаа тусгай зөвшөөрөл хүссэн байгууллага, аж ахуйн нэгжийн мэргэжлийн боловсон хүчин, ажлын туршлага, ажил үйлчилгээ явуулахад шаардлагатай машин механизм, техник, технологи, багаж хэрэгсэл, норматив техникийн баримт бичгийн бүрдэлт, бүтэц, зохион байгуулалт зэргийг харгалзан үзнэ.

10^1.5. Комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10^1.6. Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр байгуулламж, 60 метрээс дээш алгасалтай буюу 13-аас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн объектын хүрээнд олгоно.

10^1.7. Тусгай зөвшөөрөл хэмжигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зохих ёсоор биелүүлж, техник технологи, мэргэжлийн ажиллах хүчин, ажил үйлчилгээний чанарын хүрьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан байна гэж тусгай зөвшөөрөл олгогч үзвэл тусгай зөвшөөрлийн хугацааг ажлын 21 хоногийн дотор сунгана."

2 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 5.1.3, 6.1.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5.1.3 дахь заалт:

"5.1.3. барилга байгууламж барих, ашиглахтай холбогдсон нийтлэг мөрдөгдөх журам батлах;"

2/ 6.1.5 дахь заалт:

"6.1.5. барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож байгаа байдалд хяналт тавих;"

3 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 7.2.3 дахь заалтын "энэ хуулийн 6.1.5-д заасан" гэснийг "энэ хуульд заасан", 19.1.1 дэх заалтын "барилга, угсралтын ажил, үйлчилгээ, барилгын материалын үйлдвэрлэлийг" гэснийг "барилга угсралтын ажил, үйлчилгээг" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Барилгын тухай хуулийн 14.1.1 дэх заалтын "зохих зөвшөөрлийн үндсэн дээр", 14.1.2 дахь заалтын "авсан зөвшөөрлийн үндсэн дээр" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

АРИУН ЦЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ариун цэврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "гадаад" гэсний өмнө "хуульд заасан тохиолдолд" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 15.4 дэх хэсгийн "аймаг" гэсний дараа "нийслэл," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 15.5 дахь хэсэг, 15.5.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 15.5 дахь хэсэг:

"15.5. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага дараахь нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгасны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тусгай зөвшөөрөл олгоно:"

2/ 15.5.3 дахь заалт:

"15.5.3. тухайн ажил үйлчилгээнд мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас батлагдсан стандарт, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл."

3 дугаар зүйл. Авто тээврийн тухай хуулийн 6.1.3 дахь заалтын "тусгай зөвшөөрөл олгох журам боловсруулж, батлуулах" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 6.2 дахь хэсэг, 15.5.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 6.1.5 дахь заалтын "тусгай зөвшөөрөл олгох журам,", 6.1.7 дахь заалтын "хот, тосгон, бусад суурины нийтийн хэрэгцээнд эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар түлш импортлох, экспортлох зөвшөөрөл олгох." гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 9.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "журмыг Монголбанк тогтоно." гэснийг "харилцааг хуулиар зохицуулна." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн ", төлөөлөгчийн газар", 28^2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монголбанкнаас зөвшөөрөл авсан" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5, 28^2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28^4 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүнд зохих сорилт, шалгалт хийсний үндсэн дээр чанарын гэрчилгээг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага буюу түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага олгоно."

2/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/ чанарын гэрчилгээтэй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал;"

2 дугаар зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дэх хэсгийн 9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 3.1, 8.1, 30.1 дэх хэсэгт дор дурдсан заалт нэмсүгэй:

1/ 3.1.8 дахь заалт:

"3.1.8. "дээд зэрэглэлийн зочид буудал" гэж зочид буудлын цогц үйлчилгээний жишиг шаардлагын 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан үйлчилгээний байгууллагыг."

2/ 8.1.9, 8.1.10 дахь заалт:

"8.1.9. жуулчдад мэргэжлийн хөтөч-тайлбарлагчаар үйлчлэх;

8.1.10. эрх бүхий байгууллагаар зэрэглэлээ тогтоолгох."

3/ 30.1.6 дахь заалт:

"30.1.6. энэ хуулийн 8.1.6-д заасныг зөрчсөн аялал жуулчлалын байгууллагыг 100000-250000 хүртэл төгрөгөөр торгох."

2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 12.1.2 дахь заалтын "гэрчилгээ авсан" гэсний дараа ", эрх бүхий байгууллагаар хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэлээ тогтоолгосон", 16.1.7 дахь заалтын "тоо, байршлыг тогтоох" гэсний дараа ", тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх" гэх тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 5 дугаар зүйл, 10.2 дахь хэсэг, 16.1.6, 17.1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл. Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

5.1. Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

5.2. Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараахь бичиг баримт бүрдүүлнэ:

5.2.1. дээд зэрэглэлийн зочид буудлын барилгын архитектур төлөвлөлт, техник, технологийн болон инженерийн системийн М1:100 ба М1:200 масштабын тойм зураг, холбогдох хяналтын байгууллагын дүгнэлт;

5.2.2. дээд зэрэглэлийн зочид буудлын барилгын стандарт, ангилал, зэрэглэл, техник, технологийн талаар гаргасан шинжээчийн дүгнэлт;

5.2.3. дээд зэрэглэлийн зочид буудлын зэрэглэл тогтоох комиссын дүгнэлт.

5.3. Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн талаарх энэ хуулиар зохицуулагүй бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

2/ 10.2 дахь хэсэг:

"10.2. Дээд зэрэглэлийн зочид буудал болон жуулчны баазын зэрэглэл тогтоох журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална."

3/ 16.1.6 дахь заалт:

"16.1.6. аялал жуулчлалын байгууллага, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох журмыг батлах;"

4/ 17.1.2 дахь заалт:

"17.1.2. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;"

4 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 12.2 дахь хэсгийн "хувь хүнд хөтөч-тайлбарлагчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгоно." гэснийг "хувь хүний хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэлийг тогтооно", 13.2 дахь хэсгийн "аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, аялал жуулчлалын гадаадын байгууллагыг төлөөлөхийг хориглоно" гэснийг "аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно", 23.1.3 дахь заалтын "5.2;12.2-т" гэснийг "5 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 3.1.7 дахь заалтын "**зөвшөөрөл бүхий**", 9.2.1 дэх заалтын "тусгай зөвшөөрөл болон" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "худалдаа болон бусдад хэрэглүүлэх" гэснийг "худалдах" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт, 10 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "бусдад хэрэглүүлэх", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "тогтоосон журмын дагуу", 10 дугаар зүйлийн "баталсан журмын дагуу" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17.11 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 16 дугаар зүйл:

"**16 дугаар зүйл. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл**

16.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, стандартад шинжилгээ хийж, магадлан итгэмжлэл олгох, эрүүл мэндийн байгууллагын түвшинг тодорхойлж, дүгнэлт гаргах зэрэг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

16.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаог хэрэгжүүлэх журам, магадлан шинжлэх ажлын шалгуурыг Засгийн газар тогтооно."

2/ 17.11 дэх хэсэг:

"17.11. Эмнэлгийн мэргэжилтэн эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно."

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2 дахь хэсгийн "аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас" гэснийг "аймаг, нийслэлийн Засаг дарга", 17.7, 22.1, 22.2, 22.3 дахь хэсгийн "эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагаас" гэснийг "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас", 23.2 дахь хэсгийн "эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагад" гэснийг "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Улаанбаатар хот**

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио долгионы тухай хуулийн "Радио давтамж зохицуулалт, хяналтын алба" гэснийг "Зохицуулах хороо", 10.1.4 дэх заалтын "зөвшөөрөл" гэснийг "тодорхойлолт" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 31 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг:

"11. Гаалийн баталгаат агуулах, татваргүй барааны дэлгүүр байгуулах зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах эрхийг гаалийн удирдах төв байгууллага эдэлнэ."

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрээс "зөвшөөрөл олгох, түүний" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага олгоно."

2/ 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Боловсролын байгууллага үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:"

3/ 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:"

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн ", зөвшөөрөл олгох", 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "орон нутгийн өмчийн боловсролын байгууллага байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг шийдвэрлэх,", 27 дугаар зүйлийн 3 дахь заалтын "орон нутгийн өмчийн боловсролын байгууллага байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх," гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 92 | Улаанбаатар хот

Ерөнхий консулын газрын тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: газар болгон өөрчилсүгэй.

Сингапур Улс дахь Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газрыг Ерөнхий консулын **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 93 | Улаанбаатар хот

Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 2001 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь сууц өмчлөгчдийн холбоод, Орон сууц, нийтийн аж ахуйн газрын харьяа компаниуд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хоорондын холбоо, үйл ажиллагааны уялдаа, хяналт, сууц өмчлөгчдийн холбооны эрх, үүрэг, зохион байгуулалт, орон сууцны орчин тойрны газрын зээмшил, ашиглалт, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн бариулсан орон сууцанд харьяалагдах эд хөрөнгө болон шугам сүлжээ, орон сууц, түүний дундын өмчлөлийн эд хөрөнгө болон инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, орон сууц-нийтийн аж ахуйн салбарыг зах зээлийн зарчимд нийцүүлэн арилжааны хэлбэрт шилжүүлэх зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлыг хөндөөгүй байх тул хууль санаачлагчид нь буцаасугай.

2. Орон сууцтай холбогдсон хуулиудыг цогцолбороор нь авч үзэж холбогдох хууль тогтоомжийг боловсруулан 2002 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 94 | Улаанбаатар хот

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 2001 оны 7 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь ой, хээрийн түймэртэй тэмцэх, түүнээс хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын эрх, үүрэг, эрхэлсэн ажлын давхардлыг арилгах асуудлыг иж бүрнээр зохицуулаагүй байх тул эдгээр төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

2. Ой, хээрийн түймрээс хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг цогцолбороор нь шийдвэрлэх чиглэлээр гал, түймэртэй тэмцэхтэй холбогдсон хуулиудыг дахин авч үзэж, зохих хууль тогтоомжийг уялдуулан боловсруулан 2002 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

2. Хуулийн төсөлд гэнэтийн аюулд нэрвэгдсэн иргэнд халамжийн үйлчилгээ, материалын тусламж үзүүлэх зэрэг асуудлыг тусгаж төслийг 2002 оны 1 дүгээр сард багтаан өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 87 | Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Бямбажавын Баатар - "Монгол шуудан" компани /ТӨҮГ/-ийн албаны дарга
2. Дэмчигжавын Моломжамц - Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкны удирдлагын зөвлөлийн гишүүн
3. Равдангийн Цагаанхүү - Монгол Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ажлын албаны зөвлөх
4. Баатарын Цэвээн - Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Мичидийн Адьяатулгат - Өвөрханган аймгийн хянан шалгах хорооны дарга
2. Дуламсүрэнгийн Алтанцэцэг - Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны нарийн бичгийн дарга
3. Аюурцэдэнгийн Баатаржав - Ховд аймгийн Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга
4. Чимэдийн Баатаржав - Ховд аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн ах эмч
5. Жамбажамцын Батдорж - Нийслэлийн "Авто тээвэр-Тав" ХК-ийн жолооч
6. Жамъянгийн Батсайхан - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга
7. Нанцагийн Батсуурь - Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны дарга
8. Нингэрийн Бадам - Увс аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
9. Цэгмэдийн Бямбажав - МҮЭ-ийн холбооны архивч
10. Дуламжавын Ганболд - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн засварчин
11. Цэвэлсодномын Ганхүү - Улаанбаатар хотын захирагчийн албаны инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
12. Бямбажавын Даваасүрэн - "Улаанбаатар хивс" ХК-ийн ажилчин
13. Раднаагийн Дархижав - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
14. Пагваагийн Доржсүрэн - Улсын мал эмнэлгийн газрын эпидемиологийн албаны дарга
15. Гүндэгмаагийн Дулмаа - Ахмад дуучин асан
16. Монхооройн Дэжидсүрэн - Булган аймгийн Хялганат тосгоны Захирагчийн ажлын албанд

усны харуул

17. Тангадын Жимсээ - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын архивч-номын санч
18. Борын Ишцог - Монголын хүүхдийн ордны захирал
19. Дамбын Лхагважав - Булган аймгийн Могод сумын 4 дүгээр багийн Засаг дарга
20. Гун-Аагийн Мягмар - Баянгол дүүргийн МАХН-ын IY үүрийн дарга
21. Дагвын Мягмаржав - Нислэгийн цаг уурын төвийн инженер
22. Дагвын Норов - Монголын гимнастикийн холбооны зөвлөх
23. Гүнэгийн Пүрэв - Завхан аймгийн Сонгино сумын "Пунцаг-жанчивлан" хийдийн дэд хамба
24. Галдангийн Ринзаан - Увс аймгийн Наранбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
25. Мандширын Сандуй - Завхан аймгийн Асгат сумын Засаг дарга
26. Зундуйн Сонгиноо - Завхан аймгийн Улиастай сумын " Ач тэнгэр" ХХК-ийн захирал
27. Жадамбын Осоржамаа - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх хөдөлмөр зохицуулалтын албан дарга
28. Мөнхдоржийн Отгон - Улсын клиникийн төв эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал
29. Балжидын Пэлжээ - Төр захиргааны ахмад ажилтан
30. Намжилын Түмэндэмбэрэл - Санхүү эдийн засгийн яамны Төрийн нарийн бичигийн дарга
31. Аюурзанын Цанжид - Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
32. Агваанцэдэнгийн Цогзол - Нийслэлийн 1 амаржих газрын эх барих, эмэгтэйчүүдийн их эмч
33. Халтмайн Цэрэнсодном - Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Хөдөө аж ахуйн банкны эрхлэгч
34. Мөнхийн Цэндмаа - Хүүхдийн мэс заслын албаны ахмад эмч
35. Шархүүгийн Цэрэндорж - Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч
36. Хуушааны Цэрэндэжид - Улаанбаатар төмөр замын төв эмнэлгийн орлогч дарга
37. Дашийн Чойжоо - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
38. Оонойн Шаалуу - "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн гүйцэтгэх захирал
39. Бадрахын Ширчиндорж - Булган аймгийн Хянан шалгах хорооны дарга
40. Жанчивын Шоовдор - Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
41. Самбуугийн Энх-Амгалан - Дундговь аймгийн Адаацаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
42. Цэгмидийн Энэбиш - Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн тасгийн дарга

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Түмэнбаярын Баттөмөр - Хөвсгөл аймгийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал сөнөөгч
2. Цэвэгмидийн Батсуурь - Дорнод аймгийн аврах отрядын дарга
3. Сандагийн Мягмаржав - Улсын иргэний хамгаалалтын газрын цацраг, химийн хордолтоос хамгаалах хэлтсийн дарга, хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дэлгэрдоржийн Агимаа - Ховд аймгийн шүүхийн шүүгч
2. Маахүүгийн Алтангэрэл - Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, дэд хурандаа
3. Сумъяагийн Баатар - Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөө аж ахуйн газрын жолооч
4. Нацагдоржийн Баатар-Очир - Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
5. Очирбатын Бадамсамбуу - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын байгаль орчныг хамгаалах байцаагч
6. Ёндонгийн Баяраа - Улаанбаатар төмөр замын татах хэсгийн машинч
7. Тавхайн Баяраа - Нийслэлийн "Одкон холдинг" ХХК-ийн гагнуурчин
8. Бямбажавын Баярсайхан - Орхон аймгийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга
9. Дагвын Баярсайхан - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
10. Батын Бор - Сүхбаатар аймгийн Ус цаг уурын станцын дарга
11. Дамдинжамцын Буянтогтох - Төв аймгийн сум дундын П шүүхийн ерөнхий шүүгч
12. Нацагийн Бямбаа - Завхан аймгийн Отгон сумын Засаг даргын Тамгын газрын бичээч, бичиг хэргийн эрхлэгч
13. Лувсангийн Бямбацэрэн - Нийслэлийн "Үзэмжит гоо" ББН-ийн эрхлэгч
14. Балжиннямын Галбат - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн засварчин
15. Төмөртогоогийн Ганбаатар - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын хэлтсийн

	дарга, цагдаагийн дэд хурандаа
16. Ванчинтүгжийн Дайрийжав	- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "Сэлэнгэ гурил тэжээл" ХК-ийн ажилчин
17. Батбаатарын Даринчулуун	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч
18. Биндэрийн Дулмаа	- Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч
19. Шунуугийн Жавзмаа	- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын багийн Засаг дарга
20. Балсанцэрэнгийн Жаргалсайхан	- Хөвсгөл аймгийн Тариалан сумын ус, цаг уурын техникч
21. Шавдын Минжүүр	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийтлэг үйлчилгээний газрын ерөнхий нягтлан бодогч
22. Бадарчийн Мөнхбаяр	- Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа "Их тэнгэр" цогцолборын үйлчлэгч
23. Жадамбаагийн Мэргэнбаатар	- МҮЭ-ийн соёлын төв ордны слесарьч
24. Норовын Нямжав	- Нийслэлийн "Одкон холдинг" ХХК-ийн гагнуурчин
25. Аюушийн Пүрэвдорж	- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн жолооч
26. Хотмандалын Пүрэвдулам	- Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтсийн ажилтан
27. Цэрэнпунцагийн Пүрэвсүрэн	- Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч
28. Сэрээтэрийн Самбуу	- Улаанбаатар төмөр замын олон улсын тээвэр зуучлалын төвийн жолооч
29. Должинсүрэнгийн Сандагжав	- Хөвсгөл аймгийн Тариалан сумын дунд сургуулийн орос хэлний багш
30. Сангидоржийн Сандагдорж	- Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн ажилчин
31. Цэрэндэмбэрэлийн Санжмятав	- Нийслэлийн өнгөт гэрэл зургийн "Агфа" төвийн операторч
32. Төвөөгийн Сидлээ	- Хөдөө аж ахуйн банкны Увс аймгийн Тэс сум дахь тооцооны төвийн эрхлэгч
33. Төмөрийн Сүрэнжав	- Нийслэлийн "Авто тээвэр-Тав" ХК-ийн жолооч
34. Дашийн Сэвжид	- Ховд аймгийн Жаргалант сумын Нийтийн аж ахуй, үйлчилгээний "Ажилчин" хоршооны оёдолчин
35. Хандсүрэнгийн Төмөрбаатар	- Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн дарга
36. Гэндэнгийн Төмөрт	- Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөө аж ахуйн газрын дарга
37. Марлийн Туваан	- Ховд аймгийн Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын ус түгээгч
38. Бямба-Очирын Тунгалаг	- Хөвсгөл аймгийн Тариалан сумын дунд сургуулийн биологийн багш
39. Чулууны Туяа	- Монголын менежментийн холбооны менежер
40. Аюушийн Хасаг	- Орхон аймгийн даатгалын салбарын захирал
41. Цогбадрахын Цогдорж	- Нийслэлийн "Авто тээвэр-Тав" ХК-ийн жолооч
42. Жамсрангийн Цогмягмар	- Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг даргын тамгын газрын татварын улсын байцаагч
43. Банзрагчийн Цэвээнжалба	- Нийслэлийн "Мандалинтернэшнл" ХХК-ийн цахилгааны инженер
44. Мэнэрэлийн Чимидцэвэ	- Монголын Энх тайван, найрамдлын байгуллагуудын холбооны ерөнхий нягтлан бодогч
45. Хандмаагийн Шоовдор	- Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч
46. Батаагийн Шура	- МАХН-ын Удирдах зөвлөлийн улс төрийн хэлтэст улс төрийн ажилтан
47. Даанайн Энхтуяа	- Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
48. Занданбалын Явандуулдах	- Завхан аймгийн Цагаанчулуут сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Мятавгочоогийн Аюуш	- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч
2. Ёндонгийн Батбаяр	- Хөвсгөл аймгийн Гал унтраах ангийн гал сөнөөгч
3. Цэрэндагвын Ноовыч	- Ховд аймгийн Хорих ангийн ээлжийн дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Дугаар 89 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

"Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 36 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. "Прокурорт зэрэг дэв олгох дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлагдсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 80 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 89 дүгээр зарлигийн хавсралт

ПРОКУРОРТ ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Прокурорт зэрэг дэв олгох дүрэм нь прокурорт зэрэг дэв олгох, хүчингүй болсонд тооцох журмыг тогтооно.

1.2. Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу прокурор нь төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх, хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөх зэрэг дэвтэй байна.

1.3. Прокурорт зэрэг дэв олгохдоо албан тушаалын ангиллыг дараахь байдлаар харгалзана:

Зэрэг дэв	Албан тушаал
Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурор
Төрийн хууль цаазын шадар зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч
Хууль цаазын итгэмжит зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, аймаг, нийслэл, тэсвэрийн прокурор
Хууль цаазын ахлах зөвлөх	Монгол Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, аймаг, нийслэл, тэсвэрийн прокурорын орлогч, туслах прокурор, сум, сум дундын ахлах прокурор, дүүргийн прокурор
Хууль цаазын зөвлөх	Аймаг, нийслэл, тэсвэр, сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор

Хоёр. Прокурорт зэрэг дэв олгох, хүчингүй болсонд тооцох

2.1. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч, бусад зэрэг дэвийг аймаг, нийслэл, тэсвэрийн прокурорын санал болгосноор Монгол Улсын Ерөнхий прокурор олгоно.

2.2. Прокурорт зэрэг дэв олгохдоо албан тушаалын ангилал, прокуророоор ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзана.

Зэрэг дэв	Зэрэг дэв олгоход харгалзах үзүүлэлтүүд		
	Прокуророор ажилласан хугацаа	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар	Ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдал
Хууль цаазын итгэмжит зөвлөх	5 жилээс доошгүй	Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр хангалттай үнэлгээ авсан	Сахилгын шийтгэл хүлээгээгүй буюу хүлээсэн боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан
Хууль цаазын ахлах зөвлөх	3 жилээс доошгүй		
Хууль цаазын зөвлөх	1 жилээс доошгүй		

2.3. Хууль хамгаалах байгууллагад урьд нь мэргэжлээрээ ажиллаж байсан хүн прокуророор томилогдвол түүний ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг харгалзан тухайн тушаалын зэрэг дэвийг олгож болно.

2.4. Прокурорын албан тушаалын ангиллыг дээшлүүлэх, эсхүл бууруулах тохиолдолд урьд нь олгосон зэрэг дэвийг өөрчилж, шинээр томилогдсон албан тушаалын ангиллын зэрэг эзэвийг олгоно.

2.5. Онцгүй үр бүтээл гарган ажилласан прокурорт эрхэлж буй албан тушаалд нь тохирох зэрэг дэвийг зохих хугацаанаас өмнө олгох буюу нэг шат дээгүүр зэрэг дэв олгож болно.

2.6. Прокурорын албан тушаалд ажиллаж байгаад өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон, биеийн эрүүл мэндийн байдлын улмаас прокурорын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн хүн дахин прокуророор томилогдсон тохиолдолд прокурорын тухайн аблан тушаалын ангиллын зэрэг дэвийг олгож болно.

2.7. Прокурор өөр ажил, албан тушаалд шилжин ажилласан, хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын албан тушаалаас халагдсан, чөлөөлөгдсөн бол прокурорын зэрэг дэв хүчингүй болсонд тооцогдоно.

2.8. Зэрэг дэв олгох хугацаа болсон, уул зэрэг дэв нь тухайн прокурорын албан тушаалын ангилалд тохирч байгаа боловч мэргэшлийн түвшин хангалттүй, прокурорын ёс зүйн хэм хэмжээг удаа дараа зөрчсөн тохиолдолд зэрэг дэвийг олгохгүй байж болно.

2.9. Ажлаас халахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан тохиолдолд прокурорын зэрэг дэвийг бууруулж болно.

2.10. Энэ дүрэмд зааснаас бусад тохиолдолд прокурорт олгосон зрэг дэвийг бууруулах буюу хүчингүй болгохгүй.

2.11. Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр зэрэг дэв олгосон шийдвэр гарсан өдрөөс эхлэн сар бүр олгоно.

2.12. Тэтгэвэрт гарсан прокурор түр хугацаагаар ажиллаж байгаа тохиолдолд түүнд урьд нь олгосон зэрэг дэвийн нэмэгдлийг олгож болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 29–ний өдөр **Дугаар 91** **Улаанбаатар хот**

В.И.Тужилкин, Л.И. Пучкова нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын боловсролын салбарын хамтын ажиллагаат хөгжүүлэх, манай улсын хүнсний аж үйлдвэрийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Москва хотын Хүнсний үйлдвэрлэлийн их сургуулийн захирал Вячеслав Иванович Тужилкин, тус сургуулийн тэнхмийн эрхлэгч Любовь Ивановна Пучкова нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 11 дүгээр сарын 30–ны өдөр **Дугаар 92** **Улаанбаатар хот**

"Цэргийн цол олгох журам"-ын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигийн хавсралт "Цэргийн цол олгох журам"-ын "Хоёр" дахь хэсгийн 2 дахь заалтыг "Зэвсэгт хүчин, бусад цэргийн ахлагчийн анхны, офицерын "хурандаа"-гаас бусад цолыг Зэвсэгт

хүчний Ерөнхий штабын дарга, Хилийн цэргийг Удирдах газрын дарга, Дотоодын цэргийн дарга олгоно.", 14 дэх заалтыг "... цол олгох хоорондын хугацаа нь гурван жилээс доошгүй байна.", 15 дахь заалтыг "... дунд офицерт 3 жил, ахлах офицерт 4 жил ..." гэж тус тус найруулсугай.

2. Мөн журмын "Хоёр" дахь хэсгийн 1 дэх заалтыг хүчингүйд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 95 Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь :

Бямбаагийн Тунгалагсайханыг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 96 Улаанбаатар хот

Шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2,4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Бямбаагийн Тунгалагсайханыг Архангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Түндэвийн Даваасүрэнг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн, Нэргүйн Батчимэгийг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Тамжид-Ёндонгийн Батсайханыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Бямбаагийн Тунгалагсайханыг Архангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 50 (237)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай*
- *Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны гишүүнийг томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Нийслэлийн нийтийн тээврээр цнэгүй зорчих явдлыг журамлах тухай*
- *Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны арванхоёрдугаар сарын 27 №50 (237)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

652.Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-12-6-ны хууль) 1189

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

653. Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай Дугаар 97 1192
654. Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны гишүүнийг томилох тухай Дугаар 98 1192

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

655. Хөтөлбөр шинэчлэн батлах тухай Дугаар 248 1193
656. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 256 1200
657. Нийслэлийн нийтийн тээврээр үнэгүй зорчих явдлыг журамлах тухай Дугаар 259 1207
658. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох тухай Дугаар 261 1207
659. Нэрэмжит болгох тухай Дугаар 262 1208

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3.1.23, 3.1.24, 3.1.25, 3.1.26 дахь заалт:

"3.1.23. "агаарын тээвэрлэгч" гэж агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үндсэн дээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.24. "агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ" гэж агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгож буй тусгай зөвшөөрөл;

3.1.25. "нисэх баг" гэж нислэгийн хугацаанд агаарын хөлгийн ажуулгуй ажиллагааг хангах хариуцлага хүлээсэн, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй агаарын хөлгийн багийн гишүүд;

3.1.26. "агаарын хөлгийн зорчигч" гэж агаарын хөлгөөр зорчихоор агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан этгээд."

2/ 4.1.4 дэх заалт:

"4.1.4. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа гадаад улсын агаарын хөлгийн үйл ажиллагаа."

3/ 7.1.11, 7.1.12 дахь заалт:

"7.1.11. иргэний нисэхийн салбарт олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг тогтоох, нислэгийн шугамыг хуваарилах, агаарын тээвэрлэлтийн эрх олгох, тарифыг батлагаажуулах, агаарын хөлгийг хамтран эзэмших буюу түрээслэхтэй холбогдсон асуудлыг зохицуулах;

7.1.12. нислэг-техникийн осол, зөрчлийн Ерөнхий шинжээч /цаашид "Ерөнхий шинжээч" гэх/, шинжээчийг томилж чөлөөлөх, Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийг батлах;"

4/ 8.4.7 дахь заалт:

"8.4.7. нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан дүгнэлтийг үндэслэн цаашид осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;"

5/ 8.7 дахь хэсэг:

"8.7. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба бие даан хэрэгжүүлэх бөгөөд албаны дарга нь Улсын ерөнхий байцаагч байна."

6/ 39^{1}, 39^{2}, 39^{3}, 39^{4} дүгээр зүйл:

"39^{1} дүгээр зүйл. Нисэхийн ажилтны мэргэжлийн үнэмлэх

39^{1}.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгоно. Үнэмлэх, гэрчилгээ олгох журмыг Иргэний нисэхийн багц дүрмээр тогтооно.

39^{2} дугаар зүйл. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ

39^{2}.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсад бүртгэлтэй иргэний агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно. Гэрчилгээнд тухайн агаарын хөлгийн ашиглалтын төрөл, гэрчилгээний хугацаа болон аюулгүй ажиллагаанд шаардлагатай бусад нөхцөл, хязгаарлалт, мэдээлэл зэргийг тусгана.

39^{3} дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ

39^{3}.1. Энэ хуулийн 13.1.1-д заасан агаарын хөлгөөр арилжаалуй нислэгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага энэ хууль болон холбогдох дүрэм, журмын шаардлагыг хангасан тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно.

39^{4} дүгээр зүйл. Агаарын тээвэрлэгчийн үүрэг

39^{4}.1. Агаарын тээвэрлэгч нь нислэгийн үйл ажиллагааны болон агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын шаардлагад нийцсэн заавар, журам боловсруулж мөрдөх, холбогдох дүрэм, журмын дагуу нийтийн ашиг сонирхолд нийцсэн, найдвартай үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй."

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 3.1.22 дахь заалтын "конвенци" гэсний дараа "болон түүний Хавсралтууд", 24.1 дэх хэсгийн "үйлчилгээг" гэсний дараа "иргэний нисэхийн", 34.1, 38.1 дэх хэсгийн "Тээвэрлэгч" гэсний өмнө "Агаарын", 43.2.1 дэх заалтын "үнэн зөвөөр" гэсний дараа "шалган", 43.2.2 дахь заалтын "Нислэг-техникийн" гэсний өмнө "Чикагогийн конвенцийн 13 дугаар Хавсралт болон", 44.1.2 дахь заалтын "байдлын" гэсний дараа "болон аюулгүй ажиллагааны" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1.1. дэх хэсэг:

"1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

2/ 3.1.4, 3.1.15, 3.1.20 дахь заалт:

"3.1.4. "агаарын хөлөг" гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмж;"

"3.1.15. "нислэгт тэнцэх чадвар" гэж агаарын хөлөг, түүний эд ангиуд нь тэдгээрт тавих аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж байгаа байдал;"

"3.1.20. "олон улсын нислэг" гэж хоёр буюу түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэг; "

3/ 7.1.3, 7.1.4 дэх заалт:

"7.1.3. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зам, агаарын хаалгыг тогтоох, олон улсын нислэгийн чиглэлийг нээх, хаах;

7.1.4. олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авах;"

4/ 7.2. дахь хэсэг:

"7.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.12-т зааснаас бусад бүрэн эрхээ бүхэлд нь буюу заримыг Иргэний нисэхийн ерөнхий газарт шилжүүлж болно."

5/ 8.1, 8.2, 8.3 дахь хэсэг:

"8.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

8.2. Иргэний нисэхийн ерөнхий газар үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулахад чиглүүлнэ.

8.3. Иргэний нисэхийн ерөнхий газрын нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч тусгай дүрэмт хувцас хэрэглэнэ."

6/ 8.4.1 дэх заалт:

"8.4.1. Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцсэн аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;"

7/ 9.1 дэх хэсэг:

"9.1. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нь дараахь бүрэн эрхтэй:"

8/ 13 дугаар зүйл:

"13 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэхэд олгох тусгай зөвшөөрөл

13.1. Иргэн, аж ахуйн нэгж иргэний нисэхийн дараахь үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл авна:

13.1.1. агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх;

13.1.2. аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх;

13.1.3. агаарын хөлгийн засвар, үйлчилгээ хийх.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан тусгай зөвшөөрлийг Иргэний нисэхийн ерөнхий газар Иргэний нисэхийн багц дүрмийн дагуу олгоно."

9/ 14.1, 14.2 дахь хэсэг:

"14.1. Иргэний нисэхэд ашиглах техник, технологийн баримт бичгийг англи, орос хэл дээр хэрэглэж болно.

14.2. Монгол Улсын агаарын зайд нислэгийг англи хэл дээр удирдаж болно. "

10/ 20.2 дахь хэсэг:

"20.2. Аюулгүйн бүсийн нутаг дэвсгэрийн ашиглалттай холбогдсон асуудлыг Иргэний нисэхийн багц дүрмээр зохицуулна."

11/ 24.2 дахь хэсэг:

"24.2. Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийн хоорондын аюулгүйн зай, агаарын зам, түүний өргөн, өндөр нь олон улсын стандартад нийцсэн байна."

12/ 24.4 дэх хэсэг:

"24.4. Монгол Улсын хил нэвтэрч нислэг үйлдэх зөвшөөрлийг иргэний нисэхийн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас авна."

13/ 40.1 дэх хэсэг:

"40.1. Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах, агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигчийн бие болон тээшинд агаарын тээвэрлэгч буюу эрх бүхий байгууллага иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан журмын дагуу үзлэг хийнэ."

14/ 42.2 дахь хэсэг:

"42.2. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжээч удирдана."

15/ 43.3.1 дэх заалт:

"43.3.1. нислэг-техникийн осол, зөрчил гарсан газарт саадгүй нэвтрэх, осол, зөрчлийн газрыг хамгаалах арга хэмжээ авах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх".

4 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 3.1.5, 3.1.7 дахь заалт, 18.1, 20.1, 22.1, 28.1 дэх хэсгийн "байдлыг" гэснийг "ажиллагаа", 3.1.8 дахь заалтын "байдалд" гэснийг "ажиллагаанд", 9 дүгээр зүйлийн гарчигт "байдлын" гэснийг "ажиллагааны", 3.1.13 дахь заалтын "нислэгийн аюулгүй байдал" гэснийг "нисэхийн аюулгүй ажиллагаа", 8.4.5 дахь заалтын "нислэгийн аюулгүй байдлыг" гэснийг "нисэхийн аюулгүй ажиллагаа", 8.5 дахь хэсгийн "нислэгийн аюулгүй байдалд" гэснийг "нисэхийн аюулгүй ажиллагаанд", 41.1, 42.1, 42.5, 42.6 дахь хэсгийн "хэрэг" гэснийг "осол, зөрчил", Есдүгээр булгийн гарчиг, 42 дугаар зүйлийн гарчиг, 42.1, 42.5, 42.6 дахь хэсэг, 43.2.2 дахь заалтын "хэргийг" гэснийг "осол, зөрчлийг", 41 дүгээр зүйлийн гарчиг, 42.1, 42.4 дэх хэсэг, 43.2.1 дахь заалтын "хэргийн" гэснийг "осол, зөрчлийн", 42.3, 42.4 дэх хэсгийн "Улсын ерөнхий байцаагч" гэснийг "Ерөнхий шинжээч", 43.2, 43.3 дахь хэсгийн "хэргийг шинжлэн шалгах улсын байцаагч" гэснийг "осол, зөрчлийн шинжээч", 6.1.2 дахь заалтын "захирлыг" гэснийг "дарга болон Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын Улсын ерөнхий байцаагчийг", 3.1.11 дэх заалтын "атмосферын" гэснийг "хийн мандлын", 8.4.6 дахь заалтын "бүтцэд" гэснийг "бүтэц, үйл ажиллагаанд", 11.2 дахь хэсгийн "харилцаа" гэснийг "үйл ажиллагаа", 15 дугаар зүйлийн гарчигийг "Иргэний агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар", 20 дугаар зүйлийн гарчигийг "Аэродром орчмын аюулгүйн бүс", 40 дүгээр зүйлийн гарчигт "Зорчигчийн" гэсний өмнө "Агаарын хөлгийн баг", Наймдугаар булгийн нэрийг "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны зохицуулалт", 44.1.6 дахь заалтын "хориотой" гэснийг "хамгаалагдсан" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.10 дахь заалтын "хэрэглэх журмыг", 17 дугаар зүйлийн гарчигт "зорчигч", 24.6 дахь хэсгийн "таслан", 43.3.4 дэх заалтын "энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд" гэснийг болон 6.1.3, 6.1.5, 6.1.6, 7.1.2, 7.1.5, 7.1.6, 8.4.2 дахь заалт, 17.6, 43.1 дэх хэсэг, 43.2.4 дэх заалтыг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 27 дугаар зүйл, 32 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 97** **Улаанбаатар хот**

Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Гунгаадорж, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Баяртсайхан, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Шаравдорж, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Т.Очирхүү нарыг тус тус батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 98** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны гишүүнийг томилох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Түдэвийн Билэгтийг Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 10 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 248 | Улаанбаатар хот

Хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор шинэчлэн батлсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 122 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоолын хавсралт

ОЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Ой, модны салбарын өнөөгийн байдал

Манай орны ой нь Төв Азийн хээр цөл, зүүн Сибирийн их тайгын зааг дээр дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг дагаж үргасан бөгөөд гол мөрний усыг зохицуулах, цуглуулах, хөрсийг элэгдэл, эвдэрлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамлын амьдрах орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах хамгаалалтын өндөр ач холбогдолтой экэзэг тогтоцтой экосистем юм.

2000 оны байдлаар манай улсын ойн сангийн талбай нь 18.3 сая га, үүнээс ой модоор бүрхэгдсэн талбай нь 12,9 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 8,2 хувь бөгөөд заган ой, сөөг, торлогийг оруулахгүйгээр шилмүүст, навчит ойн талбай нь 10,5 сая га буюу 6.7 хувь байгаа нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан жишгээр ойн нөөцөөр хомс орны тоонд хамрагдаг байна. Манай ойн нөөцийн хэмжээ 1,4 тэрбум гаруй шоометр, түүний жилийн дундаж өсөлт 12.0 сая шоометр бөгөөд ойн нөөцийн 58 хувь нь оңцгой болон хамгаалалтын бүсийн ойд хамрагдаг байна.

Судалгаанаас үзэхэд 1940-2000 онд 43,8 сая шоометр модыг 320 гаруй мянган га газраас огтолж ашигласнаас гадна 1980 оноос хойш жилд дундажаар түймэрт 392.5 мянган га, хөнөөлт шавьж, өвчинд 101.1 мянган га талбайн ой тус тус өртсөн байна. Зөвхөн 1996-1997 онд 5.0 сая га талбайн ой түймэрт өртсөний дотор 500 гаруй мянган га талбайн ой түймэрт хүчтэй шатаж сэргэн ургах чадваргүй болжээ. Үүнээс үндэслэн ойтой талбайн деревний нэг нь мод бэлтгэл, түймэр, хөнөөлт шавьж, өвчин зэрэг гадны хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тооцоо гарч байгаа юм.

Ойн тухай, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай, Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, Зарим барааны ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуулийг 1995-2000 онд тус тус батлан гаргаж хэрэжүүлж байгаа боловч эдийн засгийн шилжилтийн үед ойн салбарын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, өмч хувьчлалыг оновчтой хийж чадаагүйгээс төв, орон нутагт ойн удирдлага, менежментийн тогтолцоо алдагдаж, энэ талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд дорвитой ахиц гарахгүй байна.

Ойн тухай хуульд ой зохион байгуулалтын ажлыг 10 жилийн давтамжтайгаар явуулж байхаар заасан боловч одоогийн хүчин чадлаар тооцвол 23 жилийн давтамжтайгаар ой зохион байгуулалт хийх боломжтой байна.

Сүүлийн жилүүдэд ойд хийх арчилгааны хэмжээ багасч, жилд дунджаар 500 га талбайгаас хэтрэхгүй байна. Харин ойн цэвэрлэгээг жилд дунджаар 1000 га талбайд явуулж, гарсан модыг төрөл бүрийн модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, иргэдийн түлшний хэрэгцээг хангахад ашиглаж ирсэн болно.

1971 оноос ойг нөхөн сэргээх ажлыг төвлөрсөн төлөвлөгөөгөр зохицуулж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацааны 88.7 мянган га талбайг ойжуулсан нь мод бэлтгэсэн талбайн 30 хүрэхгүй хувьтай тэнцэж байна. 1980-2000 онд жилд дунджаар 3,9 мянган га, 1996-1999 онд 4.6 мянган га, 2000 онд 9.0 мянган талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажил хийсэн байна. Гэвч хөрөнгийн эх үүсвэргүйгээс тарьц, суулгац ургуулах, цөлжилт, хөрсний элэгдэлтэй тэмцэх арга хэмжээ үлэмж хоцрогдож байна.

Мөн хугацаанд Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Ховд аймгийн зарим сумдад тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах, Говь-Алтай, Өмнөговь аймгийн зарим сумдад цөлжилт, хөрсний элэгдэл, эвдрэлтэй тэмцэх зорилгоор тал, хээр, говийн бүсэд мод, сөөг тарьж ургуулах ажлыг хийж ирсэн.

Одоогоор жилд дунджаар 700.0 мянга гаруй шоометр мод бэлтгэн ашиглаж мод, модон бүтээгдэхүүн, түлшний дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ гадаадын зах зээлд цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнийг бага хэмжээгээр нийлүүлж байгаа боловч мод бэлтгэх, боловсруулах чиглэлийн аж ахуйн нэгжүүдийн зориулалтын машин механизм, тоног төхөөрөмж хуучирч, үйлдвэрлэлийн технологи алдагдсанаас тэдгээрийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна. Үүний улмаас ой, модны салбар нь 1989 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 4.7 орчим хувийг эзэлж байсан бол 1998 онд 0.25 хувь болтол буурав. Манай оронд зам харилцаа, цахилгаан хангамж зэрэг дэд бүтцийн хөгжил сул байгаа нь ойг хамгаалах, зохистой ашиглах, улмаар нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учруулж, өртөг зардал өндөрсөж, үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлж байгаль орчин, ойн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтуудыг, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход оршино.

Хөтөлбөрийн зорилт нь:

Нэг. Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хохирлыг арилгах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, ойн үр өгөөжийг дээшлүүлэх, ойг хамгаалах ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх;

Хоёр. Орчин үеийн техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх, ой модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг сайжруулах, мод, модон бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

Гурав. Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбайг эхний ээлжинд ойжуулж, тал хээр, говь, цөлд хамгаалалтын ойн зурвас, төгөл, ногоон хаалт байгуулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх;

Дөрөв. Ой, модны салбарын менежмент, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

Тав. Ойн салбарт шинжлэх ухаан, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

1.Хөтөлбөрийг дараахь хугацаанд хэрэгжүүлнэ:

- 1 дүгээр үе 2005 он хүртэл;

- 2 дугаар үе 2006-2010 он;

- 3 дугаар үе 2011-2015 он.

2.Ойн үндэсний хөтөлберийн дагуу аймаг, нийслэл бүр өөрийн онцлогт тохирсон дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

1. Ойн талбайн өөрчлөлтийг санспаас тандан судлах газар зүйн мэдээллийн системийг ашиглан ойн зураг үйлдэх техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ. Ойн том масштабын гэрэл зургийг ашиглан таксацын үзүүлэлтийг тогтоох, дээж талбай дээр шалгаж засварлах аргаар ой зохион байгуулалтын ажлын 20-иос доошгүй хувийг гүйцэтгэдэг болно.

2. Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаат дэмжиж, ой зохион байгуулалтын ажлын хүчин чадлыг 1,5-2,0 дахин нэмэгдүүлнэ.

3. Модны өсөлт, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээг ойн мэргэжлийн болон ойн санг гэрээгээр аэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад түшиглэн ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, залуучуудыг өргөн хамруулах замаар гүйцэтгэнэ.

4. Түймрээс сэргийлэх, түүнтэй тэмцэх төлөвлөгөөг аймаг, сумын хэмжээнд боловсруулан түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.

5. Улсын хилийн бүс, зарим шаардлагатай газруудад түймрээс хамгаалах харлуулсан зурвас татах, түймрийн эсрэг ойн зааг гаргах ажлыг зохион байгуулах зэргээр түймрийн тархалтаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6. Санспаас тандан судлах, агаарын харуул гаргах, ой бүхий аймаг, сумдад улирлын урамшилтай эргүүл ажиллуулах замаар гарсан түймрийг шуурхай илрүүлэх арга хэмжээ авч, түймэр унтраах бүлгийг зохион байгуулна.

7. Ой бүхий аймаг, Улаанбаатар хот дахь байгалийн гамшиг, гал түймэртэй тэмцэх нэгжийг холбооны болон түймэр унтраах техник, багаж хэрэгслээр хангана.

8. Үүлэнд нөлөөлж, зориудаар хур тунадас оруулах ажлыг өргөтгөх замаар түймрээс сэргийлэх, гарсан түймрийг хохирол багатай унтраах арга хэмжээ авна.

9. Ойн хөнөөлт шавьж, өвчний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, хөнөөлт шавьжийн тархалт, олшролтын магадлал, төлвийг нарийвчлан тогтоож урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

10. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх хэсэг, судалгааны лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчилж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах арга хэмжээ авна.

11. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй биологийн болон байгальд халгүй бусад аргаар тэмцэх ажлыг өргөжүүлж, шаардлагатай бодис бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэх ажлыг зохион байгуулна.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

1. Жилд бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг тухайн ойн даацтай нь уялдуулан аймаг, сум тус бүрээр тогтоож мөрдөнө.

2. Мод бэлтгэх талбайг тусгаарлах, тухайн ойн онцлог байдалд тохирсон мод бэлтгэлийн технологийг мөрдүүлэх ажлын үр өгөөжийг дээшлүүлж, мод бэлтгэсэн талбайн байгалийн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Мод бэлтгэл, ойн нөхөн сэргээлт, хамгаалалтыг хослуулан ажиллах чадвар, техник технологи бүхий аж ахуйн нэгж, байгууллагад ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд шилжинэ.

4. Ашиглалтын насанд хүрээгүй мод огтлох үйл ажиллагааг таслан зогсооно.

5. Заган ойг хамгаалах зорилгоор говь, цөлийн бүсийн зарим аймаг, сумдын тулшний хэрэгцээг хангайн бүсээс ойн цэвэрлэгээний

журмаар бэлтгэсэн модоор хангаж, түүний тээврийн зардлыг улсын төвлөрсөн тесөвт тусгаж санхүүжүүлэх журамд шилжинэ. Дээрх бүс нутагт түлшний мод, өргөн хэрэглээний модон эдлэл борлуулах бөөний цэгүүдийг байгуулж ажиллуулна.

6. Түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, модны ашиглалтыг сайжруулах, аялал жуулчлал, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг олон талын ач холбогдлыг харгалзан ойн зам барьж байгуулах ажлыг төр, засгийн оролцоо, дэмжлэг, гадаадын хөрөнгө оруулалтаар байнга гүйцэтгэнэ.

7. Мод, модон түүхий эдийн экспортыг хязгаарлах, импортыг дэмжих бодлого баримтална.

8. Төмөр замын дэрийг модноос өөр материалаар орлуулах арга хэмжээг шийдвэрлэнэ.

9. Модны шилмүүс, үзүүр мөчир, гишүү, үртэс, холтос, зах, тайрдас, тавааргаг чанар муутай модыг механик болон химийн аргаар гүнзгий боловсруулж ашиглах судалгаа хийж, гадаад, дотоодын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх арга хэмжээ авна.

10. Модны шилмүүснээс эфирийн тос, витаминт нунтаг, эмчилгээнийханд болон шинэс, нарс модноос давирхай олборлон канифол, скипидар, хус модноос нүүрс гарган авах үйлдвэрлэлийг ой модны үйлдвэрийг түшиглэн байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.

11. Хус модыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, хусан зүймэл шал, барилгын модон хийц, эдлэлийг үйлдвэрлэх техник технологийг шинээр болон үйлдвэрлэлийн хуучин баазыг түшиглэн нэвтрүүлэх санаачилгыг дэмжинэ.

12. Мебель, модон эдлэлийн үйлдвэрлэлийг шинэчлэх, шинээр байгуулах замаар зах зээлд өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжиж, экспортын модон бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

13. Наамал болон шахмал хавтан, фанер, мебелийн хуулга үйлдвэрлэх дэвшилтэт технологи бүхий үйлдвэр шинээр байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ.

14. Хөдөөгийн малчид, иргэдийн өргөн хэрэгцээний модон эдлэл, гэрийн мод үйлдвэрлэх уламжлалт аргыг орчин үеийн технологитой хослуулан, төв, орон нутагт жижиг, дунд үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

15. Ашиглах боломжтой ойн дагалт баялгийн нэр төрөл, нөөцийг тогтоож, тэдгээрийн байршил, түүх ашиглах хугацааг бүс нутгаар гаргаж мөрдүүлнэ.

16. Самар, жимс, мөөг, эмийн ургамал зэрэг ойн дагалт баялгийг бэлтгэж ашиглах заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулж мөрдүүлнэ.

17. Ойн дагалт баялгийг бэлтгэж, боловсруулах ажлыг өргөжүүлэх, нэр төрлийг олшруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

1. Ой үргамалжилтын мужуудад селекцийн үнэлгээ хийж, үрийн хэсгийг тусгаарлаж мод, сөөгний үр бэлтгэх ажлын хэмжээг нэмэгдүүлж, зонхилох модны сайн чанарын үрийн байгууламжийн сан бий болгоно.

2. Үрийн лабораторийн тоног төхөөрөмж,багаж хэрэгслийг шинэчилж, зөвхөн стандартад тэнцсэн үрээр тарьц суулгац үргуулах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэнэ.

3. Сор, шилмэл модыг сонгон авч ойн үрийн плантаци байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4. Ойжуулах болон бэлчээр, тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэл, цөлжилтөөс хамгаалах ойн зурвас байгуулах, хот цэцэрлэгжүүлэлтэд шаардагдах тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрууд байгуулахыг дэмжиж, санхүүгийн туслапцаа үзүүлнэ.

5. Модны үр, боргоцой бэлтгэх, тарьц, суулгац бойжуулах, ойг тарьж ургуулах ажилд нутгийн иргэд, сурагчид, залуучууд, олон нийтийг өргөн оролцуулж, ойг нөхөн сэргээх ажлыг жилд 10.0 мянгаас доошгүй га талбайд гүйцэтгэнэ.

6. Үр, боргоцой бэлтгэх, тарьц, суулгац бойжуулах ажлыг механикжуулах, энгийн гар багаж, техник хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

7. Мод үржүүлэг, ойжуулалтын ажлын техник, технологийг боловсронгуй болгож энгийн, бага оврын техник хэрэгслээр хангана.

8. Ойг байгалийн аясаар болон зориудаар нөхөн сэргээх хялбар, өгөөжтэй арга технологийг ой ургамалжилтын муж, бүс нутгийн онцлогт тохируулан ялгавартай тогтоож, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

9. Ойг нөхөн сэргээх ажлыг зураг төслийн дагуу хийж, ойжуулалтын ажил явуулах, түүний үр дүнг тооцох, хүлээн авах, улсын ойн санд шилжүүлэх, санхүүжүүлэх, урамшуулах журмыг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

10. Ойг нөхөн сэргээх, говь, тал, хээрийг ойжуулахад шаардагдах үр, тарьц, суулгацын хэмжээ, үр, боргоцой бэлтгэх, тарьц, суулгац бойжуулах, ойг тарьж ургуулах ажлын норм, үнэлгээ, зардлын хэмжээг шинэчлэн тогтооно.

11. Жил тутам Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтаж бүх нийтээр мод тарих 10 хоногийн хөдөлгөөнийг аймаг, сум бүрээр зохион байгуулна.

12. Ойг тарьж ургуулах, нөхөн тарилт хийх, арчлан хамгаалах, ойн санд шилжүүлэх ажлын тасралтгүй ажиллагаа хангаж, ойжуулалтын ажлын бүртгэл, тооцоог сайжруулна.

13. Цөлжилттэй тэмцэх, тариалангийн талбайн хөрс, бэлчээрийг хамгаалах зорилгоор ойн зурвас, төгөл байгуулах ажлыг бүх талаар дэмжиж, урамшуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

14.Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ойн санг тэдгээрт өмчлүүлнэ.

15.Хот, суурин газар болон түүний дэвсгэр нутагт шинээр баригдах барилгын газрын зөвшөөрөл олгохдоо барилгын орчны талбайг цэцэрлэгжүүлэх асуудлыг төлөвлүүлж хэрэгжүүлдэг журамд шилжинэ.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

1. Ойн нөөц бүхий аймаг болон нийслэлийг орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үүрэг бүхий ой, модны асуудал хариуцсан албатай болгоно.

2. Орон нутаг дахь мэргэжлийн байгууллагыг өмчийн бүх хэлбэрээр зохион байгуулна.

3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаан дахь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогын хэрэгжилтийн асуудлыг уялдуулан зохицуулах тогтолцоог боловсронгуй болгон хэвшүүлнэ.

4. Төрийн бус байгууллагатай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага гэрээ байгуулсны үндсэн дээр ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг төсвийн болон өөрийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх хэмжээг нэмэгдүүлнэ. Төрийн бус байгууллагуудыг ой, модны чиглэлээрхи үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, техник, технологи, бизнесийн мэдээллээр хангах, төсөл боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд оролцуулна.

5. Иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж аж ахуйн нэгжийн хэлбэрээр ойн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах хөдөлгөөнийг дэмжинэ.

Тавдугаар зорилтын хүрээнд:

1. Ойн холбогдолтой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн хүрээнд шинэчлэлт хийж, хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлнэ.

2. Ойн баялгийн ач холбогдол, ойн талаар гарсан хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сурталчлах ажлыг өргөнөөр зохион байгуулна.

3. Ойн хууль тогтоомж, ойн тооллого бүртгэл, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх ажлын талаар нутгийн захиргааны удирдлагуудад тодорхой мэдлэг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

4. Ойн экосистемийн өөрчлөлт, түүний тэнцвэрт байдлыг хангах, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх дэвшилтэт техник, технологи эзэмших шинжлэх ухааны үндэслэл боловсруулах судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.

5. Тал, хээрийн бүс, цөл, цөлийн хээрт бэлчээр, тариалангийн талбайг хөрсний элэгдэл, цөлжилтөөс хамгаалах бэлчээрийн болон хөдөө аж ахуйн таримал ургамлын ургацыг нэмэгдүүлэх зорилго бүхий ойн зурвас, төгөл, ногоон хаалт ургуулахад ашиглах модны төрөл зүйл, бүрдлийг сонгож, тэдгээрийг тарьж ургуулах агротехник, технологийг боловсруулна.

6. Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн менежментийг хөгжүүлэх, ойтой нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, ойн хөрс, ус хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар судалгаа явуулж үр дүнг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

7. Мод боловсруулах үйлдвэрлэлээс гарах хаягдал, өөдсийг ашиглах, түүхий эдийг гүнзгий боловсруулах, өргөн хэрэглээний мебель, модон эдлэл үйлдвэрлэх технологи боловсруулах, ойн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн туршилт судалгаа явуулна.

8. Ойн аж ахуй, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн шинжлэх ухааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

9. Ойн салбарын мэдээ, мэдээллийн боловсронгуй тогтолцоог бий болгож, чадавхийг дээшлүүлнэ.

10.Ойн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг үндэсний дээд, тусгай мэргэжлийн сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэн өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

11. Ойн салбарт ажиллаж байгаа болон бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчнийг дотоод, гадаадын урт, богино хугацааны сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна;

12. Ой, модны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг гардан гүйцэтгэх менежер, мэргэжлийн ажилчин бэлтгэх, давтан сургах ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

13. Хил дамжсан түүмрээс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хөрш орнуудтай Засгийн газар хооронд гэрээ байгуулж хамтран ажиллана.

14. Хөтөлберийн хүрээнд гадаад орон, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж ажиллана.

Тав. Хөтөлберийн үр дүн

1. Ой, модны салбарын менежмент, бүтэц зохион байгуулалт сайжирч, эрх зүй, эдийн засгийн нэгдсэн тогтолцоо бий болж, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд чанарын ахиц гарч, байгаль орчин-хөгжлийн тогтвортой үр дүнд хүрнэ.

2. Ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгах нөхцөл бүрдэнэ.

3. Ой зохион байгуулалтыг 10 жилийн давтамжтайгаар явуулж, ойн нөөц, бусад дагалт баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ.

4. Огтолсон модны ашиглалтын түвшин дээшилж, бүтээгдэхүүний чанар, нэр төрөл нэмэгдэнэ.

5. Дотоодын мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай модон бүтээгдэхүүн экспортлоно.

6. Ойн дагалт баялгийн ашиглалтыг сайжруулах замаар хүн амын хүнсний хангамж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

7. Ойн салбарын үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоо, идэвхи санаачилга дээшилж, ажлын байр бий болж өрхийн орлого нэмэгдэнэ.

8. Мод, сөөгний үрийн улсын байнгын нөөцтэй болж, ойжуулалтад шаардагдах тарьц, суулгацын хэрэгцээг бүрэн хангана.

9. Шинээр мод бэлтгэсэн талбайг бүрэн ойжуулахын хамт өмнөх жилүүдэд модыг нь огтолсон болон хөнөөлт шавьж, өвчин, түймэрт нэрвэгдсэн талбайн 15 хүртэл хувийг сэргээн ойжуулна.

10. Бэлчээр, тариалангийн талбайг хөрсний элэгдлээс хамгаалах, ургац нэмэгдүүлэх, цөлжилтийг саруулах экологи, нийгэм, эдийн засгийн тааламжтай нөхцөл бүрэлдэнэ.

Зургаа.Санхүүжилт

Хөтөлберт тусгагдсан арга хэмжээний санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

1. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

2. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хуульд заасан орлогын зохих хувь хэмжээ;

3. Аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

5 Ой, модны чиглэлийн бизнесийн байгууллага, хувь хүмүүсийн хуримтлал;

6. Гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс хэрэгжүүлэх төсөл, өгч буй тусламж, дэмжлэг, хандивын хөрөнгө;

7. Гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгө;

8. Ядуурлыг бууруулах сан;

9. Бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

1. Хөтөлберийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Үндэсний хороо гүйцэтгэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална. Хорооны нарийн бичгийн дарга нь орон тооны ажилтан байна.

2. Үндэсний хорооны үйл ажиллагааны чиглэл:

-хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

-хөтөлберийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх, хөтөлберт өөрчлөлт оруулах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх;

-хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд оролцогч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

-орон нутгийн салбарыг арга зүй удирдамжаар хангах;

-хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах.

3. Үндэсний хорооны орон нутгийн салбарыг аймаг, нийслэлийн Засаг дарга төрүүлэх бөгөөд бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид томилно. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална бүрэлдэхүүнийг Засаг дарга Үндэсний хороонд танилцуулна. Орон нутгийн салбар нь хөтөлберт тусгагдсан зорилт арга хэмжээг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж үр дүнг Үндэсний хороонд тайлагнах үүрэг хүлээнэ.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2001 он №50 (237)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 256 | Улаанбаатар хот

Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-т тусгагдсан үндсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар зайлуулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батална.

2. "Хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар зайлуулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, тухайн жилийн үр дүнгийн талаар дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

3. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ялган ангилах, дахин ашиглах үйл ажиллагаа Улаанбаатар хотын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид үр ашигтай эрхлүүлэх ажлыг туршилтын журмаар зохион байгуулж, дүнг 2002 оны 12 дугаар сард Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгасугай.

4. Хог хаягдлыг төрөлжүүлэн ялгах, тээвэрлэн зайлуулах, заагдсан цэгт хаях, цэвэр орчинд амьдрах ач холбогдол, эрүүл ахуйн шаардлагыг нийтэд ойлгуулах сургалт, сурталчилгааг байнга явуулан, хүн амын насны онцлогт тохирсон сурталчилгааны материал, гарын авлага болон шаардагдах арга зүйгээр хангах арга хэмжээ авч байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор цаас, яс, металл эдлэл, шил, нийлэг материалыг дахин боловсруулах жижиг үйлдвэр байгуулах асуудлыг судлан үзэж 2003 онд багтаан шийдвэрлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/хог хаягдлын зайлуулалт болон хог хаягдлын бохирдолтод хяналт тавих эрүүл ахуйн хяналтын байцаагчдыг хот, суурин газарт байнга ажиллуулж, орчны бохирдолтыг бууруулж, цэвэр орчныг хэрхэн бүрдүүлсэн байдлаар тэдний үйл ажиллагааг дүгнэж байсугай;

б/хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааны техник, технологийг 3-4 жилд багтаан шинэчлэх, дэвшилтэт менежментийг буй болгох арга хэмжээ авсугай;

в/хог хаягдлын хураамжийн зарцуулалтын тогтолцоог зах зээлийн нөхцөлтэй уялдуулан боловсронгуй болгох, нэгдсэн хяналтад оруулах арга хэмжээ авсугай;

г/аж ахуйн нэгж, байгууллагыг хог хаягдлаа зөвшөөрөгдсөн цэг дээр зориулалтын машинаар тээвэрлэн зайлуулдаг болгож хэвшүүлсүгэй;

д/нийтийн эзэмшлийн гудамж, талбай болон аж ахуйн нэгж, байгууллагын орчинд хог хаягдлын савыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулсугай;

е/айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүр орчноо хог хаягдалгүй, цэвэр байлгахын төлөө хөдөлгөөн өрнүүлж түүнийг хэвшил болгон мөрдүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

ХОГ ХАЯГДЛЫГ БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙ АРГААР ЗАЙЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хөрөнгө, эх үүсвэр	Үр дүн
1. Хог хаягдалтай холбогдолтой хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг боловсронгуй болгон шинэчлэх	1.1. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:				
	1.1.1. Байгаль орчныг бохирдуулсны төлөө хүлээх хариуцлагыг чангаттах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж боловсронгуй болгох;	2002- 2003 онд	БОЯ, ХЗДХЯ ЭМЯ	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, сайжирна
	1.1.2.Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгохтой холбогдсон стандарт, норм, нормативыг боловсруулан батлуулж мөрдүүлэх;	2002 онд	БОЯ, СЗЗЯ, ДБЯ, ЭМЯ	-	Яам, байгууллагын эрх, үүрэг тодорхой болж ажлын уялдаа холбоо сайжирна
	1.1.3.Хог хаягдлын чиглэлээр гарсан хууль тогтоомжийг эмхэтгэн нийтийн хүртээл болгох.	2002 онд	БОЯ	Улсын төсөв	Тухайн ажлыг эрхлэгчид гарын авлагатай болно
	1.2.Хариуцлагын тогтолцоог сайжруулах механизмыг бүрдүүлэх хүрээнд:				
	1.2.1. Бүх шатны Засаг даргын ажлыг дүгнэхэд хог хаягдлын менежмент, зохион байгуулсан ажлын үр дүнг харгалзан үзэх ;	2002 онд	ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга	-	Ил задгай хог хаягдалгүй болно.
	1.2.2. Үйлчлэх хүрээ, хяналтад хамрах объекттой нь уялдуулан хяналтын байцаагчдын ажиллах нормативыг тогтооx мөрдүүлэх;	2001- 2004 онд	Бүх шатны Засаг дарга	-	Хог хаягдлын хяналтын ажил боловсронгуй болно
	1.2.3 Хот, суурин газрын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.	2002 онд	Бүх шатны Засаг дарга	-	Хог хаягдлын менежментийг сайжруулна

2.Хог хаягдлыг бүрэн цуглуулж, зайлуулах ажлыг боловсронгуй болгох	2.1.Хог хаягдлын цуглуулалтыг сайжруулах хүрээнд: 2.1.1. Орон сууцанд суугч айл өрхийг хог ялган хадгалах уутаар хангах;	2002 оноос	ДБЯ, ҮХЯ, ЭМЯ, БОЯ, бүх шатны Засаг дарга	Улс, хотын төсөв, аж ахуйн нэгж, байгууллагын орлого	Ил задгай хог хаягдалгүй болох, хог хаягдлыг эрүүлэн ашиглах, боловсруулах боломжтой болно.
	2.1.2. Гэр хорооллын айл өрхийг үнс хийх төмөр сав, хог ялгах уутаар хангах;	-"-	-"-	-"-	-"-
	2.1.3. Аж ахуйн нэгж, байгууллыг хогны сав, ялгах уутаар хангах;	-"-	-"-	-"-	-"-
	2.1.4. Гудамж, талбайд зориулалтын хогийн савыг шаардагдах тоогоор тавих;	-"-	Бүх шатны Засаг дарга	Аж ахуйн нэгж , байгууллагын зардал	-"-
	2.1.5. Хог хаягдлыг цуглуулах сав, хот тохижилтын багаж, техник, тоног төхөөрөмж хийдэг жижиг үйлдвэр байгуулах арга хэмжээ авах;	-"-	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Улс, хотын төсөв	Хог хаягдлыг цэвэрлэхэд шаардагдах багаж, материал,зориулалтын хогийн савны үйлдвэртэй болно.
	2.1.6. Гудамж , талбайн хог шороог цэвэрлэх, цас, мөсийг арилгах машин механизмаар хангах арга хэмжээ авах.	-"-	-"-	-"-	Гудамжны цэвэрлэгээ сайжирна, хүний эрүүл мэндэд эерэг нөлөөлж, осол гэмтлийн тоо эрс буурна

	2.2. Хог хаягдлын тээвэрлэлтийг сайжруулах хүрээнд:				
	2.2.1. Хог хаягдыг тээвэрлэх зориулалтын машин техникээр хангах арга хэмжээ авах;	2002–2006 онд	ДБЯ, СЗЗЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	Аймаг, нийслэлийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө	Хог хаягдыг бүрэн тээвэрлэдэг болно.
	2.2.2. Улаанбаатар хотын төвийн айл ерх, орон сууц, аж ахуйн нэгжийн хог хаягдыг цуглуулах аргыг шинэчлэх;	2002 онд	БОЯ, нийслэлийн Засаг дарга	-"-	Хог хаягдыг бүрэн тээвэрлэж, орчныг бохирдолгүй болгоно
	2.2.3. Орон сууцны хог хаягдыг тээвэрлэх машин техникээр хангаж, ялгасан хөрдогч түүхий эдийг дуудлагаар үйлчлэн авдаг болох .	2002-2003 онд	-"-	-"-	-"-
3. Хот, суурин газрын хог хаягдлыг цэвэрлэж, хөрсийг эрүүлжүүлэх	3.1.Хот, суурин газар, түүний орчныг цэвэршүүлэх хүрээнд:				
	3.1.1. Хот, суурин газар болон түүний ойролцоо зохих зөвшөөрөлгүй хаясан хог хаягдыг зайлуулж, хөрсийг цэвэршүүлэх арга хэмжээ авах, буруутай эздийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх журамд шилжих;	2001-2004 онд	БОЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	Аймаг, нийслэлийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө	Хүн амыг аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.
	3.1.2 Хот, суурин газар болон түүний ойролцоо зохих зөвшөөрөлгүй хаясан хог хаягдлын судалгаа гаргах;	2001-2002 онд	-"-	-"-	Хог хаягдыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга зүйг тодорхойлно.
	3.1.3 Олон жил хуримтлагдсан хог хаягдыг зайлуулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;	2001-2004 онд	-"-	-"-	Газрыг ашиглах нөхцөл бүрдэнэ
	3.2. Аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдал, цас, мөсийг нь байнга цэвэрлэх газар, гудамж, талбайг хуваарилан хариуцуулж түүнд тогтмол хяналт тавьж, дүгнэж байх;	2001- 2004 онд	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	-	Хүний аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.
	3.3.Бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрыг хог хаягдлаа орчинд халгүйгээр булах нэгдсэн цэгтэй болгох.	2001-2004 онд	Аймаг, сумын Засаг дарга	Төвлөрсөн болон орон нутгийн төсөв, зээл тусламжийн хөрөнгө	

4. Цэвэр орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан хог устгалын нэгдсэн байгууламжтай болох	4.1.Нийслэлийн цэвэр орчин, эрүүл ахуйн шаардлагыг хангах хүрээнд:				
	4.1.1 Шаардлага хангасан хог устгалын нэгдсэн байгууламжийг байгуулах бэлтгэлийг үе шаттайгаар хангана;	2002-2003 онд	Нийслэлийн Засаг дарга, ЭМЯ, ДБЯ	Олон улсын байгууллага, гадаад орны хандив, зээл тусламж, улсын төсөв	Байгаль орчинд халгүй, зохих шаардлага хангасан хог устгалын нэгдсэн байгууламжтай болно
	4.1.2. Улаанбаатар хотод хог устгалын нэгдсэн байгууламжийг байгуулах.	2002-2004 онд	-"-	-"-	-"-
	4.2. Хог хаягдлын цэгийг цэгцлэх ажлын хүрээнд:				
	4.2.1.Хог хаягдлын байдалд улсын хэмжээгээр үзлэг явуулж, дүнг нэгтгэн гаргах;	2002 онд	БОЯ, ЭМЯ, аймгийн Засаг дарга	Олон улсын байгууллага болон гадаад орны хандив, хөрөнгө, төсөв	Нэгдсэн цэгийн тоо, хэмжээний тодорхой мэдээлэлтэй болж цаашид авах арга хэмжээг тогтооно
	4.2.2. Нэгдсэн цэгээс бусад газарт байгаа хог хаягдлыг зайлуулан газрыг цэвэрлэж хөрсжүүлэх;	2002-2004 онд	-"-	-"-	Их хэмжээний газар хог хаягдалгүй болсноор оршин суугч айл өрх, хүн амын эрүүл орчин, амьдрах нөхцөл бүрэлдэнэ
	4.2.3 Хог хаягдлын нэгдсэн цэгийг орчиндоо халгүй байхаар шаардагдах арга хэмжээг авах.	-"-	-"-	-"-	Хогийн цэгүүд цэгцлэгдэж, цэвэр орчинтой болоход нөлөөлнө.

	4.3. Улаанбаатар хотын хог хаягдлын цэгийг цэгцлэх ажлын хүрээнд:				
	4.3.1. Хог хаягдлын цэгүүдийг хаах бэлтгэл ажил хийх;	2001 онд	Нийслэлийн Засаг дарга, БОЯ, ЭМЯ	Олон улсын байгуулага болон гадаад орны хандив, хөрөнгө, төсөв	Их хэмжээний газрыг аж ахуйн өөр зориулалтаар ашиглах боломжтой болно.
	4.3.2.Дарь-Эхийн овоо, Улаанчулуутын хог хаягдлын нэгдсэн цэгийг хаах арга хэмжээг хэрэгжүүлэх;	2001-2003 онд	-"-	-"-	Цэвэр орчин бүрдэнэ
	4.3.3. Дарь-Эхийн овоо, Улаанчулуутын хог хаягдал байсан газрыг хөрсжүүлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах.	2004-2006 онд	-"-	-"-	-"-
	4.4. Эмнэлгийн хог хаягдлыг устгах зуух байгуулах	2002-2003 онд	Нийслэлийн Засаг дарга, ЭМЯ	Нийслэлийн төсөв	Эмнэлгийн хог хаягдлыг шатааж элдэв халдвар тараах нөхцөлийг зогсоох
5. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	5.1.Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах хүрээнд:				
	5.1.1.Хог хаягдлыг дахин ашиглах болон боловсруулах үйлдвэр байгуулах арга хэмжээ авах;	2002-2004 онд	Нийслэлийн Засаг дарга, ҮХЯ	Олон улсын хандив, зээл тусламж, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө	Хог хаягдлын хэмжээ багасна
	5.1.2. Хог хаягдлын бүтцийг судлан, дахин ашиглах, боловсруулах хог хаягдлын нэр төрөл, нөөцийг тогтоох;	2002 онд	БОЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	-"-	Хог хаягдлын хэмжээ, бүтэц, шинж чанарын улсын хэмжээний тодорхой мэдээлэлтэй болно.
	5.1.3. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрүүдийг сонгож, техник, эдийн засгийн тооцоо хийсний үндсэн дээр Дархан-Уул, Орхон, Дорнод, Ховд аймагт бүсчлэн байгуулах;	2002-2004 онд	-"-	-"-	Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах бодлого, чиглэл тодорхой болно
	5.1. 4. Аюултай хог хаягдлыг хайж олох арга замыг тодорхойлох устгалын цэг байгуулах;	2002-2003 онд	-"-	-"-	Үйлдвэрүүдтэй болсноор хог хаягдлын хэмжээ багасч, орчны бохирдолтыг бууруулна
	5.1.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа аюултай хог хаягдлыг илрүүлэн тогтоох.	-"-	БОЯ, ЭМЯ, ЦЕГ, ТЕГ	-"-	Орчин дахь аюултай хортой нөхцөлийг таслан зогсоох арга хэмжээ авна

6. Хог хаягдлын менежментийн чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэх, хүн амын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх :	6.1.Хог хаягдлын менежментийн хүрээнд: 6.1.1. Гадаад, дотоодын их, дээд сургуульд хог хаягдлын чиглэлээр мэргэжсэн боловсон хүчин бэлтгэх асуудлыг судлан шийдвэрлэх; 6.1.2. Яам тусгай газар, нутгийн захиргааны удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг хог хаягдлын менежментийн туршлага бүхий аль нэг гадаад оронд сургах, туршлага судлуулах, богино хугацааны сургалтад хамруулах.	2002 оноос тогтмол -"-	БСШУЯ, БОЯ, холбогдох их, дээд сургууль, коллежууд ГХЯ, БОЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	Улсын төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө -"-	Мэргэшсэн мэргэжилтэнтэй болно Менежмент сайжирна.
	6.2. Хүн амын дунд хог хаягдлын тухай , түүнийг багасгах, зайлуулах асуудлаар сургалт, сурталчилгааг өргөтгөх хүрээнд: 6.2.1. Холбогдох мэргэжлийн сургуулиудад хог хаягдлын чиглэлээр хичээл оруулж байх; 6.2.2. Цэцэрлэг, сургуулиудад хог хаягдлыг зайлуулах чиглэлээр танин мэдэхүй- эрүүл ахуйн сургалт, дадлагын хичээл явуулж байх; 6.2.3. Хог хаягдлыг багасгах, түүний хор нөлөөг таниулах талаар олон нийтэд зориулсан сурталчилгааны программ гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчлах;	2001 оноос 2001 оноос 2001 оноос	ЭМЯ, БОЯ, бусад төрийн болон төрийн бус байгууллага -"- Хэвлэл, мэдээллийн байгууллагууд	Улсын төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө -"- -"-	Хүмүүсийг эрүүл аж төрөх ёсыг ээмшүүлж хэвшүүлэх, цэвэр, аюулгүй орчинд амьдарч сурах, мэдлэг чадвар дээшилнэ Хүүхдийг бага наснаас эрүүл аж төрөх ёсны дадал заншилд сурган хэвшүүлнэ. -"-
	6.2.4.Хог хаягдлыг багасгах асуудлаар алсын зайны сургалт явуулах; 6.2.5.Хог хаягдлыг зүй зохистой зайлуулах, эрүүл ахуйн дадал хэвшил олгох сэдвээр олон нийтэд зориулан хялбаршуулсан сургалт сурталчилгааны материал бэлтгэх.	2001 оноос 2001 оноос	Төрийн болон төрийн бус байгууллага -"-	Улсын төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө -"-	Иргэдийн мэдлэг дээшилнэ. -"-

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Дугаар 259 **Улаанбаатар хот**

Нийслэлийн нийтийн тээврээр үнэгүй зорчих явдлыг журамлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчиж буй ахмад настан, тахир дутуу иргэдийн унааны хөлсний нөхөн олговорт шаардагдах хөрөнгийг шийдвэрлэж түүнийг олгох журмыг тээврийн байгууллагуудын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тооцож холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн, 2002 оноос эхлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгасугай.

2. Нийслэлд албан үүргээ гүйцэтгэж яваа цагдаагийн байгууллагын ажилтны нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих зардлыг тухайн байгууллагын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Нийтийн тээврийн үйлчилгээний орлого хураах ажлыг сайжруулж, нийтийн тээврийн хэрэгслээр мөнгөө төлөхгүй зорчих явдлыг зогсоох талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллаж алдагдлыг бууруулан, үнэ төлбөргүй зорчих талаар гарсан шийдвэрүүдийг хянан үзэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт үүрэг болгосугай.

4. "Тэтгэвэр авагчдын нийтийн тээврийн унааны зардлын зарим хэсгийг нөхөн олгох тухай" Засгийн газрын 1995 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 61 дүгээр тогтоол, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 209 дүгээр тогтоолоор батлагдсан "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-ийн гуравдугаар бүлгийн 10-ын "к" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 261 **Улаанбаатар хот**

Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Зэвсэгт хүчин, бусад цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор батлалсугай.

2. Зэвсэгт хүчин, бусад цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгохыг Батлах хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2001 оны 261 дүгээр тогтоолын хавсралт

ЗӨВСӨГТ ХҮЧИН, БУСАД ЦЭРГИЙН ОФИЦЕР, АХЛАГЧ, ГЭРЭЭТ ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Зөвсөгт хүчин, бусад цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагчид албаны онцлогоос хамааран өдөр, шөнө, улирлын ямар ч нөхцөлд байлдааны жижүүрлэлт, харуул хийх, хэзэрийн сургууль, дадлагад оролцох, байлдааны зөвсөг техник, тэсэрч дэлбэрэх болон хорт бодис, цэргийн нууцтай байнга харьцах, байгалийн гамшиг, осол гарсан үед авран хамгаалах ажил явуулах зэрэг онцгой үүрэг гүйцэтгэдигийг харгалзан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг олгоход энэ журмыг баримтална.

2. Зөвсөгт хүчний байлдааны анги, салбарын офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч, байлдааны жижүүрлэлтийн бүрэлдэхүүн болон дотоодын цэргийн улсын онц чухал объектын хамгаалалтын тусгай салбарын офицер, ахлагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг олгоно.

3. Энэ журмын 2-т дурдсан бие бүрэлдэхүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар тооцож сар бүр олгоно.

4. Зөвсөгт хүчний сургууль-байлдааны, сургуулийн, хангалт үйлчилгээний анги салбарын офицер, ахлагчид байгалийн болон нийтийг хамарсан гамшиг ослын аюул, хөнөөлөөс хүн амд, эд хөрөнгийг хамгаалах, тогтоосон хорио цээрийн дэглэм сахиулах үүрэг гүйцэтгэсэн хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгож болно.

5. Инженер, холбоо, хангалт үйлчилгээний анги, салбарын офицер, ахлагчид хилийн хамгаалалт, хилийн инженерийн ажилд үүрэг гүйцэтгэсэн хугацаанд нь, мөн Буянт-Ухаа дахь шалган нэвтрүүлэх боомтын офицер, ахлагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгож болно.

6. Энэ журмын дагуу олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн анги салбарын төсөөс гаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 262** **Улаанбаатар хот**

Нэрэмжит болгох тухай

Завхан, Төв аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Завхан аймгийн Сантмаргац сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Магсарын Санждоржийн, Төв аймгийн Зуунмод сумын 10 жилийн дунд сургуулийн "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Жанчивын Намсрайн нэрэмжит болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487